



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.08 № 1 / 2395

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Санал авах тухай

Тус яамнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу санал авахаар хүргүүлэв.


Хуулийн төслийг судлан үзэж, саналаа ирүүлнэ үү.

Хавсралт:

1. Үзэл баримтлал;
2. Хуулийн төсөл;
3. Дагалдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төсөл;
4. Товч танилцуулга;
5. Дэлгэрэнгүй танилцуулга;
6. Хуулийн төслийн судалгааг агуулсан QR бүхий хавсралт.



С.АМАРСАЙХАН



**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

2026 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

**С.АМАРСАЙХАН**

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

### 1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгаа бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээж эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай Хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээж эдлүүлэх, шударга шүүхээр шүүлтгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг<sup>2</sup> 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.3.2-т "Хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ" гэж, 7.4.8-д "ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор "Цахим хяналтын төв"-ийг байгуулж, пробацацийн тогтолцоог хөгжүүлнэ" гэж, 7.4.14-т "Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна" гэж тус тус заасан.<sup>3</sup>

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>4</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>5</sup> 4.1.1.8-д "... Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна" гэж, 4.2.1.11-д "ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, ялтныг хөдөлмөртөлх нөхцөлөөр хангаж, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэж, 3.2.2.7-д "...

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралт.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2020 оны 25 дахь дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>5</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж тус тус заасан.

### 1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Нэг.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг боловсронгуй болгох дараах практик хэрэгцээ, шаардлага үүссэн:

1.2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг журамлан, нэгдсэн тогтолцоогоор хэрэгжүүлэхээр зохицуулсан. Гэвч хуулийн хэрэгжилтийн явцад иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ял, шийтгэл эдлүүлэх чиг үүрэгтэй нэг тогтолцоонд хамруулсан зохицуулалт нь практикт тодорхой хүндрэл үүсгэж байна.

Тухайлбал, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүх засаглалаас салангид байдлаар хэрэгжиж ирсэн тул шүүхийн шийдвэр заавал биелэгдэх баталгааг хангах, иргэд, бизнес эрхлэгчдийн эерчигдсэн эрхийг шуурхай, үр дүнтэй сэргээх нөхцөлийг бүрэн бүрдүүлэхэд хүндрэл учруулж байна.

Харин олон улсын туршлагаас харахад, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь ял, шийтгэл эдлүүлэх ажиллагаанаас чиг үүрэг, зорилго, арга хэрэгслийн хувьд ялгаатай тул тогтолцооны хувьд бие даасан байдлаар, ихэвчлэн гүйцэтгэх засаглал, эсхүл шүүхийн харьяанд, шүүхийн хяналт, зохицуулалтын дор хэрэгждэг нийтлэг жишиг байна. Иймд иргэний шийдвэр гүйцэтгэлийг ял, шийтгэл эдлүүлэх тогтолцооноос салгаж, гүйцэтгэлийн үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бий болгон, шүүхийн шийдвэрийг шуурхай, бодитой, үр дүнтэй биелүүлэх бие даасан, мэргэшсэн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсон.

Олон улсад төрийн, хувийн, холимог тогтолцоонууд хэрэгжиж байгаа бөгөөд үр дүнгийн хувьд хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо илүү байгаа нь ажиглагдаж байна. Хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоонд шилжсэн улс орнууд болох Казахстан, Гүрж, Болгар, Эстони зэрэг улс орнуудын туршлагаас харахад иргэний шийдвэр гүйцэтгэлийг төрийн байгууллага дангаар хэрэгжүүлэх тогтолцооноос татгалзаж, эхний ээлжид төр, хувийн хэвшлийг хослуулсан холимог заагарыг хэрэгжүүлж, тодорхой хугацаанд үр нөлөөг нь үнэлсний үндсэн дээр хувийн шийдвэр гүйцэтгэл илүү үр ашигтай нь нотлогдож, уг тогтолцоонд үе шаттайгаар бүрэн шилжсэн нийтлэг зүй тогтол байна.

Иймд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ял, шийтгэл эдлүүлэх тогтолцооноос салгаж, үе шаттайгаар хувийн шийдвэр гүйцэтгэлийн бие даасан, мэргэшсэн, гүйцэтгэлийн үр дүнд суурилсан тогтолцоонд шилжүүлэх, тодруулбал, жил бүр 10 хувийг хувийн шийдвэр гүйцэтгэл хэлбэрт шилжүүлж, 10 жилийн дараа гэхэд иргэний шийдвэр гүйцэтгэлийг бүрэн хэмжээгээр хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоогоор хэрэгжүүлдэг болох эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Гэвч дээрх зохицуулалт нь хөдөлмөрийн хөлсний үнэлгээг зах зээлийн жишиг үнэтэй уялдуулах, хөдөлмөр эрхлэлтийг бодитоор дэмжих, хоригдлын хохирол, төлбөр барагдуулах үр нөлөөг нэмэгдүүлэхэд хангалтгүй байна. Иймд хоригдлын хөдөлмөрийн хөлсний үнэлгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд суурилан тогтоох механизмыг илүү тодорхой болгож, аливаа албан тушаалтны үзэмжээр тогтоох боломжийг хязгаарлах шаардлага үүсэж байна. Ингэснээр хоригдлын хөдөлмөрийн хөлс зах зээлийн жишиг үнээс хэт доогуур тогтоогохоос сэргийлж, хөдөлмөр эрхлэлтийг бодитоор дэмжих нөхцөл бүрдэх боломжтой. Түүнчлэн хоригдлын хөдөлмөрийн хөлсний тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлж, үлдэх хэсгийг хохирол барагдуулах, төлбөр төлөх, суллагдах үед нь хуримтлал үүсгэхэд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох практик шаардлага үүсэж байна.

Эдгээр өөрчлөлт нь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үйлдвэрлэлийг өргөжүүлэх, хорих байгууллагын ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг сайжруулах, улмаар улсын төсвийн ачааллыг бууруулах зорилтыг ханган хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Мөн улс орны бүтээн байгуулалт, бүсчилсэн хөгжилд хоригдлыг ажиллуулах зорилгоор хорих ангийг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ бий болж байна.

Түүнчлэн эрүүгийн хариуцлагын зорилтын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, хоригдолд мэргэжлийн боловсрол эзэмшүүлж, хөдөлмөрийн дадал олгох, нийгмийн амьдралд бие даан ухамсартайгаар оролцох чадвартай, бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Иймд нийт хоригдол, өсвөр насны хүний ял эдлүүлэх ажиллагааны журам, нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох эрүүгийн хэрэгт ял шийтгэгдсэн этгээдүүдийг бусад төрлийн ял эдэлж байгаа хоригдлоос тусгаарлан ял эдлүүлэх замаар сөрөг нөлөөлөл, гэмт зан үйлийн харилцан дамжих эрсдэлийг бууруулж, аюулгүй орчин бүрдүүлэх шаардлага үүссэн.

Үүний зэрэгцээ тэдгээрт зан үйл засах, сэтгэл зүйн зөвлөгөө, донтох эмгэгийн эмчилгээ, нийгэмшүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлтийн тусгай хөтөлбөр, арга зүйг хэрэгжүүлж, үр нөлөөтэйгээр хүмүүжүүлэх тогтлооог бий болгох шаардлага бий болсон.

Хоёр, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт:

2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 206 дугаар тогтоолын 1.2-т эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актуудад дүн шинжилгээ хийж, тэдгээрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дүгээр зүйлд нийцүүлэх, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг хууль тогтоомжоор зохицуулах хуулийн төслийг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг олон харилцааг дүрэм, журмаар зохицуулж байна. Тухайлбал, хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх, хорих ангийн болон хувийн өмчийн хуулийн этгээдийн үйлдвэрлэлээс олсон орлогыг хуваарилах, түүнд хяналт тавих, сахилтын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах, хорих анги, баривчлах байрны журам зэрэг чухал харилцаанууд захиргааны хэм хэмжээний актаар зохицуулагдаж байна.

Иймд дээрх дүрэм, журамд дүн шинжилгээ хийж, хүний эрхэд аливаа сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй цөм харилцааг хуульд тусгаж, хууль хүн бүрд адил тэгш хэрэгждэг байх зарчмыг хангаж, журам, дүрмийн тоог цөөлөх талаарх Монгол Улсын Засгийн газрын бодлого, чиглэлтэй нийцүүлэх шаардлага үүсэж байна.

3. 2025 оны байдлаар 4649 хоригдол ял эдэлж байгаагаас 3557 хоригдол буюу нийт хоригдлын 77.7 хувийг ажлын байраар хангаж, 623.5 сая төгрөгийн цалин хөлсний орлого олсон байна.

Гэвч 2024 онд хорих ангийн үйлдвэрлэлд 1307, аж ахуйн үйлчилгээнд 328 хоригдол, аж ахуй нэгжид гэрээгээр 120 буюу нийт 1775 хоригдол /нийт хоригдлын 38 хувь/ хөдөлмөрт хамрагдсан нь хоригдлыг хөдөлмөрт хамруулах хуульд заасан зорилт бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

Мөн хоригдлын хохирол, төлбөр барагдуулалт туйлын хангалтгүй хэмжээнд байна. Тодруулбал, 2025 онд нийт 1581 хоригдол 255.9 тэрбум төгрөгийн хохирол, төлбөртэй байснаас ердөө 1 хүрэхгүй хувь нь хохирол, төлбөрөө барагдуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215 дугаар зүйлийн 215.5 дахь хэсэгт хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батлахаар, мөн хоригдлын хөдөлмөрийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багатай байхаар заасан. Энэхүү зохицуулалтын хүрээнд хоригдлын нэг өдрийн цалинг 3929 төгрөгөөс дээш байхаар тогтоож, хоригдлыг гэрээгээр ажиллуулах журмын дагуу хөдөлмөр эрхлүүлж байна.

Монгол Улс эрх зүйт төрийн үзүүлэлт (Rule of Law/-ийн иргэний эрхийн хамгаалалт үзүүлэлт, Дэлхийн банкаас гаргадаг бизнэс эрхлэх үзүүлэлт /Doing business index/-ийн гэрээний хэрэгжилт дэд үзүүлэлтээр урагшлахын тулд иргэд, бизнес эрхлэгчдийн хувийн эрх зүйн хүрээнд дэх зөрчилдсөн эрхийг үр дүнтэй, шуурхай сэргээх замаар шүүхийн шийдвэр заавал биелэгддэг байх зарчмыг хангах шаардлагатай болсон.

Эрх зүйт төрийн үзүүлэлт (Rule of law Index/-ээр 7 хүчин зүйлийг хэмждэг бөгөөд иргэний эрхийн хамгаалалт /civil justice/ нь эрх зүйт төрийн үзүүлэлтийн нэг үндсэн дэд үзүүлэлт болно.<sup>6</sup> Тус дэд үзүүлэлтээр иргэнд учирсан хохирлыг тухайн улс тавьан, үр дүнтэй аргаар иргэний эрх зүйн тогтолцоогоороо барагдуулж байгаа эсэх, тогтолцоо нь нээлттэй, боломжит үнэтэй эсэх, ялгаварлан гадуурхалт, авлига, төрийн албан хаагчийн зохисгүй нөлөөллөөс ангид эсэх, иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь үндэслэлгүйгээр удааширдаг эсэх, шүүхийн шийдвэр үр дүнтэй хэрэгждэг эсэхийг хэмждэг байна.<sup>7</sup> Монгол Улс Civil Justice буюу иргэний эрхийн хамгаалалт үзүүлэлтийн дэд хүчин зүйл болох иргэний шийдвэр гүйцэтгэл үр дүнтэй байх үзүүлэлтээр 80 дугаарт жагсаж байна.<sup>8</sup>

Гэтэл Монгол Улс дахь иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны биелэлт жилд дундажаар 20-30 хувьтай буюу хангалтгүй байна.

Өнгөрсөн жилийн байдлаар иргэний хэргийн 4.3 их наяд гаруй төгрөгийн үнийн дүн бүхий 87204 гүйцэтгэх хуудаснаас 1.1 их наяд төгрөгийн 183,451 гүйцэтгэх хуудас нь биелж, 3.4 их наяд төгрөгийн 83,212 гүйцэтгэх хуудас нь биелэгдээгүй үлдсэн бөгөөд шийдвэрийн биелэлт мөнгөн дүнгээр ердөө 21 хувьтэй байна. Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн 70 орчим хувь нь биелэгдээгүй байна.

Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 19 гүйцэтгэх хуудсанд хамаарах 120 орчим тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, дотоод, гадаадын арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 20.1 хувь буюу 478.5 тэрбум орчим төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэд сүүлийн 5 жилийн дунджаар дүн шинжилгээ хийхэд гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 54,4%, мөнгөн дүнгийн бодит биелэлт 24.1%, биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар 94,3%-аар өссөн.

<sup>6</sup> [https://eaurcm.eu/news/new-2022-rule-of-law-index/?fbclid=IwAR0dsWAPqyVDA7nIa6GZNd0iMMf4PZv\\_Smg4RSG1Evi6St6EPn\\_6YLuo](https://eaurcm.eu/news/new-2022-rule-of-law-index/?fbclid=IwAR0dsWAPqyVDA7nIa6GZNd0iMMf4PZv_Smg4RSG1Evi6St6EPn_6YLuo)

<sup>7</sup> [https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2022/Denmark/Civil%20Justice/?fbclid=IwAR2AdiPD06v6enmr2qS7ScaAbnkoXqnpPbZaWTiWERACTYzTtqVBI6eF\\_4Q](https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2022/Denmark/Civil%20Justice/?fbclid=IwAR2AdiPD06v6enmr2qS7ScaAbnkoXqnpPbZaWTiWERACTYzTtqVBI6eF_4Q)

<sup>8</sup> <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2022/Mongolia/Civil%20Justice>

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан маш олон өргөдөл, гомдол Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандан ирүүлдэг бөгөөд 2025 оны хууль зүйн салбарын 42,188 өргөдөл, гомдлын 8109 нь буюу нийт өргөдөл, гомдлын 19.2 хувь нь тус ажиллагаанд холбогдсон өргөдөл, гомдол байв. Үүнээс 64.9 хувь буюу 5265 нь иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой байна.

Гэвч шүүхийн шийдвэрийн биелэлт 70–80 хувь нь биелэхгүй байгаа атлаа нэг жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн зөрчлийн хэрэгт шалгагдсан 60 иргэн, хуулийн этгээдээс ердөө 3-т нь Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл ногдуулсан нь хариуцлагын механизм бодит нөлөө үзүүлэхгүй, хэрэгжилт сул байгааг харуулж байна. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шуурхай торгууль оногдуулах, албадан ирүүлэх зэрэг шууд албадлагатайг хэмжээг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг нэн даруй бий болгох шаардлагатайг илтгэж байна. Олон улсын сайн туршлага ч шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангахад ийм шуурхай, шууд албадлагын механизм илүү үр нөлөөтэй болохыг нотолдог.

Жишээ дурдахад, 2015 онд 234.2 сая төгрөг гаргуулах шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлж, барьцаа хөрөнгийг битүүмжилсэн боловч төлбөр төлөгч үнэлгээ, дуудлага худалдаатай холбоотойгоор удаа дараа гомдол гаргаж, шүүхийн захирмааар 3 удаа түдгэлзүүлснээр ажиллагаа нийт 7 жил сунжирсан байна. Улсын дээд шүүх 2022 онд хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараа төлбөрийг бүрэн барагдуулсан ч энэ хугацаанд инфляц өсөж, 2015 онд авах ёстой мөнгөний худалдан авах чадвар мэдэгдэхүйц буурсан байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удаашрал нь төлбөр төлөгчид давуу байдал бий болгож, төлбөр авагчийн эрх, эдийн засгийн ашиг сонирхлыг бодитоор хохироодог бөгөөд учирсан алдагдлыг нөхөн сэргээх эрх зүйн механизм дутмаг байгааг энэхүү жишээ харуулж байна.

Олон улсын сайн туршлагаас үзэхэд шүүхийн шийдвэрийг шуурхай, бодитой биелүүлэхийн тулд төлбөр төлөгчид албадлага, хөшүүрэг үүсгэх буюу хугацаанд нь биелүүлэхэд эдийн засаг, эрх зүйн хөшүүрэг бий болгох арга хэмжээг цогцоор хэрэгжүүлдэг. Тухайлбал, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алданги, хүү тооцох, шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг ердийн олон шатлалт шүүхийн журмаар бус шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шуурхай шийдвэрлэх, төлбөр төлөлттэй эсэх мэдээллийг олон нийтэд ил тод байршуулах, мөн тодорхой эрх (жишээлбэл, гадаадад зорчих, амин хэрэгцээг хангахаас бусад зарим төрийн үйлчилгээ авах, төрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах зэрэг)-д хязгаарлалт тогтоох замаар шийдвэрийг хугацаанд нь биелүүлэх үр нөлөөтэй процессыг бий болгосон байдаг.

Иймд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг боловсронгуй болгох дараах хэрэгцээ, шаардлага байна:

1. Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэгч цэргийн албан хаагч байх нь практикт олон асуудал дагуулж, түүний хараат бус, бие даасан, мөргэжлийн байдал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөтэй, шуурхай байдалд сөргөөр нөлөөлж байна.

Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 50 гаруй ахлах шийдвэр гүйцэтгэгч байгаа ч шийдвэр гүйцэтгэгчид туслах алба хаагч дутмаг байна. Гэтэл Гүрж улс 3 сая 800 мянга гаруй хүн амтай ч<sup>9</sup> нийт 424 албан хаагчтай 158 шийдвэр гүйцэтгэгчтэй бөгөөд тэдэнд туслах 157 захиргааны албан хаагч, 57 шийдвэр гүйцэтгэлийн цагдаа байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх чиг үүргийг шийдвэр гүйцэтгэгч бие даан гүйцэтгэх боломжтой төдийгүй шат дамжин зөвшөөрөл авснаар ажиллагаа удаашрах, зөвшөөрөл авахгүйгээр хариуцлага хүлээж, тэдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлж болохоор байна.

Тухайлбал, орон байранд нэвтрэн орох, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан авах боломжтой байна.

Түүнчлэн ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хийх үйл ажиллагааг цахимжаар шийдэх боломжтой. Тухайлбал, ажиллагааг нээх, хаах, гүйцэтгэх баримт бичгийг буцаах, дуудлага худалдаа явуулах шийдвэр гаргах гэх мэт үйл ажиллагаа үүнд хамаарна. Ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчдэд жилд шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан олон гомдол ирдэг бөгөөд энэхүү чиг үүргийг шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгчид хариуцуулж, шуурхай шийдвэрлэх боломжтой.

Шийдвэр гүйцэтгэгч урамшуулалгүй мөртлөө цэргийн цолтой буюу дэслэгчээс хурандаа хүртэл цалингийн 26-36 хувийн цолны нэмэгдэл<sup>10</sup> авдаг бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн<sup>11</sup> дагуу тэтгэмж, тэтгэврийн онцлог зохицуулалт үйлчилдэг.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчдыг цэргийн эрдэмд сургах шаардлагагүй бөгөөд эрх зүйн болон эдийн засгийн бусад ур чадваруудыг сургах шаардлагагүй талаар судалгаанд дурджээ.<sup>12</sup>

БНСУ, ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэгч нь төрийн захиргааны алба хаагч байх бөгөөд олон улсад шийдвэр гүйцэтгэгч төрийн албан хаагчийн цалингаас гадна гүйцэтгэсэн төлбөрийн үнийн дүнгээс тооцсон урамшуулал авах жишиг байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэлийг үр дүнтэй, шуурхай болгож, төлбөр авагчийн зөрчилдсөн эрхийг шуурхай сэргээх үүднээс иргэний шийдвэр гүйцэтгэгч цэргийн бус,

<sup>9</sup> <https://www.worldometers.info/world-population/georgia-population/>

<sup>10</sup> Засгийн газрын 1999 оны 38 дугаар тушаалын хавсралт.

<sup>11</sup> Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>12</sup> ЕСБХБ-ны хийсэн Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам, холбогдох эрх зүйн актын шинэчлэлийн үзэл баримтлал, 2024.

төрийн алба хаагч байх, харин урамшууллыг зохистой хэмжээнд авах, цаашид үе шаттайгаар хувийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлэх шаардлага үүсчээ.

2. Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь олон улсад гүйцэтгэлд суурилсан урамшуулал /performance based fee/-д тулгуурлан ажиллагаа явуулдаг байхад манай улсын хувьд тус зохицуулалт байхгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үр нөлөөтэй биш байна.

1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийг 2002 он хүртэл дагаж мөрдөж байсан ба энэ үед шийдвэр гүйцэтгэгч урамшуулал авдаггүй байсан байна.<sup>13</sup> Харин 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгч цалингаас гадна урамшуулал авдаг болсон байжээ.<sup>14</sup> Энэхүү зохицуулалт 2017 оны буюу одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдах хүртэл хэрэгжсэн.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10 хүртэлх хувиар урамшуулна" гэж, мөн зүйлийн 83.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчилэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна" гэж тус зүйлд заасан бөгөөд хуулийн 83.3 дахь хэсэгт урамшуулал олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заажээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмын<sup>15</sup> 2.1-д зааснаар биелүүлсэн шүүхийн шийдвэрийн хувьд мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс 5-10 хувийн урамшууллыг суутгаж, аймаг, нийслэлийн ШГА-ны дансанд төвлөрүүлнэ. Журмын 3-т зааснаар урамшууллыг шийдвэр гүйцэтгэгчид, болзошгүй эрсдэлийн санд, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны бусад зардалд хуваарилдаг. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэгчид хуваарилах урамшууллын хэмжээ нь 1 сая хүртэлх төгрөгийн шийдвэрийн хувьд 5.5 хувь, 1-5 сая бол 4 хувь, 5-10 сая бол 3 хувь, 10-25 сая бол 2.5 хувь, 25-50 сая бол 2 хувь, 50-75 сая 1.5 хувь, 75-100 сая төгрөгийн 1 хувь, 100 саяас дээш бол 0.5 хувь байхаар заасан байна.

Урамшуулалтай байсан 2002-2016 оны хоорондын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл 4,7 тэрбум орчим мөнгөн дүн бүхий 413916 гүйцэтгэх хуудаст хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 1,6 тэрбум мөнгөн дүн бүхий гүйцэтгэх ажиллагаа биелэгдсэн байх бөгөөд энэ нь нийт гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх хуудасны 53 хувь, мөнгөн дүнгийн 35 хувийг эзэлж байна.

<sup>13</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=7165>

<sup>14</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=89>

<sup>15</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=203760>

ажиллагааг түдгэлзүүлдэг нь төлбөр төлөгч үндэслэлгүй олон гомдол шүүхэд гаргаж ажиллагааг удаашруулах арга барил болгон ашигладаг практик тогтсон байна.

Тухайлбал, 2022 онд хийсэн судалгаагаар, 2022 онд 786 гүйцэтгэх хуудасны 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг битүүмжлэн, хурааснаас 508 гомдлыг шүүхэд талууд гаргасан. Үүний 435 гомдлыг төлбөр төлөгч гаргасан. Төлбөр төлөгч ажиллагааг удаашруулах, түдгэлзүүлэх зорилгоор ихэвчлэн шүүхэд гомдол гаргадаг.

Харин гадаад орны зарим туршлагын хувьд, тухайлбал, БНСУ-д, нэн даруй гомдол гаргах нь гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй. Гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл төлбөр төлөгчийн барьцаатайгаар, эсхүл барьцаагүйгээр шийдвэрийн биелэлтийг хэсэчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх шийдвэр гаргах, эсхүл төлбөр авагчийн барьцаатайгаар гүйцэтгэлийн ажиллагааг үргэлжлүүлэх шийдвэр гаргана. Энэ түдгэлзүүлэх, эсхүл үргэлжлүүлэх шийдвэрт гомдол гаргах үл болно.<sup>18</sup>

Мөн ХБНГУ-ын хувьд, гомдол гаргасан бол шүүх хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг төлбөр төлөгчөөс баталгаа гаргуулан, эсхүл баталгаа гаргуулахгүйгээр түр түдгэлзүүлэх, эсхүл зөвхөн төлбөр авагчаас баталгаа гаргуулсныг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна. Төлбөр авагч баталгаа гаргах чадахгүй, эсхүл онцгой хүндрэлтэй байгаа бөгөөд хойшлуулах нь төлбөр авагчид нөхөн төлөхөд бэрхшээлтэй байх, эсхүл хохирол учрахаар бол, эсхүл бусад шалтгааны улмаас төлбөр авагч зөвшөөрөхгүй байгаа бол хүсэлтийг нь үндэслэн шүүхийн шийдвэрийг урьдчилсан байдлаар гүйцэтгэх боломжтойд тооцно. Төлбөр авагчийн ашиг сонирхол илт давамгай байх тохиолдолд төлбөр төлөгчийн түдгэлзүүлэх хүсэлтийг хангахгүй байх зохицуулалттай байна.<sup>19</sup>

БНСУ-д нэн даруй гомдол (immediate compliant) гаргах буюу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрт зөвхөн хуульд заасан үндэслэлээр нэн даруй гомдол гаргаж болдог.<sup>20</sup> Харин ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэлийн шүүх нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдлыг хянадаг байна.<sup>21</sup>

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол нь нэхэмжлэл (law suit) биш, шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь эсэргүүцэл буюу гомдол (objection, complaint) бөгөөд энэ утгаараа шийдвэр гүйцэтгэл харуцсан шүүгч шуурхай 7-14 хоногт шийдвэрлэдэг буюу заавал хуралдаан хийхгүйгээр шийддэг.

Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох гомдлыг шуурхай шийдвэрлэх шийдвэр гүйцэтгэлийн шүүгч, мөн гомдлыг нэхэмжлэл гэж үзэхгүй байх, харин

<sup>18</sup> [https://elaw.kiri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kiri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>19</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>20</sup> [https://elaw.kiri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kiri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>21</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

Харин урамшуулалгүй үеийн /2017-2024/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн үзүүлэлт дундажаар 52.5 хувь, мөнгөн дүн 26.3 хувьтай ажилласан байна. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүнгээс бодогдох урамшуулалгүй болсноор гүйцэтгэх баримт бичиг бага үнийн дүнтэй эсэхээс үл хамааран гүйцэтгэх баримт бичгийн биелэлт өндөр, мөнгөн дүнгийн биелэлт буурсан байна.

Өөр нэг ажиглагдаж буй чухал давтамж бол урамшуулалгүй үеийн 2017-2024 оны шийдвэрийн биелэлтийг үзэхэд, бүх онуудад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт мөнгөн дүнгийн биелэлтээс илүү байсан байна. 2015 онд буюу ШШГТХ 2017 батлагдахаас өмнө гүйцэтгэх хуудасны биелэлт 46.3 хувь, 2022 онд 54.6 хувь болж өссөн ч энд бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн өсөлтийн хувь 9.2 байсан, 5 саяас дээш гүйцэтгэх хуудаст явуулсан ажиллагааны биелэлт 3.3 хувиар өссөн. Шийдвэр гүйцэтгэгч урамшуулалтай байсан 2017 оноос өмнөх үед өндөр үнийн дүнтэй буюу урамшуулал ахиухан авах гүйцэтгэх баримт бичигт хийх ажиллагаа түлхүү явагдаж, бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн биелэлт сул, харин 2017 оноос хойш урамшуулалгүй тул бага үнийн дүнтэй хялбар гүйцэтгэж болох гүйцэтгэх баримт бичгийн биелэлт нь нэмэгджээ.<sup>16</sup>

Нөгөө талаас, урамшууллын хувь хэмжээг зохистой тогтоохгүй бол төлбөр төлөгч, төлбөр авагчийн хувьд санхүүгийн дарамт болох, улмаар шүүхийн шийдвэрийн биелэлтэд сөргөөр нөлөөлөх, гагцхүү том үнийн дүнтэй хэргүүд дээр ажиллагаа төвлөрөх зэрэг сөрөг үзэгдлүүд түгээмэл ажиглагддаг.<sup>17</sup>

Иймд гүйцэтгэлд суурилсан урамшууллыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүссэн.

3. Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдон гаргасан гомдол нь шүүхэд хэрэг маргаан шийдвэрлүүлэх нэхэмжлэл, хүсэлт биш боловч манай улсын хувьд тус гомдлыг шүүхэд хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар анхан, давах шатны шүүхээр шийдвэрлэж байна. Үр дүнд нь гомдол гаргаснаар шийдвэр гүйцэтгэх албадлагын арга хэмжээ сунжрах гол нөхцөл болдог.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гаргах талуудын гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гаргаж, төлбөр төлөгч нэхэмжлэгч, шийдвэр гүйцэтгэгч харууцагч болж, зохигчийн эрх, үүргийг эдэлж, 3 шатны шүүхээр явах боломжтой байдаг төдийгүй тус хугацаанд

<sup>16</sup> Я.Батгэрэл, Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал, хэрэгцээ шаардлага, ШШГГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлэх хүчин зүйлс, Тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

<sup>17</sup> З.Шардарсүрэн, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо, олон улсын туршлага, ШШГГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

албадлагын үе шатны гомдол гэж үзэж түргэн шийдвэрлэж, ажиллагаа удаашрахаас сэргийлэх шаардлага тулгарчээ.

4.Эд хөрөнгийн үнэлгээний тайланг эс зөвшөөрөөл шүүхэд хандан гаргасан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэдэг.

Төлбөрийн үүргийг хангуулах эд хөрөнгийн үнэлгээний тайланг эс зөвшөөрөөл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу төлбөр төлөгч нэхэмжлэгч, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болж, зохигчийн эрх, үүргийг эдэлж, 3 шатны шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой байдаг төдийгүй тус хугацаанд ажиллагааг түдгэлзүүлдэг нь төлбөр төлөгч үндэслэлгүй олон гомдол шүүхэд гаргаж, ажиллагааг удаашруулах арга барил болгон ашигладаг практик тогтсон байна.

Эд хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гаргасан гомдол 2023 онд 362 буюу нийт 546 гомдлын 66.3 хувь нь байсан бол 2024 онд үнэлгээний гомдол 377 буюу нийт 486 гомдлын 77.5 хувь нь байсан байна.<sup>22</sup> Харин 2023 онд нийт гаргасан энэ төрлийн гомдлын 31.5 хувь буюу 172 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн бол 2024 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 35.8 хувь буюу 174 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн байна.<sup>23</sup>

2023 оны байдлаар 267 тэрбумын 330 төлбөр төлөгчид хамаарах ажиллагаатай холбоотой эд хөрөнгийн үнэлгээний гомдол шүүхэд гаргаснаас улбаалан түдгэлзсэн байна.<sup>24</sup>

Үнэлгээний үнэлгээ тогтоосон үнэлгээний тайланг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах нь дараах эрсдэлийг бий болгож байна.<sup>25</sup> Үүнд:

- ойролцоогоор 2-4 жил шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зогсох;
- төлбөр авагч төлбөрөө барьцаа хөрөнгөөс хүртэл гаргуулах боломжгүй хязгаарлагдах, удаашрах.

Иймээс эд хөрөнгийн үнэлгээний талаар гарсан гомдлыг шүүхэд бус, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу дахин, эсхүл нэмэлт үнэлгээ хийлгэх байдлаар шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага үүсчээ.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулахад хариуцлага оногдуулах нь Эрүү, зөрчлийн хууль тогтоомжоор зохицуулагддаг тул цагдаа,

<sup>22</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025

<sup>23</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

<sup>24</sup> Т.Наранцогт, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

<sup>25</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023-аас.

прокурор, шүүх гээд олон шат дамжлагыг туулдаг, гэтэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх сүүлийн үе шат байдаг ч шийдвэр гүйцэтгэгчид албадлага хэрэглэх хөшүүргүүд байхгүй байна.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдаж, дагаж мөрдөж эхэлсэн буюу 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хойш 7 орчим жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх гэмт хэрэгт 11 тохиолдолд шүүх хуралдаан хийж, гэм бурууг шийдвэрлэсэн байна.<sup>26</sup> Үүнээс нийслэлд 7, орон нутагт 4 шүүхийн шийдвэр хамаарч байна. Үүнээс 2 хэрэгт 6 сарын хугацаагаар хорих шийдвэр гаргасан байна. Гэхдээ эдгээр тохиолдлуудад хөрөнгийн мэдүүлээс буруу гаргасан, зайлсхийсэн гэх үйлдлийг шийтгэсэн тохиолдол байхгүй буюу хөрөнгийн мэдүүлэг гаргахгүй байсан ч хариуцлага тооцдоггүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2-т заасан хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан, төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл бүхий зөрчлийн хэргээр маш цөөн хүн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор шалгасан дараах тохиолдол байна. Үүнд:

2023 онд 16 хүнд, 2024 онд 28 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан бол мөн хуулийн 15.27 дугаар зүйлд заасан Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх зөрчлийн хэргээр 2022 онд 14 хүн шалгаснаас 4, 2023 онд 8 хүнд, 2024 онд 5 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан байна.<sup>27</sup> Гэтэл биелэгдээгүй иргэний шийдвэр гүйцэтгэл их буюу 2024 онд гэхэд 26619 төлбөр төлөгч төлбөрөө төлөөгүй байна.

БНСУ, ХНБГУ, Гүржийн туршлагаас харахад, шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид эдгээр торгох, баривчлах хөшүүргийг шуурхай хэрэглэх эрх нь байна. ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 802g-д зааснаар шийдвэр гүйцэтгэлийн шүүх баривчлах /soercive detention/ шийдвэр гаргана.<sup>28</sup> Гүрж улсын Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 14<sup>ч</sup>-<sup>18</sup>-д зааснаар даатгалд хамрагдсан шийдвэр гүйцэтгэлийн цагдаа /enforcement police officer/ ажилладаг бөгөөд шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн цагдаагаар гүйцэтгүүлэх ажлын хүсэлт гаргах, хувийн шийдвэр гүйцэтгэгч ижил хүсэлт гаргах ч энэ тохиолдолд төлбөр төлдөг байна.<sup>29</sup>

Иймд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч эдгээр арга хэмжээг шүүд хэрэглэх боломжтой байдлаар зохицуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

<sup>26</sup> <https://shuukh.mn/cases/2/1>

<sup>27</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл.

<sup>28</sup> [https://www.gesetze-im-internet.de/english\\_zpo/english\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/english_zpo/english_zpo.html)

<sup>29</sup> <https://matzne.gov.ge/file/document/view/18442?publication=99>

6. Эд хөрөнгийн мэдүүлгийг албадан гаргуулдаг тогтолцоо байхгүй бөгөөд төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх нь тухайн этгээдийг төлбөрөө төлөх хөшүүрэг болох хэлбэрийн төдий бүртгэл болжээ.

Манай улсын хувьд төлбөртэй этгээдийн бүртгэл нь хаалттай мэдээлэл байна. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлэгч этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.<sup>30</sup> Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргаж иргэн, хуулийн этгээдэд олгож болохоор заасан. Ийнхүү тодорхойлолт, лавлагаа авахад төлбөртэй байхаар заажээ. Төлбөртэй бол лавлагаа, төлбөргүй бол тодорхойлолт гаргана. Гэхдээ энэхүү сангаас иргэн, хуулийн этгээдэд бусад этгээдийн талаарх мэдээлэл өгөхийг хориглосон.<sup>31</sup>

ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 882f-д зааснаар төлбөр төлөгчтэй цаашид гэрээ байгуулах гэсэн ямар ч этгээд эдийн засгийн сөрөг үр дагавар гарахаас сэргийлж, гэрээ байгуулах эсэхээ шийдэхийн тулд энэхүү төлбөртэй этгээдийн бүртгэлээс мэдээлэл авч болдог байна.<sup>32</sup> Гүрж улсын хувьд, төлбөртэй этгээдийн бүртгэл нь банк, ББСБ, төрийн байгууллагуудад нээлттэй бөгөөд сонирхогч этгээдэд төлбөртэйгээр нээлттэй байна.<sup>33</sup>

Төлбөртэй этгээдийн бүртгэлд заавал бүртгэх, түүнд бүртгэгдсэнээр төлбөр төлөгч төлбөрөө төлөх эрхийн хязгаарлалт бүхий хөшүүргүүдийг хуульчлах шаардлага үүсэж байна. Гүрж улсын хувьд, энэхүү бүртгэлд бүртгэгдсэнээр аливаа бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох үр дагавартай байдаг.<sup>34</sup> Тус улсын хувьд, Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн 191-д зааснаар төлбөртэй этгээдийн бүртгэлийг мөнгөн хөрөнгө гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эхэлмэгц заавал хийнэ.<sup>35</sup>

Түүнчлэн эд хөрөнгийн мэдүүлэг заавал авах бөгөөд өгөхгүй, эсхүл худал мэдүүлбэл албадан ирүүлэх, төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулах үндэслэл болох зохицуулалтыг бий болгох шаардлага үүссэн.

ХБНГУ-ын Иргэний процессын хуульд зааснаар эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахаар дуудахад төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацааг хожимдуулсан, эсхүл мэдүүлэг өгөх үүргээ зөрчсөн бол төлбөр төлөгчдийн бүртгэлд бүртгэгдэх үр дагавартай байна.<sup>36</sup>

<sup>30</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.1 дэх хэсэг.  
<sup>31</sup> ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаал.  
<sup>32</sup> [https://www.gesetze-im-internet.de/english\\_zpo/english\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/english_zpo/english_zpo.html)  
<sup>33</sup> <https://maatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>  
<sup>34</sup> <https://maatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>  
<sup>35</sup> <https://maatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>  
<sup>36</sup> [https://www.gesetze-im-internet.de/english\\_zpo/english\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/english_zpo/english_zpo.html)

Түүнчлэн хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс баривчлах шийдвэр гаргана. Баривчлах шийдвэрт төлбөр авагч ба төлбөр төлөгчийг, түүнчлэн баривчлах үндэслэлийг заана. Баривчлах шийдвэрийг биелүүлэхээс өмнө зайлшгүй хүргүүлэх шаардлагагүй.<sup>37</sup>

Эд хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, эсхүл буруу өгсөн, эсхүл төлбөр төлөх хөрөнгөгүй, хөрөнгө нь хүрэлцэхгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулдаг. Тус бүртгэлд орсноор банк, санхүүгийн байгууллагаас авах эзэл, бусадтай бизнесийн үйл ажиллагааг хамтрах боломж хязгаарлагдахын зэрэгцээ тухайн төлбөр төлөгчийн үндсэн үйл ажиллагааг хязгаарладаг. Тухайлбал, төлбөр төлөгч хуульч бол хуульчаар ажиллах зөвшөөрлийг түдгэлзүүлдэг. Мөн төлбөртэй этгээдийн бүртгэл нь нийтэд нээлттэй байдаг тул төлбөр төлөгчид даруй төлбөрөө төлж, бүртгэлээс гарах гэж хичээх хөшүүрэг нь болдог.<sup>38</sup>

Иймд эд хөрөнгийн мэдүүлгийг албадан заавал гаргуулах, мэдүүлгээ буруу, эсхүл дуутуу мэдүүлсэн, зайлсхийсэн бол шийтгэдэг байх, мэдүүлэг өгөөгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдэх, төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэнээр зарим эрхэд нь хязгаарлалт тогтоож, төлбөрийг төлүүлэх хөшүүрэгтэй байхаар хуульчлах шаардлагатай байна. Тухайлбал, гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэхэд субьектив байдлаар хандах боломж олгохгүйгээр хуульч алагчлахгүй үйлчлэх объектив шаардлагыг бий болгох шаардлагатай болжээ.

7. Хугацаа хэтэрсний хүү төлдөггүй, шийдвэр гарсан дүнгээр хэдэн ч жилийн дараа төлөхөд хариуцлага тооцохгүй байгаа нь төлбөр төлөгч төлбөрийг төлөхгүй удаашруулах боломжийг олгож байна.

Төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүйн хүү, торгууль, алдангийг ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапур, Эстонид төлбөр төлөгчид оногдуулдаг байна. Гэрээгээр зохицуулаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэгчдэд ийнхүү төлбөр төлөгчөөс хугацаандаа төлөөгүй нөхцөлд хүү, алданги, торгуулийг авах эрхийг олгосон байдаг.<sup>39</sup>

Энэ асуудлыг хуульчилж, төлбөр төлөгч төлбөрөө цаг тухайд нь төлөх хөшүүргийг бий болгох шаардлага үүссэн.

8. Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагааны журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал, үл хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаанд битүүмжлэх, хураах 2 ажиллагааг заавал хийдэг. Гэтэл хураах асуудал үл хөдлөх эд хөрөнгийн тухайд байхгүй байдаг. Мөн барьцааны зүйл бол битүүмжлэх шаардлагагүй

<sup>37</sup> [https://www.gesetze-im-internet.de/english\\_zpo/english\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/english_zpo/english_zpo.html)  
<sup>38</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын алчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.  
<sup>39</sup> ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

шуурхай албадан худалдах зэрэг зохицуулалт байхгүйгээс барьцааны зүйлийг үл маргах журмаар гаргуулах Иргэний хуулийн зохицуулалт хэрэгжих боломжгүй болдог.

Иймд шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа явуулах ялгамжтай бөгөөд үр нөлөөтэй зохицуулалт бий болгох буюу барьцааны зүйл бол битүүмжлэх шаардлагагүй шууд дуудлага худалдаа явуулах зэргээр гэрээнд итгэх итгэлийг хамгаалж, ажиллагаа шуурхай, үр нөлөөтэй явагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүссэн.

10. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах гүйцэтгэх хуудасны биелэлтийг авч үзвэл, 2025 оны хувьд 50 гаруй тэрбум төгрөгийн 16596 гүйцэтгэх хуудаснаас, 15186 гүйцэтгэх хуудасны 36 гаруй тэрбум төгрөгийн тэтгэлэг төлөгдөөгүй буюу гүйцэтгэх хуудасны биелэлт 49 хувьтай байна.<sup>40</sup>

Хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа хөрөнгө, орлогогүй тэтгэлэг төлөгч бол төрөөс хүүхдийн тэтгэлийг урьдчилан төлөх, тухайн этгээд ажил хөдөлмөр, аж ахуй эрхлэх зэргээр төлбөрийн чадартай болсны дараа төлбөрийг нөхөн гаргуулж, уг санд төлдөг механизмыг бүрдүүлэх замаар хүүхдийн тэтгэлэг тасралтгүй байх зарчмыг хангах шаардлагатай байна. ХБНГУ-д ийм төрлийн тэтгэлийн сан ажилладаг байна.<sup>41</sup> Иймд хүүхдийн тэтгэлийг тодорхой тохиолдолд төрөөс урьдчилан төлөх, тэтгэлэг төлөгчөөс төрд нөхөн төлүүлэх зохицуулалтыг бий болгох зэрэгцээ, шаардлага үүсчээ.

**Гурав.** Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох дараах практик хэрэгцээ, шаардлага бий болсон:

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт 2018 оноос хойш тогтмол буурч ирсэн нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээнээс харагдаж байгаа бөгөөд захиргааны мөнгөн төлбөр гаргуулах гүйцэтгэх хуудсын хувьд 2023 онд 26 тэрбум төгрөгийн 406 гүйцэтгэх хуудас байснаас 19.5 тэрбум төгрөгийн 194 гүйцэтгэх хуудас биелэгдэж, 212 гүйцэтгэх хуудасны 6 тэрбум гаруй төгрөгийн үлдэгдэлтэй байна.<sup>42</sup>

Дээрх асуудлын шалтгаанд, эрх зүйн зохицуулалтын хангалтгүй, үр нөлөөгүй байдал нөлөөлж байна. Өнөөдрийн байдлаар захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг Захиргааны хэрэг зүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт ердөө хоёр зүйлээр зохицуулж байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зохицуулалт оновчгүй, дутуу, үр нөлөө багатай байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг одоогоор иргэний шийдвэр гүйцэтгэгчээр дамжуулан гүйцэтгүүлж, шийдвэр биелээгүй тохиолдолд дээд шатны албан тушаалтанд мэдэгдэх арга хэмжээ авах зохицуулалттай бөгөөд бодит

<sup>40</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024

<sup>41</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>42</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023

байдал дээр захиргаа шийдвэрээ биелүүлэхгүй байх тохиолдол түгээмэл, албадлагын үр нөлөөтэй механизм дутмаг байна. Үүний улмаас шүүхийн шийдвэр бодитоор хэрэгжихгүй байна.

Харин олон улсын туршлагаас үзвэл, захиргааны шийдвэрийг заавал биелүүлэх зарчмыг хангах үндэс шүүгч өөрөө захиргааны дээд байгууллагад мэдэгдээс гадна шийдвэр биелүүлэх хүртэл өдөр тутмын мөнгөн торгууль оногдуулах, сахилгын харууллага хүлээлгэх, үл биелүүлсээр байвал энэ талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох зэрэг албадлагын хөшүүргийг хэрэглэдэг бөгөөд ингэснээр захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэл үр дүнтэй хэрэгждэг байна.

Иймд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн төрөл, онцлогт нийцсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тусгай журмыг нарийвчлан тогтоож, шүүхийн шийдвэрийг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор харуулагчид мөнгөн хэлбэрийн үүрэг хүлээлгэх, албадан гаргуулах, биелүүлээгүй хугацаанд давтан торгууль ногдуулах, сахилгын харууллага оногдуулах, олон нийтэд мэдээлэх зэрэг албадлагын үр нөлөөтэй арга хэмжээг хуульчлан, дээд шатны байгууллага болон хянан шийдвэрлэсэн шүүгчийн идэвхтэй хяналтад хэрэгжүүлэх замаар захиргааны шийдвэр гүйцэтгэлийг заавал биелэгддэг тогтолцоонд шилжүүлэх практик шаардлага байна.

#### **Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай гэж өөрчилнө.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тогтолцоо;
- Бүрэн эрх, чиг үүрэг;
- Шийдвэр гүйцэтгэгчид тавигдах шаардлага, эрх зүйн байдал;
- Бусад.

4.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр захиргааны шийдвэр гүйцэтгэлийн журмыг боловсронгуй болгоно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар бий болно:

1.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог ял шийтгэл эдлүүлэх тогтолцооноос салгаж, бие даасан, хараат бус, үр дүнтэй, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Түүнчлэн үе шаттайгаар хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоонд шилжих бодлогыг хэрэгжүүлнэ. Тодруулбал, жил бүр нийт иргэний шийдвэр гүйцэтгэчийн 10 хувийг хувийн шийдвэр гүйцэтгэл хэлбэрт шилжүүлж, 10 жилийн дараа гэхэд иргэний шийдвэр гүйцэтгэлийг бүрэн хэмжээгээр хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоогоор хэрэгжүүлдэг болно;

2.Төлбөр авагч төлбөрөө цаг тухайд нь авч, эрхээ сэргээлтгэх боломжгүй удаан хугацаа өнгөрдөг, иргэд, бизнес эрхлэгчдийн шүүхэд итгэх итгэл алдагдсан явдлыг шийдвэрлэх ач холбогдолтой, Нөгөөтэйгүүр, шүүхийн шийдвэрийг цаг тухайд нь заавал биелүүлэх ёстой гэх төлбөр төлөгчийн ухамсар, хариуцлагыг дээшлүүлнэ;

3.Чанаргүй зээлийн хэмжээ буурч, зээлийн хүү багасах, эдийн засаг дахь мөнгөний эргэлт идэвхжих, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэх нөхцөл бүрдэнэ. Мөн шүүхийн шийдвэр зөвхөн цаасан дээр үлдэх бус бодитоор хэрэгжиж, төлбөр төлөгч үүргээ хугацаанд нь биелүүлэх хариуцлагын тогтолцоо төлөвшинэ. Үүний үр дүнд шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх эрх зүйн соёл, нийгмийн ёс зүй, хандлага бэхжинэ;

4.Иргэний шийдвэр гүйцэтгэл үр дүнтэй хэрэгжиж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үндэслэлгүй удаширдаг байдал үгүй болсноор эрх зүйт төрийн үзүүлэлтийн нэгэн үзүүлэлт болох иргэний эрхийн хамгаалалт үзүүлэлтээр Монгол Улс урагшлах, улмаар хөрөнгө оруулалт нэмэгдэх, бизнес эрхлэх таатай орчин бүрэлдэх нэгэн чухал хөшүүрэг болно;

5.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын хуульд заагаагүй, эсхүл үндэслэлээ тодорхойлоогүй гомдол удаа дараа гаргадаг байдлыг хязгаарлах буюу гомдол шийдвэрлэх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа бүхий иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн журмаар гомдлыг шийдвэрлэдэг байдлыг халж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын заавал биелүүлэх онцлог тохирсон шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдуулан гомдол шийдвэрлэх тусгай журам бий болгосноор эдгээр төрлийн гомдлоос

2.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулна. Уг хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл

- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргах тухайд шуурхай гомдол гаргах үндэслэл, гомдолд тавигдах шаардлага, аман хуралдаан хийлгүүгээр шуурхай шийдвэрлэх, давж заалдах, гомдол гаргах, шийдвэрлэх хугацаа, хожимдуулж гомдол гаргавал гомдол гаргах эрхээ алдах зэргийг тусгана.

- Ажиллагаа үүсгэх, хөөн хэлэлцэх хугацаа, түдгэлзүүлэх үндэслэл, дуусгавар болгох асуудлыг тусгана.

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшуулал зэргийг хуульчлана.

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг хуульчлах, үүнд эд хөрөнгийн мэдүүлэг, төлбөртэй этгээдийн бүртгэлийн ач холбогдолтой болгоход чиглэсэн өөрчлөлтийг тусгана.

- Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаа, эдийн бус шаардлагыг хангуулах журмыг боловсронгуй болгож, төлбөрт гаргуулж болохгүй хөрөнгө, орлогын талаарх зохицуулалтыг тусгана.

- Төлбөрийн шаардлагыг хангах дараалал, гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэр, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мөн тусгана.

3.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэлд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсэх үндэслэл, зарчим, шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх хугацаа, мэдэгдэх асуудал зэргийг тусгана.

- Зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

- Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, үүнд хорихоос өөр төрлийн болон хорих ял эдлүүлэх ажиллагааг тусгах ба энэ хэсэгт хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтийг тусгана.

шалтгаалан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тодорхойгүй хугацаагаар удааширдаг байдал үгүй болно. Түүнчлэн гомдол гаргаснаар ажиллагаа түдгэлзэхгүй болсноор ажиллагааны эсрэг үндэслэлгүй гомдлыг төлбөр төлөгч гаргаж, гацаах байдал буурна;

6. Үнэлгээ тогтоох асуудал нь зах зээлийн ханш хөрхөн өөрчлөгдөхөөс хамаарах цаг хугацаанаас хамаарсан асуудал тул дахин, эсхүл нэмэлт үнэлгээ Шүүх шинжилгээний тухай хуулийн дагуу хийлгүүлэх хүсэлт гаргах, харин үнэлгээчин томилсон шийдвэрийн талаарх гомдлыг шийдвэр гүйцэтгэх шүүхэд шуурхай гаргах байдалар ялгамжтай хуульчилснаар үнэлгээг хүчингүйд тооцох гомдлыг шүүхэд гарган ажиллагаа удаан хугацаанд удаашрах, уг ажиллагаа нь зорилгодоо хүрч чадахгүй буюу энэхүү хугацааны дараа үнэлгээ нь өөрчлөгдсөн байдаг тул дахин, нэмэлт үнэлгээ хийлгэх хүсэлтийг гаргаж ажиллагаа түдгэлзэгдэхгүй үргэлжлэх нөхцөл бүрдэнэ;

7. Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагааг барьцааны болон барьцааны бус үл хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаа гэж ялгамжтай тусгаж, битүүмжлээд, дараа нь хураасны үндсэн дээр үнэлгээ хийлгэн албадан дуудлага худалдаанд оруулах нусэр ажиллагааг давхцалгүй шуурхай болгож зөвхөн битүүмжлэн үнэлүүлж, дуудлага худалдаанд оруулснаар ажиллагаа удаашрахаас сэргийлнэ;

8. Анхны болон хоёр дахь дуудлага худалдаанд 2022 онд буюу жилийн хугацаанд 193 оролцогч оролцож, нийт нийтэд зарласан анхны дуудлага худалдааны 1.8 хувь, хоёр дахь дуудлага худалдааны 18.5 хувьд харгалзах үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулагдсан буюу нийт 536.8 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгө албадан дуудлага худалдаа явуулахаар нийтэд зарласнаас 30.4 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгө нь албадан дуудлага худалдаагаар зарагдсан. Иймд дуудлага худалдааны хүртээмж, нээлттэй, шуурхай байдлыг нэмэгдүүлж, байршил үл харгалзан цахим дуудлага худалдаа явуулах, улмаар дуудлага худалдаанд оролцох оролцогч нэмэгдэж, худалдан борлуулагдах хөрөнгийн хэмжээ нэмэгдэнэ. Түүнчлэн борлуулалтын бусад хэлбэрийг нээлттэй болгосноор шийдвэр гүйцэтгэлийн чанар, хэмжээ нэмэгдэнэ;

9. Албадан дуудлага худалдаанд ялагч төлбөрөө шилжүүлсэн бол тухайн хөрөнгийн өмчлөх эрхийг нэн даруй шилжүүлэх талаарх зохицуулалтыг бий болгосноор дуудлага худалдаанд оролцож, хөрөнгө худалдан авах шийдвэр гаргах этгээдийн тоо нэмэгдэхэд нөлөөлнө;

10. Хөрөнгийн мэдүүлгийг шүүхээс авснаар төлбөр авагч хөрөнгө сонгох боломжийг бүрдүүлснээр шийдвэр гүйцэтгэл үр дүнтэй, оновчтой явагдахад нөлөөлнө. Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэний үр дагаврыг хуульчилснаар төлөх хөшүүрэг бий болно;

11. Хугацаа хэтрүүлсний хүүг бий болгосноор төлбөр төлөх хөшүүрэг болж, төлбөр авагчийн эрх удаан хугацаанд зөрчилгөхөөс сэргийлнэ;

12. Албадлагын арга хэмжээний хөшүүрэг болох торгох, саатуулах арга хэмжээг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч авч болохоор тусгаснаар төлбөр төлөгчийг харьцуулагдахуулах хөшүүрэг болно;

13. Түүнчлэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн "үргэлжлэл" гэдэг утгаараа захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шүүхийн шийдвэрт гомдол, нэхэмжлэл гаргахгүй байхаар зохицуулж, одоо байгаа удааширсан журмыг багасгаж, хугацааны хувьд хурдан шийдэгдэхээр зохицуулж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх удирдан явуулахаар тусгаснаар ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн, Монгол Улсад захиргааны хэргийн шүүхийн шийдвэр тогтоосон хугацаанд заавал биелэгдэхэд түлхэц болно;

14. Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх, хоригдлын эрхийг сайжруулах, хоригдлын ажлын байр нэмэгдсэнээр гэмт хэргийн улмаас бусдад учирсан хохирлыг бүрэн төлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, улсын төсвийн ачаалал буурч, улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтоцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, түүнчлэн "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа, зохион байгуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Хууль тогтоомж

2.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа, зохион байгуулалтад энэ хууль үйлчилнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

##### 4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

4.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон эерчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

##### 5 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын туг, бэлгэ тэмдэг

5.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага туг, бэлгэ тэмдэгтэй байна.

5.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын туг, бэлгэ тэмдэгний загвар, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын туг, далбаа, бэлгэ тэмдгийг бусад хүн, хуулийн этгээд хэрэглэх, ашиглахыг хориглоно.

##### 6 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг

6.1.Монгол Улсын иргэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад орохдоо "Монгол Улсын иргэн би шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаахдаа хуулийг дээдлэн биелүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлж, амь биеэ үл хайрлан ажиллахаа батлан тангараглая. Би энэ тангарагаасаа няцаас хуулийн хариуцлага хүлээнэ." гэж тангараг өргөнө.

6.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

##### 7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн үнэмлэх, таних тэмдэг, хувийн дугаар бүхий тэмдэг

7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас олгосон, ажлын үнэмлэх, таних тэмдэгтэй байна.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан алба хаагч хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэнэ.

7.3.Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан ажлын үнэмлэх, таних тэмдэг, хувийн дугаар бүхий тэмдгийн загварыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

##### 8 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо

8.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, баривчлах, цагдан хорих шүүхийн шийдвэр болон хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх алба /цаашид "хорих ял эдлүүлэх алба" гэх/, хорихоос өөр төрлийн ял, тэнсэх, албадлагын арга хэмжээ, албадан эмчлэх шүүхийн шийдвэр болон эерчлийн шийдвэр гүйцэтгэх алба /цаашид "хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба" гэх/, иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх, хохирол, төлбөр гаргуулах ажиллагааг гүйцэтгэх алба /цаашид "иргэний шийдвэр гүйцэтгэх алба" гэх/, төв, орон нутаг дахь хорих байгууллага, аймаг, нийслэл дэх газар, хэлтсээс бүрдэнэ.

8.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг хоригдлоос гаргуулах, түүнийг хөдөлмөрлүүлэх, ажил, мэргэжлийн дадал олгох зорилгоор үйлдвэрлэлийн нэгжтэй байна.

#### **9 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зохион байгуулалт**

9.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь нутаг дэвсгэрийн болон тусгайлсан чиг үүргийн зарчмаар зохион байгуулагдаж, бүтэц, зохион байгуулалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.2. Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, газар зүйн байршил, дэд бүтэц, ял шийтгүүлсэн этгээд болон гүйцэтгэх баримт бичгийн тоог харгалзан сүм, дүүрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийг Засгийн газрын шийдвэрээр байгуулж болно.

9.3. Хорих байгууллага, нутаг дэвсгэр хармуцсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын газар, хэлтэс, салбар нэгжийн бүтэц, орон тоог шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

9.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын газар, хэлтэс нь цагдан хорих, баривчлах байрнаас оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, хорих байгууллагаас оргосон хоригдол, төлбөрийн үүргээ биелүүлэхээс зайлсхийсэн төлбөр төлөгч, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий нэгжтэй байна.

9.5. Энэ хуулийн 9.2-д заасан газар, хэлтсийг байгуулахдаа иргэний шийдвэр гүйцэтгэлчид оногдох ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс гэрээ, хэлцлээс үүдэлтэй эрх зүйн маргааны давтамж, хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзана.

#### **10 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага**

10.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хорих анги, нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг нэгдсэн болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

10.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Засгийн газар, зохион байгуулалтын бүтцийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

10.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага харьяандаа дараах чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжтэй байна:

10.3.1. судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт дадлага, үйлдвэрлэл, материал техник, архив, спорт, урлаг, соёл, мэдээллийн технологи, цахим хяналт, шуурхай удирдлага, эрэн сурвалжлах;

10.3.2. онцгой нөхцөл байдал үүссэн үед алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, учирч болох хор уршгийг багасгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох.

10.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага тэргүүн дэд дарга болон хоёр дэд даргатай байна.

10.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар, тэргүүн дэд дарга, дэд даргыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ**

#### **11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын чиг үүрэг**

11.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

11.1.1. хүний нөөцийн бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх;

11.1.2. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон хууль тогтоомжийн талаар санал боловсруулах;

11.1.3. хууль тогтоомжид нийцүүлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд холбогдох журам, стандарт, заавар, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах;

11.1.4. шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, дүн шинжилгээ хийх, нэгдсэн удирдлагаар хангах, харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээ авах;

11.1.5. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүү, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

11.1.6. үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

11.1.7. хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, тэдгээрийн харьяа газар, хэлтсийн алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч,

ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг арилгах, дотоод хяналт, аюулгүй байдлыг хангах;

11.1.8.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, програм хангамж, мэдээллийн нэгдсэн сүлжээ ашиглах, мэдээлэл дамжуулах, солилцох, кибер аюулгүй байдлыг хангах болон бусад мэдээллийн сан, хяналтын систем нэвтрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

11.1.9.хуульд заасан чиг үүргийн хүрээнд гадаад улсын ижил төрлийн байгууллагатай харилцах;

11.1.10.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, харьяа байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах;

11.1.11.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх;

11.1.12.шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын хэмжээнд онцгой нөхцөл байдал бий болсон үед шаардлагатай арга хэмжээ авах;

11.1.13.хуульд заасан бусад чиг үүрэг.

11.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага энэ хуулийн 11.1.7-д заасан чиг үүргийн хүрээнд алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тэдгээрт холбогдох хууль тогтоомж зөрчих, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлүүлэх зэргээр байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангана.

11.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналт шалгалт хариуцсан нэгж алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгах явцад гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй болох нь илэрсэн тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлнэ.

11.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа алба нь хариуцсан чиг үүргийн хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлагнана.

**12 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын бүрэн эрх**

12.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хэрэгжүүлнэ:

12.1.1.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах;

12.1.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

12.1.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

12.1.4.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд, эсхүл хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст онцгой дэглэм тогтоох, албаны өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт болон хүч нэмэгдүүлсэн хамгаалалтад шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах;

12.1.5.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын барилга байгууламж, автомашин, галт зэвсэг болон түүнтэй адилтгах хэрэгсэл, тусгай техник, хэрэгсэл, хувцас, бусад хангамжийн талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;

12.1.6.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

12.1.7.хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, мэргэшлийн зэрэг олгох;

12.1.8.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, сэлгэн ажиллуулах, хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу алба хаагчид цэргийн цол олгох, сэргээх, бууруулах, хураан авах;

12.1.9.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

12.1.10.нууц гүйцэтгэх ажилтан ажиллуулах, халах шийдвэр гаргах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

12.1.11.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажлын төсвийг төлөвлөх, Улсын Их Хурлын тусгай хяналтын дэд хороогоор хянуулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

13.2.4.Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт, үр дүнгийн талаар нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, цахим сан бүрдүүлэх, лавлагаа, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулах;

13.2.5.энэ хуулийн 8.6-т заасан хөдөлгөөнд тогтмол хяналт тавьж, зохион байгуулалтын арга хэмжээг авах.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан алба шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, биелэгдээгүй шийдвэрийн шалтгаан нөхцөл, ажлын үр дүнг жил бүр Улсын дээд шүүхэд танилцуулна.

#### **14 дүгээр зүйл.Хорих ял эдлүүлэх албаны чиг үүрэг**

14.1.Хорих ял эдлүүлэх алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.Баривчлах, цагдан хорих шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэл тогтоолыг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;

14.1.2.хорих байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.1.3.хорих байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, мөдлөг, үр чадварыг дээшлүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах;

14.1.4.хорих байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар санал боловсруулах;

14.1.5.хорих ял, баривчлах, цагдан хорих талаарх гомдлыг шийдвэрлэх;

14.1.6.хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх;

14.1.7.хоригдол, хоригдсон этгээд, шийтгүүлсэн хүний зүгээс алба хаагч руу чиглэсэн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, шалгах, хариуцлага тооцох.

#### **15 дугаар зүйл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны чиг үүрэг**

15.1.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1.хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх;

15.1.2.согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх;

12.1.12.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

12.1.13.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, зарим чиг үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, харьяа алба, нэгж, түүний алба хаагчид гүйцэтгүүлэхээр даалгах;

12.1.14.цэргийн мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

12.1.15.хуульд заасан бусад бүрэн эрх.

12.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга алба хаагч, ажилтныг томилж, чөлөөлөх, цэргийн ахлагч цол олгох, сэргээх, бууруулах, хураан авах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх, байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах бүрэн эрхээ харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргад шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### **13 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг**

13.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяанд байх бөгөөд тус албаны дарга нь эрх зүйч мэргэжлээр арваас доошгүй жил, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр таваас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхлээгүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, удирдах ажил, албан тушаал эрхэлсэн туршлагатай Монгол Улсын иргэн байна.

13.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мөдлөг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй болгоход чиглэсэн төлөвлөгөө, санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.2.1.иргэний шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

13.2.2.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн харьяаллыг тогтоох;

13.2.3.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан урамшууллыг хуваарилах, захиран зарцуулах;

15.1.3.хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх талаарх гомдлыг шийдвэрлэх;

15.1.4.тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

15.1.5.хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа бусад байгууллагын ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

15.1.6.хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээний талаар санал боловсруулах;

15.1.7.албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, нийгэмшүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

15.1.8.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг сэргээх.

#### **16 дугаар зүйл.Хорих байгууллага, түүний чиг үүрэг**

16.1.Хорих байгууллага нь шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллага бөгөөд хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

16.2.Хорих байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.2.1.хорих ялыг албадан эдлүүлэх;

16.2.2.хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

16.2.3.хоригдлыг нийгэмшүүлэх;

16.2.4.хоригдлыг хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох;

16.2.5.хоригдолд албан, албан бус хэлбэрээр боловсрол олгох;

16.2.6.хоригдлын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

16.2.7.гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгах, хорих байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

16.2.8.хоригдлыг суллагадахад бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлэх;

16.2.9.хуульд заасан бусад чиг үүрэг.

16.3.Хорих байгууллага нь гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг хоригдлоос гаргуулах, түүнийг хөдөлмөрлүүлэх, ажил, мэргэжлийн дадал олгох үйлдвэрлэлтэй байна.

16.4.Хорих байгууллагын хамгаалалтын бүсэд хувийн өмчит хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

16.5.Хорих байгууллага, салбар нэгжийн үйлдвэрлэл болон хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтарсан үйлдвэрлэлээс олсон орлогыг хорих ангийн харуул хамгаалалтыг сайжруулах, хоригдлыг нийгэмшүүлэх, үйлдвэрлэлийг дэмжиж, тоног төхөөрөмж худалдаж авахад зарцуулах бөгөөд хөрөнгийг хуваарилах, түүнд хяналт тавих журмыг санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

16.6.Орон нутгийн төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч байгууллагаас хоригдлыг ажлын байраар хангах хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгэх бүтээн байгуулалтын ажил, үйлчилгээнд ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

**17 дугаар зүйл.Нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн чиг үүрэг**

17.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын газар, хэлтэс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;

17.1.2.байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

17.1.3.иргэний, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

17.1.4.байгууллага, алба хаагч, ажилтан, тэдгээрийн гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

17.1.5.иргэний шийдвэр гүйцэтгэгчээс бусад алба хаагчийн үйл ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх;

17.1.6.хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хорих, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүний цахим сан хөтлөх, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

17.1.7.баривчлах шийтгэл, цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх;

17.1.8.согтуурах, мансуурах донтой хүн болон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг албадан эмчлэх эмнэлэгт хүргэх ажиллагааг гүйцэтгэх;

17.1.9.хуульд заасан бусад чиг үүрэг.

17.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх албаны харьяа газар, хэлтэс нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажллагаанд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй.

**18 дугаар зүйл.Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэх албатай харилцах**

18.1.Засгийн газар санхүү, материал, техникийн хангамжийн хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

18.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцсан нутаг дэвсгэртээ хорих байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

18.3.Аймаг, сумын Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих байгууллага, салбар нэгжийн удирдлага болон алба хаагчдад орон сууцаар хангах арга хэмжээ авна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД ТАВИГДАХ  
ШААРДЛАГА, НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ**

**19 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч,  
түүнд тавигдах шаардлага**

19.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын алба хаагчаас бүрдэнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, 18 насанд хүрсэн, Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан алба хаагчид тавигдах эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, ёс зүйн шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

19.4.Цагдан хорих, баривчлах төв, байр, мөргөжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх байгууллага, төрийн эмчит, аж ахуйн тооцоот, улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтныг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзнэ.

19.5.Энэ хуулийн 19.1-д заасан алба хаагчийн албан тушаалд тавигдах тусгайлан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад болон мөргөжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрдэнэ.

19.6.Гүйцэтгэх чиг үүргийн онцлогоос хамааран тодорхой албан тушаалд тавигдах тусгайлан шаардлага, шалгуур үзүүлэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд тогтоож болно.

**20 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэгчид тавигдах шаардлага**

20.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгчээр хууль зүйн дээд боловсролтой, санхүү, нягтлан бодох бүртгэлийн зохих мэдлэгтэй, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага, эрүүл мэнд, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, эрх зүйн чиглэлээр хоёроос доошгүй жил ажилласан туршлагатай, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэнийг ажиллуулна.

20.2.Дараах этгээд иргэний шийдвэр гүйцэтгэгчээр ажиллахыг хориглоно:

20.2.1.төрийн албанаас энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр халагдаж байсан;

20.2.2.эрүүгийн хариуцлага хүлээж байсан.

20.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**21 дүгээр зүйл.Хорих байгууллагын алба хаагчийн бүрэн эрх**

21.1.Хорих байгууллагын алба хаагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.оргосон хоригдол, хоригдсон этгээд, ялтан, баривчлагдсан болон эмчлүүлэгч хүн байгаа, эсхүл энэ талаар үндэслэл бүхий сэжиг байвал хуульд заасан журмын дагуу тухайн байгууллага, иргэний орон байр, бусад газарт нэвтрэн орох, орон байр, бусад газар, тээврийн хэрэгсэл, биед үзлэг хийх, оргосон этгээдэд тусалцаа үзүүлсэн, эсхүл тусалцаа үзүүлсэн байх үндэслэл бүхий сэжигтэй иргэний бичиг баримтыг шалгах, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, эрэл явагдаж байгаа зураас дахь төмөр замын өртөө, зөрлөг,

нисэх буудал, хилийн боомтод орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд зогсоох, шалгах;

21.1.2.оргосон хоригдол, хоригдсон этгээд, ялтан, баривчлагдсан болон эмчлүүлэгч хүнийг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах үед зайлшгүй шаардлагатай тохиолдолд Дипломат төлөөлөгчийн, үүргээ гүйцэтгэж яваа түргэн тусламжийн, гал унтраах албаны, техникийн ослын дуудлагын автомашинаас бусад хүн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түр дайчлах, холбоо, мэдээллийн хэрэгслээр дараалал харгалзахгүйг үйлчлүүлэх;

21.1.3.хоригдол, хоригдсон этгээд, ялтан, баривчлагдсан болон эмчлүүлэгч этгээдийн бие, эд зүйл, байранд үзлэг нэгжлэг хийх, зэвсэг, хулга, мэс, зэвсгийн чанартай бусад зүйл, мансууруулах болон хордуулах үйлчилгээтэй эм, тариа, өвс ургамал, согтууруулах ундаа, хориглосон тоглоом, хууль, холбогдох журмаар зөвшөөрөгдсөнөөс бусад зүйлийг хураан авах, бэлэн мөнгө, валют, үнэт зүйлсийг хураан авч акт тогтоон хадгалах, хорих байгууллагын аюулгүй байдал, түүнд мөрдөгдөх дэг журмыг сахиулах зорилгоор хоригдсон этгээд, ялтан, баривчлагдсан болон эмчлүүлэгч хүнд байнгын хяналт тавих;

21.1.4.хорих байгууллага, түүний үйлдвэрлэлийн талбайд орж, гарч байгаа хүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, холбогдох хууль, тогтоомжийн дагуу галт зэвсэг, тустай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хэрэглэх;

21.1.5.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах.

## **22 дугаар зүйл.Хорих байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн даргын бүрэн эрх**

22.1.Хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга нь энэ хуулийн 21.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, тушаал, шийдвэр гаргах, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

22.1.2.баривчлагдсан хүн, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан, хоригдлыг өвчний учир ял, шийтгэлээс чөлөөлүүлэх тухай саналыг прокурорт гаргах;

22.1.3.баривчлагдсан хүн, нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан, хоригдолд чөлөө олгох;

22.1.4.хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан, хоригдолд шагналын хоног олгох, хасах;

22.1.5.хуурамчаар, эсхүл санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулж хэвлэлт хэвтэж эмчлүүлсэн, чөлөөнөөс хоцорсон, оргосон хугацааг ял эдэлсэн хугацаанаас хасах тооцох;

22.1.6.хоригдлын хүсэлтийг үндэслэн удаан хугацааны уулзалтыг түр уулзалтаар, эсхүл утсаар ярих эрхээр, эсхүл түр уулзалтыг утсаар ярих эрхээр солих;

22.1.7.Иргэний хуульд заасны дагуу хоригдлын итгэмжлэлийг гэрчлэх;

22.1.8.хоригдол, хоригдсон этгээдэд сахилгын шийтгэл ногдуулах;

22.1.9.байгууллага, алба хаагчийн ажил үүрэгт хамаарах гомдлыг хянан шийдвэрлэх;

22.1.10.шийдвэр гүйцэтгэчийн саналыг үндэслэн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авадсан хүн, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх талаарх саналыг харьяа албанд хүргүүлэх;

22.1.11.хуульд заасан бусад.

## **23 дугаар зүйл.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх**

23.1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.гүйцэтгэх баримт бичиг болон эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх;

23.1.2.гүйцэтгэх баримт бичиг болон эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга тодорхойгүй тохиолдолд түүнийг тодруулахаар шүүхэд хүсэлт гаргах;

23.1.3.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авадсан хүн шилжин суурьших хөдөлгөөн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхийг түдгэлзүүлэх;

23.1.4.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн шинж бүхий баримт илэрсэн тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

23.1.5.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн сонирхолтой, эсхүл шударгаар ажиллахад эргэлзээ байгаа тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас татгалзан гарах;

23.1.6.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цахим бүртгэл хөтлөх, мэдээ тайлан гаргах;

23.1.7.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчил шийтгүүлсэн, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүн болон түүнийг шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийхэд туслалцаа үзүүлсэн гэх үндэслэлтэй бусад этгээдийн орон байр, эзэмшил газар, ажлын байранд хуульд заасан журмын дагуу нэвтрэн орох;

23.1.8.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүн, тэдгээрийн төлөөллийг дуудан ирүүлэх;

23.1.9.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил шийтгүүлсэн, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүнээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;

23.1.10.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх;

23.1.11.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил илэрсэн тохиолдол бүрд шалгалт хийж шалтгаан, нөхцөлийг тогтоох, хуульд заасан арга хэмжээ авах;

23.1.12.хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хорих ялаар солих саналыг прокурорт гаргах;

23.1.13.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүн шүүхээс хүлээлтгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлсэн байдлын талаар тодорхойлолт гаргах, хуульд заасан үндэслэлээр оногдуулсан ял, албадлагын арга хэмжээг хүчингүй болгох, ял оногдуулах саналыг прокурорт гаргах;

23.1.14.шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн хүнийг эрэн сурвалжлах, уг зорилгоор хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил шийтгүүлсэн хүний оршин суугаа /оршин байгаа/ хаягийг тогтоох зорилгоор шаардлагатай лавлагаа, мэдээлэл авах;

23.1.15.хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг өвчний учир ял, шийтгэлээс чөлөөлүүлэх саналыг прокурорт гаргах;

23.1.16.зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүнд ашигласан хяналтын тоног төхөөрөмжийг санаатайгаар устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан буруутай эдгээдээр нөхөн төлүүлэх, төлбөрийг нөхөн төлөөгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэх;

23.1.17.хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд холбогдох баримт, мэдээллийг мөрдөгчид хүргүүлэх.

23.2.Эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 23.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.2.1.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, тэдгээрт тодорхой шийдвэр гаргах тухай даалгах;

23.2.2.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

23.2.3.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тодорхой төрлийн арга хэмжээг гүйцэтгэх, шийдвэр гаргах талаар энэ хуульд заасан зөвшөөрөл олгох;

23.2.4.гүйцэтгэх баримт бичиг болон хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил шийтгүүлсэн, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний бүртгэл хөтлөх, ажиллагааны мэдээ, тайланг нэгтгэн гаргах.

23.3.Эрүүгийн ерөнхий шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 23.1, 23.2-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.3.1.эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, тэдгээрт тодорхой шийдвэр гаргах тухай даалгах;

23.3.2.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих;

23.3.3.эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаарх гомдлыг хянан шийдвэрлэх;

23.3.4.эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал тогтоох;

23.3.5.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил шийтгүүлсэн хүн, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх.

## 24 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх

24.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. Гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх;

24.1.2. Гүйцэтгэх баримт бичиг, шүүхийн шийдвэрийн агуулга тодорхойгүй тохиолдолд түүнийг тодруулахаар шүүхэд хүсэлт гаргах;

24.1.3. Төлбөр төлөгчийн улсын бүртгэлийн мэдээллийн санд өөрчлөлт бүртгүүлэхийг түдгэлзүүлэх;

24.1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн шинж бүхий баримт илэрсэн тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

24.1.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн сонирхолтой, эсхүл шударгаар ажиллахад эргэлзээ байгаа тохиолдолд тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас татгалзан гарах;

24.1.6. Гүйцэтгэх баримт бичиг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цахим бүртгэл хөтлөх, мэдээ тайлан гаргах;

24.1.7. Төлбөр төлөгч, түүний хамаарал бүхий этгээд болон шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийхэд туслалцаа үзүүлсэн гэх үндэслэлтэй бусад этгээдийн орон байр, эзэмшил газар, ажлын байранд хуульд заасан журмын дагуу нэвтрэн орох.

**25 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нийтлэг эрх, үүрэг, түүнд хориглох зүйл**

25.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь энэ хуулийн 21 дүгээр зүйлд зааснаас гадна Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

25.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулиар хориглосон үйл ажиллагаанаас гадна дараах зүйлийг хориглоно:

25.2.1. Хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах;

25.2.2. Албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах;

25.2.3. Бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрд хохирол учруулж болзошгүй мэдээ, мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх;

25.2.4. Төр, байгууллага, хувь хүний нууцыг хуульд заасан үндэслэл, журмаас гадур бусдад задруулах, удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр албан ажлын мэдээллийг мэдээлэх;

25.2.5. Албан үүргээ гүйцэтгэх болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

25.2.6. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх;

25.2.7. Бусдыг хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг уриалах, чиглүүлэх, шууд болон шууд бус хэлбэрээр едөөн хатгах, оролцох;

25.2.8. Намын гишүүн байх, албаны бие бүрэлдэхүүний дотор аль нэг намын үйл ажиллагаа, улс төрийн үзэл баримтлалыг сурталчлах, дэмжлэг үзүүлэх;

25.2.9. Удирдах албан тушаалтны хууль ёсны шийдвэр, тушаалыг биелүүлэхээс татгалзах;

25.2.10. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилогдсон ажилд очихгүй байх, ажил хаях, албаны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

25.2.11. Гэмт хэрэг, зөрчлийн талаар хүнээс мэдээлэл, тайлбар авах зорилгоор эрүүдэн шүүх, эсхүл ийм үйлдлийг аливаа хэлбэрээр зөвтгөх;

25.2.12. Хөдөлмөрийн маргаан зохицуулах зорилгоор албан үүргээ орхих

25.1.13. Хуулиар хориглосон бусад.

25.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгчээс бусад алба хаагч албан тушаалын зэрэглэл, цолны эрэмбээр нэг нь нөгөөдөө захирагч, захирагдагч байна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ**

**26 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баталгаа**

26.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн болон энэ хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.

26.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баталгааг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Төрийн албаны тухай хууль, цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хууль тогтоомж, бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

тэврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэржлэг хийсэн бол шууд удирдах даргад нь даруй мэдэгдэнэ.

28.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд, бусад алба хаагчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

28.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.

28.8.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, сонсогчоор суралцсан, хугацаат цэргийн алба хаасан, байгууллагын захиалгаар суралцсан хугацааг төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.

## **29 дүгээр зүйл.Алба хаагчийн нийгмийн баталгаа**

29.1.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох асуудлыг төр хариуцана.

29.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулсан бол энэ хуулийн 29.1-т заасан баталгаа нэгэн адил хамаарна.

29.3.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно.

29.3.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;

29.3.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

29.3.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

29.4.Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

26.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн талаарх судалгаа, мэдээ, мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

26.4.Алба хаагч бүрд мэргэжлээрээ суралцах, албан тушаал дэвших тэгш боломж, нөхцөл бүрдүүлнэ.

## **27 дугаар зүйл.Алба хаагчийн улс төрийн баталгаа**

27.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.

27.2.Алба хаагчийг энэ хуулийн 27.1-д заасан үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.

27.3.Алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.

27.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно.

27.5.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ нийтийг хамарсан жагсаал, цуглаан, аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагаанд оролцохгүй байх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.

## **28 дугаар зүйл.Алба хаагчийн хууль зүйн баталгаа**

28.1.Иргэн, албан тушаалтан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.

28.2.Алба хаагч албан үүргээ хуульд нийцүүлэн гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.

28.3.Алба хаагч ажлын бус цагаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

28.4.Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцна.

28.5.Алба хаагчийг албан үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас шалгасан, баривчилсан, цагдан хорьсон, орон байр, албан тасалгаа,

29.5.Энэ хуулийн 29.1-д заасан зардлыг Засгийн газар хариуцан гаргаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх бөгөөд энэ хуулийн 28.3-т заасан нөхөх олговор, тусламж олгох журам, 29.4-т заасан зардал олгох журмыг Засгийн газар батална.

29.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хаалттай хорих анги, цагдан хорих төв болон байгууллагын нууцлал зохицсон гүйцэтгэх ажилтнаар ажилласан, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн зургаан сар турмыг найман сараар, бусад байгууллагад ажиллаж байгаа алба хаагчийн 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сараар тус тус тооцно.

29.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, өндөржүүлсэн бэлэн байдал, онц байдал зарласан, хээрийн сургууль, дадлагын үеэр эмнэлгийн баг ажиллуулна.

29.8.Алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

29.9.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай нь холбоотойгоор шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулна.

29.10.Энэ хуулийн 29.6-д заасан нийгмийн баталгаа иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид хамаарахгүй.

### 30 дугаар зүйл.Алба хаагчийн эдийн засгийн баталгаа

30.1.Засгийн газар алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

30.2.Алба хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр/нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл, түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангана.

30.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.

30.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.

30.5.Аймаг, хот хооронд түүнчлэн аймаг, хот дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжин ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам

хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын тээврийн үнэлгээгээр тооцож олгоно.

30.6.Офицер, ахлагч ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

30.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалаагаар гадаад улсын их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлсний зардлыг төр хариуцна.

30.8.Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:

30.8.1.төрийн тусгай алба хаасан хугацааны;

30.8.2.албан ажлын онцгой нөхцөлийн;

30.8.3.ялтан, хоригдол, хоригдсон этгээдтэй ажилласны;

30.8.4. мэргэшлийн зэргийн;

30.8.5. мэргэжлийн зэргийн;

30.8.6. эрдмийн зэрэг, цолны;

30.8.7. гүйцэтгэх ажлын, төрийн болон албаны нууцын зэргийн;

30.8.8.хуульд заасан бусад.

30.9.Иргэний шийдвэр гүйцэтгэгч, алба хаагч Төрийн албаны тухай хуульд заасан цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал авна.

30.10.Алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

30.11.Энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан нийгмийн баталгаа иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид хамаарахгүй.

### 31 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн бусад баталгаа

31.1.Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууцаар хангах үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээнэ.

31.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан таван жил тутамд Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдлэнэ.

31.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авна.

31.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийгмийн хамтаалал, хөдөлмөрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

31.5.Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

31.6.Энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан бусад баталгаа иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид хамаарахгүй.

### **32 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах**

32.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг дараах тохиолдолд нэг нэгжээс нөгөө нэгжид ажиллуулахаар шилжүүлэн томилж болно.

32.1.1.ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх;

32.1.2.албан ажлын шаардлага;

32.1.3.ажлын байр, албан тушаал нь цомхоттогдсон;

32.1.4.урьд өмнө эрхэлж байсан ажил албан тушаалд эгүүлэн тогтоох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

32.1.5.алба хаагчийн хүсэлт.

32.1.6.эрүүл мэндийн шалтгаанаар.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг шилжүүлэн томилж шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн зөвшөөрөөгүй, томилогдсон албан тушаалд очоогүй нь алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

32.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг гэмт хэрэг, зөрчил болон ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний аюулгүй байдлыг хангах зорилгоор албан тушаал бууруулахгүйгээр харьяа байгууллага, салбар нэгжид сэлгэн ажиллуулж болно.

32.4.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нийслэлд гурав ба түүнээс дээш жил ажилласан бол түүний хүсэлтийг харгалзан орон нутаг дахь тойрогт сэлгэн ажиллуулж болно.

### **33 дугаар зүйл. Албан тушаал дэвшүүлэх, бууруулах**

33.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан албан тушаал дэвшүүлж, бууруулна.

33.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

33.3.Энэ хуулийн 33.1-д заасан алба хаагчийг дараах тохиолдолд захиргааны санаачилгаар албан тушаал бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно.

33.3.1.энэ хуульд заасны дагуу албан тушаал бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан;

33.3.2.албан тушаалын үүрэгтээ тэнцэхгүй тухай эрүүл мэндийн болон эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан;

33.3.3.ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;

33.3.4.үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон.

### **34 дүгээр зүйл. Албанаас халах**

34.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг дараах тохиолдолд албанаас хална:

34.1.1.өргөсөн тангараг, сахилга, ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн;

34.1.2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

34.1.3.алба хаагчид тавигдах шаардлагыг хангаагүй болох нь илэрсэн;

34.1.4.Монгол Улсын харьяатаас гарсан, иргэний давхар харьяалалтай нь илэрсэн.

### **35 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цол, дүрэмт хувцас**

35.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, дэд даргад цэргийн дээд цол олгож болно.

35.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хармуцсанаас бусад алба хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ.

35.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэртэй байж болно.

35.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиралгаар гадаад улсын их, дээд сургуульд суралцаж байгаа сонсогч цэргийн цол, дүрэмт хувцастай байна.

35.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч, эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

35.6.Хуульд зааснаас бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дүрэмт хувцсыг иргэн, байгууллага хэрэглэхийг хориглоно.

**36 дугаар зүйл.Цол, дүрэмт хувцас, үнэмлэх, таних тэмдэг, хувийн дугаар бүхий тэмдгийг хураан авах, хадгалуулах**

36.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд томилогдсон, сонгогдсон тохиолдолд түүний цол, дүрэмт хувцас, үнэмлэх, таних тэмдэг, хувийн дугаар бүхий тэмдэг, галт зэвсэг, тусгай хэрэгслийг хураан авна.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан алба хаагч биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон, тэтгэвэр тогтоолох насанд хүрсэн, алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр албанаас бэлтгэлээр чөлөөлөгдсөн бол ёслолын дүрэмт хувцас, цолыг түүнд хадгалуулна.

**37 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид ногдуулах сахилгын шийтгэл**

37.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь үйл ажиллагаандаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас тогтоосон олон нийттэй харилцах, хууль хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүй, сахилгын дүрмийг мөрдөж ажиллана.

37.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ёс зүй, сахилгын дүрмийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

37.3.Төрийн албаны тухай хууль, энэ хууль, ёс зүй, сахилгын дүрмийг зөрчсөн алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах сахилгын шийтгэл ногдуулна:

37.3.1.цолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасах;

37.3.2.цол бууруулах;

37.3.3.албан тушаал бууруулах;

37.3.4.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

37.4.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн зөрчлийг энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

37.4.Энэ хуулийн 37.3.2, 37.3.3, 37.3.4-т зааснаас бусад сахилгын шийтгэлийг харьяа алба, хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дарга ногдуулна.

37.5.Энэ хуулийн 37.3-т заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дарааллан хэрэглэхийг шаардахгүй.

37.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн мөрдөх ёс зүй, сахилгын дүрэм нь алба хаагчийн хувьд Монгол Улсын нутаг дэвсгэр, хилийн чанадад нэгэн адил үйлчилнэ.

37.7.Энэ хуулийн 37.3-т заасан шийтгэл хүлээсэн алба хаагч тогтоосон хугацаанд хувийн зардлаар ёс зүйн сургалтад хамрагдах үүрэгтэй. Энэ хугацаанд байгууллага цалингүй чөлөө олгоно.

37.8.Хуульд өөрөөр заагаагүй бол сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно. Энэ хугацаанд сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийн байгуулсан онцгой гавьяа, гаргасан зөрчлийн шинж чанар зэргийг харгалзан сахилгын шийтгэл ногдуулсан албан тушаалтны шийдвэрээр хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

**38 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх**

38.1.Гэмт хэрэг, зөрчил болон ёс зүй, сахилгын зөрчилд холбогдсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн бүрэн эрхийг уг дараах үндэслэлээр түр түдгэлзүүлж болно:

38.1.1.шүүхийн шийдвэр;

38.1.2.алба хаагч үргэлжлүүлэн албан үүргээ гүйцэтгэх нь шалгалтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй тухай санал, дүгнэлтийг дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж, алба хаагчаас ирүүлсэн.

38.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албан тушаалын бүрэн эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд цол, дүрэмт хувцас хэрэглэхийг хориглож, албаны үнэмлэх, таних тэмдэг, галт зэвсэг, тусгай хэрэгслийг түр хураан авна.

38.3.Энэ хуулийн 38.1-д заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн алба хаагчийн гэм буруугүй нь тогтоогдсон бол бүрэн эрхийг түдгэлзүүлсэн хугацааг ажилласан хугацаанд оруулан тооцож, энэ хугацааны цалин хөлсийг нөхөн олгоно.

**39 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх**

39.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн үйл ажиллагааны үр дүнг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу үнэлж дүгнэнэ.

39.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн мэргэшлийн түвшинг үнэлэх, зэрэг олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

39.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга нь үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээний үр дүнг харгалзан алба хаагчийг зохих шатны сургалтад хамруулах, цалингийн нэмэгдлийг тогтоох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

**40 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах**

40.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

40.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг Цэргийн албаны тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

40.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц албанаас чөлөөлөгдөх, сунгуулах тухай хүсэлтээ насны дээд хязгаарт хүрэх хугацаа болохоос 3 сарын өмнө гаргаагүй нь түүнийг захиргааны санаачилгаар албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

40.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь насны дээд хязгаарт хүрч албанаас чөлөөлөгдсөн иргэнийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажилд гэрээгээр ажиллуулж болно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН САХИЛГЫН ХАРИУЦЛАГА,  
САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

**41 дүгээр зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн сахилгын хариуцлага**

41.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гаргасан, энэ хуульд заасан сахилгын зөрчилд (цаашид "сахилгын зөрчил" гэх) сахилгын хариуцлага хүлээнэ.

41.2. Энэ хуулийн 41.1-д заасан сахилгын зөрчлийг хөнгөн, хүндэвтэр, хүнд гэж ангилна.

**41.3. Дараах тохиолдлыг сахилгын хөнгөн зөрчил гэж үзнэ:**

41.3.1. иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дотоод журмыг мөрдөхгүй байх;  
41.3.2. иргэний шийдвэр гүйцэтгэх албаны бусад иргэний шийдвэр гүйцэтгэгч, ажилтан, эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бусад ажиллантай зүй бус харьцах;

41.3.3. олон нийтийн газар, арга хэмжээнд зохисгүй авирлах, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх алба болон иргэний шийдвэр гүйцэтгэгчийн мэргэжлийн нэр хүндэд хохирол учруулах;

41.3.4. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, бусад этгээдтэй үл хүндэтгэсэн байдлаар, зүй бус харьцах.

**41.4. Дараах тохиолдлыг сахилгын хүндэвтэр зөрчил гэж үзнэ:**

41.4.1. өөрийн татгалаан гарах ёстой хэрэг, ажиллагаа явуулах, түүнд оролцох;

41.4.2. хуулиар олгогдсон бүрэн эрхийг илтэд буюу ноцтойгоор урвуулан ашиглах, эсхүл хэтрүүлэх;

41.4.3. эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлэхгүй байх;

41.4.4. хуульд заасан журмын дагуу хяналт шалгалт явуулахад саад учруулах;

41.4.5. шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад олж авсан хэргийн нууц мэдээллийг задруулах;

41.4.6. ажлын цагаар согтууруулах ундаа, эсхүл мансууруулах бодис хэрэглэх;

41.4.7. жилийн дотор сахилгын хөнгөн зөрчлийг давтан гаргах;

41.4.8. санхүүгийн бүртгэл, данс, бүртгэлийн дэвтэр болон бусад баримтад холбогдох хууль, журамд заасан мэдээллийг буруу тусгах, эсхүл тусгахгүйгээр эмх цэгцгүй хөтлөх;

41.4.9. шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох материалыг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзах;

41.4.10. иргэний шийдвэр гүйцэтгэх алба болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалтын төвөөс зохион байгуулсан заавал хамрагдах мэргэжлийн сургалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцохгүй байх;

42.2.Сахилгын хүндэвтэр зөрчилд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгууль ногдуулна.

42.3.Сахилгын хүнд зөрчилд ногдуулах сахилгын шийтгэл нь ажлаас халах байна.

42.4.Иргэний шийдвэр гүйцэтгэгч сахилгын зөрчил үйлдсэн үйлдсэн улмаас эд хөрөнгийг ашиг хүртсэн бол уг ашигласан хөрөнгийг буцаан төлөх үүрэгтэй.

#### 43 дугаар зүйл.Сахилгын хороо

43.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгчид сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлыг 5 гишүүнтэй хараат бус сахилгын хороо хянан шийдвэрлэнэ.

#### 44 дүгээр зүйл.Сахилгын хэрэг үүсгэх

44.1.Сахилгын хэрэг үүсгэх гомдлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргаж болно.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан сахилгын хэрэг үүсгэх саналыг тухайн иргэний шийдвэр гүйцэтгэгчтэй холбоотой гомдлыг шийдвэрлэсэн нийдвэр гүйцэтгэлийн шүүгч гаргаж болно.

#### 45 дугаар зүйл.Гомдол, санал хянан шийдвэрлэх ажиллагаа

45.1.Сахилгын хороо сахилгын хэрэг үүсгэх тухай санал, гомдлыг хүлээн авмагц уг саналыг холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж, саналд дурдсан үндэслэлийн талаар долоо хоногийн дотор тайлбар гаргах боломж олгоно.

45.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь өмгөөлөгч авах эрхтэй.

45.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн тайлбарыг хүлээн авсны дараа, эсхүл энэ хуулийн 45.1-д заасан хугацаа дуусмагц сахилгын хороо хуралдааны товыг тогтооно.

#### 46 дугаар зүйл.Хуралдаан

46.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгчид холбогдох сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуралдаан нь хаалттай байна. Иргэний шийдвэр гүйцэтгэгч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд нээлттэй явуулж болно.

46.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол сахилгын хорооны шийдвэрийг гүүний эзгүйд гаргаж болно.

#### 47 дугаар зүйл.Сахилгын хорооны шийдвэр

41.4.11.эрх бүхий байгууллагын шаардсанаар ажлын тайланг ирүүлэхгүй байх, эсхүл эмх цэгцгүй, ойлгомжгүй байдлаар гаргаж өгөх.

41.5.Дараах тохиолдлыг сахилгын хүнд зөрчил гэж үзнэ:

41.5.1.шийдвэр гүйцэтгэгчийн ажлын хөлс болон зардлын нөхөн төлбөрийн тарифыг зөрчиж, илүү буюу дутуу хэмжээний хөлс тооцох, эсхүл шаардах;

41.5.2.нээлттэй дуудлага худалдаа, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэгчийн явуулж буй бусад ажиллагааны явцад худалдаалж байгаа эд хөрөнгийг өөрөө буюу хамаарал бүхий этгээд худалдан авах, шаардлага болон бусад эрхийг шилжүүлэн авах;

41.5.3.үйлчлүүлэгч төлөөлөх, эсхүл энэ хууль болон Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэгчийн үүрэгтэй үл нийцэх бусад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;

41.5.4.түр хугацаагаар түдгэлзүүлсэн хугацаанд иргэний шийдвэр гүйцэтгэгчийн үүргийг гүйцэтгэх;

41.5.5.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд байгаа хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах.

41.6.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь дараах тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн бус, ёс зүйгүй байдлаар хэрэжүүлсэн гэж үзнэ. Үүнд, нэг жилийн хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр:

41.6.1.хэргийн нийт тохиолдлын 10 болон түүнээс дээш хувьд шийдвэр гүйцэтгэх тогтоол гаргаагүй байх, эсхүл хуульд заасан хугацаанд арга хэмжээ аваагүй байх;

41.6.2.гаргасан шийдвэрийн 40-өөс доошгүй хувь хүчингүй болсон байх;

41.6.3.явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нь гарсан гомдлын 30-аас доошгүй хувь нь хангагдсан байх.

41.7.Эрүүгийн, эсхүл зөрчлийн хариуцлага хүлээсэн нь иргэний шийдвэр гүйцэтгэгчийг сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### 42 дугаар зүйл.Сахилгын шийтгэл

42.1.Сахилгын хөнгөн зөрчилд дараах сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

42.1.1.сануулах;

42.1.2.хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

47.1.Сахилгын хороо гомдол, саналыг хангавал сахилгын шийтгэл оногдуулах тухай, гомдол, саналыг хангахгүй бол сахилгын шийтгэл оногдуулахаас татгалзах тухай шийдвэр гаргана.

#### ДОЛДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ, ДАНС БҮРТГЭЛ

48 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв  
санхүүжилт, данс, бүртгэл, тайлан тэнцэл

48.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь улсын төсөв, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжинэ.

48.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, харьяа алба, хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь арилжааны банкинд данстай байна.

48.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь энэ хуулийн 48.1-д заасны дагуу улсын төсвөөс болон Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан урамшууллын 30 хувиас санхүүжинэ.

48.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага арилжааны банканд гадаад төлбөр тооцооны данстай байна.

48.5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын данс, бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу хөтөлнө.

48.6.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлогийг тусгасан данс, бүртгэл, тайлан тэнцлийн тухай журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

48.7.Эрүүгийн болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг улсын төсөв болон ялтан этгээдээс, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

48.8.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдээр нөхөн төлүүлнэ.

48.9.Хоригдлыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хөдөлмөр эрхлүүлсний орлогоос энэ хуулийн 48.1-д заасан байгууллагын туслах үйл ажиллагааны орлогын санхүүжилтийг бүрдүүлж болно.

48.10.Энэ хуулийн 48.7-д заасан зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

48.11.Энэ хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад зардал болон хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

#### НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

49 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт

49.1.Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжид заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

50 дугаар зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Эерчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны .. дугаар сарын ..-ны өдөр

Улаанбаатар хот

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний хэргийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шуурхай, үр нөлөөтэй албадан гүйцэтгэх (цаашид "иргэний шийдвэр гүйцэтгэх" гэх) замаар иргэн, хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, явуулах, уг ажиллагааны явцад гаргасан гомдол, эсэргүүцлийг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомж**

2.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талууд, гуравдагч этгээдээс гаргасан гомдол, эсэргүүцлийг энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгч хянан шийдвэрлэнэ.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."гуравдагч этгээд" гэж төлбөр авагч, төлбөр төлөгчөөс бусад иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас эрх, үүрэг нь хөндөгдөж байгаа этгээдийг;

4.1.2."гүйцэтгэх хуудас" гэж иргэний хэргийн хүчин төгөлдөр шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх зорилгоор, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үндэслэл болох баримт бичгийн үндсэн дээр шүүхээс олгосон баримт бичгийг;

4.1.3."иргэний шийдвэр гүйцэтгэгч" гэж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэний шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий албан тушаалтныг;

4.1.4."иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа" гэж иргэний хэргийн хүчин төгөлдөр шийдвэрийг албадан гүйцэтгэх зорилгоор энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ болон түүнтэй холбогдох энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах үйл ажиллагааг;

4.1.5."иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үндэслэл болох баримт бичгийг;

4.1.6."оролцогч" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох орчуулагч, хэлмэрч, шинжээч, хөндлөнгийн гэрч, үнэлгээччин зэрэг этгээдийг;

4.1.7."талууд" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох төлбөр авагч, төлбөр төлөгчийг;

4.1.8."тогтоол" гэж иргэний шийдвэр гүйцэтгэгчээс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэрийг;

4.1.9."төлбөр авагч" гэж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалуулахаар гүйцэтгэх хуудаст, эсхүл энэ хуульд гүйцэтгэх хуудас шаардлагагүй гэж заасан тохиолдолд холбогдох шийдвэрт заасан этгээдийг;

4.1.10."төлбөр төлөгч" гэж төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх хуудас, эсхүл энэ хуульд гүйцэтгэх хуудас шаардлагагүй гэж заасан тохиолдолд холбогдох шийдвэрт заасан этгээдийг;

4.1.11."төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, орлого" гэж төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө, орлого гэж энэ хуульд зааснаас бусад иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар тогтсон төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогыг;

4.1.12."цахим систем" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүртгэх, удирдах, хянах зориулалт бүхий нэгдсэн цахим хэргийн удирдлагын системийг;

4.1.13."шаардлага" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр авагч төлбөр төлөгчөөр мөнгөн төлбөр төлүүлэх, тодорхой үйлдэл хийлгэхийг, эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байхыг шаардах агуулга бүхий шаардлагыг;

4.1.14."шүүгчийн захирамж" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэлийн шүүгчээс гаргасан шийдвэрийг.

**5 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим**

5.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болох баримт бичиг заавал биелэгдэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 5.1.2.хүний эрх, эрх чөлөөг зөвхөн энэ хуульд заасны дагуу хязгаарлах буюу албадлага хэрэглэх;
- 5.1.3.шуурхай байх;
- 5.1.4.үр дүнтэй байх;
- 5.1.5.тасралтгүй байх;
- 5.1.6.найдавартай байх.

5.2.Мөнгөн шаардлагад холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн аль нэг эд хөрөнгө, орлогод албадлагын арга хэмжээ авсан нь энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу бусад эд хөрөнгө, орлогод иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хязгаарлах үндэслэл болохгүй.

5.3.Мөнгөн шаардлагыг хангах зорилгоор албадлагын арга хэмжээ, төлбөр гаргуулах эд хөрөнгийг сонгохдоо иргэний шийдвэр гүйцэтгэгч нь авах албадлагын арга хэмжээний шинж чанар болон тухайн эд хөрөнгийн үнэ цэнэ нь төлбөр төлөгчийн үүргийн хэмжээнд нийцсэн, зохистой харьцаатай байх зарчмыг баримтална.

5.4.Төлбөр гаргуулах хэд хэдэн албадлагын арга хэмжээ, эд хөрөнгө байгаа тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчид хамгийн бага дарамт, хохирол учруулах хувилбарыг сонгон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулна.

5.5.Мөнгөн шаардлагад холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр гаргуулах ганц боломжит албадлагын арга хэмжээ, төлбөр гаргуулах эд хөрөнгө байгаа, эсхүл тухайн нөхцөл байдал тодорхой, эргэлзээгүй тохиолдолд энэ хуулийн 5.3-т заасан үүргийн хэмжээнд нийцсэн, зохистой харьцаатай байх зарчим хамаарахгүй.

## **6 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хориглох үйлдэл, эс үйлдэхүй**

6.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэгч дараах үйлдэл, эс үйлдэхгүйг гаргахыг хориглоно:

6.1.1.хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл хувийн ашиг сонирхлоор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах;

6.1.2.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үүргээс зайлсхийх;

6.1.3.энэ хуульд зааснаас бусад шалтгаанаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх;

6.1.4.энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах;

6.1.5.хувийн ашиг сонирхлын үүднээс бусад дарамт, шахалт үзүүлэх;

6.1.6.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа бусдад ялгаавартай хандах, хууль бусаар давуу эрх олгох.

6.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

6.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **7 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл**

7.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах баримт бичгийг үндэслэн явуулна:

7.1.1.иргэний болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр;

7.1.2.хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж;

7.1.3. эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж;

7.1.4.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэхээр хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;

7.1.5.шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тухшаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр;

7.1.6.шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;

7.1.7.барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах тухай шүүхийн шийдвэр;

7.1.8.шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж;

7.1.9.хуульд заасан бусад.

## **8 дугаар зүйл.Шуурхай байдал, гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэх дараалал**

8.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай явуулах үүрэгтэй.

8.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүлээн авсан дарааллын дагуу явуулна.

8.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг энэ хуулийн 8.2-т заасан хүлээн авсан дараалал харгалзахгүй яаралтай явуулж болно.

8.3.1.төлбөр төлөгчийн эд хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй болох бодит эрсдэл үүссэн;

8.3.2.хугацаа алдахтай холбоотойгоор эд хөрөнгийн үнэлгээний хэмжээ мэдэгдэхүйц буурах нөхцөл байдал үүссэн;

8.3.3.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширснаас аль нэг талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учрах нь тодорхой болсон;

8.3.4.энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасан барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах тухай шийдвэр, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж.

#### **9 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал**

9.1.Энэ хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах анхан шатны нэрж нь тогтоосон тойрог байна.

9.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь аймаг бүрд, нийслэлд дүүрэг бүрд тус бүр нэг, шаардлагатай тохиолдолд суманд нэгжтэй байж болно.

9.3.Төлбөр авагчийн шаардлагыг шуурхай хангах үүднээс энэ хуулийн 9.2-т заасан нэржийг тухайн нутаг дэвсгэрт нь байршуулна.

9.4.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой нутаг дэвсгэрийн харьяаллыг энэ хуульд заасан албадлагын арга хэмжээ, төлбөр гаргуулах эд хөрөнгөд үндэслэн тогтоож болно.

9.5.Төлбөр төлөгч иргэнтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн хамгийн сүүлд бүртгэгдсэн оршин суугаа газрын, эсхүл түүний эд хөрөнгө, эсхүл эд хөрөнгийн дийлэнх хэсэг байрлаж байгаа газрын харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.6.Төлбөр төлөгч хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагатай холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын байнгын үйл ажиллагаа явуулж байгаа газрын, эсхүл хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн, удирдах байгууллагын байрлаж байгаа газрын, эсхүл эд хөрөнгө байрлаж байгаа газрын харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.7.Төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байх үүрэгтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн, эсхүл шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг биелүүлэх газрын харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.8.Хүний амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр авагчийн, эсхүл төлбөр

төлөгчийн хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.9.Өөр өөр газар оршин суугаа хэд хэдэн төлбөр төлөгчтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгчдийн аль нэгийн хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.10.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, эсхүл гадаад улсад байрлах хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр авагчийн хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байрлаж байгаа газрын харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

9.11.Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгчийн хамгийн сүүлд бүртгэгдсэн хаягийн харьяалах иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

#### **10 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх даалгавар хүргүүлэх**

10.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухайн иргэний шийдвэр гүйцэтгэгчийн харьяаллын нутаг дэвсгэрээс өөр нутаг дэвсгэрт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах шаардлага үүсвэл уг ажиллагааг гүйцэтгүүлэхээр тухайн нутаг дэвсгэрийг харууцсан иргэний шийдвэр гүйцэтгэгчид даалгавар хүргүүлнэ.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан даалгаврыг хүлээн авсан иргэний шийдвэр гүйцэтгэгч нь тогтоосон хугацаанд даалгаварт заасан ажиллагааг гүйцэтгэнэ.

#### **11 дүгээр зүйл.Шүүхийн харьяалал**

11.1.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч нь иргэний хэргийн анхан шатны шүүхэд харьяалан ажиллана.

11.2.Энэ хуульд заасан гомдол, эсэргүүцлийг энэ хуулийн 11.1-д заасан шийдвэр гүйцэтгэлийн шүүгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

#### **12 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэгч**

12.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг энэ хууль болон холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэгч явуулна.

#### **13 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа тоолох**

13.1.Энэ хуульд заасан хугацааг минут, цаг, ажлын өдөр, хоног, сар, жилээр тоолно.

13.2.Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй.

13.3.Хугацааг тоолоход уг хугацаа нь дуусах хугацааны сүүлийн цаг, минутад дуусна.

13.4.Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь хугацаа дуусах сүүлийн хоногийн 24 цагт дуусна.

13.5.Хугацааг сараар тоолоход уг хугацааг дуусах сүүлийн сарын мөн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв энэ сард тухайн өдөр байхгүй бол мөн сарын эцсийн өдөр хугацаа дуусна.

13.6.Хугацааг жилээр тоолоход хугацаа нь дараа оны тухайн сарын тухайн өдөр дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно.

13.7.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичгийг тогтоосон хугацааны сүүлийн өдрийн 24 цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад, эсхүл энэ хуулийн дагуу цахим хэлбэрээр хүргүүлсэн бол түүнийг хугацаанд нь хүргүүлсэнд тооцно.

13.8.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг 06.00 цагаас 22.00 цагийн хооронд гүйцэтгэх бөгөөд тодорхой цагийг иргэний шийдвэр гүйцэтгэгч бие даан тогтооно.

13.9.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг ажлын бус өдөр, эсхүл 22.00 цагаас 06.00 цагийн хооронд гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд гүйцэтгэсэн бол тэмдэглэлд энэ тухай тусгана.

13.10.Төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг гүйцэтгэх тохиромжтой хугацааны талаар санал гаргаж болно.

#### 14 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн хэлбэр

14.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнг баталгаажуулах зорилгоор тэмдэглэл үйлдэнэ.

14.2.Тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

14.2.1.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан газар, он, сар, өдөр;

14.2.2.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл, холбогдох асуудлын товч утга;

14.2.3.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан иргэний шийдвэр гүйцэтгэчийн овог, нэр, хариуцсан тойргийн дугаар, уг ажиллагаанд оролцогчийн овог, нэр, хуулийн этгээдийн нэр;

14.2.4.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүн;

14.2.5.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцсон этгээд болон иргэний шийдвэр гүйцэтгэчийн гарын үсэг.

14.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол татгалзсан шалтгааныг тэмдэглэлд тусгана.

7

14.4.Иргэний шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээний үйл явц, үр дүнг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж, бэхжүүлнэ.

14.5.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэр нь захирамж хэлбэртэй байна.

14.6.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

14.7.Энэ хуулийн 14.6-д заасан тогтоолд дараах мэдээллийг тусгана:

14.7.1.тогтоол үйлдсэн газрын нэр, байршил;

14.7.2.тогтоолын гарчиг, он, сар, өдөр;

14.7.3.тогтоол гаргасан иргэний шийдвэр гүйцэтгэгчийн овог, нэр, хариуцсан тойргийн дугаар;

14.7.4.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн дугаар;

14.7.5.тогтоолын хууль зүйн үндэслэл, агуулга;

14.7.6.тогтоолыг биелүүлэх хугацаа;

14.7.7.гомдол гаргах, эсэргүүцэл гаргах эрх.

14.8.Энэ хуулийн 14.5-д заасан шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн захирамжийг захирамжид заасан хугацаанд биелүүлнэ.

14.9.Энэ хуулийн 14.6-д заасан тогтоолыг нэн даруй биелүүлнэ.

#### 15 дугаар зүйл.Мэдэгдэх хуудас

15.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч мэдэгдэх хуудсыг дуудан ирүүлж танилцуулах бөгөөд боломжгүй тохиолдолд цахимаар, эсхүл баталгаат шуудангаар хүргүүлнэ.

15.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ төлбөр төлөхийг шаардах, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байх хугацааг заана.

15.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хаягаа өөрчилсөн бол иргэн нь Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19.1, хуулийн этгээд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22.4-т заасны дагуу шинэ хаягаа нэн даруй бүртгүүлнэ.

15.4.Энэ хуулийн 15.3-т заасны дагуу хаягийн өөрчлөлтийг бүртгүүлээгүй бол улсын бүртгэлд бүртгэгдсэн сүүлийн хаягаар хүргүүлснийг баримт бичгийг түүнд мэдэгдсэнд тооцно.

15.5.Энэ хуулийн 15.4-т заасны дагуу хүргүүлж чадаагүй баримт бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Иргэний шийдвэр гүйцэтгэх албаны албан ёсны цахим хуудсанд нэн даруй байршуулна.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасны дагуу баримт бичгийг цахим хуудсанд байршуулснаас хойш ажлын гурван өдрийн дараа уг баримт бичгийг талуудад мэдэгдсэнд тооцно.

8

15.7. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон эд хөрөнгийг нь хураах, битүүмжлэх шаардлагатай гуравдагч этгээд нь цахим мэдэгдэл хүлээн авах зорилгоор цахим шуудангийн хаяг, холбогдох мэдээллээ урьдчилан бүртгүүлсэн бол мэдэгдлийг цахимаар хүргүүлнэ.

15.8. Цахим мэдэгдэл нь бичгээр хүргүүлсэнтэй адил эрх зүйн хүчинтэй байна.

15.9. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой мэдэгдэл, тогтоол, шийдвэрийг Цахим гарын үсгийн тухай хуулийн 5.1-д заасан цахим гарын үсэг, эсхүл 7.1-д заасан цахим тамгаар баталгаажуулна.

15.10. Цахим баримт бичиг нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30.5-д заасны дагуу цаасан баримт бичигтэй адил эрх зүйн хүчинтэй байна.

#### **16 дугаар зүйл. Хугацаа хэтрүүлсний хариуцлага**

16.1. Төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаанд мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлээгүй бол үүргийг сайн дураар биелүүлэх хугацаа дууссан өдрөөс эхлэн бүрэн биелүүлэх хүртэлх хугацаанд төлөгдөөгүй дүнд үндэслэсэн хугацаа хэтрүүлсний хүүг төлбөр авагчид төлнө.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан хүүгийн хэмжээг банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол биелүүлээгүй үүргийн үнийн дүнд үндэслэн тухайн хугацаанд Монголбанкнаас зарласан бодлогын хүүгээр тооцно.

16.3. Төлбөр төлөгч нь тодорхой үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байх тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхлэн үүргийг бүрэн биелүүлэх хүртэл Иргэний хуулийн 232.6-д заасан алданги төлнө.

16.4. Энэ хуулийн 16.3-т заасан алдангийг хоног тутамд тооцох бөгөөд төлбөр төлөгч иргэн бол алдангийн хэмжээ нь 0.3 хувь хүртэл, хуулийн этгээд бол 0.5 хувиас ихгүй байна.

16.5. Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол бүрэн төлж барагдуулах хүртэл Иргэний хуулийн 232.6-д заасан алдангийг энэ хуулийн 16.4-т заасан хэмжээгээр тэтгэлэг авагчид төлнө.

16.6. Тэтгэлэг авагч 18 насанд хүрсэн нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.7. Энэ хуулийн 38.1.4-т заасан эвлэрлийн гэрээ байгуулахдаа талууд тохиролцсон хугацаанд төлбөрийг биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсний хүү тооцохоор харилцан тохиролцож болно.

16.8. Энэ хуулийн 32.1.9-д заасны дагуу гүйцэтгэх хуудсанд хүү, алдангийг тооцож гаргуулах эрх иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч бодолтыг хийж, төлбөр төлөгчийн үүргийг тэрхүү хэмжээгээр нэмэгдүүлнэ.

16.9. Энэ хуулийн 32.1.9-д заасан гүйцэтгэх хуудсанд хүү, алдангийг тооцож гаргуулах эрх иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон гаргуулах эрх иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон талаар тусгаагүй бол хүү, алдангийг тооцож гаргуулах эрх иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгох талаар шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид хүсэлт гаргаж, бодолт хийх эрх авсны үндсэн дээр холбогдох бодолтыг хийнэ.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ, ЭСЭРГҮҮЦЭЛ, ТОРГУУЛЬ ОНОГДУУЛАХ**

#### **17 дугаар зүйл. Гомдол, эсэргүүцэл**

17.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа энэ хуульд нийцэж байгаа эсэхийг тогтоолох зорилгоор гомдол гаргах эрхтэй. Гомдол гаргах эрх нь гагцхүү энэ хуульд тусгайлан заасан тохиолдолд үүснэ.

17.2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад иргэний шийдвэр гүйцэтгэгчээс гаргасан, энэ хуульд зохицуулаагүй зөрчил, алдаа дутагдалтай холбоотойгоор эсэргүүцэл гаргана.

17.3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан талууд, эсхүл гуравдагч этгээдээс гаргасан гомдол, эсэргүүцэл нь зөвхөн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой асуудлаар хязгаарлагдах бөгөөд хэргийн материаллаг маргааныг дахин хянан шийдвэрлэх үндэслэл болохгүй.

17.4. Гомдол, эсэргүүцлийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шуурхай хянан шийдвэрлэнэ.

17.5. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол талууд, гуравдагч этгээдээс гомдол, эсэргүүцэл гаргасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

17.6. Төлбөр төлөгч гомдол гаргахдаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан бол дараах нөхцөлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлнэ:

17.6.1. гомдол гаргагч энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу барьцаа гаргасан;

17.6.2. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх нь гомдол гаргагчид ноцтой хохирол учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж шийдвэр гүйцэтгэлийн шүүгч үзсэн.

Тайлбар: Энэ зүйлд заасан "ноцтой хохирол" гэж иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхгүй бол иргэний амь нас нь эрсдэлд орох, эрүүл мэнд нь доройтох, эд хөрөнгө нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, тухайн этгээд түүнийг өөрийн хүчээр эргүүлэн сэргээх боломжгүй, эсхүл сэргээсэн ч өмнөх байдлаасаа чанар байдлын хувьд дордохоор сөрөг үр дагавар үүсэхийг ойлгоно.

## 20 дугаар зүйл.Гомдол гаргах, хүлээн авах, хүлээн авахаас татгалзах

20.1.Энэ хуулийн 18.1-д заасан гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол гомдол гаргагчийн хүсэлт, тухайн шалтгааны талаарх баримтат үндэслэл шийдвэр гүйцэтгэлийн шүүгч уг хугацааг сэргээж, гомдлыг хүлээн авч болно.

20.2.Гомдол гомдлын агуулга, түүний үндэслэлийг тодорхой зааж, холбогдох баримтыг хавсаргана. Гомдол нь энэ бүрдүүлбэрийг хангаагүй бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч 7 хоногийн хугацаа тогтоон гомдол гаргагчид уг шаардлагыг хангах боломж олгоно.

20.3.Гомдлыг дараах тохиолдолд гомдол гаргагчид буцаана:

- 20.3.1.энэ хуулийн 20.2-т заасан хугацаанд бүрдүүлбэрийг хангаагүй;
- 20.3.2.энэ хуульд заасан гомдол гаргах үндэслэлээр гаргаагүй бол.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан үндэслэл бүрдээгүй бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хянан үзэх үндэслэл болно.

## 21 дүгээр зүйл.Гомдолд хариу тайлбар гаргах

21.1.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор гомдлын хувийг иргэний шийдвэр гүйцэтгэгч, гомдол гаргаагүй талд хүргүүлж, хариу тайлбар, баримт ирүүлэх талаар мэдэгдэнэ.

21.2.Гомдол гаргаагүй тал гомдлын талаар тайлбар, баримт гаргаж болох бөгөөд тайлбар, баримт ирүүлээгүй нь гомдлыг шийдвэрлэхэд саад болохгүй.

21.3.Шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдолд дурдсан асуудлын хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэгчээс нэмэлт баримт шаардаж болно. Иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтоосон хугацаанд шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн шаардсан баримт, хариу тайлбарыг гаргаж өгөх үүрэгтэй.

21.2.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн шаардсанаар иргэний шийдвэр гүйцэтгэгч нь нэмэлт нотлох баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

## 22 дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэх

22.1.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдол гаргагчийн гомдол, холбогдох баримт, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн тайлбар, баримтат үндэслэл шүүх хуралдаан хийлгүүгээр гомдлыг шийдвэрлэж, гомдлыг хангах, хангахаас татгалзах тухай шүүгчийн захирамж гаргана.

22.3.Гомдлыг шийдвэрлэхэд нэмэлт тайлбар авах шаардлагатай гэж шийдвэр гүйцэтгэлийн шүүгч үзвэл талууд, иргэний шийдвэр гүйцэтгэгч, холбогдох бусад этгээдийг дуудан ирүүлж, уулзалт хийж, энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу уулзалтад ирэх боломжгүй бол цахимаар нэмэлт тайлбарыг авч болно.

## 18 дугаар зүйл.Гомдол, эсэргүүцэл гаргах харьяалал

18.1.Гомдол гаргагч иргэний шийдвэр гүйцэтгэгчийн холбогдох шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Улсын дээд шүүхээс баталсан маягтын дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гомдлоо гаргана.

18.2.Эсэргүүцэл гаргагч нь Улсын дээд шүүхээс баталсан маягтын дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид иргэний шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан энэ хуульд зохицуулаагүй зөрчил, алдаа дутагдлын талаарх эсэргүүцлээ гаргана.

18.2.Энэ хуулийн 18.1, 18.2-т заасан гомдол, эсэргүүцлийг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх дэх шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргана.

## 19 дүгээр зүйл.Гомдол гаргах үндэслэл

19.1.Гомдлыг дараах үндэслэлээр гаргана:

19.1.1.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хөөн хэлэлцэх хугацаа дууссан;

19.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан нөхцөл бүрдээгүй;

19.1.3.иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичиг гаргах үндэслэл болсон баримт бичиг нь энэ хуулийн 7.1-д хамаарахгүй;

19.1.4.иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичиг гаргах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичиг хүчингүй болсон, өөрчлөгдсөн, хүчингүйд тооцогдсон, эсхүл хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдсан буюу гүйцэтгэгдэх боломжгүй болсон;

19.1.5.төлбөр авагч нь тухайн шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгүүлэх эрхгүй, эсхүл тухайн төлбөр төлөгчөөр гүйцэтгүүлэх эрхгүй;

19.1.7.төлбөр төлөгч тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт гаргах боломжгүй болсон үеэс хойш үүссэн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шаардлага хүчингүй болсон;

19.1.8.төлбөр төлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт гаргах боломжгүй болсон үеэс хойш үүссэн үйл явдлын улмаас шаардлагыг хангах нь тодорхой хугацаагаар хойшлогдсон, хориглогдсон, өөрчлөгдсөн, эсхүл өөрөөр боломжгүй болсон;

19.1.9.шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа дууссан;

19.1.10.шийдвэр гүйцэтгэх баримт бичиг гаргасан шүүх харьяаллын хувьд эрх бүхий бус байсан;

19.1.11.энэ хуульд заасан бусад үндэслэл.

25.4.1. гуравдагч этгээдийн овог, эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл;

25.4.2. маргаж буй шийдвэр гүйцэтгэх баримт бичиг;

25.4.3. гомдлын үндэслэл;

25.4.4. гомдлын үндэслэлийг нотлох баримт;

25.4.5. гуравдагч этгээдийн гарын үсэг.

25.5. Энэ хуульд өөрөөр заагаагүй, эсхүл шийдвэр гүйцэтгэлийн шүүгч өөрөөр шийдвэрлээгүй бол гуравдагч этгээдийн гомдол нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, саатуулах үндэслэл болохгүй.

#### **26 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн гомдлыг шийдвэрлэх**

26.1. Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч нь гуравдагч этгээдийн гомдлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд хянан шийдвэрлэнэ.

26.2. Төлбөр авач нь гомдолд заасан хугацаанд хариу тайлбар, эсэргүүцэл гаргахгүй, эсхүл гуравдагч этгээд хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, албан ёсны баримт бичиг, эсхүл хуульд нийцүүлэн баталгаажуулсан бусад баримтаар гомдлын үндэслэлийг нотлон харуулсан бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хангаж шийдвэрлэнэ.

26.3. Гомдлыг хангаж шийдвэрлэсэн бол тухайн эд хөрөнгөтэй холбоотой иргэний шийдвэр гүйцэтгэх албадлагын арга хэмжээг хүчингүйд тооцно.

26.4. Гуравдагч этгээдийн гомдлыг шийдвэрлэхэд энэ бүлэгт заасан шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хянан шийдвэрлэх журам үйлчилнэ.

#### **27 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль бус болохыг тогтоолгох тухай нэхэмжлэл**

27.1. Гуравдагч этгээд нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль бус болохыг тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасны дагуу нэхэмжлэл гаргасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

#### **28 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарсан зөрчил, ёс зүйн зөрчилд гаргах гомдол**

28.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон бусад этгээд нь энэ хуульд тусгайлан зохицуулаагүй боловч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах явцад иргэний шийдвэр гүйцэтгэгчээс гаргасан зөрчилтэй үйлдэл, эс үйлдэхүйтэй холбогдуулан шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид эсэргүүцэл гаргаж болно.

28.2. Эсэргүүцлийг шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн агуулга, хууль ёсны хүчин төгөлдөр байдлын талаар гаргахгүй.

22.4. Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг хангасан бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн дуусгавар болгоно. Энэ тохиолдолд өмнө авсан иргэний шийдвэр гүйцэтгэлийн арга хэмжээг хүчингүйд тооцно.

22.4.1. Гомдлыг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг гомдол гаргагч 3 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж өөрөө гардан авна.

#### **23 дугаар зүйл. Барьцаа**

23.1. Барьцаа гаргахыг энэ хуульд тусгайлан заасан тохиолдолд гаргаж болох бөгөөд мөнгөн хэлбэрээр гаргана. Барьцааны хэмжээ нь гүйцэтгэх хуудасны үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

23.2. Барьцаа гаргуулах нь төлбөр төлөгчид ноцтой хохирол учруулах нөхцөл байдал тогтоогдсон бол барьцаа шаардахгүй байж болно.

23.3. Гомдлыг хангах тухай эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд төлбөр төлөгчөөс гаргасан барьцааг үүргийн гүйцэтгэлд тооцож, төлбөр авагчид шилжүүлнэ.

23.4. Гомдлыг хангахгүй тухай эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд төлбөр төлөгчөөс гаргасан барьцааг буцааж олгохгүйгээр шүүхийн зардлыг нөхөхөд зарцуулна.

23.5. Төлбөр төлөгч нь төрийн байгууллага, албан газар бол барьцаа гаргах үүрэг хүлээхгүй.

#### **24 дүгээр зүйл. Давж заалдах гомдол**

24.1. Гомдол гаргагч нь шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 22.4-т заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн захирамжийг гардан авснаас хойш ажлын таван өдрийн дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй.

24.2. Давж заалдах гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.

#### **25 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн гомдол гаргах үндэслэл**

25.1. Талуудаас бусад этгээд нь эд хөрөнгөд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг өөрийн эрхэд хамаарах хэсгээр зөвшөөрөхгүйд тооцуулах тухай гомдлыг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргаж болно.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан гуравдагч этгээдийн гомдолд заасан тухайн эрхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлүүлэхүйц гэж үзвэл шийдвэр гүйцэтгэлийн шүүгч энэ тухай шүүгчийн захирамж гаргаж, гомдлыг хүлээн авахас татгалзана.

25.3. Гуравдагч этгээд гомдлыг иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болохоос өмнө гаргана.

25.4. Гуравдагч этгээдийн гомдолд дараах мэдээллийг тусгана:

28.3.Эсэргүүцлийг тухайн зөрчил гарсан гэж үзсэн өдрөөс хойш долоон хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх дэх шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргана.

28.4.Эсэргүүцэлд дараах мэдээллийг тусгана:

28.4.1.эсэргүүцэл гаргагчийн овог, эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл;

28.4.2.эсэргүүцлийн үндэслэл;

28.4.3.үндэслэлийг нотлох баримт;

28.4.4.эсэргүүцэл гаргагчийн гарын үсэг.

28.5.Энэ хуулийн 28.1-д заасан эсэргүүцэл гаргасан бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч эсэргүүцлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор эсэргүүцлийг шийдвэрлэх тухай хэрэг үүсгэж, ажлын гурван өдрийн дотор иргэний шийдвэр гүйцэтгээс хариу тайлбар, нотлох баримтыг гаргуулан авч, ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэж, эсэргүүцлийг хангах, хангахгүй тухай захирамж гаргана.

28.6.Иргэний шийдвэр гүйцэтгэчийн ёс зүйн дүрмийг Улсын дээд шүүх баталж, олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсруулна.

28.7.Иргэний шийдвэр гүйцэтгэчийн эсрэг эсэргүүцэл гаргасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

#### **29 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад торгууль оногдуулах**

29.1.Иргэний шийдвэр гүйцэтгэчийн гаргасан шийдвэрийг биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхгүйг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргасан бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч өөрийн санаачилгаар, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэчийн үндэслэл бүхий саналд үндэслэн торгууль оногдуулна.

29.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож байгаа иргэнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн, хуулийн этгээдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн торгууль оногдуулна.

29.3.Энэ хуулийн 29.2-т заасан торгуулийг иргэний шийдвэр гүйцэтгэчийн хууль ёсны шаардлагыг давтан биелүүлээгүй, эсхүл хууль бус үйлдлээ зогсоогоогүй тохиолдолд давтан оногдуулж болно.

29.4.Торгууль оногдуулахын өмнө шийдвэр гүйцэтгэлийн шүүгч тухайн этгээдэд тайлбар гаргах боломж олгоно. Шаардлагатай гэж үзвэл нотлох баримт үнэлэх зорилгоор шүүх хуралдаан товлож болно.

29.5.Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч торгуулийн хэмжээг тогтоохдоо тухайн хэргийн нөхцөл байдал, зөрчлийн шинж, үр дагавар, холбогдогч этгээдийн эдийн засгийн байдлыг харгалзан үзнэ.

29.6.Торгууль оногдуулсан захирамжийг хүлээн авснаас хойш ажлын долоон өдрийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

15

29.7.Торгууль оногдуулсан захирамжийг биелүүлэхтэй холбогдон гарсан зардлыг торгуулсан этгээд хариуцна.

29.8.Торгууль оногдуулсан захирамж хүчин төгөлдөр болсон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч уг торгуулийг албадан гүйцэтгэнэ.

29.9.Төлбөр төлөгч, бусад иргэн, хуулийн этгээд нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн эд хөрөнгийн талаар мэдээлэл өгөхөөс татгалзсан, иргэний шийдвэр гүйцэтгэчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эд хөрөнгийг нуун дарагдуулсан, бууруулсан, гэмтээсэн, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан бол энэ зүйлд заасан торгуулийг оногдуулах үндэслэл болно.

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА ҮҮСГЭХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХОЙШЛУУЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ**

**30 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа**

30.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дараах хугацаа дууссанаас хойш иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй:

30.1.1.энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3-т заасан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш зургаан жил;

30.1.2.хэрэв Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 7.1.4, 7.1.5-д заасан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш таван жил;

30.1.3.энэ хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жил;

30.1.4.энэ хуулийн 7.1.8, 7.1.9-д заасан шийдвэрийн хүчинтэй хугацаа дууссан.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн нь тогтоогдвол төлбөр авагч нотлох баримтын хамт хугацааг сэргээх хүсэлтийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргаж болно. Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч хугацаа дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор хугацааг сэргээж болно.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасны дагуу хугацааг сэргээсэн бол хугацаа сэргээх тухай захирамж гарсан өдрөөс хойш нэг сарын дотор гүйцэтгэх хуудас олгоно.

30.4.Энэ хуулийн 7.1-д заасан шийдвэрээс тэтгэмж, эсхүл тодорхой хугацаанд тогтмол төлбөр төлөх үүрэгтэй холбоотой шийдвэрийг тухайн үүрэг бүрэн биелэгдэх хүртэл бүх хугацаанд албадан гүйцэтгэх боломжтой байна.

**31 дүгээр зүйл.Гүйцэтгэх хуудас**

31.1.Энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан шийдвэрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах тухай

16

шийдвэр нь шийдвэр гүйцэтгэх баримт бичигт хамаарна. Харин энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасан баримт бичигт гүйцэтгэх хуудас шаардахгүй.

31.2. Гүйцэтгэх хуудсыг цахим хэлбэрээр илгээж болох бөгөөд цахим гүйцэтгэх хуудас нь цаасан баримт бичигтэй адил эрх зүйн хүчинтэй байна.

31.3. Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг үрэгдсэн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118, 119 дүгээр зүйлд заасан журмын дагуу уг баримт бичгийг олгосон шүүхэд дахин олгуулах хүсэлт гаргана.

31.4. Энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д зааснаас бусад тохиолдолд гүйцэтгэх хуудасгүйгээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй.

31.5. Шүүхийн шийдвэрт барьцааны зүйлээс төлбөр гаргуулахаар заасан бол гүйцэтгэх хуудасгүйгээр дараах баримт бичгийн үндсэн дээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлж болно:

31.5.1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу бүртгэгдсэн барьцааны гэрчилгээ;

31.5.2. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 34.1-д заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн барьцааны мэдэгдэл.

31.6. Энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасан шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжид тухайн шийдвэрийг гүйцэтгэх хуудас олгохгүйгээр албадан гүйцэтгэх талаар тусгана. Энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас олгохгүйгээр албадан гүйцэтгэхээр заасан бол тухайн шийдвэр нь гүйцэтгэх хуудасгүйгээр албадан гүйцэтгэх үндэслэл болж болно.

### 32 дугаар зүйл. Гүйцэтгэх хуудасны агуулга, түүнд тавигдах шаардлага

32.1. Гүйцэтгэх хуудас нь дараах агуулгатай байна:

32.1.1. Гүйцэтгэх хуудас олгосон байгууллага, албан тушаалтны нэр, албан тушаал, гүйцэтгэх хуудасны дугаар, олгосон он, сар, өдөр;

32.1.2. Гүйцэтгэх хуудас олгох үндэслэл болсон шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрийн он, сар, өдөр, дугаар;

32.1.3. Гүйцэтгэх хуудас олгосон эрх зүйн үндэслэл;

32.1.4. Төлбөр авагч, төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, регистрийн дугаар, хаяг, иргэн бол овог, нэр, оршин суугаа болон ажлын газрын хаяг, холбоо барих мэдээлэл, регистрийн дугаар;

32.1.5. Төлбөр авагчид төлөх мөнгөн дүн;

32.1.6. Төлбөрийг гаргуулах эд хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрх, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх арга, журам;

32.1.7. Шийдвэрээр эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хамгаалагдсан этгээд, шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий этгээдийн овог, эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр, хаяг;

32.1.8. Гүйцэтгэх хуудас олгох үндэслэл болсон шийдвэрийн дагуу битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгө, хураан авсан хөдлөх эд хөрөнгө, эсхүл төлбөр гаргуулахаар тогтоосон барьцааны зүйл, түүний байршил;

32.1.9. Гүйцэтгэх хуудас олгох үндэслэл болсон шийдвэрийн тогтоох хэсэгт заасан төлбөр төлөгчөөс гаргуулах мөнгөн дүн, эсхүл тодорхой үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байх үүрэг, төлбөр төлөгч холбогдох үүргийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан хүү, алданийг тооцож гаргуулах эрх иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгогдсон талаар.

32.2. Гүйцэтгэх хуудас нь түүнийг олгосон шүүгч, эсхүл эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажсан байна.

### 33 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх

33.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр авагчийн хүсэлтээр, эсхүл хуульд заасан тохиолдолд шүүхийн санаачилгаар иргэний шийдвэр гүйцэтгэгч үүсгэнэ.

33.2. Энэ хуульд заасан гүйцэтгэх хуудас болон бусад шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг цахим мэдээллийн сүлжээгээр харьяалах нутаг дэвсгэрийн иргэний шийдвэр гүйцэтгэгчид ажлын гурван өдрийн дотор хуваарилна. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь баримт бичгийг хүлээц авмагц шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргана. Уг тогтоолыг цахим хэлбэрээр гаргана.

33.3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоолтой хамт шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө битүүмжилсэн тухай тэмдэглэл, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж, харилцах дансны гүйлгээг шаардлагын хэмжээнд битүүмжилсэн болохыг нотлох баримт, түүнчлэн шаардлагатай бусад баримт бичгийг цахим мэдээллийн системд байршуулна.

### 34 дүгээр зүйл. Төлбөр авагчийн шаардлага өөр этгээдэд шилжих

34.1. Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт төлбөр авагчаар нэрлэгдээгүй этгээд төлбөр авагчийн шаардлага өөрт нь шилжсэн болохыг албан ёсны баримт бичиг, эсхүл хуульд заасан журмын дагуу баталгаажуулсан бусад баримтаар нотолсон бол түүний хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, эсхүл төлбөр авагчийг өөрчилж болно. Иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ талаар төлбөр төлөгчид мэдэгдэнэ.

34.2. Төлбөр авагчийн шаардлага өөр этгээдэд шилжсэн нь энэ хуулийн 34.1-д заасан баримтаар тогтоогдохгүй бол хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, эсхүл түүнтэй адилтгах шийдвэрээр тогтоогдсон байна.

### 35 дугаар зүйл. Нөхцөлт болон харилцан үүрэг

35.1. Төлбөр авагч урьдчилан, эсхүл харилцан үүрэг гүйцэтгэсний дараа төлбөр төлөгчийн үүрэг биелэгдэхээр, эсхүл тодорхой нөхцөл биелснээс хамааран хэрэгжих шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгүүлэх бол төлбөр авагч өөрийн үүргийг гүйцэтгэсэн, эсхүл тухайн нөхцөл биелсэн болохыг албан ёсны баримт бичиг, эсхүл хуульд заасан журмын дагуу баталгаажуулсан бусад баримтаар нотолсон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулна.

35.2.Төлбөр авагч энэ хуулийн 35.1-д заасан журмаар нотлох боломжгүй бол үүрэг гүйцэтгэсэн, эсхүл нөхцөл биелсэн болохыг маргаан хянан шийдвэрлэх журмаар гарсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, түүнтэй адилтгах шийдвэрээр нотолж болно.

35.3.Төлбөр төлөгч гаргасан гомдолдоо төлбөр авагч өөрийн үүргийг гүйцэтгэж, эсхүл гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлээгүй, эсхүл нөхцөл биелээгүй гэж маргасан бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч уг гомдлыг энэ хуулийн дагуу шийдвэрлэнэ. Харин уг асуудлыг шийдвэрлэхэд маргаантай нөхцөл байдлыг нотлох баримтаар тогтоох шаардлагатай бол энэ хэсэг хамаарахгүй.

35.4.Энэ хуулийн 35.3-т заасан асуудлыг шийдвэрлэхэд маргаантай нөхцөл байдлыг тогтоох шаардлагатай боловч дараах тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гомдлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд шийдвэрлэж болно:

35.4.1. тухайн нөхцөл байдал нийтэд илэрхий, эсхүл маргаангүй;

35.4.2. төлбөр авагч өөрийн үүргийг гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн, эсхүл нөхцөл биелсэн болохыг албан ёсны баримт бичиг, эсхүл хуульд заасан журмын дагуу баталгаажуулсан бусад баримтаар нотолсон.

35.5.Төлбөр авагч өөрийн үүргийг гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн, эсхүл нөхцөл биелсэн болохыг нотолж чадаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу нэхэмжлэл гаргаж болно.

### **36 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх**

36.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэл, хугацаагаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно:

36.1.1. төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч нас барсан, сураггүй алга болсон, иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, эсхүл төлбөр авагч, төлбөр төлөгч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжих, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл;

36.1.2. орон сууцнаас албадан гаргах тухай шийдвэрийг өвлийн улиралд гүйцэтгэх тохиолдолд албадан гаргах этгээдийн амьдрах нөхцөлийг харгалзан өвлийн улирал дуустал тодорхой хугацаагаар;

36.1.3. төлбөр төлөгч энэ хуульд заасны дагуу хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн, эсхүл төлбөр гаргуулах боломжтой эд хөрөнгө, орлогогүй нь тогтоогдсон бол төлбөр төлөгч хангалттай эд хөрөнгө, орлоготой болох хүртэл;

36.1.4. барьцааны зүйлээс төлбөр гаргуулахаар шүүх шийдвэрлэсэнээс бусад тохиолдолд төлбөр төлөгчид холбогдуулан дампуурлын хэрэг үүссэн бол шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл;

36.1.5. шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас иргэний шийдвэр гүйцэтгэх үндэслэл болсон шийдвэрийг хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг шүүх

хүлээн авч, хэрэг үүсгэсэн бол тухайн хэргийг хянан шийдвэрлэж, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл;

36.1.6. төлбөр төлөгчийн эд хөрөнгөд холбогдох хэд хэдэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн явуулж байгаа бөгөөд энэ хуулийн 36.1.1-36.1.5-д заасан түдгэлзүүлэх үндэслэл аль нэг төлбөр авагч, төлбөр төлөгчид хамаарч байгаа бол.

36.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн энэ хуулийн 36.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг эс зөвшөөрөөл энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

### **37 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах**

37.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг удаа хойшлуулах тухай хүсэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болно.

37.2. Төлбөр төлөгч үүрэгз сайн дураар биелүүлэх тухай хүсэлт гаргасан бол иргэний шийдвэр гүйцэтгэгч хүсэлтэд заасан хугацаагаар шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг хойшуулж болно. Энэ тохиолдолд төлбөр авагчийн саналыг болон төлбөр төлөгчийн төлбөрийн чадварыг нотлох баримтыг харгалзан үзнэ.

37.3. Энэ хуулийн 37.1-д заасны дагуу төлбөр авагч хүсэлт гаргаж, төлбөр төлөгч зөвшөөрсөн бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 30 хүртэл хоногоор хойшуулж болно. Энэ тохиолдолд хойшуулах үндэслэлийг хянан шалгахгүйгээр иргэний шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшуулах тухай тогтоол гаргана.

37.4. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшуулсан хугацаанд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан хугацаа хэтрүүлсний хүү, алданги тооцохгүй.

37.5. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшуулсан хугацаа дуусмагц иргэний шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэн даруй сэргээнэ.

### **38 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгаар болгох, сэргээх**

38.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах үндэслэлээр дуусгаар болгож, хувийн хэргийг хааж, талуудад мэдэгдэнэ:

38.1.1. шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг шүүх, бусад байгууллага, албан тушаалтан хүчингүй болгосон, өөрчилсөн, хүчингүйд тооцсон, эсхүл өөрөөр эрх зүйн үйлчлэлгүй болгосон;

38.1.2. төлбөр авагч төлбөр хүлээн авахаас татгалзаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгаар болгуулах тухай хүсэлт гаргасан;

38.1.3. төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг бүрэн төлсөн;

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
МӨНГӨН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХ ИРГЭНИЙ ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА**

**41 дүгээр зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны  
албадлагын арга хэмжээ**

- 41.1. Шийдвэр гүйцэтгэлийн шүүгч дараах албадлагын арга хэмжээг гүйцэтгэнэ:
- 41.1.1. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн хөрөнгө төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй, эсхүл хөрөнгөгүй бол тухайн хуулийн этгээдийн хувь эзэмшигчийн хөрөнгө хуулийн этгээдийн хөрөнгөөс зааглагдсан эсэхийг төлбөр авагчийн хүсэлтээр тогтоох;
  - 41.1.2. Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах, худалдан борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгчид шилжүүлэх тухай захирамж гаргах;
  - 41.1.3. Энэ хуульд заасан тохиолдолд торгууль оногдуулах;
  - 41.1.4. Энэ хуульд заасан гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх.
- 41.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч мөнгөн төлбөрийн шаардлагыг хангуулах зорилгоор дараах албадлагын арга хэмжээг гүйцэтгэнэ:
- 41.2.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, бусад этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
  - 41.2.2. Төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
  - 41.2.3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэн, хуулийн этгээдийг дуудан ирүүлэх, гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
  - 41.2.4. Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
  - 41.2.5. Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх;
  - 41.2.6. Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг битүүмжлэх, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;
  - 41.2.7. Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг төлбөр төлөгч, холбогдох этгээдээс албадан гаргуулах;
  - 41.2.8. Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар эрх бүхий байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;

38.1.4. Төлбөр авагч, төлбөр төлөгч харилцан тохиролцож эвлэрсэн бөгөөд төлбөр авагч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгуулах тухай хүсэлт гаргасан;

38.1.5. Төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхгүй байх тухай шийдвэрийг бүрэн биелүүлсэн;

38.1.6. Тэтгэмж төлөх үүрэг бүхий шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг бүрэн биелүүлсэн;

38.1.7. Төлбөр төлөгчид холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэн шийдвэрлэсэн, эсхүл татан буулгах ажиллагаа дууссан бөгөөд шүүх төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхэд хүрэлцэх эд хөрөнгө байхгүй гэж тогтоосон;

38.1.8. Төлбөр төлөгч нас барсан, сураггүй алга болсон, эсхүл төлбөр төлөгч, төлбөр авагч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бөгөөд шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих боломжгүй;

38.1.9. Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан тодорхой үйлдэл, үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

38.1.10. Гуравдагч этгээд төлбөр төлөгчийн өмнөөс үүргийн гүйцэтгэлийг төлбөр авагчид хангасан;

38.1.11. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй болсон, эсхүл шийдвэр гүйцэтгэх хугацааны хөөн хэлэлцэх хугацаа дууссан.

**39 дүгээр зүйл. Гүйцэтгэсэн шийдвэрийг хүчингүй болгох**

39.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг хүчингүй болгосон бол шийдвэр гүйцэтгэлийг буцаах, анхны байдлыг сэргээх арга хэмжээ авна.

39.2. Хүчингүй болгосон шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн үндсэн дээр төлбөр авагчид олгосон мөнгөн хөрөнгийг буцаан гаргуулж, төлбөр төлөгчид шилжүүлнэ.

39.3. Төлбөр авагчид шилжүүлсэн эд хөрөнгийг бодитоор буцаан гаргах боломжгүй бол тухайн үеийн үнэлгээгээр мөнгөн дүнг нь төлбөр авагчаас гаргуулж, төлбөр төлөгчид шилжүүлнэ.

**40 дүгээр зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээн явуулах**

40.1. Энэ хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд, түүнчлэн энэ хуулийн 38.1.8, 38.1.9-т заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл арилсан, эсхүл төлбөр төлөгч энэ хуулийн 38.1.4-т заасан эвлэрлийн гэрээг зөрчсөн бол төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргаж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх тухай тогтоол гаргана.

41.2.9.төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээдийн дансан дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хязгаарлах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;

41.2.10.төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;

41.2.11.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхийг түдгэлзүүлэх;

41.2.11.шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн захирамжийн үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулах;

41.2.12.эд хөрөнгийг албадан удирдлагад шилжүүлэх, энэхүү ажиллагаанд хяналт тавих;

41.2.13.хөдлөх эд хөрөнгийг хураах, үнэ хаялцуулах ажиллагаа явуулах, холбогдох хуулийн этгээдээр дамжуулан худалдан борлуулах;

41.2.14.худалдан борлогдсон, эсхүл борлогдоогүй хөрөнгө, түүнчлэн төлбөр авагчийн албадан удирдлагад шилжүүлсэн хөрөнгийг албадан чөлөөлж, төлбөр авагч, бусад этгээдэд шилжүүлэх;

41.2.15.төлбөр төлөгчийг төлбөртэй этгээдийн бүртгэлд болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатан дахь хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэх;

41.2.16.төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг албадан гаргуулан авах;

41.2.17.энэ хуульд заасан хугацаа хэтрүүлсний хүү, алдангийг төлбөр төлөгчөөс төлбөрөө төлөх хүртэл тооцож гаргуулах;

41.2.18.төлбөр төлөгчийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах нэгжээр эрэн сурвалжлуулах;

41.2.19.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу түдгэлзүүлэх, сэргээх;

41.2.20.талууд төлбөрийг хуваарийн дагуу хэсэгчлэн барагдуулахаар тохиролцсон тохиолдолд холбогдох баримт, тодорхойлолтыг үндэслэн талуудын тохиролцоог шийдвэр гүйцэтгэгч баталгаажуулах;

41.2.21.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, зайлсхийсэн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгүүлэх тухай саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

41.2.22.энэ хуульд заасан бусад.

41.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 41.2-т заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг төлбөр төлөгчийн хөрөнгийг өөр

этгээд эзэмшиж байгаагаас үл хамааран хэрэгжүүлж болно.

41.4.Энэ хуулийн 41.1.1-д заасны дагуу хөрөнгө зааглагдсан эсэхийг нотлох холбогдох дансны хууль, гэрээ хэлцлийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид төлбөр төлөгч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч гаргах үүрэгтэй бөгөөд зааглагдсан нь тогтоогохгүй бол хувь эзэмшигчийн хөрөнгөөс төлбөр төлөгч хуулийн этгээдийн төлбөрийг гаргуулах тухай гүйцэтгэх хуудсыг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч олгоно.

#### 42 дугаар зүйл. Төлбөртэй этгээдийн бүртгэл

42.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх хуудас олгогдож, ажиллагаа үүсгэсний дараа нэн даруй төлбөртэй этгээдийн бүртгэлд төлбөр төлөгчийг бүртгэнэ.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасан бүртгэлд төлбөр төлөгч бүртгэлтэй эсэх мэдээллийг төлбөр төлөгчид үнэ төлбөргүй олгоно. Сонирхогч этгээд төлбөр төлөгчтэй гэрээ байгуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор уг мэдээллийг төлбөртэйгээр авч болно.

42.3.Энэ хуулийн 42.2-т заасны дагуу сонирхогч этгээд төлбөр төлөгчийн төлбөртэй эсэх талаарх мэдээллийг авахаас өмнө бусдад задруулахгүй байх тухай нууцлалын баталгаа гаргана. Мэдээллийг бусдад задруулбал холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

42.4.Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгч төлбөрийг барагдуулж дуусах хүртэл дараах хязгаарлалтад хамрагдана:

42.4.1.нийтийн албанд ажиллах эрхийг хязгаарлах;

42.4.2.төрөөс санхүүжүүлсэн орон сууцны зээлд хамрагдах эрхийг хязгаарлах;

42.4.3.тусгай зөвшөөрөл, эрх олгосон баримт бичгийн үйлчлэлийг түдгэлзүүлэх;

42.4.4.гадаадад зорчих эрхийг хязгаарлах;

42.4.5.гадаад паспорт авах эрхийг хязгаарлах;

42.4.6.жолооны үнэмлэх авах эрхийг хязгаарлах;

42.4.7.улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох;

42.4.8.банк, эрх бүхий этгээдэд данс нээхийг хязгаарлах;

42.4.9.хуулийн этгээд үүсгэн байгуулах эрхийг хязгаарлах;

42.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжих бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах.

42.5.Энэ хуулийн 42.4-т заасан хязгаарлалтыг хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллагад төлбөртэй этгээдийн бүртгэлийн мэдээлэлд нэвтрэх эрх олгоно.

42.6.Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн гарын гишүүн батална.

42.7.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болоход тухайн төлбөр төлөгчийг төлбөртэй этгээдийн бүртгэлээс хасна.

44.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгө, орлогын мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу бөглөж, гарын үсэг зурсан хэлбэрээр ирүүлэхийг үүрэг болгож болно. Шаардлагатай бол төлбөр төлөгчийг биечлэн ирж тайлбар өгөхийг шаардаж болно.

44.4.Эд хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчид нэн даруй хүргүүлж, хүргүүлсэн огноог тэмдэглэнэ.

#### **45 дугаар зүйл.Эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгах мэдээлэл**

45.1.Төлбөр төлөгч өөрийн болон дундын хэсгээр, эсхүл хамтран өмчилж байгаа бүх хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон дараах асуудлыг эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгана:

45.1.1.Төлбөр төлөгчийн дангаар болон дундаа өмчилж буй хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө;

45.1.1.1.2. мэдүүлэг гаргах үед төлбөр төлөгчийн эзэмшилд байгаа бэлэн мөнгө;

45.1.1.3.Монгол Улсад болон гадаад улсад байгаа банк, санхүүгийн байгууллагад нээлгэсэн өөрийн болон хамтран эзэмшдэг хадгаламж, дансны үлдэгдэл;

45.1.1.4.дангаар болон хамтран эзэмшиж буй бусад бэлэн болон бэлэн бус мөнгөн хөрөнгө, данс;

45.1.1.5.үнэт цаас болон түүнээс үүсэх эрх;

45.1.1.6.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн эрх, уг эрхээс сүүлийн нэг жилийн хугацаанд олсон орлого;

45.1.1.7.сүүлийн зургаан сарын хугацаанд хамаарах цалин хөлс, ажил олгогчийн нэр, хөдөлмөр эрхлэлтийн төрөл, хугацаа;

45.1.1.8. бусад орлого болон орлогын эх үүсвэр;

45.1.1.9.төлбөр төлөгчийн эзэмшиж буй барьцаа, баталгаа, мөн төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд бусдын тогтоосон барьцаа, баталгааны эрх;

45.1.1.10.нэг жилийн дотор бусдад төлөх, эсхүл хугацаа нь болсон өр төлбөрийн талаарх мэдээлэл болон тэдгээрт холбогдох барьцаа хөрөнгө;

45.1.1.11.төлбөр төлөгчид холбогдуулан явагдаж байгаа бусад шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, түүний дотор татвар, хураамжийн өртэй холбоотой мэдээлэл;

45.1.1.12.эд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас өмнөх нэг жилийн хугацаанд бусдад үнэ төлбөртэй шилжүүлсэн эд хөрөнгө;

45.1.1.13.эд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас өмнөх нэг жилийн хугацаанд эхнэр, нөхөр, хүүхэд, төрөл садан, гэр бүлийн гишүүдэд шилжүүлсэн эд хөрөнгө;

45.1.1.14. эд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бусдад шилжүүлсэн бэлэг, хандив;

26

42.8.Энэ зүйлд заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгч энэ хуулийн 42.7-д заасан төлбөртэй этгээдийн бүртгэлээс хасах үндэслэл үүссэн боловч хасаагүй бол энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болно.

42.9.Тэжээн тэтгэх үүргийг хугацаанд нь төлж байгаа төлбөр төлөгчид энэ хуулийн 42.4-т заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд тавигдах хязгаарлалтыг тавихгүй.

42.10.Энэ хуулийн 42.4.4-т заасан гадаадад зорчих эрхийг төлбөр төлөгч албан ажлаар гадаад улсад зорчих, өөрөө болон гэр бүлийн гишүүд нь гадаад улсад эмчилгээ хийлтгэх шаардлагатай болсон, гадаад улсад амьдарч буй гэр бүлийн гишүүн, төрсөн эцэг, ах, эгч, дүү нас барсан, хүндээр өвчилсөн зэрэг зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд түүний хүсэлт, гэр бүлийн лавлагаа, нас барсны гэрчилгээ, эмнэлгийн байгууллагын шийдвэр, магадлагаа, дүгнэлт зэрэг нотлох баримтыг үндэслэн түр хугацаагаар сэргээж болно.

#### **43 дугаар зүйл.Эд хөрөнгө, орлогын мэдүүлэг**

43.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болохоос өмнө аль ч үе шатанд төлбөр авагч төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогын талаар тодруулах тухай хүсэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болно.

43.2.Эд хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй төлбөр авагч танилцах эрхтэй бөгөөд төлбөрийн шаардлагыг хангуулах хөрөнгө, орлогыг сонгох эрхтэй.

43.3.Төлбөр төлөгчийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахад шаардагдахаас илүү олон шийдвэр гүйцэтгэлийн арга хэмжээ, эд хөрөнгө байгаа бол төлбөр авагчийн шаардлагыг хангахад хангалттай хэмжээгээр зарим арга хэмжээ, эд хөрөнгөөр хязгаарлан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна.

#### **44 дүгээр зүйл.Төлбөр авагчийн хүсэлтийг шийдвэрлэх**

44.1.Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хялбар илрүүлэх боломжтой бол иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн энэ хуулийн 43.1-д заасан хүсэлтээс татгалзаж болно.

44.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 44.1-д заасан төлбөр авагчийн хүсэлтийг хүлээн авсны дараа дараах арга хэмжээг авна:

44.2.1.хүсэлт гаргаснаас хойш 5 хоногийн дотор төлбөр төлөгч болон шаардлагатай бусад этгээдэд мэдүүлэг гаргахаас татгалзсан тохиолдолд албадан ирүүлэх, торгууль оногдуулах талаар урьдчилан мэдэгдэж, эд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргуулахаар дуудан ирүүлэх;

44.2.2.энэ хуулийн 44.2.1-д заасны дагуу хүрэлцэн ирээгүй, үндэслэлгүйгээр татгалзан бол иргэний шийдвэр гүйцэтгэгч тухайн этгээдийг албадан ирүүлэх тухай саналыг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргаж, шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн өмнө мэдүүлэг өгүүлэх арга хэмжээ авна.

25

45.1.1.15. төлбөр төлөгчийн одоогийн оршин суугаа хаяг, хуулийн этгээд бол үйл ажиллагаа явуулж буй хаяг;

45.1.1.16. төлбөр төлөгчийн хөдлөх эд хөрөнгө байрлаж буй хаяг;  
45.1.1.17. төлбөр төлөгчийн эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийн үр шим хүртэгч гуравдагч этгээдийн талаарх мэдээлэл болон хэлцлийн төрөл;

45.1.1.18. төлбөр төлөгчийн гарын үсэг.

45.2. Төлбөр төлөгч эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгах эд хөрөнгө, орлогогүй бол энэ тухай тодорхой тусана.

45.3. Эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгасан мэдээлэл хангалтгүй, эсхүл эд хөрөнгө, орлогыг тогтоох боломжгүй тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгчийн гэр бүлийн гишүүн, хамтран ажиллагч болон эд хөрөнгийн талаар мэдээлэл өгөх боломжтой бусад этгээдээс эд хөрөнгийн байршил, хэлбэр, эзэмшлийн талаар тайлбар гаргуулж болно.

#### **46 дугаар зүйл: Эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт оруулах өөрчлөлт**

46.1. Төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгө, орлогын байдалд орсон өөрчлөлтийн талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй бичгээр, эсхүл цахимаар мэдэгдэж, өөрчлөлтийг эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт зохих ёсоор тусуулна.

46.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус гуравдагч этгээдээс төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогын талаар бичгээр мэдүүлэг авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээд заавал мэдүүлэг өгөх үүрэгтэй.

46.3. Эд хөрөнгө, орлогын мэдүүлийг төлбөр төлөгч өгөхөөс зайлсхийсэн, хөрөнгөө нуун далдалсан, худал, эсхүл дутуу мэдүүлсэн, эсхүл өөрчлөлтийг тухай бүр мэдэгдээгүй, эсхүл тогтоосон хугацаанд мэдүүлээгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно.

#### **47 дугаар зүйл: Бусдын орон байранд нэвтрэх, үзлэг, нэгжлэг хийх**

47.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээ, тэдгээрийн үнэлгээ, үнэлгээнд нөлөөлөхүүйц шинж чанарыг тогтоох зорилгоор өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа түүний өмчлөлийн эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийх, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орж шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах, бусдын орон байранд нэвтрэн орох эрхтэй.

47.2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, эсхүл хураах явцад түүний биедээ, эсхүл бусад газарт нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн биед болон тухайн эд хөрөнгийг нуусан газарт нэгжлэг хийж болно.

47.3. Төлбөр төлөгчийн биед болон эд хөрөнгөд нэгжлэг хийх үед бэлэн мөнгө илэрсэн тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагын хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авна.

47.4. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг явуулахад хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

47.5. Энэ хуулийн 47.1, 47.2-т заасан ажиллагааг явуулахад төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчийг байлцуулна.

47.6. Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн төлөөлөгчийг, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчийг байлцуулна.

47.7. Иргэний шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг явуулахдаа энэ хуульд заасны дагуу тэмдэглэл хөтөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюулгүй арга, хэрэгсэл ашиглаж, хүний нэр төрд хүндэтгэлтэй хандана.

47.8. Нэвтрэн ороход оршин суугч, эзэмшигч саад учруулбал эсэргүүцлээ зогсоохыг шаардах, шаардлагыг үл биелүүлсэн тохиолдолд албадлагын арга хэмжээ хэрэглэхийг анхааруулах бөгөөд цагдаагийн тусламж авна.

47.9. Нэвтрэн ороход эд зүйл, цоож, түгжээ, байгууламжийн хэсгийг эвдэх, дохиолол, хяналтын систем, цахилгааныг салгах, нохой, бусад амьтныг номхотгох, техник, хэрэгсэл ашиглах зэргээр учрах саадыг арилгаж болно.

47.10. Энэ хуулийн 47.1-д заасны дагуу үзлэг, нэгжлэг хийх орон байранд нэвтрэн орох ажиллагааг эсэргүүцэх, эсхүл саад учруулбал иргэний шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэж, шийдвэр гүйцэтгэлийн шүүгч торгох болон тухайн этгээдийг албадан ирүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

#### **48 дугаар зүйл: Хөрөнгө хадгалах, хамгаалах**

48.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгч, түүний гэр бүлийн гишүүн, эзэмшигч, эсхүл хадгалалтын гэрээ байгуулсан бусад этгээдэд хадгалж, хамгаалуулахаар шилжүүлж болно.

48.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч хураан авсан хөдлөх эд хөрөнгийг хадгалалтын гэрээ байгуулсан бусад этгээдэд, эсхүл тусгай зориулалтын иргэний шийдвэр гүйцэтгэх албаны байранд хадгалж болно.

48.3. Энэ хуулийн 48.1, 48.2-т заасан этгээд хөрөнгийг хадгалж, түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүрэгтэй бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

48.4. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийн шинж чанараас хамааран түүнийг ашиглах нь эд хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх, үрэгдүүлэх, гэмтээх эрсдэлтэй бол аливаа этгээдэд ашиглуулахыг хориглоно.

48.5. Хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор хөрөнгийг ашиглах зайлшгүй шаардлагатай тохиолдолд түүнийг зохих ёсоор ашиглахад иргэний шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрөл шаардахгүй.

48.6.Хадгалагч нь төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн гишүүн, эзэмшигч бус бол гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд хадгалсны хөлсийг тохиролцсоны дагуу шилжүүлнэ.

48.7.Мал, гэрийн тэжээвэр амьтан болон бусад хөрөнгийг хадгалуулсны хөлсийг тэдгээрийг хадгалахад зарцуулсан зардлыг тооцож, тухайн эд хөрөнгөөс бий болсон үр шимийг хасаж олгоно.

48.8.Хадгалагч иргэний шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр хадгалуулсан эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн, сольсон, үрэгдүүлсэн, гэмтээсэн, устгасан, нуусан, эд хөрөнгийн хэвийн байдлыг өөрчилсөн бол учирсан хохирлыг бүрэн харуулна.

48.9.Тухайн хөдлөх эд хөрөнгө нь тэвэрлэхэд хүндрэлтэй бол пацдаж, төлбөр төлөгчийн эзэмшилд үлдээж болно.

48.10.Хадгалалтын зардлыг төлбөр авагч урьдчилж төлөх бөгөөд төлбөр төлөгчөөс дараа гаргуулна.

48.11.Хадгалахад хэт алдагдалтай бол шууд худалдан борлуулах эрхийг иргэний шийдвэр гүйцэтгэгч эдлэнэ.

#### **49 дүгээр зүйл. Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаар мэдээлэх үүрэг**

49.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагаар эрх бүхий албан тушаалтан, байгууллага, хуулийн этгээд, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч нь төлбөр төлөгчийн талаар дараах мэдээллийг гаргаж өгнө:

49.1.1.эцэг, эхийн нэр, өөрийн нэр, эсхүл хуулийн этгээдийн оноосон нэр;  
49.1.2.байнгын болон түр оршин суугаа хаяг;

49.1.3. төрсөн он, сар, өдөр;

49.1.4.иргэний бүртгэлийн дугаар;

49.1.5.татвар төлөгчийн дугаар;

49.1.6.цалин хөлс болон бусад тогтмол мөнгөн орлогын хэмжээ, түүнийг олгогчийн талаарх мэдээлэл, мөн цалин, орлогоос суутгал хийгдсэн эсэх талаарх мэдээлэл;

49.1.7.банк, санхүүгийн байгууллагад нээлгэсэн данс, хадгаламжийн дугаар, үлдэгдэл, гүйлгээний жагсаалт, түүнд хийгдсэн битүүмжлэл, суутгалын талаарх мэдээлэл;

49.1.8.төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон цахим мөнгө гаргагч байгууллагад нээлгэсэн төлбөрийн данс, цахим мөнгөний үлдэгдэл, гүйлгээний жагсаалт, түүнд хийгдсэн битүүмжлэл, суутгалын талаарх мэдээлэл;

49.1.9.санхүүгийн хэрэгслийн дансны дугаар, үлдэгдэл;

49.1.10.компанийн хувьцаа, хувь оролцоо болон бусад хуулийн этгээдэд эзэмшиж буй хувь оролцооны талаар, мөн сүүлийн нэг жилийн хугацаанд түүнээс олсон ашиг;

49.1.11.төлбөр төлөгчийн өмчлөх эрх бүхий үл хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээлэл;

29

49.1.12.улсын бүртгэлд бүртгэгдсэн тээврийн хэрэгсэл болон бусад тээврийн хэрэгслийн мэдээлэл;

49.1.13.хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээлэл;

49.1.14.тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээлэл;

49.1.15.иргэний бүртгэлийн мэдээлэл;

49.1.16. амь нас, эд хөрөнгийн даатгалын талаарх мэдээлэл;

49.1.17.сүүлийн гурван жилийн татварын тайлангийн талаарх татварын байгууллагын мэдээлэл;

49.1.18.дараах хэлцэлтэй холбоотой талуудын таних мэдээлэл, хэлцлийн баримт бичгийн хуулбар, баримт бичиг байхгүй бол хэлцлийн агуулгын талаар мэдээлэл;

49.1.18.1.төлбөр төлөгч сүүлийн нэг жилийн хугацаанд өөрийн эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн, эрх шилжүүлсэн, эс үйлдэхүйгээр эрхээс татгалзсан зэрэг төлбөртэй хэлцэл;

49.1.18.2.төлбөр төлөгч сүүлийн нэг жилийн хугацаанд эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, төрөл саданд эд хөрөнгө, эрх шилжүүлсэн төлбөртэй хэлцэл;

49.1.18.2.сүүлийн хоёр жилийн хугацаанд хийсэн үнэ төлбөргүй шилжүүлэг.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан мэдээллийг гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй, худал, дууш, буруу мэдээлэл өгсөн этгээд холбогдох эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээнэ. Энэ талаар иргэний шийдвэр гүйцэтгэгч урьдчилан мэдэгдэнэ.

49.3.Энэ хуулийн 49.1-д заасан этгээд, байгууллага нь тухайн мэдээллийг иргэний шийдвэр гүйцэтгэгч шаардсан талаар төлбөр төлөгчид мэдэгдэхийг хориглоно.

#### **50 дугаар зүйл. Хөрөнгийн эрхийн бүртгэлийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт гаргуулах**

50.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахуйц хөрөнгийг олж тогтоох зорилгоор хууль тогтоомжийн дагуу бүртгүүлбэл зохих хөрөнгө, тэдгээрийн эрхийн талаар эрх бүхий байгууллагад хандаж, лавлагаа, тодорхойлолт гаргуулах бөгөөд холбогдох этгээд заавал гаргаж өгөх үүрэгтэй.

50.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгасан сүүлийн нэгээс хоёр жилийн хооронд шилжүүлсэн хөрөнгийн бүртгэлийг эрх бүхий байгууллагад хандаж, лавлагаа, тодорхойлолт гаргуулна.

50.3.Энэ хуулийн 50.1-д заасан лавлагаа, тодорхойлолтыг төрийн мэдээлэл солилцооны Хур системээс гаргах боломжтойгоос бусад тохиолдолд холбогдох байгууллага ажлын 3 өдрийн дотор, эсхүл цахим сүлжээгээр нэн даруй иргэний шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлнэ.

30

53.1.Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч бүрэн эрхийнхээ хүрээнд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор төлбөр авагчийн хүсэлтээр энэ хуульд заасан албадлага хэрэглэх ажилтнаар эрэн сурвалжлах ажиллагааг гүйцэтгүүлэх тухай тогтоол гаргана. Уг тогтоолд эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн оршин суух хаг, холбоо барих мэдээлэл, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгийн талаар олж тогтоох талаар тусгана.

53.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дахь албадлага хэрэглэх ажилтан гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах талаар дараах эрх эдэлнэ:

53.2.1.Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжилж байгаа тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлах;

53.2.2.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаарх иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ач холбогдол бүхий мэдээллийг төлбөртэйгээр авах;

53.2.3.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгө мөн гэх, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгийг нуун далдлалсан, төлбөр төлөгчийг шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийхэд нь туслалцаа үзүүлсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд Хүн, хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах, тайлбар авах, тодорхойлолт гаргуулах, тэдгээрийн бие, эд зүйл болон орон байрнаас бусад байр, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт үзлэг хийх.

53.4.Эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний хөрөнгийг олж ирүүлсэн тохиолдолд эрэн сурвалжлах тухай шийдвэрт заасан арга хэмжээг албадлага хэрэглэх ажилтан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлагын арга хэмжээг иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

53.5.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлал болон эрэн сурвалжлагдаж байгаа төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

53.6.Эрэн сурвалжлахтай холбоотой гарсан зардлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллаганы зардалд тооцож, төлбөр авагчаас урьдчилан гаргуулж, төлбөр төлөгчөөр дараа төлүүлнэ.

53.7.Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах тухай шийдвэр нь тэдгээрийг улсын хэмжээнд болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлах үндэслэл болно.

#### **54 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дахь албадлага хэрэглэх ажилтан**

54.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дахь албадлага хэрэглэх ажилтан иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрээр энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах арга хэмжээг авна:

54.1.1.Төлбөр төлөгч, түүний нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж ирүүлэх;

50.4.Энэ хуулийн 50.2-т заасан шилжүүлэг бий тохиолдолд тэдгээр хөрөнгийг Иргэний хуулийн 56.1.3-т зааснаар өөр хэлцэлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл буюу хүчин төгөлдөр бус хэлцэл эсэхийг тогтоолохоор төлбөр авагч шүүхэд хандах эрхтэй.

50.5.Энэ хуулийн 4.1.12-т заасан цахим системд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мэдээлэл нийлүүлэх шаардлагатай төрийн байгууллага мэдээлэл нийлүүлэх үүрэгтэй.

#### **51 дугаар зүйл.Хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэл**

51.1.Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн, хөрөнгө, орлогогүй этгээдийг зургаан сараас доошгүй хугацаанд шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөрөө төлөхгүй бол хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэнэ.

51.2.Төлбөр авагч энэ хуулийн 51.1-д заасан бүртгэлд төлбөр төлөгчийг бүртгүүлэх талаар хүсэлт гаргах эрхтэй.

#### **52 дугаар зүйл.Хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэний үр дагавар**

52.1.Энэ хуулийн 51.1-д заасан бүртгэлд бүртгэгдсэнээр энэ хуулийн 42.4-т заасан хязгаарлалт тавигдах бөгөөд төлбөр төлөгч хөрөнгө, орлоготой болтол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болно. Энэ тохиолдолд төлбөр төлөгчид энэ хуулийн 42.4-т заасан хязгаарлалт тавигдана.

52.2.Төлбөр төлөгчийг хөрөнгө, орлогогүй эсэх талаарх мэдээлэл нээлттэй байна.

52.3.Энэ хуулийн 52.1-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзсэн хугацаанд төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгчийг хөдөлмөр эрхлэхэд зучилж болно. Энэ тохиолдолд холбогдох зардлыг төлбөр авагч урьдчилан гаргах бөгөөд уг зардлыг энэ хуульд заасны дагуу төлбөр төлөгчөөс гаргуулна.

52.4.Энэ хуулийн 52.1-д заасан бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогын байдалд иргэний шийдвэр гүйцэтгэх алба хяналт тавих бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан нэгжтэй байж болно.

52.5.Төлбөр авагч энэ хуулийн 52.1-д заасан бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогын өөрчлөлтийн талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээлгэх хүсэлт гаргаж болно.

52.6.Хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээдийг ажилд авсан ажил олгогч болон тухайн этгээд нь энэ тухайгаа иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Үүргээ биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

#### **53 дугаар зүйл.Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах**

54.1.2.орон байранд нэвтрэх, үзлэг хийх болон албадан чөлөөлөх ажиллагааг хэрэгжүүлэх.

**55 дугаар зүйл.Хөрөнгө хурааж улсын орлого болгох**

55.1.Төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авч, улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг худалдан борлуулахгүйгээр төрийн өмчид шилжүүлэхээр төрийн өмчийн асуудал харуулсан төрийн захиргааны байгууллагаас санал авч, шилжүүлнэ. Хэрэв төрийн өмчийн асуудал харуулсан төрийн захиргааны байгууллага худалдан борлуулахаар санал өгсөн бол төрийн өмчид шилжүүлэхгүйгээр худалдан борлуулж, улсын орлого болгоно.

55.2.Галт завсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрлөөр олж авах эд зүйлийг шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад худалдаж, эсхүл шилжүүлнэ.

**ТАВДУГААР БҮЛЭГ  
ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨД ЯВУУЛАХ ИРГЭНИЙ ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА**

**56 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

56.1.Үл хөдлөх эд хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хөрөнгийн үнэлгээ хийлгэсний дараа албадан дуудлага худалдаагаар борлуулна.

56.2.Үл хөдлөх эд хөрөнгийг албадан удирдлагад шилжүүлж болох бөгөөд албадан удирдлага болон албадан дуудлага худалдааг зэрэг хэрэгжүүлж болно.

56.3.Албадан удирдлагыг албадан дуудлага худалдаа явуулахаас өмнөх урьдчилсан арга хэмжээний хэлбэрээр хэрэглэж болно.

**57 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах албадлагын ажиллагааны харьяалал**

57.1.Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах албадан гүйцэтгэх ажиллагааг тухайн үл хөдлөх эд хөрөнгө орших нутаг дэвсгэрийн шийдвэр гүйцэтгэлийн шүүгч харьяалан дуудлага худалдаа явуулах шийдвэрийг гаргана.

57.2.Хэрэв үл хөдлөх эд хөрөнгө нь хэд хэдэн нутаг дэвсгэрийн шүүх бүхий нутаг дэвсгэрт хамаарах бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн иргэний шийдвэр гүйцэтгэгч тухайн үл хөдлөх эд хөрөнгө орших нутаг дэвсгэрийн иргэний шийдвэр гүйцэтгэгчид энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу даалгавар хүргүүлнэ.

57.3.Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах ажиллагааны харьяалал нь тухайн эд хөрөнгө байрлаж байгаа нутаг дэвсгэрийн шийдвэр гүйцэтгэлийн шүүгч албадан борлуулах тухай захирамж гаргаж, борлуулах хэлбэр, журмыг тогтооно.

**58 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгөд холбогдох эрхэд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах**

58.1.Төлбөр төлөгчийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгөд бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх /узууфрукт/ тогтоогдсон бол төлбөр авагч төлбөр төлөгчийн уг эрхээс бий болох шаардлагаа хангуулах бөгөөд эд хөрөнгийн эрхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах журмыг хэрэглэнэ.

58.2.Дуусаагүй барилга байшин, дэд бүтцийн объектыг албадан дуудлага худалдаагаар борлуулж болно.

**59 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн болон хөлслөх гэрээ**

59.1.Худалдан авагч болон түрээслүүлэгч өөрөөр тохиролцоогүй бол шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хангуулах эрх, эсхүл барьцааны эрх үүсэхээс өмнө байгуулсан түрээсийн болон хөлслөх гэрээ нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлэх тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр дуусгавар болно.

**60 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх**

60.1.Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх гэж тухайн хөрөнгийг захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагааг ойлгоно.

60.2.Энэ хуулийн 60.1-д заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарласан тухай улсын бүртгэлийн байгууллагад ажлын 1 өдрийн дотор мэдэгдэнэ.

60.3.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч өөрчлөгдсөн нь тухайн эд хөрөнгөд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоох, эсхүл шинэ өмчлөгчийг төлбөр төлөгчөөр үргэлжлүүлэн оролцуулахад саад болохгүй. Тухайн үл хөдлөх эд хөрөнгөд өмнө хийгдсэн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчинтэй хэвээр хадгалагдана.

60.4.Энэ хуулийн 60.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах хүрээ болон хугацааг тухайн хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэх үүрэг, түүнийг эзэмшиж, ашиглаж байгаа хэлбэр, гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхэд эзлэх хувийг харгалзан иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

60.5.Иргэний шийдвэр гүйцэтгэгч дараах зорилгоор төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилнэ:

60.5.1.үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл хөрөнгийг хамгаалах;

60.5.2.төлбөр төлөгчийн болон бусдад байгаа түүний өмчлөлийн хөрөнгийг албадан борлуулах, эсхүл албадан удирдлагад шилжүүлэх тухай шийдвэрийг гүйцэтгэх.

60.6.Битүүмжилсэн хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах тухай иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг төлбөр төлөгч зөрчсөн бол шийдвэр гүйцэтгэлийн шүүгч торгууль оногдуулна.

60.7. Төлбөр төлөгч тогтоосон хугацаанд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлсэн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийг битүүмжилсэн шийдвэрийг хүчингүй болгож, холбогдох эрхийг сэргээх тухай шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлж, эрхийг сэргээнэ.

#### **61 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ**

61.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгөөс шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангуулах зорилгоор тухайн эд хөрөнгө битүүмжлэгдсэн, эсхүл шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс хангуулахаар тогтоогдсон бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн талаар энэ хуульд заасны дагуу мэдэгдсэнээс хойш Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу үнэлгээчнээр үнэлгээ хийлгэх тухай тогтоол гаргана. Шаардлагатай гэж үзвэл уг тогтоолыг гаргахаас өмнө талуудын тайлбарыг сонсож болно.

61.2. Талууд үл хөдлөх эд хөрөнгийн үнийг бичгээр харилцан тохиролцож тогтоож болно.

61.3. Талууд үнэлгээчний гаргасан анхны үнэлгээний тайлантай санал нийлэхгүй бол тайланг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор иргэний шийдвэр гүйцэтгэгчид өөр үнэлгээчнээр дахин үнэлгээ хийлгэх тухай хүсэлт гаргаж болно. Дахин үнэлгээг анхны үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш ажлын долоон өдрийн дотор хийж гүйцэтгэх бөгөөд уг үнэлгээний тайлан эцсийнх байна.

61.4. Энэ хуулийн 61.3-т заасны дагуу дахин үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан тал тухайн үнэлгээтэй холбоотой зардлыг хариуцна.

#### **62 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдан борлуулах**

62.1. Үл хөдлөх эд хөрөнгө хөрөнгийг анхны болон хоёр дахь албадан дуудлага худалдаа /цаашид "дуудлага худалдаа" гэх/-аар худалдан борлуулна.

62.2. Үл хөдлөх эд хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулж дуусгана.

62.3. Дуудлага худалдааг дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор явуулна.

#### **63 дугаар зүйл. Худалдан борлуулах тухай тогтоол**

63.1. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагаа дууссаны дараа иргэний шийдвэр гүйцэтгэгч үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах тухай тогтоол гаргана. Уг тогтоолд дараах зүйлсийг тусгана:

63.1.1. Үл хөдлөх эд хөрөнгийн нэр, хэмжээ, зориулалт, үнэлгээний тайланд тусгагдсан, эсхүл талуудын харилцан тохиролцсон үнэ, өмчлөгч, эзэмшигчийн тухай;

63.1.2. Дуудлага худалдааг явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;  
63.1.3. Уг дуудлага худалдаа нь албадан дуудлага худалдаа гэсэн

тодотгол;

63.1.4. Үл хөдлөх эд хөрөнгө болон бүртгүүлбэл зохих бусад хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар.

63.1.5. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгчийг томилох.

#### **64 дүгээр зүйл. Дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч**

64.1. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгчийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч дуудлага худалдаа зохион байгуулах тухай шийдвэртээ томилж, тусгана.

64.2. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгчөөр иргэний шийдвэр гүйцэтгэлийг томилно.

#### **65 дугаар зүйл. Дуудлага худалдааны журам**

65.1. Үл хөдлөх эд хөрөнгө дуудлага худалдаагаар албадан борлуулах ажиллагааны журмыг Улсын дээд шүүх батална

65.2. Үл хөдлөх эд хөрөнгийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн тогтоосон аргаар худалдан борлуулна.

#### **66 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах газар**

66.1. Дуудлага худалдааг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны байранд, эсхүл шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн шийдвэр, талуудын хүсэлтээр өөр газарт явуулж болно.

66.2. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

66.3. Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрыг цахим дуудлага худалдаагаар худалдан борлуулах тохиолдолд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны газрын бирж цахимаар худалдан борлуулалж болно.

#### **67 дугаар зүйл. Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ**

67.1. Дуудлага худалдааны доод үнийг Иргэний хуулийн 177 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

#### **68 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрт барьцааны үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулахаар заасан үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдан борлуулах**

68.1. Шүүхийн шийдвэрт барьцааны үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөрийн шаардлагыг хангуулахаар заасан бол үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх шийдвэр гаргахгүйгээр үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг тогтоосны дараа шийдвэр гүйцэтгэлийн шүүгч дуудлага худалдааг явуулах тухай захирамж гаргана. Иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ тухай мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад цахим сүлжээгээр нэн даруй хүргүүлнэ.

68.2. Барьцаалуулсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болон барьцаагаар баталгаажсан шаардлага бүхий төлбөр авагч хамтран хүсэлт гаргасан, мөн тухайн эд хөрөнгөд эрх бүхий бусад этгээдийн саналыг харгалзан үзээний үндсэн дээр шийдвэр

гүйцэтгэлийн шүүгч худалдан борлуулах өөр аргыг тогтоож болно. Энэ тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын тусгай зөвшөөрөл бүхий этгээд, эсхүл барьцаа эзэмшигч банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан худалдан борлуулж болно.

68.3. Дуудлага худалдаа явагдах хүртэл хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн худалдан авагч болон барьцаагаар баталгаажсан шаардлага бүхий төлбөр авагч харилцан тохиролцож, барьцааны эрхийг хэвээр хадгалах, эсхүл худалдан авагч барьцаагаар баталгаажсан үүргийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар гаргуулж болох хэмжээгээр шилжүүлэн хүлээхээр бичгээр гэрээ байгуулж болно. Энэ тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн худалдан авах үнийг зохих хэмжээгээр бууруулна.

#### **69 дүгээр зүйл. Дуудлага худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшлуулах**

69.1. Төлбөр төлөгчийн хүсэлтээр төлбөр авагч дуудлага худалдааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулахыг зөвшөөрсөн тохиолдолд уг хүсэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгч шийдвэрлэнэ.

69.2. Энэ хуулийн 69.1-д заасан хугацаа өнгөрсний дараа төлбөр авагч дуудлага худалдааг үргэлжлүүлэн явуулах тухай хүсэлт гаргаагүй, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан тохиолдолд дуудлага худалдааг явуулахгүй.

69.3. Энэ хуулийн 69.1-д заасны дагуу дуудлага худалдааг хойшлуулсан бол үл хөдлөх эд хөрөнгийг хойшлуулах үед тогтоосон үнэлгээгээр дуудлага худалдаанд оруулна.

#### **70 дугаар зүйл. Дуудлага худалдааг нийтэд мэдээлэх**

70.1. Үл хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах тухай шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн захирамжийг иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудаст нэн даруй нийтэлнэ. Иргэний шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай гэж үзвэл бусад хэлбэрээр нийтэлж болно.

70.2. Талууд, үл хөдлөх эд хөрөнгөд өмчлөх болон бусад эрх бүхий этгээд өөрийн зардлаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр уг тогтоолыг нийтлэх, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчид мэдээлэх эрхтэй.

70.3. Үл хөдлөх эд хөрөнгийг борлуулах тухай шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн захирамжийг талуудад, шаардлага тэргүүн ээлжид хангуулах эрхтэй буюу төлбөр авагчтай адил дарааллын эрх бүхий этгээдэд, тухайн эд хөрөнгөд эрх, давуу эрх, эсхүл бусад хууль ёсны эрхээ бүртгүүлсэн этгээдэд, мөн эрх бүхий татварын байгууллагад тус тус хүргүүлнэ.

70.4. Энэ хуулийн 70.1-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудаст нийтэлснээс хойш 30 хоногийн дараа дуудлага худалдааг зохион байгуулна.

70.5. Энэ хуулийн 70.1-д заасан дуудлага худалдааг олон нийтэд мэдээлэхэд хөрөнгийн үнэлгээ, байршил, зориулалт, ашиглалтад орсон хугацаа, давхарын мэдээлэл, орчны нийтийн зориулалттай зам, сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн талаарх

мэдээлэл, дуудлага худалдааны дуудах доод үнэ болон хөрөнгийн фото зургийг хавсаргана.

#### **71 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг үзүүлэх**

71.1. Энэ хуулийн 70.1-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудаст нийтэлсний дараа иргэний шийдвэр гүйцэтгэгч нь уг үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авах сонирхолтой этгээдэд үзүүлэх өдөр, цагийг тогтооно. Энэ тухайгаа төлбөр авагч болон төлбөр төлөгчид мэдэгдэнэ.

71.2. Үндэслэл бүхий шалтгаанаар худалдан авах сонирхолтой этгээдийн хүсэлтээр тогтоосон хугацаанаас өөр цагт үл хөдлөх эд хөрөнгийг үзүүлэхийг иргэний шийдвэр гүйцэтгэгч зөвшөөрч болно. Ийм тохиолдолд нэмэлт зардлыг хүсэлт гаргасан этгээд харьцулна.

71.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг саадгүй үзүүлэх нөхцөлийг хангана. Төлбөр төлөгч, эсхүл бусад этгээд үзлэгт саад учруулсан бол иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргаж тухайн этгээдийг үзлэг хийх хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөхийг даалгана. Шаардлагатай бол уг тогтоолыг цагдаагийн байгууллагын дэмжлэгтэйгээр албадан гүйцэтгэнэ.

71.4. Энэ хуулийн 71.3-т заасан саад учруулсан этгээдэд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч энэ хуульд заасан торгууль оногдуулна.

#### **72 дугаар зүйл. Дуудлага худалдааны оролцогч**

72.1. Дуудлага худалдаанд талууд оролцож болох бөгөөд дараах этгээд оролцож үл болно:

72.1.1. Гүйцэтгэх хуудас олгосон шүүгчийн шүүгч болон шийдвэр гүйцэтгэлийн шүүгч, харьцсан иргэний шийдвэр гүйцэтгэгч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд;

72.1.2. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг үнэлсэн үнэлгээчин, эсхүл шинжээч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд.

72.2. Дуудлага худалдаагаар албадан борлуулах үл хөдлөх эд хөрөнгө нь Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газар бол дуудлага худалдаанд зөвхөн Монгол Улсын иргэн оролцоно.

#### **73 дугаар зүйл. Дуудлага худалдаанд оролцох дэнчин**

73.1. Дуудлага худалдаанд урьдчилан тогтоосон хугацаа, журмын дагуу дэнчин төлсөн оролцогч оролцоно.

73.2. Дэнчингийн хэмжээ нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэнэ.

73.3. Дараах тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй:

73.2.1. Ялагч төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй, эсхүл дараагийн өндөр үнийн санал гаргагч, эсхүл гуравдугаар байрт орсон этгээд ялагчид тооцсоны дараа тухайн ялагчид тооцогдсон этгээд төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол;

75.3.Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх хугацаа нь дуудлага худалдаа явагдснаас хойш 30 хоногоос хэтрэхгүй байна. Үнийг нэг удаа, эсхүл хувааж төлөхөөс үл хамааран уг хугацаа хэтрэхгүй байна.

75.4.Дуудлага худалдааны ялагч худалдаж авсан эд хөрөнгийн үнийг энэ хуулийн 75.3-т заасан хугацаанд төлөх үүрэгтэй бөгөөд худалдаж авсан эд хөрөнгийн үнийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд байршуулна.

75.5.Тогтоосон хугацаанд дуудлага худалдааны үнийг төлөөгүй тохиолдолд дараагийн өндөр үнийн санал гаргагчийг ялагчид тооцож, шаардлагатай бол гуравдугаар байрт орсон оролцогчид энэ хуулийн 75.3-т зааснаас хэтрэхгүй хугацаа тогтоож, тухайн хугацаанд дараагийн өндөр үнийн санал гаргагч эд хөрөнгийн үнийг төлнө.

75.6.Энэ хуулийн 75.4-т зааснаар ялагчийн дараагийн өндөр үнийн санал гаргагч ялагчид тооцогдож, үнийг төлснөөр үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрх ялагчид шилжинэ.

#### **76 дугаар зүйл.Хоёр дахь дуудлага худалдаа зохион байгуулах**

76.1.Хоёр дахь дуудлага худалдааг дараах тохиолдолд явуулна:

76.1.1.дуудлага худалдаанд оролцогч бүртгүүлээгүй;  
76.1.2.энэ хуулийн 75.6-д заасан этгээд эд хөрөнгийн үнийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол.

#### **77 дугаар зүйл.Дуудлага худалдаагаар худалдан борлогдсон эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих**

77.1.Энэ хуулийн 75 дугаар зүйлд зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлснөөр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх тухай захирамжийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч гаргана.

77.2.Энэ хуулийн 77.1-д заасан өмчлөх эрхийг шилжүүлэх тухай захирамжид дараах мэдээллийг тусгана:

77.2.1.дуудлага худалдаанд ялагч болсон худалдан авагчийн овог, нэр;  
77.2.2.дуудлага худалдаагаар тогтсон худалдан авах үнэ;  
77.2.3.худалдан авах үнийг бүрэн төлсөн тухай баталгаа;  
77.2.4.өмчлөх эрх үүсэх болон шилжих эрх зүйн үндэслэл;  
77.2.5.үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд хийгдсэн дуудлага худалдааны тэмдэглэлийг хүчингүй болгох;

77.2.6.үл хөдлөх эд хөрөнгийг бодитоор эзэмшиж байгаа этгээдэд тогтоосон хугацаанд худалдан авагчид эзэмшлийг шилжүүлэх тухай даалгавар;

77.2.7.худалдан авагч эзэмшлийг олж авах хугацаа;  
77.2.8.үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулсны улмаас дуусгавар болох барьцааны эрхийн тухай мэдэгдэл;

77.2.9.үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулсны улмаас дуусгавар болох сервитут болон эрхийн бусад хязгаарлалт.

40

73.2.2.энэ хуулийн 73.2.1-д заасан этгээд хоёр дахь дуудлага худалдаанд оролцсон бол.

73.3.Энэ хуулийн 73.2-т зааснаас бусад тохиолдолд оролцогчийн байршуулсан дэнчинг дуудлага худалдаа дуусгавар болсны дараа нэн даруй буцаан олгоно.

73.4.Энэ хуулийн 75.2-т заасан дараагийн өндөр үнийн санал гаргагч ялагчаар бүртгүүлэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд дэнчинг нэн даруй буцаан олгоно.

#### **74 дүгээр зүйл.Дуудлага худалдаа зохион байгуулах**

74.1.Дуудлага худалдааны эрхлэн хөтлөгч төлбөр авагчийн нэр, төлбөрийн хэмжээ, үл хөдлөх эд хөрөнгийн талаар танилцуулга, үнэлгээний тайланг түүнийг битүүмжилсэн он, сар, өдөр, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг танилцуулна.

74.2.Барьцааны зүйл үл хөдлөх эд хөрөнгө бол битүүмжилсэн талаар танилцуулах зохицуулалт хамаарахгүй.

74.3.Дуудлага худалдааны эрхлэн хөтлөгч хөрөнгийн өсгөн дуудах үнийг хөрөнгийн үнийн дүнгийн 3 хувиас багагүй, дээд хэмжээ нь 10 хувиас ихгүй байхаар тогтоож, тэмдэглэлд тусгах ба анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцно.

74.4.Сүүлийн үнэ хэлэхийг зарлана. Тухайн үнийн саналыг дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч хүлээж аваагүй бол саналыг хүчингүйд тооцно.

74.5.Дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч сүүлийн үнэ зарлаж гурван удаа дуудсаны дараа дуудлага худалдаа дуусгавар болно.

74.6.Үл хөдлөх эд хөрөнгө борлогдсон тохиолдолд төлбөрийн шаардлагыг хангах хэмжээний мөнгө болон дуудлага худалдааны зардлыг тооцон суутгаж, шийдвэр гүйцэтгэх албаны дансанд байршуулна.

74.8.Дуудлага худалдаа дуусгавар болсноос хойш ажлын 2 өдрийн дотор дуудлага худалдаа хууль бус явагдсан гэж үзвэл гомдлыг энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргана. Энэ тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэх үндэслэл болохгүй.

74.9.Эд хөрөнгийн үнэлгээний асуудлаар дуудлага худалдаа явагдсаны дараа дахин, эсхүл нэмэлт үнэлгээний хүсэлт гаргаж үл болно.

#### **75 дугаар зүйл.Ялагч, дараагийн өндөр үнийн санал гаргагч**

75.1.Хамгийн өндөр үнийг санал болгосон этгээдийг ялагч гэнэ.

75.2.Дараагийн өндөр үнийн санал гаргагчид энэ хуулийн 75.3-т заасан үр дагаврыг танилцуулж, зөвшөөрсөн тохиолдолд дэнчинг энэ хуулийн 73.3-т заасны дагуу олгохгүй.

39

77.2.10. худалдан авагчийн өмчлөх эрхийг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэх тухай даалгавар;

77.2.11. үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулсны улмаас дуусгавар болсон, худалдан авагч шилжүүлэн аваагүй эрх, хязгаарлалтыг улсын бүртгэлээс хасах тухай даалгавар;

77.2.12. үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөх хугацаа.

77.3. Энэ хуулийн 77.1-д заасан шүүгчийн захирамжийг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэнэ. Дуудлага худалдаагаар үл хөдлөх эд хөрөнгийн хамт борлуулсан бусад эд зүйлсийн өмчлөх эрх мөн худалдан авагчид шилжинэ.

77.4. Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлогдсон мөчөөс эхлэн төлбөр төлөгч тухайн эд хөрөнгийг эзэмших эрхээ алдана. Өмчлөх эрхийг худалдан авагчид шилжүүлэх тухай захирамжийг гардуулснаас хойш, хуульд өөрөөр заагаагүй буюу худалдан авагчтай өөрөөр тохиролцоогүй бол үл хөдлөх эд хөрөнгийг нэн даруй худалдан авагчид шилжүүлнэ.

#### **78 дугаар зүйл. Төлбөр төлөгч болон бусад этгээдийг албадан гаргах**

78.1. Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг худалдан авагчид шилжүүлэх тухай захирамж гарсны дараа худалдан авагчийн хүсэлтийн үндсэн дээр иргэний шийдвэр гүйцэтгэгч үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлүүлж, худалдан авагчид шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

78.2. Үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөх хугацаа нь 1 сараас хэтрэхгүй байна.

78.3. Төлбөр төлөгч болон бусад этгээд шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн тогтоосон хугацаанд төлбөр авагчид санал болгосон, эсхүл дуудлага худалдаагаар гуравдагч этгээдэд худалдан борлуулсан үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөөгүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч албадан гаргана.

78.4. Энэ хуулийн 78.3-т заасан албадан гаргах ажиллагааны зардлыг худалдан авагч урьдчилан гаргах бөгөөд уг зардлыг бодитоор эзэмшиж байсан, албадан гаргасан этгээдээс гаргуулна.

#### **79 дүгээр зүйл. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй үл хөдлөх эд хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах**

79.1. Үл хөдлөх эд хөрөнгө улсын бүртгэлд бүртгэгдээгүй бол холбогдох нотлох баримтыг хавсаргасан төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч холбогдох баримтыг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн байгууллагад даруй хүргүүлж, бүртгүүлнэ.

79.2. Төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч буюу бусад этгээдээс бүртгэлгүй өмчлөх эрхийг нотлох баримтыг гаргаж өгөхийг шаардаж, биелүүлээгүй тохиолдолд энэ хуульд заасан торгуулийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч оногдуулах тухай анхааруулна. Мөн иргэний шийдвэр гүйцэтгэлийн тогтоолд заасны дагуу холбогдох төрийн байгууллага холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

41

79.3. Улсын бүртгэлд бүртгэх боломжгүй үл хөдлөх эд хөрөнгөнд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж, түүнийг худалдах нөхцөлд уг эд хөрөнгө нь бүртгэлгүй өмчлөлд хамаарахыг онцлон тэмдэглэнэ. Энэ тохиолдолд бүртгэлийн тэмдэглэл хийхийн оронд эд хөрөнгийн үзлэг, тооллогыг явуулна.

#### **80 дугаар зүйл. Худалдан борлогдоогүй үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид санал болгох**

80.1. Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй эд хөрөнгийг үнэлээний тайлангаар үнэлэгдсэн үнээр төлбөр авагчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг хасаж, төлбөртөө суутган авахыг санал болгоно.

80.2. Энэ хуулийн 80.1-д заасны дагуу санал болгосон хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй, эсхүл төлбөр гаргуулах өөр хэрэгсэл, шийдвэр гүйцэтгэх зүйлийн талаар санал гаргаагүй бол тухайн үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгчид буцааж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа төлбөр төлөгчийн бусад эд хөрөнгийн хувьд үргэлжилнэ.

80.3. Энэ хуулийн 80.1-д заасны дагуу санал болгосон хөрөнгө нь шүүхийн шийдвэрээр төлбөрт гаргуулахаар заасан барьцааны хөрөнгө бол төлбөр авагч шүүхийн бус журмаар худалдан борлуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болно.

80.4. Худалдан борлогдоогүй хөрөнгийн үнэ гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлагаас илүү дүнтэй бол төлбөр авагч үнийн дүнгийн зөрүүг төлснөөр худалдан борлогдоогүй хөрөнгийг хүлээн авах эрх нээгдэнэ.

#### **81 дүгээр зүйл. Албадан удирдлага**

81.1. Төлбөр авагчийн хүсэлтээр гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг албадан удирдлагыг хэрэгжүүлэгчид иргэний шийдвэр гүйцэтгэгч шилжүүлж болно.

81.2. Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах албадан удирдлагыг хэрэгжүүлэхдээ төлбөр төлөгчөөс үл хөдлөх эд хөрөнгийг албадан чөлөөлөлтөөр чөлөөлүүлж хэрэгжүүлнэ. Албадан чөлөөлүүлэх хугацаа албадан удирдлага хэрэгжүүлэгчид шилжүүлсэн энэ хуулийн 81.1-д заасан шийдвэр гарснаас хойш нэг сар байна.

81.3. Албадан удирдлагад шилжүүлэхэд төлбөр төлөгч тухайн үл хөдлөх эд хөрөнгөд амьдарч байгаа бол тухайн үл хөдлөх эд хөрөнгийн нэг өрөөг нь хөлсөлж болно. Энэ тохиолдолд орон сууц хөлсөлсний төлбөрийг албадан удирдлагыг хэрэгжүүлэгчид төлнө.

81.4. Төлбөр төлөгч, эсхүл хамт амьдарч байгаа этгээд үл хөдлөх эд хөрөнгийн удирдлагад саад учруулбал, төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийг үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөхийг үүрэг болгоно.

81.5. Үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, эзэмшихээс олох орлого нь түүнийг эзэмших, ашиглахтай холбогдон гарах зардлаас их байх тохиолдолд тухайн үл хөдлөх эд хөрөнгийг албадан удирдлагад шилжүүлнэ.

42

81.6. Албадан удирдлагыг хэрэгжүүлснээр олох орлого, ашгаас энэ хуулийн 82.2-т заасан зардлыг хассан дүнгээр төлбөр төлөгчийн төлбөл зохих мөнгөн дүнгээс хасагдаж, төлбөр авагчид тухай бүр шилжинэ.

#### **82 дугаар зүйл.-Албадан удирдлага хэрэгжүүлэгчийг томиллох**

82.1. Албадан удирдлага хэрэгжүүлэгчийг иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

82.2. Энэ хуулийн 82.1-д заасан албадан удирдлага хэрэгжүүлэгчид үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлж, эзэмшиж, ашиглах эрх олгох бөгөөд ажлын хөлсийг албадан удирдлага хэрэгжүүлэгчид үл хөдлөх эд хөрөнгийг ашигласнаас олсон орлогоос төлнө.

82.3. Энэ хуулийн 82.1-д заасан албадан удирдлага хэрэгжүүлэгч нь энэ талаарх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байж болно.

82.4. Төлбөр авагчийг албадан удирдлага хэрэгжүүлэгчээр томилвол иргэний шийдвэр гүйцэтгэгч ажиллагаанд хяналт тавина.

82.5. Хэрэв төлбөр авагч албадан удирдлага хэрэгжүүлэгчийн үүргээ зөрчвөл иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийг үүргээ зөрчихгүй байхыг сануулж, дахин үүргээ зөрчвөл албадан удирдлага дуусгавар болох үндэслэл болно.

#### **83 дугаар зүйл.-Албадан удирдлага хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа**

83.1. Албадан удирдлага хэрэгжүүлэгч нь тухайн эд хөрөнгийн эдийн засгийн ач холбогдлыг хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, зохистойгоор ашиглахыг баталгаажуулах үүрэгтэй.

83.2. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг албадан удирдлагад шилжүүлэхээс өмнө хөлслөгч, түрээслэгчид шилжүүлсэн байсан бол тухайн хөлслөх, эсхүл түрээслэх гэрээ нь албадан удирдлагыг хэрэгжүүлэгчтэй байгуулагдсанд тооцож болно.

83.3. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг эзэмшиж, ашигласнаас бий болох үр шимийг төлбөрт суутган авч, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдон гарах бүх зардлыг төлбөрөөс суутган төлнө.

#### **84 дүгээр зүйл.-Албадан удирдлага дуусгавар болох**

84.1. Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг бүрэн хангасан, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлснээр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах боломжгүй болох нь тодорхой болсон бол албадан удирдлага иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрээр дуусгавар болно.

84.2. Төлбөр авагч үр шимийг санаатайгаар бууруулсан, нуун далдасан, эсхүл үр шим гарахгүй байх нөхцөл байдлыг санаатайгаар бүрдүүлсэн нь тогтоогдсон бол үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх тухай шийдвэрийг хүчингүйд тооцно.

84.3. Энэ хуулийн 84.2-т заасан нөхцөл байдал бий болсон гэж үзвэл төлбөр төлөгч энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гомдол гаргаж болно.

84.4. Төлбөр авагчаас бусад албадан удирдлага хэрэгжүүлэгч үр шимийг санаатайгаар бууруулсан, нуун далдасан, эсхүл үр шим гарахгүй байх нөхцөл байдлыг санаатайгаар бүрдүүлсэн нь тогтоогдсон бол үл хөдлөх эд хөрөнгөд албадан удирдлага хэрэгжүүлэгч томилсон шийдвэрийг төлбөр авагчийн хүсэлтээр өөрчилж, өөр этгээдийг томилж болно.

84.5. Албадан удирдлагыг дуусгавар болгож, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах хүсэлтийг төлбөр авагч хэдийд ч гаргах эрхтэй.

#### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨД ЯВУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГАА**

#### **85 дугаар зүйл. Хөдлөх эд хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

85.1. Хөдлөх эд хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь биет хөдлөх эд хөрөнгөд, биет бус хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаанаас бүрдэнэ

85.2. Төлбөр авагчийн шаардлага болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал хангагдсан бол хөдлөх эд хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахгүй.

85.3. Төлбөр авагч төлбөр төлөгчийн хөдлөх эд хөрөнгийн байршлын талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдээлэл гаргаж болно.

85.4. Худалдан борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийг үнэлэгдсэн үнээр тооцон төлбөр авагчид шилжүүлж болно.

#### **86 дугаар зүйл. Биет хөдлөх эд хөрөнгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

86.1. Биет хөдлөх эд хөрөнгийг хураах тухай тогтоол гаргаж, иргэний шийдвэр гүйцэтгэгч, эсхүл гуравдагч этгээдийн эзэмшилд шилжүүлснээр авснаар хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаа эхэлнэ.

86.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч хураан авсан эд хөрөнгийн төрөл, шинж байдал, тоо, ширхэгийн мэдээллийг хураах тухай тогтоолд тусгана.

86.3. Энэ хуулийн 86.1-д заасны дагуу хураах тогтоол үйлдэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэгч тухайн хөдлөх эд хөрөнгийг үнэлж болох бөгөөд энэ тохиолдолд тэмдэглэл үйлдэнэ.

86.4. Хурдан борлогдох, бусдын эрх бүртгэгдээгүй, түргэн муудаж үнэ цэнээ алдахгүй хөдлөх эд хөрөнгөөс эхлэн тооллого хийж бүртгэн авна.

86.5. Энэ хуулийн 86.2-т заасны дагуу хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээллийг хураах тухай тогтоолд тусгахдаа тухайн хөдлөх эд хөрөнгөд бусдын эрх байгаа эсэх талаар талууд болон гуравдагч этгээдийн гаргасан тайлбар, нотлох баримтыг харгалзан үзнэ.

86.6. Хураах тухай тогтоол гаргах үед мэдэгдээгүй боловч уг тогтоолыг гаргасны дараа аливаа гуравдагч этгээд төлбөр төлөгчийн эзэмшилд байгаа хөдлөх эд хөрөнгөд

холбогдох эрхтэй гэж үзвэл энэ талаар хураах тухай тогтоолыг гардуулснаас хойш 30 хоногийн дотор иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, энэ талаар нотлох үүрэгтэй. Энэ хугацаанд мэдэгдээгүй, нотлоогүй бол тухайн хөдлөх эд хөрөнгөд гуравдагч этгээдийн эрх байхгүй буюу төлбөр төлөгчийг өмчлөгч гэж үзнэ.

86.7. Энэ хуулийн 86.3-т заасан хураах тухай тогтоолын тэмдэглэлд хөдлөх эд хөрөнгөд үнэлгээ хийсэн иргэний шийдвэр гүйцэтгэгчийн нэр, тооллого, үнэлгээ хийхэд байцсан этгээдийн нэр, тооллого, үнэлгээг хийсэн огноо, төлбөр гаргуулах мөнгөн дүн, хугацаа, хөдлөх эд хөрөнгийн төрөл, шинж чанар, төлөв байдал, тоо хэмжээ зэрэг мэдээлэл, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон бусад этгээдийн тайлбар, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулахуйц гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрхийн тухай тусгана.

86.8. Хураах тухай тогтоолыг эд зүйл, баримт бичгээ хураалгасан төлбөр төлөгч, эсхүл уг ажиллагаанд байцсан хүний гарын үсэг, хурууны хэзгээр, эсхүл цахим хэрэгслээр баталгаажуулж хувийг тухайн эд зүйлийг өмчлөгчид, эсхүл түүний төлөөлөгчид нэн даруй гардуулна. Төлбөр төлөгч хураах тогтоолыг баталгаажуулахаас татгалзсан тохиолдолд энэ тухай тэмдэглэлд тусгана.

86.9. Хураан авах ажиллагаанд эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг оролцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

86.10. Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валют, үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр бүтээсэн эд өлгийн зүйл, түүх, соёлын бусад үнэт зүйл, бусад үнэт зүйлийг энэ зүйлд заасан үндэслэл, журмын дагуу хураана.

86.11. Үндэсний мөнгөн тэмдэгт, гадаад валютыг хураан авснаас хойш 24 цагийн дотор иргэний шийдвэр гүйцэтгэх албаны банканд дахь дансанд, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны үнэ бүхий эд зүйл хадгалах тусгай зориулалтын байранд нэн даруй шилжүүлнэ.

86.12. Хураасан хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгч болон тухайн эд хөрөнгийг эзэмшиж байгаа этгээд захиран зарцуулах эрхгүй бөгөөд уг хориглолтыг зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **87 дугаар зүйл. Хөдлөх эд хөрөнгөд үнэлгээ хийх**

87.1. Энэ хуулийн 86.3-т заасан тохиолдолд үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд, иргэнээс авсан бичгээр гаргасан үнийн мэдээлэлд үндэслэн хийж болно.

87.2. Талууд үнэлгээнээр үнэлгээ хийлгэх санал гаргаж болно.

87.3. Талууд үнэлгээнчийг гаргасан үнэлгээний тайланг хүлээн зөвшөөрөхгүй бол анхны тайланг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу өөр үнэлгээнээр дахин үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болно. Дахин үнэлгээг ажлын долоо хүртэл өдрийн дотор хийж дуусгах бөгөөд уг үнэлгээний тайлан эцсийнх байна.

87.4. Талууд бичгээр тохиролцож, эд зүйлийн үнэлгээг тогтоож болно.

87.5. Энэ хуулийн 87.3-т заасан дахин үнэлгээ хийлгүүлэх хүсэлт гаргасан тал холбогдох зардлыг хариуцна.

#### **88 дугаар зүйл. Хураасан хөдлөх эд хөрөнгийг хадгалах журам**

88.1. Хураан авсан хөдлөх эд хөрөнгө нь тээвэрлэхэд хүндрэлтэй бол пацдаж, төлбөр төлөгчийн хадгалалтад үлдээж болно.

88.2. Энэ хуулийн 88.1-д зааснаас бусад тохиолдолд хураан авсан хөдлөх эд хөрөнгийг хадгалалтын гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдэд хадгалуулах, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх албаны тусгайлсан байранд хадгалж болно.

88.3. Мал, амьтныг хамгаалалт, хадгалалт, тэжээл, арчилгаа, саалийн зэрэг шаардлагатай нөхцөл хангагдсан хашаа, саравч, эсхүл түүнтэй адилтгах байгууламжид байрлуулна.

88.4. Хөдлөх эд хөрөнгийг хураан авч, хадгалалтад шилжүүлэхийн өмнө иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хадгалалтын шаардлага хангагдсан эсэхийг шалгаж, энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

88.5. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хураан авсан хөдлөх эд хөрөнгийг хадгалуулах газарт хүргэж, шилжүүлэн өгнө. Энэ талаар тэмдэглэл үйлдэж, хадгалалтад хүлээн авсан этгээд гарын үсэг зурна.

88.6. Энэ хуулийн 89.4, 89.6-д заасан өөр аргаар худалдах, эсхүл шууд худалдах үед худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд тухайн эд хөрөнгийг өөрөө тээвэрлэсэн бол иргэний шийдвэр гүйцэтгэгч дагалдан явахгүй. Энэ тохиолдолд холбогдох хөдлөх эд хөрөнгийг түүний хадгалалтад шилжүүлсэн тухай тэмдэглэлд тусгана.

88.7. Хадгалалтын зардлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд тооцох бөгөөд уг зардлыг төлбөр төлөгчөөс гаргуулна.

#### **89 дүгээр зүйл. Хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулах арга**

89.1. Хөдлөх эд хөрөнгийг энэ хуульд заасны дагуу хураах тухай тогтоол үйлдэж, Иргэний хуульд заасан үнэ хаялцуулах ажиллагаагаар худалдан борлуулна.

89.2. Энэ хуулийн 89.1-д заасан үнэ хаялцуулах ажиллагааг цахимаар явуулж болно.

89.3. Хөдлөх эд хөрөнгийг цахимаар үнэ хаялцуулах ажиллагаа явуулах журмыг Улсын дээд шүүх батална.

89.4. Төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу иргэний шийдвэр гүйцэтгэгч хураасан хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 88.1-д зааснаас өөр аргаар борлуулж болно. Энэ тохиолдолд худалдан борлуулсны хөлсийг худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдтэй тохиролцож, худалдуулж болно.

89.5.Энэ хуулийн 89.4-т заасан худалдан борлуулсны хөлсийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд тооцно.

89.6.Түргэн муудах зүйл, эсхүл бижээр худалдаалагдах боломжтой хөрөнгийг хураан авсны дараа нэн даруй худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж худалдан борлуулж болно.

89.7.Хөдлөх эд хөрөнгөд үнэлгээ хийснээс хойш 30 хоногийн дараа үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулах бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтоосон хугацаанд үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулаагүй бол төлбөр авагч энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гомдол гаргаж болно.

89.8.Төлбөр төлөгч, эсхүл төлбөр төлөгч төлбөр авагчийн гаргасан саналыг хүлээн авсан тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 88.7-д заасан хугацаанаас өмнө хөдлөх эд хөрөнгийг албадан борлуулж болно.

89.9.Хурдан гэмтэж муудах, чанараа алдах бараа, материал, эд зүйлийг төлбөр төлөгч энэ хуульд заасан гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг сайн дураар биелүүлэх хугацааг дуусахаас өмнө худалдан борлуулж болно.

89.10.Төлбөр төлөгч энэ хуулийн 89.9-д заасны дагуу тухайн бараа, эд зүйлийг сайн дураар худалдан борлуулаагүй тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч бараа, эд зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулна.

#### **90 дүгээр зүйл. Үнэ хаялцуулах ажиллагаа явуулах газар**

90.1.Үнэ хаялцуулах ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны байранд, эсхүл цахимаар гүйцэтгэж болно.

90.2.Талууд үнэ хаялцуулах ажиллагаа явуулах газрыг хэлэлцэн тохиролцож болно.

#### **91 дүгээр зүйл. Ялагч**

91.1.Хамгийн өндөр үнэ амласан оролцогчийн нэр, худалдан авсан үнийг зарласнаар үнэ хаялцуулах ажиллагааг амжилттай болсныг хүлээн зөвшөөрнө. Тухайн хөдлөх эд хөрөнгийн үнийг төлснөөр ялагч өмчлөгч болно.

91.2.Хөдлөх эд хөрөнгийн үнийг төлбөл зохих өдөр ялагч үнийг төлөөгүй бол хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна.

91.3.Анхны дуудлага худалдаанд хамгийн өндөр үнэ амласан худалдан авагчийг дараагийн дуудлага худалдаанд оролцуулахгүй бөгөөд хэрэв хоёр дахь дуудлага худалдаагаар тухайн эд хөрөнгө анхны дуудлага худалдаанаас бага үнийн санал авбал тухайн үнийг зөрүүг эхний дуудлага худалдаанд өндөр үнэ амласан оролцогчоор төлүүлнэ.

91.4.Үнэ хаялцуулах ажиллагаагаар худалдан борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад гарсан зардлыг хасаж, үнэлээний үнээр төлбөртөө тооцон авахыг санал болгоно. Төлбөр авагч татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид буцаана.

47

91.5.Үнэ хаялцуулах ажиллагаатай холбогдуулан талууд болон худалдан авагч энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гомдол гаргаж болно.

#### **92 дугаар зүйл. Худалдан авагчийн эрх, үүрэг**

92.1.Үнэ хаялцуулах ажиллагаагаар үнийн санал гаргасан оролцогчдын овог, нэр эсхүл хуулийн этгээдийн нэрийг хамгийн өндөр санал гаргаснаас эхлэн дарааллаар нь тусгана.

92.2.Хамгийн өндөр үнийн санал гаргасан оролцогч тогтоосон хугацаанд санал болгосон үнийг төлөөгүй бол эд хөрөнгийг дараагийн байр эзэлсэн оролцогчид, мөн тэр нь төлөөгүй бол гурав дахь оролцогчид, цаашлаад жагсаалтын сүүлийн оролцогч хүртэл дарааллаар шилжүүлэн олгохоор тогтоолд заана.

92.3.Ялагч, боломжгүй бол энэ хуулийн 92.2-т заасан дараагийн байр эзэлсэн оролцогч нь дуудлага худалдаа, эсхүл шууд худалдах ажиллагаа дуусмагц худалдан авах үнийг байршуулж, эд зүйлийг даруй хүлээн авна.

92.4.Хэрэв аль ч оролцогч тогтоосон хугацаанд санал болгосон үнийг төлөөгүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч дуудлага худалдааг амжилтгүй болсонд тооцно.

92.5.Энэ хуулийн 92.3-т заасан этгээд худалдан авах үнийг бүрэн шилжүүлсэн нөхцөлд эд зүйлийг өөрийн эзэмшилд хүлээн авсан мөчөөс эхлэн өмчлөх эрх түүнд шилжинэ.

92.6.Худалдан авагч нь эд зүйлийн биет болон эрх зүйн доголдолтой холбоотой гомдол гаргах, түүнтэй холбоотой хариуцлагын шаардлага гаргах эрхгүй.

#### **93 дугаар зүйл. Биет бус хөдлөх эд хөрөнгө болон соёлын өвд хамаарах үнэт зүйлд явуулах ажиллагаа**

93.1.Соёлын өвд хамаарах үнэт зүйл, эдийн бус хөрөнгө болох оюуны өмч, тусгай зөвшөөрлийг худалдан борлуулахаас өмнө заавал үнэлүүлнэ. Эдгээр төрлийн биет бус хөдлөх эд хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур худалдан борлуулж үл болно.

#### **ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ШААРДАХ ЭРХЭД ЯВУУЛАХ ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА**

**94 дүгээр зүйл. Шаардах эрхэд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

94.1.Төлбөр авагчийн саналаар энэ хуулийн 95 дугаар зүйлд заасан төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгчийн талаарх мэдүүлэгт үндэслэн төлбөр төлөгчийн гуравдагч этгээдээс шаардах эрхийг төлбөр авагчид шилжүүлж болно. Ингэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд гуравдагч этгээд шаардах эрхийн шаардлагыг шилжүүлнэ.

94.2.Энэ хуулийн 94.1-д заасны дагуу төлбөр авагч зөвшөөрөхгүй бол уг шаардах эрхийг үнэ хаялцуулах ажиллагаагаар худалдан борлуулна.

94.3.Шаардах эрхийг төлбөр авагчид дараах тохиолдолд шилжүүлэхгүй:

48

шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэх буюу төлбөрийн үүргийг хэсэгчлэн гүйцэтгэхээр бол гүйцэтгэх баримт бичигт заасан үнийн дүнд хүртэл үргэлжлүүлэн шилжүүлнэ.

96.3. Үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээд нь энэ хуулийн 96.1-д заасан шийдвэрийг хүлээн авах үед төлбөрийн үүргээ гүйцэтгэх хугацаа болоогүй бол үүрэг гүйцэтгүүлэгч-төлбөр төлөгчөөс төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүртэл, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэчийн шийдвэрээр гэрээ, хэлцлийн дагуу үүссэн төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхийг төлбөр авагчид шилжүүлэх тухай шийдвэр гарах хүртэл гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгохыг хориглоно.

**97 дугаар зүйл. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажсан шаардах эрх**

97.1. Ипотек, барьцаагаар баталгаажсан бөгөөд улсын бүртгэлд бүртгэгдсэн шаардах эрхийг төлбөр гаргуулах зорилгоор шилжүүлэх бол шийдвэр гүйцэтгэчийн хүсэлтээр эрх бүхий байгууллага тухайн шилжүүлгийг улсын бүртгэлд бүртгэнэ.

97.2. Шаардах эрхийг шилжүүлэн авснаар төлбөр авагч нь уг авлагад холбогдох барьцаа, ипотекийн эрхийг хамтад нь шилжүүлэн авч, өмнөх эрх эзэмшигчийн дарааллын дагуу шаардлагаа хангуулах эрх эдэлнэ.

97.3. Хэрэв шаардах эрх нь эзэмшлийн барьцаагаар баталгаажсан бол гагцхүү барьцаалуулагч зөвшөөрсөн тохиолдолд төлбөр төлөгч барьцааны зүйлийг төлбөр авагчид шилжүүлнэ.

97.4. Төлбөр төлөгч барьцааны зүйлийг шилжүүлэхээс татгалзвал уг хөрөнгийг хураан авч, эзэмшлийг төлбөр авагчид шилжүүлнэ.

97.5. Төлбөр төлөгчийн шаардах эрхэд батлан даалт, баталгаа гаргасан этгээд нь баталгаагаар хангагдсан авлагын баталгаа гаргагч, батлан даагч хэвээр байна.

**98 дугаар зүйл. Нөхцөлтэй үүргийг биелүүлэх**

98.1. Шаардах эрхийн төлбөрийг төлөх төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэчийн үүрэг нь төлбөр төлөгч тодорхой эд зүйлийг хүлээлгэн өгөхөөс хамаарах бөгөөд уг үүрэг хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр гаргуулах зорилгоор шаардах эрх шилжүүлэн авсан төлбөр авагчийн саналын дагуу тухайн эд зүйлийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгөхийг төлбөр төлөгчид даалгана. Иргэний шийдвэр гүйцэтгэгч уг эд зүйлийг төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

98.2. Төлбөр төлөгч тогтоосон хугацаанд эд зүйлийг хүлээлгэн өгөгүй бол төлбөр авагчийн хүсэлтээр хөдлөх эд хөрөнгө шилжүүлэн өгөх тухай шийдвэр гүйцэтгэх журамд заасны дагуу албадан шийдвэр гүйцэтгэл явуулна.

**99 дүгээр зүйл. Төлбөр авагч төлбөрийн шаардлагаас илүү мөнгөн дүн гаргуулах**

99.1. Шаардах эрхээс төлбөр авагч өөрийн хангагдах хэмжээнээс илүү дүн гаргуулсан бол илүү гарсан дүнг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд байршуулна.

94.3.1. шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан;  
94.3.2. үүрэг гүйцэтгэгч гадаад улсад оршин сууж байгаа бөгөөд гэрээ байгуулах боломжгүй;

94.3.3. үүрэг гүйцэтгэчийн эсрэг дампуурлын хэрэг үүссэн;  
94.3.4. үүрэг гүйцэтгэгч хуулийн этгээд бол хуулийн этгээдийн бүртгэлээс хасагдсан буюу татан буугдсан.

**95 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэчийн мэдүүлэг**

95.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгчээс дараах мэдээллийг агуулсан мэдүүлэг ирүүлэхийг шаардна:

95.1.1. үүргийн шинж, агуулга буюу төлбөр төлөгчийн шаардах эрх;  
95.1.2. битүүмжилсэн шаардах эрхийг хүлээн зөвшөөрөх эсэх;  
95.1.3. шаардах эрхийг ямар хэмжээгээр хүлээн зөвшөөрөх, уг шаардлагыг биелүүлэхэд бэлэн эсэх;

95.1.4. төлбөрийн үүрэг нь өөр ямар нэгэн үүргийн биелэлтээс хамаарах эсэх.

95.2. Төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэчийн мэдүүлгийг иргэний шийдвэр гүйцэтгэгч хүлээн авснаас хойш тав хоногийн дотор төлбөр авагч болон төлбөр төлөгчид хүргүүлнэ.

95.3. Хэрэв төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгч мэдүүлгийг зохих хугацаанд ирүүлээгүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ тухай төлбөр авагчид мэдэгдэнэ.

95.4. Хэрэв төлбөр төлөгчийн шаардах эрхэд холбогдох бүртгэгдээгүй барьцааны эрх байгаа бол төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгч энэ талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

95.5. Төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэгч нь мэдүүлэг гаргаагүй, эсхүл буруу, худал, дутуу мэдүүлэг өгсний улмаас төлбөр авагчид учирсан хохирлыг хариуцна.

95.6. Төлбөр авагч нь төлбөр төлөгчийн үүрэг гүйцэтгэчийн буруутай үйлдлээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хэрэг хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэл гаргаж болно.

**96 дугаар зүйл. Гуравдагч этгээдээс шаардах эрхийг төлбөр авагчаас бусад этгээдэд шилжүүлэхийг хориглох**

96.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь гэрээ, хэлцлийн дагуу үүссэн хөрөнгийн шинжтэй үүргийг гүйцэтгүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэгч-төлбөр төлөгч болон үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээдийн хооронд байгуулсан гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, тухайн гэрээ, хэлцлийн дагуу үүссэн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхээ бусдад шилжүүлэхийг хориглох тухай шийдвэр гаргана.

96.2. Үүрэг гүйцэтгэгч-гуравдагч этгээд энэ хуулийн 96.1-д заасан шийдвэрийг хүлээн авсны дараа гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлагыг хангасан дүнг үүрэг гүйцэтгүүлэгч-төлбөр төлөгчид төлөх хугацаа нь болсон төлбөрөөс шүүхийн

99.2.Шийдвэр гүйцэтгэгч илүү гарсан дүнг тухайн шаардлагад барьцаагаар баталгаажсан бусад төлбөр авагч, мөн эрх нь байгаа бол төлбөр төлөгчид шилжүүлнэ.

#### **100 дугаар зүйл. Шаардах эрхийг шилжүүлэх**

100.1. Шаардах эрхийг төлбөр төлөгчийн төлбөрийн оронд шилжүүлэх замаар төлбөр авагчид шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнгийн хэмжээнд төлбөр төлөгчийн үүрэг хангагдсанд тооцно.

100.2. Хэрэв шилжүүлж буй шаардах эрх нь улсын бүртгэлд бүртгэгдсэн ипотека, эсхүл барьцааны эрхээр баталгаажсан бол иргэний шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар барьцааны эрхийг төлбөр төлөгчөөс төлбөр авагчид шилжүүлэх тухай бүртгэлийг хийлгэж, төлбөр төлөгчийн нэр дээр бүртгэгдсэн барьцааны эрхийг хүчингүй болгуулна.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ ҮНЭТ ЦААСАНД ХОЛБОГДОХ ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА**

#### **101 дүгээр зүйл. Үнэт цаасанд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

101.1. Үнэт цаасанд холбогдох иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үнэт цаасыг битүүмжлэх, холбогдох бүртгэлд тэмдэглэл хийх, үнэлэх, худалдах замаар явуулна.

101.2. Үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагаар дамжуулан нээлттэй зах зээлээр арилжих боломжгүй үнэт цаасыг төлбөр авагчийн хүсэлт, төлбөр төлөгчийн зөвшөөрлөөр битүүмжилсэн үнэт цаасыг төлбөрт тооцон төлбөр авагчид шилжүүлж болно.

101.3. Үнэт цаасанд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад тухайн хуулийн этгээдийн гэрээ, дүрэм, эсхүл бусад эрх зүйн актын дагуу хувьцаа, хувь оролцоог шилжүүлэхийг хязгаарласан, хориглосон нь хамаарахгүй.

#### **102 дугаар зүйл. Үнэт цаасыг битүүмжлэх**

102.1. Үнэт цаасыг битүүмжлэх тогтоол гаргасны дараа иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичиг болон тогтоолыг үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагаар дамжуулан нээлттэй зах зээлээр арилжих үнэт цаасны хувьд тус байгууллагад, хаалттай хувьцаат компанийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.2-т заасан үнэт цаасны хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад нэн даруй хүргүүлнэ. Үүнтэй нэгэн зэрэг гүйцэтгэх баримт бичиг, тогтоолыг тухайн компанид мөн хүргүүлнэ.

102.2. Битүүмжлэх тогтоолыг хүлээн авсан энэ хуулийн 102.1-д заасан байгууллага нь холбогдох үнэт цаасыг битүүмжилсэн талаарх тэмдэглэгээг бүртгэлд оруулна.

102.3. Энэ хуулийн 102.2-т заасан бүртгэлд дараах мэдээллийг оруулна:

102.3.1. Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, тогтоолыг үнэт цаасны бүртгэл хөтлөгч байгууллага болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж буй хуулийн этгээдэд хүргүүлсэн өдөр, цаг;

102.3.2. Шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг гаргасан шүүхийн нэр;

102.3.3. Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон тогтоолын дугаар, огноо;

102.3.4. Шийдвэр гүйцэтгэл явагдаж буй хуулийн этгээдийн нэр;

102.3.5. Шийдвэр гүйцэтгэлийн объект болох хувьцаа, хувь оролцооны

хэмжээ;

102.3.6. Төлбөр төлөгчийн овог, нэр, эсхүл хуулийн этгээдийн нэр;

102.3.7. Шаардлагын хэмжээ.

102.3. Энэ хуулийн 102.1-д заасан байгууллага нь бүртгэл хийсэн тухай, эсхүл бүртгэл хийх боломжгүй болсон шалтгааныг иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэнэ. Холбогдох хуулийн этгээд нь битүүмжлэх тогтоолын талаар томдол гаргах эрхгүй.

102.4. Үнэт цаасыг битүүмжилснээс хойш төлбөр төлөгч тухайн хувьцааг захиран зарцуулахыг хориглоно. Энэхүү хоригийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх иргэний болон эрүүгийн хариуцлагын талаар битүүмжлэх тогтоолд тэмдэглэнэ.

102.5. Гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд шаардлагатай бол үнэт цаасыг битүүмжилсэн тохиолдолд ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлаж болно. Энэ тохиолдолд ногдол ашиг хуваарилах эрх бүхий этгээдэд хуваарилсан ногдол ашгийг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.

#### **103 дугаар зүйл. Үнэт цаасыг үнэлэх, худалдах**

103.1. Үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагаар дамжуулан арилжих үнэт цаасыг битүүмжлэх тогтоол хүлээж авсан өдрийн тухайн бирж, зах зээл дээрх худалдах өдрийн нээлтийн болон хаалтын ханшийн дундаж үнээр борлуулна.

103.2. Үнэт цаасны арилжаа эрхлэгч байгууллагаар дамжуулан арилжих боломжгүй үнэт цаасыг энэ хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, энэ хуулийн үнэ хаялцуулах ажиллагаагаар худалдана.

103.3. Арилжааны үр дүнд бий болсон үнэт цаас, бусад хөрөнгө нь битүүмжлэгдсэнд тооцогдох бөгөөд арилжааг гүйцэтгэсэн этгээд арилжаа хийсэн тухай шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

103.4. Үнэт цаасыг битүүмжлэх болон худалдан борлуулах шийдвэрийг гүйцэтгэж байгаа хуулийн этгээд үнэт цаасыг хадгалах, худалдахад саад учрах аливаа тохиолдол бий болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэгч битүүмжлэгдсэн үнэт цаасыг хамгаалах зорилгоор хуульд заасан шаардлагатай арга хэмжээг холбогдох этгээдээр гүйцэтгүүлнэ.

103.5. Энэ хуулийн 103.4-т заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдээгүйгээс төлбөр авагчийн эрх ашиг зөрчигдөхөд хүрсэн, эсхүл тухайн үнэт цаасны зах зээлийн ханш унахад хүрсэн бол учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

105.5.Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн, хөрөнгө, орлогогүй, зургаан сараас доошгүй хугацаанд шүүхийн шийдвэрээр тогтоосон хүүхдийн тэтгэлийг төлөөгүй энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгчийн мэдээлэл нээлттэй байх бөгөөд төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгчийг хөдөлмөр эрхлэхэд зуучилж, хөрөнгө, орлогын байдалд иргэний шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина.

#### **106 дугаар зүйл. Төрөөс хүүхдийн тэтгэлэг төлөх**

106.1.Энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгчийн төлөх хүүхдийн тэтгэлийг тухайн бүс нутгийн амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр төрөөс Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24-т заасан хүүхдийн төлөө сангаас олгоно.

106.2.Төлбөр төлөгч хөдөлмөр эрхлэх, бусад эх үүсвэрээс орлого олох болсон тохиолдолд төрөөс төлсөн хүүхдийн тэтгэлийн дүнг түүнээс нөхөн гаргуулж, энэ хуулийн 106.1-д заасан санд холбогдох алдангийн хамт нөхөн төлүүлнэ.

### **АРАВДУГААР БҮЛЭГ ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ХӨРӨНГӨ, ОРЛОГООС ГАРГУУЛАХ**

#### **107 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны мөнгөн хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

107.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн мөнгөн төлбөрийн үүргийг хангуулах зорилгоор түүний банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны бүх мөнгөн хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж болно.

107.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь албан мэдэгдэл хүлээн авах цахим хаягийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх үүрэгтэй.

107.3.Иргэний шийдвэр гүйцэтгэгч банк, эрх бүхий хуулийн этгээд дэх төлбөр төлөгчийн дансны мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэр гаргаж, иргэний шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн хамт банк, эрх бүхий хуулийн этгээдэд нэн даруй цахим хэлбэрээр хүргүүлнэ.

107.4.Энэ хуулийн 107.3-т заасан цахим хэлбэрээр хүргүүлсэн мэдэгдлийг банк, эрх бүхий хуулийн этгээд хүлээн авсан даруй дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжилж, төлбөр төлөгч болон шийдвэрт нэр дурдсан бусад этгээдийн нэр дээр бүртгэлтэй дансны мэдээлэл, битүүмжилсэн дүнгийн талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэнэ.

107.5.Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан дүнг тухайн данснаас шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлэхийг банк, эрх бүхий хуулийн этгээдэд даалгана. Төлбөр төлөгчийн данснаас иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлэх мөнгөн хөрөнгө нь бусад этгээдэд хийх аливаа шилжүүлгээс давуу эрхтэй байна.

107.6.Энэ хуулийн 107.3-т заасан шийдвэрийг хүлээн авсан банк, эрх бүхий хуулийн этгээд нь иргэний шийдвэр гүйцэтгэгч битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгох

54

103.6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч битүүмжилсэн виртуал хөрөнгийг иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрээр тухайн өдрийн ханшаар худалдан борлуулна.

103.7.Үнэт цаас борлогдоогүй бол төлбөр авагчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад гарсан зардлыг хасаж, төлбөртөө тооцон авахыг санал болгоно. Төлбөр авагч саналаас татгалзсан, эсхүл хуульд заасан хугацаанд хариу ирүүлээгүй бол үнэт цаасыг төлбөр төлөгчид буцаан олгоно.

### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТЭЖЭЭН ТЭТГЭХ ҮҮРЭГ**

#### **104 дүгээр зүйл.Хүүхдийн тэтгэлийг гаргуулах**

104.1.Хүүхдийн тэтгэлийг төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос гадна шүүхийн шийдвэрт дурдсан мөнгөн болон бусад эд хөрөнгөөс гаргуулна.

104.2.Хүүхдийн тэтгэлийг төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлого, мөнгөн болон бусад эд хөрөнгөөс гаргуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа энэ хуульд заасны дагуу явуулна.

104.3.Төлбөр авагч зөвшөөрсөн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр, эсхүл нэг удаа мөнгөн болон эд хөрөнгөөр төлбөр төлөгчөөс гаргуулж болно.

104.4.Шүүхийн шийдвэрээр тогтоосон хүүхдийн тэтгэмжийн төлөгдөөгүй үлдэгдлийг хүүхэд насанд хүрсэн эсэхээс үл хамааран төлбөр төлөгчөөс гаргуулна.

104.5.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхээс өмнөх хугацааны хүүхдийн тэтгэлийн суутгалын талаар маргаан гарвад шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болно.

#### **105 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага**

105.1.Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй, хөдөлмөр эрхлэх чадвартай бөгөөд хөдөлмөр эрхлээгүй үндэслэлээр тогтоосон тэтгэлийг төлөөгүй, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зориуд саад учруулсан төлбөр төлөгчид энэ хуульд заасан торгууль оногдуулах, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

105.2.Тэжээн тэтгүүлэгч хүүхэд бусдад үрчлэгдсэн бол үрчлэлт үүсэхээс өмнөх хугацааны төлөгдөөгүй хүүхдийн тэтгэлийг төлбөр төлөгчөөс гаргуулна.

105.3.Хүүхдийн тэтгэлийг хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам энэ хуульд заасан алдангийг төлбөр төлөгчөөс гаргуулна.

105.4.Хүүхдийн тэтгэлийг хугацаанд нь төлөөгүй төлбөр төлөгчийг энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулж, энэ хуулийн 42.4-т заасан төлбөртэй этгээдийн бүртгэлд тавигдах хязгаарлалт тавигдана.

83

хүртэл төлбөр төлөгчид шинээр данс нээх болон төлбөр төлөгчөөс гаргасан аливаа төлбөрийн даалгаврын гүйлгээг гүйцэтгэхийг хориглоно.

107.7.Энэ хуулийн 107.6-д заасан хориглолт нь зөвхөн битүүмжлэх тогтоолд заасан дүнгээр хязгаарлагдана.

107.8.Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 107.4-т заасны дагуу мөнгөн хөрөнгийг битүүмжилж, энэ тухай иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдсэний дараа битүүмжлэх тогтоолд заасан дүнгээс илүү хэмжээгээр битүүмжилсэн нь тогтоогдвол иргэний шийдвэр гүйцэтгэгч илүү битүүмжилсэн хэсгийг нэн даруй цуцлах тухай мэдэгдлийг тухайн банк, эрх бүхий хуулийн этгээдэд хүргүүлнэ.

#### **108 дугаар зүйл.Хамтын үүрэг бүхий төлбөр төлөгчийн хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах**

108.1.Хоёр буюу түүнээс дээш төлбөр төлөгч хамтран үүрэг хүлээсэн бол төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан хэмжээгээр төлбөр төлөгчдийн дансыг битүүмжилнэ.

108.2.Хамтын үүрэг бүхий төлбөр төлөгчдийн бүх данснаас нэгэн зэрэг ижил хэмжээний дүнг суутгах замаар гаргуулна. Суутгасан нийт дүн нь төлбөр авагчийн шаардлагын хэмжээнээс хэтрэхгүй байна.

#### **109 дүгээр зүйл.Дансанд мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд авах арга хэмжээ**

109.1.Битүүмжлэх тогтоолд заасан дансанд мөнгөн хөрөнгө байхгүй бол банк, эрх бүхий хуулийн этгээд нь төлбөр төлөгчийн тухайн банк, байгууллагад эзэмшдэг бусад данснаас мөнгөн хөрөнгийг шилжүүлнэ.

109.2.Төлбөр төлөгчийн дансан дах хөрөнгө хүрэлцэхгүйгээс шаардлагыг бүрэн хангаж чадаагүй бол банк, эрх бүхий хуулийн этгээд нь энэ талаар тусгай бүртгэл хөтөлж, тухайн дансанд мөнгө орж ирсэн даруйд битүүмжлэх тогтоол, гүйцэтгэх баримт бичигт заасан дүнг шилжүүлнэ.

109.3.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь төлбөр төлөгчийн дансанд мөнгөн хөрөнгө байхгүй тухай иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж, тухайн дансны гүйлгээний мэдээллийг хавсаргана.

#### **110 дугаар зүйл.Төлбөр төлөгчийн хэд хэдэн дансанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах**

110.1.Төлбөр төлөгч нэг банк, эрх бүхий хуулийн этгээдэд хэд хэдэн данстай, эсхүл хэд хэдэн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данстай бол иргэний шийдвэр гүйцэтгэгч түүний бүх дансанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргаж, тухайн данс дахь мөнгөн хөрөнгийг битүүмжилнэ.

110.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчийн бүх банк, эрх бүхий хуулийн этгээдэд байгаа дансанд битүүмжлэл тогтоож, тухайн байгууллагуудад байгаа нийт үлдэгдлийн хэмжээнд харьцуулан хувь тэнцүүлэн суутгах аргыг сонгож болно.

#### **111 дүгээр зүйл.Гадаад валютын дансанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах**

111.1.Гадаад валютын дансыг битүүмжилсэн тохиолдолд төлбөр төлөгчийн тухайн данс дахь мөнгөн хөрөнгийг шилжүүлэг хийх өдрийн Монголбанкны албан ханшаар Монгол Улсын мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж бодно.

111.2.Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт шаардлагыг гадаад валютаар тогтоосон бөгөөд төлбөр төлөгч тухайн валютаар данстай бол банк, эрх бүхий хуулийн этгээдэд төлбөр авагчийн шаардлагын хэмжээгээр тухайн гадаад валютаар тооцож, шилжүүлнэ.

#### **112 дугаар зүйл.Хадгаламжийн дансанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах**

112.1.Төлбөр төлөгчийн хадгаламжийн данс дахь мөнгөн хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг битүүмжлэх, шилжүүлэх замаар явуулж, төлбөр авагчийн шаардлагыг хангана.

112.2.Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах энэ хуульд заасан зохицуулалтыг хадгаламжийн данснаас төлбөр гаргуулахад нэгэн адил хэрэглэнэ.

112.3.Хугацаатай хадгаламжийн данснаас өмнө харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснаас суутгал хийнэ.

#### **113 дугаар зүйл.Саад учирсан тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлага**

113.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь энэ бүлэгт заасны дагуу шийдвэр гүйцэтгэхэд аливаа саад байна гэж үзвэл төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгийг битүүмжилж, саад учирсан нөхцөл байдал, шаардлагатай арга хэмжээний талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэнэ.

113.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь битүүмжлэх тогтоол болон иргэний шийдвэр гүйцэтгэгчийн бусад хууль ёсны шаардлагыг биелүүлээгүйгээс төлбөр авагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

#### **114 дүгээр зүйл.Төлбөр төлөгч хуулийн этгээдийн мөнгөн болон бусад хөрөнгөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах нэмэлт зохицуулалт**

114.1.Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгчийн дансанд төлбөр гүйцэтгэхэд зориулагдсан хөрөнгө хүрэлцэхгүй бол тухайн үүргийг дараа жилийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

114.2.Хэрэв төлбөр төлөгч нь арилжааны банк бол шаардлагатай дүнг Монголбанк дахь тухайн банкны харилцах данснаас битүүмжлэн суутгах замаар албадан гүйцэтгэнэ.

114.3.Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангахад хүрэлцэхгүй, эсхүл төлбөрт гаргуулах хөрөнгө, орлого тогтоогдоогүй бол төлбөр авагч нь хувьцаа эзэмшигчид эд хөрөнгийн хариуцлага

хүлээлгэх, ногдох хөрөнгийн хувь хэмжээ, дүнг тогтоолгох тухай хүсэлтийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гаргаж болно.

114.4.Төлбөр төлөгч энэ хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар эзэлдүүлэгч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас бий болсон хөрөнгийн өөрчлөлтийн талаар улсын бүртгэл, татварын байгууллагад нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

114.5.Иргэний шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгчийн төлбөр гүйцэтгэх чадварт ноцтой нөлөөлөх, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгч хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдэд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

#### **115 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах, суутгал тооцох**

115.1.Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос гаргуулах төлбөрийн хувь хэмжээг төлбөр авагч болон төлбөр төлөгчийн төлбөрийн чадвар, бусад байдлыг харгалзан иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтооно.

115.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийлгүүлэх тухай шийдвэрийг түүний ажиллаж байгаа, тэтгэвэр, тэтгэмж олгож байгаа хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд хүргүүлнэ. Ажил олгогчоос шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх боломжтой цахим хаягийг өгсөн тохиолдолд мэдэгдэлийн хуулбарыг тухайн цахим хаяг руу цахим хэлбэрээр илгээнэ. Энэ тохиолдолд ажил олгогчийн хувьд мэдэгдлийн цахим хувь нь эх хувь болно.

115.3.Хүн, хуулийн этгээд, албан тушаалтан иргэний шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авмагч төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос сар тутам хийх суутгалын хуваарь гаргаж, урьдчилан иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчид энэ тухай мэдэгдэнэ. Үүний дагуу сар бүр суутгасан орлогыг суутгал хийсэн өдрөөс хойш ажлын 1 өдрийн дотор мэдэгдэл олгосон иргэний шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

115.4.Энэ хуулийн 115.3-т заасан шилжүүлгийн зардлыг төлбөр төлөгч хариуцна.

115.5.Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос дараах тохиолдолд төлбөр гаргуулна:

115.5.1.тогтмол төлөгдөх төлбөрийг гаргуулах;

115.5.2.төлбөр төлөгч хөрөнгөгүй нь тогтоогдсон, эсхүл байгаа хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй.

115.6.Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэл болон татварт ногдох хэсгийг хассан үүний дүнгээс тооцно.

115.7.Төлбөр төлөгч хэд хэдэн газраас цалин хөлс, бусад орлого, эсхүл эд хөрөнгөөр хөлс авдаг бол тэдгээрийг нийлүүлэн тооцно.

57

115.8.Цалин хөлс, бусад орлогоос төлбөр гаргуулах, суутгал хийхтэй холбогдсон гомдлыг шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид шуурхай гомдол гаргаж болно.

115.9.Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос нэг удаа гаргуулах төлбөрийн хэмжээ цалин хөлсний 50 хувиас хэтрэх болохгүй. Төлбөрийг гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх хүртэл суутгана.

115.10.Хорих ял эдэлж байгаа хоригдлын төлөх төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дууу хэсгийг төлүүлэхээр хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх тухай мэдэгдлийг ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд хүргүүлнэ.

115.11.Мэдэгдэл хүлээн авсан хорих ангийн захиргаа хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж, иргэний шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.

115.12.Хорих ял эдэлж байгаа хоригдлын хөдөлмөрийн хөлс, бусад орлогоос суутгал хийхэд энэ хуульд заасан хязгаарлалт хамаарахгүй ба хөдөлмөрийн хөлсний 70 хувиар суутгал хийнэ.

#### **116 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох**

116.1.Төлбөр төлөгч ажлаас чөлөөлөгдсөн бол энэ хуулийн 115.2-т заасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд нь ажлаас чөлөөлөгдсөн өдрөөс хойш ажлын гураван өдрийн дотор төлбөр төлөгчийн цалингаас өмнө нь суутгасан орлогын тооцоог гаргана.

116.3.Шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон цалин хөлснөөс суутгал хийлгүүлэх тухай шийдвэр нь төлбөр төлөгчийг шинээр ажилд авсан ажил олгогчид тухайн шийдвэрийг хүргүүлсэн өдрөөс эхлэн хууль зүйн хүчинтэй байна.

116.4.Төлбөр төлөгчийн өмнөх ажил олгогч нь шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон цалин хөлснөөс суутгал хийлгүүлэх тухай шийдвэрийг шинэ ажил олгогчид баталгаат шуудангаар нэн даруй хүргүүлж, энэ тухай иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

116.4.Хэрэв хуучин ажил олгогч шинэ ажил олгогчийн талаар мэдээлэлгүй бол төлбөр төлөгчийн хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсныг иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэнэ. Иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ тухай төлбөр авагчид мэдэгдэж, шинэ ажил олгогчид энэ хуулийн 116.4-т заасны дагуу шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон цалин хөлснөөс суутгал хийлгүүлэх тухай шийдвэрийг хүргүүлнэ.

116.5.Энэ зүйлд заасан үүргийг зөрчсөн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгчийн саналын дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгч буруутай этгээдэд торгууль ногдуулна.

116.6.Төлбөр төлөгч ажлаас чөлөөлөгдсөн тухайгаа иргэний шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдсэн, эсхүл мэдэгдээгүй боловч ажиллах чадвартай атлаа ажилгүй байгаа бол төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч хөдөлмөрийн

58

асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандаж, төлбөр төлөгчийг тохирох ажилд зуучлуулах арга хэмжээ авна.

#### **117 дугаар зүйл. Ажил олгогчийн хариуцлага**

117.1. Ажил олгогч цалин хөлснөөс суутгах дүнг хугацаанд нь суутган шилжүүлээгүй бол төлбөр авагч нь шийдвэр гүйцэтгэл дуусах хүртэл иргэний шийдвэр гүйцэтгэгчид хандаж, ажил олгогчоос төлөгдөөгүй суутгалын дүнг төлбөр авагчид төлүүлэх, шийдвэр гүйцэтгэх арга, объектыг тогтоосон шийдвэр гаргуулах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч ажил олгогчид торгууль ногдуулна.

117.2. Ажил олгогч нь шийдвэр гүйцэтгэх тогтоолыг биелүүлээгүйгээс төлбөр авагчид учирсан хохирлыг хариуцна. Үүнд дараах тохиолдлууд хамаарна:

117.2.1. Суутгалын хуваарийн дагуу төлбөрийг шилжүүлээгүй;

117.2.2. Төлбөр төлөгчийн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон даруйд шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон цалин хөлснөөс суутгал хийлгүүлэх тухай шийдвэрийг шинэ ажил олгогчид баталгаат шуудангаар илгээгүй;

117.2.3. Төлбөр төлөгчийн шинэ ажил олгогч хэн болох талаар мэдээлэлгүй тохиолдолд төлбөр төлөгчийг ажлаас чөлөөлсөн талаар иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдээгүй.

117.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хугацаа хэтрүүлсэн үүргийн дүнд хүүг тооцож, ажил олгогчоос гаргуулна.

#### **118 дугаар зүйл. Төлбөр төлөгчөөс мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах**

118.1. Төлбөрийг төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа, эсхүл төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, бэлэн мөнгө, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргуулна.

118.2. Энэ хуулийн 118.1-д заасан хөрөнгө гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулах тухай шийдвэр гүйцэтгэгчид хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулах тухай шийдвэр гүйцэтгэгч тухайн хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу битүүмжлэх, эсхүл хураана.

118.3. Энэ хуулийн 118.2-т заасан төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулах тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч тухайн хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу битүүмжлэх, эсхүл хураана.

118.4. Төлбөр авагч нь төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх хөрөнгийн түүнд ногдох хэсгээ бусад өмчлөгчид зах зээлийн үнээр худалдан борлуулах, бусад дундаа хэсгээр буюу хамтран өмчлөгч худалдан авахаас татгалзсан тохиолдолд албадан худалдан борлуулах, олсон орлогыг төлбөрт суугтуулан авах шаардлага гаргах эрхтэй.

118.5. Төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхээс зайлсхийх, төлбөрт суутгаж болзошгүй хөрөнгийг нуун дийлдэх зорилгоор хийсэн хэлцэл нь Иргэний хуулийн 56.1-д заасны дагуу хүчин төгөлдөр бус байх бөгөөд төлбөр авагч Иргэний хуулийн 56.4-т заасны дагуу түүний үр дагаврыг арилгуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардлагыг шүүхэд гаргах эрхтэй.

118.6. Төлбөр төлөгч өөрт нь өвлүүлсэн хөрөнгийг хүлээн авсны дараа түүнд холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд шаардлагатай төлбөрийг уг хөрөнгөөс гаргуулж болно.

118.7. Төлбөр авагч хүсэлт гаргасан тохиолдолд төлбөрийг тодорхой хугацаанд хувааж, тогтмол төлөх хуваарь бүхий тохиролцоог талуудын тохиролцоог хийлгэж, баталгаажуулж болно.

118.8. Энэ хуулийн 118.7-д заасан тохиролцооны хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчийн цалин, орлогоос суутгал хийж болно.

#### **119 дүгээр зүйл. Төлбөр төлөгч хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах**

119.1. Төлбөр төлөгч хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөгдөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

#### **120 дугаар зүйл. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах**

120.1. Төлбөр төлөгч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан ээргээр үйл ажиллагааг нь зогсоосон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тудгалзүүлж, гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ. Энэ нь барьцааны зүйлд явуулж байгаа ажиллагаанд хамаарахгүй болно.

120.2. Төлбөр төлөгч хуулийн этгээд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн шаардлагаас илүү гарсан хэмжээгээр хөрөнгийг битүүмжилсэн, хураан авсан шийдвэрийг хүчингүй болгож, энэ талаар дампуурлын хэрэг гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

120.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийн үнэ нь гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагын хэмжээнээс илүүгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор албадан борлуулах, эсхүл төлбөрт суутган шилжүүлэх тухай шийдвэр гаргана.

120.4. Шаардлагыг нь хангасан гүйцэтгэх баримт бичгийг дампуурлын хэрэг гүйцэтгэгч, эсхүл татан буулгах комисст хүргүүлнэ.

120.5. Татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгч барьцааны зүйлээс бусад тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль, Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг ирүүлсэн иргэний шийдвэр гүйцэтгэгчид танилцуулж, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төлбөрийг шилжүүлнэ.

## **байгаа хөрөнгөөс суутгал хийх**

- 125.1. Төлбөр төлөгчийн хөрөнгө гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй бол түүний өмчлөлийн бусад барьцаалсан хөрөнгөөс төлбөр гаргуулна.
- 125.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор бусдын барьцаанд байгаа хөрөнгөөс доор дурдсан журмаар суутгал хийнэ:
- 125.2.1. хуульд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг барьцаалагчаас хураан авах, хамгаалах, холбогдох бүртгэлд тэмдэглэгээ хийлгэх зорилгоор шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэх;
- 125.2.2. барьцааны зүйл, баримт бичгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулах ажиллагааг гүйцэтгэх зорилгоор барьцаалагчид мэдэгдэх.
- 125.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагч, эсхүл барьцаалагчийн хүсэлтийг үндэслэн барьцааны хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулах, эсхүл төлбөрт суутган төлбөр авагчид шилжүүлэх тухай шийдвэр гаргана.
- 125.4. Гүйцэтгэх баримт бичигт зааснаар барьцаалагч болон төлбөр авагч нь нэг этгээд бол төлбөр төлөгчид өөр эд хөрөнгө байгаа эсэхээс үл хамааран барьцааны хөрөнгөөс төлбөрийг суутгана.
- 125.5. Барьцааны хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулна.
- 125.6. Барьцааны хөрөнгийг худалдан борлуулсны дараа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг суутган барьцаалагчийн шаардлагыг хангасны дараа бусад төлбөр авагчийн шаардлагыг биелүүлнэ.
- 125.7. Бусдын барьцаанд байгаа үнэт цаасыг энэ хуульд заасан журмын дагуу битүүмжилнэ.
- 126 дугаар зүйл. Төлбөр авагчийн хөрөнгийн эрхийг бүртгүүлэх**
- 126.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийн шаардлагын гүйцэтгэлд шилжүүлсэн хөрөнгийн эрхийг бүртгүүлэх зорилгоор дараах тохиолдолд зохих баримт, материалыг бүрдүүлэн төлбөр авагчид гаргаж өгнө:
- 126.1.1. Гүйцэтгэх баримт бичигт тухайн хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхээр заасан;
- 126.1.2. Төлбөр авагч иргэний шийдвэр гүйцэтгэгчийн санал болгосноор төлбөр төлөгчийн хөрөнгийг төлбөрт суутган хүлээн авсан.
- 126.2. Энэ хуулийн 126.1-д заасны дагуу хөрөнгийг бүртгүүлэх зардлыг төлбөр авагч хариуцах бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд тооцогүй.
- 127 дугаар зүйл. Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах**

62

120.6. Төлбөр төлөгч хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэж, төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг харьяалах тойргийн иргэний шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

120.7. Төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч өөрийн шилжүүлсэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах талаар татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хуульд нийцсэн эсэхийг шалгаж болно.

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ХӨРӨНГӨӨС СУУТГАЛ ХИЙХ, ТӨЛБӨРТ ГАРГУУЛСАН МӨНГӨН ХӨРӨНГИЙГ ХУВААРИЛАХ, ТӨЛБӨР АВАГЧИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАХ**

### **121 дүгээр зүйл. Төлбөр төлөгчийн бие даан худалдан борлуулаагүй хөрөнгийг төлбөрт суутган авах тухай хүсэлт гаргах**

121.1. Төлбөр авагч хөрөнгийн үнэлгээний талаарх мэдэгдэх хуудсыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гүйцэтгэх баримт бичгийн шаардлагад нийцэхүйц хөрөнгийг төлбөрт суутган авах тухай хүсэлт гаргаж болно.

121.2. Төлбөр авагч энэ хуулийн 121.1-д заасан санал гаргасан, төлбөр төлөгч энэ хуульд заасан хугацаанд хөрөнгөө бие даан борлуулаагүй бөгөөд хөрөнгийн үнэлгээний талаар гомдол гаргаагүй тохиолдолд хөрөнгийг хөрөнгийн үнэлгээний талаарх мэдэгдэх хуудсанд заасан үнээр төлбөр авагчид төлбөрт суутган шилжүүлнэ.

### **122 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичигт заасны дагуу хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх**

122.1. Гүйцэтгэх баримт бичигт заасан тохиолдолд хөрөнгийг төлбөр төлөгчөөс хураан авч, төлбөр авагчид шилжүүлнэ.

122.2. Төлбөр авагч тухайн хөрөнгийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд төлбөр төлөгчид буцаан олгоно.

### **123 дугаар зүйл. Талуудын харилцан шаардлагыг биелүүлэх**

123.1. Гүйцэтгэх баримт бичигт заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд харилцан үүрэг бүхий ижил төрлийн шаардлагыг гүйцэтгүүлэхээр нэхэмжилсэн тохиолдолд аль бага шаардлагыг их шаардлагаас нь хасаж суутган, уг хэмжээгээр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелэгдсэнд тооцно.

### **124 дүгээр зүйл. Гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа төлбөр төлөгчийн хөрөнгөөс суутгал хийх**

124.1. Төлбөр төлөгчийн гуравдагч этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгөөс энэ хуульд заасан үндэслэл, журмыг баримтлан суутгал хийнэ.

### **125 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн бусдын барьцаанд**

61

127.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хураан авсан, төлбөр авагчид шилжүүлбэл зохих мөнгөн хөрөнгийг ажлын 1 өдрийн дотор төлбөр авагчид шилжүүлнэ.

127.2.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулан авсан /үүний дотор төлбөр төлөгчийн эд хөрөнгийг худалдан борлуулснаас бий болсон/ мөнгөн хөрөнгөөс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг эхний ээлжид төлүүлж, урамшууллыг суутгаж, бусад мөнгөн хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлнэ.

127.3.Гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангасны дараа үлдсэн мөнгөн хөрөнгийг төлбөр төлөгчид буцааж олгоно.

127.4.Төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгө нь хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй бол энэ хуульд заасан дарааллыг баримтлан гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангана.

127.5.Энэ бүлэгт заасан хугацаанд төлбөр авагчид төлбөрийг олгоогүй бол төлбөр авагч энэ хуульд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид гомдол гаргаж болно.

#### **128 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэгч бэлэн мөнгө хүлээн авах**

128.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөрт бэлэн мөнгө хүлээн авах, түүнийг төлбөр авагчид олгохдоо энэ тухай баримтыг хоёр хувь үйлдэж, үйлдсэн он, сар, өдрийг бичиж, гарын үсэг зуруулан, төлбөр төлөгчид нэг хувийг өгч, нэг хувийг нь хувийн хэрэгт хавсаргана.

128.2.Бэлэн мөнгө хүлээн авах баримт нь нэгдсэн дугаартай, хэвлэмэл маягт байна.

128.3.Бэлэн мөнгө хүлээн авсан баримт нь ямар нэгэн засваргүй байна.

128.4.Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цаг, хөдөө орон нутагт 72 цагийн дотор төлбөр авагчид олгож, боломжгүй бол нэн даруй иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлнэ.

128.5.Гадаад валютаар хийгдэх төлбөрийг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төлөгдөх өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тодорхойлно.

#### **129 дүгээр зүйл.Гаргуулсан төлбөрийг олгох**

129.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч гаргуулсан төлбөрийг ажлын 1 өдрийн дотор төлбөр авагчийн банканд дахь дансанд бэлэн бусаар шилжүүлэх, эсхүл төлбөр авагчид бэлнээр хүлээлгэн өгөх ба дансны дугаар тодорхойгүй тохиолдолд мөнгийг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлнэ.

129.2.Гадаадад оршин суугаа /оршин байгаа/ төлбөр авагчид төлбөрийн мөнгийг иргэний шийдвэр гүйцэтгэх албаны данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгох бөгөөд шилжүүлэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батална.

63

129.3.Энэ хуулийн 129.2-т заасны дагуу хийх шилжүүлгийн хураамжийг төлбөр авагч хариуцна.

#### **130 дугаар зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх албаны данснаас мөнгө олгох**

130.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх албаны дансанд мөнгө шилжиж орсон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагчид ажлын 1 өдрийн дотор шилжүүлнэ.

130.2.Дансанд мөнгө шилжүүлэгч нь төлбөр төлөгч, төлбөр авагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаягийг үнэн зөв, тодорхой бичих үүрэгтэй ба хаягийг буруу бичсэнээс гарсан нэмэгдэл зардлыг буруутай этгээд хариуцна.

#### **131 дүгээр зүйл.Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгох**

131.1.Хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараах журмаар олгоно:

131.1.1.Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийсэн иргэн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох, эсхүл харилцах болон хадгаламжийн дансанд нэн даруй шилжүүлэх;

131.1.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дансанд шилжиж орсон тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан төлбөр авагчид бэлнээр олгох, эсхүл түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан дансанд нэн даруй шилжүүлэх.

131.2.Хүүхдийн тэтгэлгийн мөнгөнд тооцон төлбөр төлөгчөөс гаргуулан авсан эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, эсхүл шилжүүлнэ.

#### **132 дугаар зүйл.Төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэх**

132.1.Төлбөр төлөгчөөс гаргуулсан хөрөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй байгаа тохиолдолд төлбөрийг хэсэгчлэн гүйцэтгэж болно. Энэ тохиолдолд төлбөр авагчийн саналыг харгалзана.

#### **133 дугаар зүйл.Хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг хангах дараалал**

133.1.Иргэний шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулсан хөрөнгө, мөнгө нь нэгэн зэрэг /нэг гүйцэтгэх баримт бичгээр/ шаардлага гаргасан хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг нэгэн зэрэг хангахад хүрэлцэхгүй бол төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн олгоно.

133.2.Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжид олгоно.

133.3.Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн дагуу хэд хэдэн төлбөр авагчийн хөрөнгийн шинжтэй шаардлагыг гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэгч хүлээн авч, бүртгэгдсэн дарааллын дагуу хангах бөгөөд эхний гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаснаар дараагийн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

64

этгээдийн үнийн саналд үндэслэн тогтооно. Үнийн саналыг төлбөр авагч хүсэлтдээ хавсаргана.

### **136 дугаар зүйл. Үйлдэл хийхгүй байх болон бусдын үйлдлийг тэвчих үүрэг**

136.1. Төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийхээс татгалзах (эс үйлдэх), эсхүл бусдын тодорхой үйлдлийг тэвчих үүрэгтэй бөгөөд уг үүргээ зөрчиж байна гэж төлбөр авагч үзвэл түүний хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч тогтоол гаргаж, төлбөр төлөгчийг үүрэг нь нийцүүлэн үйл ажиллагаагаа зогсоох, эсхүл зохих байдлаар биелүүлэхийг даалгана. Үүргээ зөрчсөн хэвээр байвал шийдвэр гүйцэтгэлийн шүүгч иргэний шийдвэр гүйцэтгэгчийн саналаар торгууль ногдуулна.

136.2. Иргэний ийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг үл харгалзан төлбөр төлөгч үүргээ зөрчсөн хэвээр байвал төлбөр авагч нь торгууль ногдуулах тухай хүсэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болно. Хүсэлтийг төлбөр авагч зөрчлийн талаар мэдсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор, аль ч тохиолдолд зөрчил гарснаас хойш нэг жилийн дотор гаргана.

136.3. Энэ хуулийн 136.1-д заасан торгууль ногдуулсны дараа ч төлбөр төлөгч үүргээ зөрчсөн хэвээр байвал шийдвэр гүйцэтгэлийн шүүгч өөрийн санаачилгаар анхны торгуулийн хэмжээнээс өндөр хэмжээний шинэ торгууль ногдуулна. Төлбөр төлөгч зөрчлөө үргэлжлүүлбэл энэ ажиллагаа давтагдана.

136.4. Энэ хуулийн 136.2-т заасан хугацаа өнгөрсөн бол иргэний шийдвэр гүйцэтгэгч торгууль ногдуулах тухай хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсооно. Энэ тохиолдолд төлбөр авагч ижил гүйцэтгэх баримт бичгийн үндсэн дээр дахин шийдвэр гүйцэтгэх санал гаргах эрхгүй болно.

### **137 дугаар зүйл. Эзэмшилд давтан саад учруулах**

137.1. Эзэмшлийг буцаан шилжүүлэх тухай шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг төлбөр төлөгч сайн дураар биелүүлсэн, эсхүл уг баримт бичгийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэсэн боловч төлбөр төлөгч дараа нь төлбөр авагчийн эзэмшилд өмнөхтэй ижил байдлаар давтан саад учруулсан бол төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэлийн саналаар шийдвэр гүйцэтгэлийн шүүгч нь гүйцэтгэх баримт бичгийн үндсэн дээр эзэмшлийг буцаан олгох тухай, эсхүл эс үйлдэх үүргийг зөрчсөнд тооцож энэ хуульд заасан торгууль ногдуулах үндэслэл болно.

137.2. Энэ хуулийн 137.1-д заасан хүсэлтийг төлбөр авагч нь давтан саад учруулсныг мэдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор, аль ч тохиолдолд давтан саад учруулснаас хойш нэг жилийн дотор гаргана.

### **138 дугаар зүйл. Хохирол нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах**

138.1. Энэ бүлгийн зохицуулалт нь төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг зөрчсөний улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх талаар төлбөр авагчийн маргаан хянан шийдвэрлэх журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхэд нөлөөлөхгүй.

**ХОЁРДУГААР ДЭД БҮЛЭГ. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ ЧӨЛӨӨЛҮҮЛЭХ БОЛОН ШИЛЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ**

133.4. Дараагийн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах нь эхний гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг хангуулах төлбөр авагчийн ашиг сонирхолд хамааралгүй бол энэ хуулийн 133.3-т заасан дарааллыг баримтлахгүй.

### **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ МӨНГӨН БУС ҮҮРГИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ**

### **НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ. ТОДОРХОЙ ҮЙЛДЭЛ ХИЙХ, ХИЙХГҮЙ БАЙХ, ЭСХҮЛ ҮЙЛДЛИЙГ ТЭВЧИХ ҮҮРГИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ**

#### **134 дүгээр зүйл. Зөвхөн төлбөр төлөгч өөрөө гүйцэтгэх боломжтой үүрэг**

134.1. Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үйлдлийг зөвхөн төлбөр төлөгч өөрөө гүйцэтгэх боломжтой бол иргэний шийдвэр гүйцэтгэгч нь тогтоолоор уг үүргийг биелүүлэх хугацааг тогтооно.

134.2. Төлбөр төлөгч тогтоосон хугацаанд үүргээ биелүүлээгүй бол төлбөр авагчийн хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан саналаар шийдвэр гүйцэтгэлийн шүүгч нь торгууль оногдуулна.

134.3. Төлбөр авагчийн хүсэлтээр шинэ, зохистой хугацаа тогтоож, уг хугацаанд үүргээ биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч өөрийн санаачилгаар анх оногдуулсан торгуулиас өндөр хэмжээний торгууль ногдуулна. Энэхүү ажиллагаа нь төлбөр төлөгч үүргээ биелүүлэх хүртэл давтагдана.

134.4. Төлбөр төлөгч үүргээ биелүүлсэн бол энэ тухайгаа иргэний шийдвэр гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж, нотлох баримтыг ирүүлнэ. Нотлох баримтад төлбөр авагчийн баталгаажуулсан бичгээр гаргасан мэдэгдэл, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт, эсхүл тухайн үйлдлээр бий болсон эд зүйлийг хүлээлгэн өгсөн баримт багтана. Ийм баримт ирүүлээгүй бол үүрэг биелэгдээгүйд тооцно.

134.5. Зөвхөн төлбөр төлөгчийн хүсэл зоригоос хамааран гүйцэтгэх боломжтой уран бүтээл туурвих, хөгжим, дүрслэх урлаг, уран зохиол, архитектурын бүтээл бий болгох зэрэг үйлдлийг гүйцэтгэхгүй бол төлбөр авагч тухайн үйлдлийг албадан гүйцэтгүүлэхийг шаардах эрхгүй бөгөөд зөвхөн хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардаж болно.

#### **135 дугаар зүйл. Бусад этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой үүрэг**

135.1. Бусад этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой үйлдэл хийлгүүлэх үүргийг албадан гүйцэтгэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагчид тухайн үйлдлийг өөрөө гүйцэтгэх, эсхүл гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхийг тодорхой хугацаанд зөвшөөрч, гарсан зардлыг төлбөр төлөгчөөс гаргуулах журмаар хэрэгжүүлнэ.

135.2. Төлбөр авагч нь хүсэлтдээ тухайн үйлдлийг өөрөө буюу гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхэд гарах зардлыг урьдчилан төлүүлэх тухай шийдвэр гаргуулах санал гаргаж болно. Энэ тохиолдолд төлбөр төлөгчийг уг зардлыг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд урьдчилан байршуулахыг даалгана. Урьдчилан байршуулах мөнгөн дүнг иргэний шийдвэр гүйцэтгэгч нь тухайн үйлдлийг гүйцэтгэх эрх бүхий

### 139 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга хэлбэр

139.1. Үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлүүлж, шилжүүлэх зорилгоор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэгч дараах байдлаар явуулна:

139.1.1. Үл хөдлөх эд хөрөнгөөс албадан гаргах, эд зүйлсийг гаргах, уг үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн эзэмшилд шилжүүлэх;

139.1.2. Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн эзэмшилд шилжүүлэх;

139.1.3. Хүмүүсийг албадан гаргах, эд зүйлсийг шилжүүлэх.

139.2. Орон сууц, үйлчилгээний барилга, агуулах, контейнер зэргээс төлбөр төлөгч, эсхүл албадан гаргах этгээд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд, хувийн эд хөрөнгө, мал, тээвэр амьтдыг бүрэн гаргаснаар албадан гаргах ажиллагаа дууссанд тооцно. Чөлөөлөгдсөн үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлж, төлбөр төлөгч цаашид эзэмших, ашиглахыг хориглоно.

139.3. Газар чөлөөлөх ажиллагаа нь төлбөр төлөгч, эсхүл албадан гаргах этгээдийн хөдлөх болон үл хөдлөх бүх эд хөрөнгийг тухайн газраас гаргаж, газрыг төлбөр авагчид шилжүүлэн, төлбөр төлөгч цаашид ашиглахыг хориглосноор дуусгавар болно. Хэрэв шийдвэр гүйцэтгэх баримт бичигт барилга байгууламжийг буулгах, зайлуулах талаар тусгайлан заасан бол уг ажиллагааг мөн гүйцэтгэнэ.

139.4. Барилга байгууламжийг буулгах тухай шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн биелэлт нь тухайн барилгыг буулгаж, барилгын хог хаягдлыг бүрэн зайлуулснаар хангагдсан тооцно.

139.5. Албадан гаргах, үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэх баримт бичиг, эсхүл албадан гаргах шийдвэрийг төлбөр төлөгчид гардуулснаас хойш долоо 7 хоногийн дараа, төлбөр төлөгч гомдол гаргаагүй бол явуулна. Хэрэв гомдол гаргасан бол гомдлыг хангаагүй талаарх шийдвэр гарснаас хойш долоо 7 хоногийн хугацаа тоологдоно.

139.6. Насанд хүрээгүй хүн албадан гаргагдах бол иргэний шийдвэр гүйцэтгэгч тухайн нутаг дэвсгэрийн хүүхдийн эрх, хамгааллын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

139.7. Барилга, байрыг суллах тухай хугацаатай мэдэгдлийг биелүүлээгүй тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч албадан гаргах тодорхой өдөр, цагийг заасан нэмэлт шийдвэр гаргаж, албадан гаргах этгээдэд хүргүүлнэ.

139.8. Энэ хуулийн 139.1-д заасан ажиллагааг явуулахдаа иргэний шийдвэр гүйцэтгэгч хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийг байлцуулна. Шаардлагагүй бол сууц өмчлөгчдийн холбоо, баг, хорооны албан тушаалтан, тухайн нэгжийн Засаг даргын төлөөллийг оролцуулж болно.

139.9. Үл хөдлөх эд хөрөнгөөс гаргасан хөдлөх эд зүйлсийг төлбөр төлөгчид, эсхүл түүний эзэгнэйд насанд хүрсэн гэр бүлийн гишүүнд, эсхүл эрх бүхий төлөөлөгчид шилжүүлнэ. Хэрэв эдгээр этгээд байгаагүй, эсхүл хүлээн авахаас татгалзсан бол эд зүйлсийг төлбөр төлөгчийн зардлаар хадгалагчид хүлээлгэн өгнө. Үлдсэн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч тэдгээрийг төлбөр төлөгчийн зардлаар хадгалуулж болно. Энэ талаар иргэний шийдвэр гүйцэтгэгч тэмдэглэл үйлдэнэ.

67

139.10. Төлбөр төлөгч энэ хуулийн 139.9-д заасан эд зүйлсийг хоёр сарын дотор аваагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч урьдчилан мэдэгдэж, хуульд заасан журмаар худалдан борлуулна. Худалдан борлуулсны орлогоос эхлээд албадан гаргах болон бусад иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг, дараа нь шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангана. Үлдэгдэл дүнг төлбөр төлөгчид буцаан олгоно.

139.11. Албадан гаргах этгээд мэдэгдэлд заасан хугацаанд үндэслэлгүйгээр байгаагүй, эсхүл байрыг өөр этгээд ашиглаж байсан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад болохгүй.

139.12. Энэ хуулийн 139.11-д заасан тохиолдолд гаргах этгээдийн эд зүйллийг лацдаж, зохих этгээдэд төлбөр төлөгчийн зардлаар хадгалуулж, барилга, байрыг суллана.

139.13. Албадан гаргах ажиллагааг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд явуулахгүй.

139.14. Энэ зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагагүй ажиллах хүч, тээврийн хэрэгслийг төлбөр авагч гаргана. Энэ тухай иргэний шийдвэр гүйцэтгэгч долоогоос доошгүй хоногийн өмнө төлбөр авагчид мэдэгдэнэ. Үүнтэй холбоотой зардлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд тооцно.

### 140 дүгээр зүйл. Шаардлагатай үед албадлагын арга хэмжээ авах

140.1. Энэ хуулийн 139 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бол иргэний шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтээр цагдаагийн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллага туслахаа үзүүлнэ. Ийм туслацаатай холбоотой зардлыг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд тооцно.

140.2. Энэ хуулийн 140.1-д заасан арга хэмжээтэй холбоотой зардлыг төлбөр авагчаас урьдчилан гаргуулж болох бөгөөд уг зардлыг дараа нь шийдвэр гүйцэтгэх зардалд багтаан нөхөн төлүүлнэ.

140.3. Үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлүүлэх, шилжүүлэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд энэ хуульд заасан торгуулийн арга хэмжээг нэгэн адил хэрэглэнэ.

### 141 дүгээр зүйл. Төлбөр авагчийг барилга, байранд нүүлгэн оруулах тухай шийдвэрийг гүйцэтгэх

141.1. Төлбөр авагчийг тодорхой барилга, байранд нүүлгэн оруулах тухай шүүхийн шийдвэрийг тухайн шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан барилга, байранд төлбөр авагчийг нүүлгэн оруулж, түүнийг хэвийн, тасралтгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлснээр биелэгдсэнд тооцно.

### 142 дугаар зүйл. Төлбөр төлөгчийн шаардах эрхийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх

142.1. Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийн талаарх шаардах эрхийг шилжүүлэх тухай шийдвэр гаргасан тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр

68

төлөгчийн үүрэг гүйцэтгэгчид уг үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэхийг даалгана.

142.3. Төлбөр авагч нь шилжүүлэн авсан үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр төлөгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар зохих анхаарал, болгоомжтойгоор удирдан ашиглах бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэгчийн шаардсанаар уг удирдлагын тайланг гаргана.

142.4. Төлбөр авагч нь өөрийн шаардлагыг хангуулах зорилгоор, шаардах эрх шилжүүлэх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш гуч 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийг худалдах тухай саналыг иргэний шийдвэр гүйцэтгэгчид гаргах эрхтэй.

142.5. Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах болон төлбөр авагчийн шаардлагыг хангах ажиллагааг энэ хуульд заасан үл хөдлөх эд хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх журмын дагуу явуулна.

142.6. Төлбөр авагч энэ хуулийн 142.4-т заасан хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийг худалдах тухай санал гаргаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч өмнө хийсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгоно.

#### **ГУРАВДУГААР ДЭД БҮЛЭГ. ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ХАМААРАХ ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ – ХҮҮХДИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, АВАХ**

##### **143 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх арга**

143.1. Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл асран хамгаалах, хүмүүжүүлэхээр томилогдсон байгууллагад шилжүүлэх, эсхүл тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардсан шүүхийн шийдвэрийг төлбөр төлөгч тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авна шийдвэрийг гүйцэтгэнэ.

143.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг баримтална. Хүүхэд болон шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан этгээдийн уулзалт, харилцааг хангах явцад хүүхдийн эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн, эсхүл төрийн болон төрийн бус хүүхэд хамгааллын байгууллагаас энэ талаар санал, дүгнэлт ирүүлсэн бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулж болно.

143.3. Энэ хуулийн 143.1-д заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд энэ хуульд зөвхөн төлбөр төлөгч өөрөө гүйцэтгэх боломжтой үйлдэлд хамаарах зохицуулалтын дагуу торгууль ногдуулж, гүйцэтгэнэ.

143.4. Шүүхийн шийдвэрийн дагуу хүүхэдтэй уулзах, харилцаа тогтоох эрх бүхий этгээдтэй уулзах, харилцаагаа хадгалах нөхцөлийг хангах тухай талууд бичгээр тохиролцсон бол иргэний шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелэгдсэнд тооцож болно.

143.5. Энэ хуулийн 143.4-т заасан тохиролцооны биелэлтийг иргэний шийдвэр гүйцэтгэгч хянана. Төлбөр төлөгч уг тохиролцоог зөрчсөн бол иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх, эсхүл дахин явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

69

#### **ДӨРӨВДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ. АЖИЛД ЭГҮҮЛЭН ТОМИЛОХ ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

##### **144 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх арга**

144.1. Ажил олгогчийг ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоох, эсхүл тохирох албан тушаалд томилохыг даалгасан шийдвэрийг ажил олгогч болон холбогдох хариуцлагатай албан тушаалтанд торгууль ногдуулах замаар гүйцэтгэнэ.

144.2. Ажил олгогч өмнөх шийдвэрээ хүчингүй болгож, ажилтныг өмнөх ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелэгдсэнд тооцно. Харин шаардсан үйлдлийг хийж гүйцэтгээгүй, эсхүл хийхээс татгалзсан бол шүүхийн шийдвэр биелэгдсэнд тооцохгүй.

144.3. Хуулийн этгээд татан буугдсан, эсхүл өөрчлөн байгуулагдсаны улмаас шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болсон бол иргэний шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг буцаана.

##### **145 дугаар зүйл. Ажилд эгүүлэн тогтоосон тохиолдолд олговор гаргуулах**

145.1. Ажилд эгүүлэн тогтоох тухай хүсэлт гаргасан төлбөр авагч нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн эгүүлэн тогтоогдох хүртэл хугацаанд олговол зохих сарын цалин, түүнтэй холбоотой татвар, шимтгэлийг ажил олгогчоор төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж болно.

##### **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ**

#### **ГАДААД БОЛОН ОЛОН УЛСЫН ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ, МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАЛАЛГҮЙ ХҮН, ГАДААД УЛС, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨРӨНГӨД ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ**

##### **146 дугаар зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс болон олон улсын байгууллагатай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

146.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс, олон улсын байгууллага болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах тэдгээрийн өмчтэй холбоотой шийдвэрийг гүйцэтгэхэд энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтална.

146.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах байгууллагын өмчид холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахын өмнө тухайн этгээд, эсхүл өмч нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан дархан эрх, халдашгүй байдалд хамаарах эсэхийг иргэний шийдвэр гүйцэтгэгч шалгаж тогтооно.

146.3. Энэ хуулийн 146.2-т заасан асуудлаар иргэний шийдвэр гүйцэтгэгч нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас мэдээлэл, дүгнэлт гаргуулж болно.

70

146.4.Хэрэг хянан шийдвэрлэх шатанд тухайн этгээдийн дархан эрх, халдашгүй байдал тогтоогдсон бол энэ хуулийн 146.3-т заасан журмыг дахин хэрэглэхгүй.

146.5.Гадаад улс, олон улсын байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа өмчид холбогдуулан шийдвэр гүйцэтгэх тухай шийдвэрийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөл, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авсны үндсэн дээр гаргана. Харин тухайн гадаад улс, олон улсын байгууллага өөрөө зөвшөөрсөн бол энэ заалт хамаарахгүй.

146.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс, олон улсын байгууллага, эсхүл гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын иргэнтэй холбоотой шийдвэр гүйцэтгэхэд төлбөр төлөгчийн байршил, хөрөнгийн талаарх мэдээллийг цуглуулж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу тухайн этгээдийн оршин суугаа улс, эсхүл хөрөнгө байрлаж байгаа улсын эрх бүхий байгууллагад шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг хүргүүлнэ.

#### **147 дугаар зүйл.Гадаадын шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх**

147.1.Гадаад улсын шүүхийн шийдвэр, арбитрын шийдвэр болон бусад шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх нөхцөлийг хангасан тохиолдолд энэ хууль болон Иргэний хуульд заасан холбогдох олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн журмын дагуу гүйцэтгэнэ.

#### **148 дугаар зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөрөнгийг битүүмжлэх, хураан авах**

148.1.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хязгаарлах, хориглох үндэслэл тогтоогдоогүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгийг энэ хууль болон холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу битүүмжлэх, хураан авах, төлбөрт тооцож болно.

148.2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгөтэй эсэхийг тогтоох зорилгоор иргэний шийдвэр гүйцэтгэгч холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл, лавлагаа авч болно.

148.3.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улс, олон улсын байгууллага болон тэдгээрийн өмчид холбогдуулан шийдвэр гүйцэтгэх боломжгүй гэж тогтоогдсон бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгоно.

#### **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧИД**

##### **149 дүгээр зүйл.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд**

149.1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь төлбөр авагч болон төлбөр төлөгч байна.

149.2.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэд хэдэн төлбөр авагч, эсхүл хэд хэдэн төлбөр төлөгч оролцож байгаа бол тэдгээр нь тус бүрдээ бие даан оролцох эрхтэй.

149.3.Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талд хамаарахгүй. Энэ хуульд заасан тохиолдолд тухайн этгээд өмчлөх эрхийн талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Ийм нэхэмжлэл гаргасан нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

##### **150 дугаар зүйл.Талуудын эрх, үүрэг**

150.1.Төлбөр авагч дараах эрхтэй:

150.1.1.шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан зөрчигдсөн эрхээ хугацаанд нь сэргээж, хэрэгжүүлэхийг шаардах, төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгагдсан хөрөнгөөс сонгох;

150.1.2.цахимаар хийгдэхээс бусад иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд биечлэн оролцох;

150.1.3.хэрэгт холбогдох материалтай танилцах, хуулбар авах, нэмэлт баримт бичиг гаргах, амаар болон бичгээр тайлбар өгөх;

150.1.4.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эсэргүүцэл гаргах, ёс зүйн зөрчлийн талаар гомдол гаргах;

150.1.5. энэ хуульд заасан тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол гаргах;

150.1.6.хөрөнгийн үнэлгээ, дахин үнэлгээ, нэмэлт үнэлгээ хийлгэхийг хүсэх;

150.1.7.иргэний шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

150.1.8.иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусахаас өмнө төлбөр төлөгчтэй эвлэрэх;

150.1.9.энэ хуульд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох тухай хүсэлт гаргах;

150.1.10. энэ хуульд заасан бусад.

150.2.Төлбөр авагч дараах үүрэгтэй:

150.2.1.дуудсан цагт хүрэлцэн ирэх, хаягийн өөрчлөлтөө бүртгүүлэх, бүртгэлтэй хаягаар хүргүүлсэн мэдэгдэл, баримт бичгийг хүлээн авах;

150.2.2.энэ хуульд заасан бусад.

150.3.Төлбөр төлөгч дараах эрхтэй:

- 150.3.1. хэрэгт холбогдох материалтай танилцах, хуулбар авах, нэмэлт баримт бичиг гаргах, амаар болон бичгээр тайлбар өгөх;
- 150.3.2. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад санал, хүсэлт гаргах, ёс зүйн зөрчлийн талаар гомдол гаргах;
- 150.3.3. энэ хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол гаргах;
- 150.3.4. хөрөнгийн үнэлгээ, дахин үнэлгээ хийлгэхийг хүсэх;
- 150.3.5. иргэний шийдвэр гүйцэтгэчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
- 150.3.6. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусахаас өмнө эвлэрэх;
- 150.3.7. энэ хуульд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх, дуусгавар болгох тухай хүсэлт гаргах;
- 150.3.8. энэ хуульд заасан бусад.
- 150.4. Төлбөр төлөгч дараах үүрэгтэй:
- 150.4.1. цахимаар хийгдэхээс бусад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох, бүртгэлтэй хаягаар хүргүүлсэн мэдэгдэл, баримт бичгийг хүлээн авах;
- 150.4.2. эд хөрөнгө, орлогын мэдүүлгийг үнэн зөв, хугацаанд нь гаргах;
- 150.4.3. эд өрөнгө, ажил болон оршин суух хаягийн өөрчлөлтийн талаар нэн даруй мэдэгдэх;
- 150.4.4. иргэний шийдвэр гүйцэтгэчийн тогтоосон хугацаанд ирж, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 150.4.5. шийдвэр гүйцэтгэх баримт бичиг болон холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг тогтоосон хугацаанд биелүүлэх;
- 150.4.6. хугацаа хэтрүүлсэн тохиолдолд энэ хуульд заасан алданги, хүү төлөх;
- 150.4.7. энэ хуульд заасан бусад.
- 151 дүгээр зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчийн эрх зүйн чадамж**
- 151.1. Иргэний бүрэн эрх зүйн чадамжтай этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өөрийн биеэр, эсхүл төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.
- 151.2. Иргэний эрх зүйн хязгаарлагдмал, эсхүл чадамжгүй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Иргэний хуульд заасан журмын дагуу эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хамгаална.
- 151.3. Талуудын аль нэг нь сураггүй алга болсон, нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл эрх, үүрэг нь бусдад шилжсэн бол, мөн хуулиар эрх залгамжлал үүссэн тохиолдолд нөгөө талын хүсэлтээр иргэний шийдвэр гүйцэтгэгч тухай этгээдийг эрх залгамжлагчаар солино.

151.4. Энэ хуулийн 151.3-т заасны дагуу тал сольсноос өмнө хийгдсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, түүний эрх зүйн үр дагавар нь эрх залгамжлагчид хүчинтэй, заавал биелэгдэхээр үйлчилнэ.

#### **152 дугаар зүйл. Төлөөлөгчөөр дамжуулан оролцох**

152.1. Шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг төлбөр төлөгч өөрийн биеэр гүйцэтгэхээр заагаагүй бол иргэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өөрийн биеэр, эсхүл төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно. Төлөөлөгч нь Иргэний хууль болон холбогдох хуульд заасан журмын дагуу эрх олгогдсон байна.

152.2. Төлөөлөгчийн бүрэн эрхийг Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлага хангасан бичгээр олгосон итгэмжлэл, эсхүл эрх олгосон бусад албан ёсны баримт бичгээр нотолно.

152.3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглах итгэмжлэлд төлөөлөгч дараах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг тодорхой заасан байна:

152.3.1. шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг буцаан авах;

152.3.2. төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх;

152.3.3. энэ хуульд заасан журмын дагуу талуудын өмнөөсгомдол гаргах;

152.3.4. төлбөр төлөгчөөс гаргуулсан тодорхой хөрөнгийг төлбөр

авагчийн нэрийн өмнөөс хүлээн авах, татгалзах;

152.3.5. энэ хуульд заасан бусад.

152.4. Итгэмжлэлд энэ хуулийн 152.3-т заасан эрхийг хэрэгжүүлэхийг тусгайлан хязгаарлаагүй бол төлөөлөгчийг энэ хуульд заасан төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгчийн бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэйд тооцно.

#### **153 дугаар зүйл. Төлөөлөгчөөр оролцох эрхгүй этгээд**

153.1. Дараах этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцох эрхгүй:

153.1.1. хуульд өөрөөр заагаагүй бол, арван найман насанд хүрээгүй

этгээд;

153.1.2. иргэний эрх зүйн чадамжгүй этгээд;

153.1.3. тухайн хэрэгт өөрийн хувийн эрх ашиг, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн хувиар, эсхүл өөрийн ажил олгогчийг төлөөлөн оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, иргэний шийдвэр гүйцэтгэгч.

#### **154 дүгээр зүйл. Орчуулагч, хэлмэрчийн оролцоо**

154.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч Монгол хэл мэдэхгүй, эсхүл сонстол, хэл ярианы бэрхшээлтэй бол орчуулагч, хэлмэрчийг оролцуулна.

154.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч этгээд орчуулагч, хэлмэрчээр ажиллахыг хориглоно.

154.3. Орчуулагч, хэлмэрч нь иргэний бүрэн эрх зүйн чадамжтай, шаардлагатай хэлний мэдлэг, мэргэжлийн ур чадвартай байна.

154.4. Орчуулагч, хэлмэрчигч тал өөрөө гаргах бол иргэний шийдвэр гүйцэтгэгч зохих хугацаа тогтооно. Тухайн хугацаанд орчуулагч, хэлмэрч гаргаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч томилж болно.

154.5. Орчуулагч, хэлмэрч нь ажиллагааг үнэн зөв орчуулж, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар ирэх үүрэгтэй.

154.6. Орчуулга, хэлмэрчлэлийн зардлыг тухайн үйлчилгээг авсан тал урьдчилан төлнө.

154.7. Орчуулагч, хэлмэрчид санаатайгаар буруу орчуулах, буруу хэлмэрчлэх тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагын талаар урьдчилан сануулж, энэ тухай тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

#### **155 дугаар зүйл. Гэрч**

155.1. Төлбөр төлөгчийн орон сууц, эзэмшил, өмчид үзлэг хийх, нэгжлэг явуулах, эд хөрөнгө битүүмжлэх, хураан авах ажиллагааг хоёроос доошгүй гэрчийн оролцоотой явуулна.

155.2. Шаардлагатай тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 299.1-д зааснаас бусад ажиллагаанд мөн гэрч оролцуулж болно.

155.3. Гэрч нь иргэний бүрэн эрх зүйн чадамжтай, тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хувийн ашиг сонирхолгүй, ажиллагаанд оролцогч этгээдтэй, түүнчлэн гэрч хоорондоо төрөл, садан, гэр бүлийн болон хөдөлмөрийн харилцаагүй байна.

155.4. Иргэний шийдвэр гүйцэтгэгч ажиллагаа эхлэхийн өмнө гэрчид түүний эрх, үүргийг тайлбарлана.

155.5. Гэрч дараах эрхтэй:

155.5.1. өөрийн оролцож буй ажиллагааны зорилгыг мэдэх;

155.5.2. тухайн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэл болох баримт бичигтэй танилцах;

155.5.3. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой санал, тайлбар гаргах.

155.6. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд гэрчийн эцэг (эх)-ийн нэр, нэр, регистрийн дугаарыг тусгана.

155.7. Гэрчийн гаргасан санал, тайлбарыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэлд тэмдэглэнэ. Гэрч хүсвэл санал, тайлбараа бичгээр гаргаж болно.

#### **156 дугаар зүйл. Шинжээч, үнэлгээчин**

156.1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тусгай мэргэжлийн мэдлэг шаардлагатай асуудал үүссэн бол иргэний шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл талын хүсэлтээр шинжээч, үнэлгээчнийг томилж, дүгнэлт гаргуулна. Томилогдсон шинжээч, үнэлгээчин нь тухайн ажиллагааны үр дүнд хувийн ашиг сонирхолгүй байна.

156.2. Шинжээч, үнэлгээчин нь шинжилгээ хийх, үнэлгээ тогтоох, дүгнэлт гаргахдаа Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан журмыг баримтална.

156.3. Шинжээч, үнэлгээчний хөлс, зардлыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд оруулна.

#### **157 дугаар зүйл. Татгалзан гаргах**

157.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч, хэлмэрч, орчуулагч нь дараах үндэслэлээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас өөрөө татгалзан гарна:

157.1.1. шийдвэр гүйцэтгэх баримт бичигтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч, шүүгч, шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн нарийн бичгийн дарга, нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, шинжээчийн хувиар оролцож байсан;

157.1.2. талууд болон тэдгээрийн төлөөлөгчтэй төрөл, садан, гэр бүлийн холбоотой;

157.1.3. талуудын аль нэгтэй хувийн харилцаатай, шууд захирагдах, эсхүл ажиллагааны үр дүнд хувийн ашиг сонирхолтой, эсхүл түүний хараат бус байдалд эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал үүссэн.

157.2. Энэ хуулийн 157.1-д заасан үндэслэл нь үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдах ажиллагаанд оролцож буй дуудлага худалдаа эрхлэгч, тэмдэглэл хөтлөгчид мөн адилаар хамаарна.

157.3. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 157.1-д зааснаас өөр үндэслэлээр татгалзан гарч болохгүй.

157.4. Шинжээч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах тохиолдолд оролцох эрхгүй:

157.4.1. түүний албан тушаалын болон бусад нөхцөл байдал нь талуудын нөлөөлд автах боломжтой;

157.4.2. өмнө хийсэн шинжилгээ, дүгнэлт нь тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэс болсон.

157.5. Энэ хуулийн 157.1 болон 157.4-т заасан үндэслэл тогтоогдсон бол холбогдох этгээд ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл тухайн үндэслэл илэрсэн даруйд өөрөө татгалзан гарна.

157.6. Татгалзан гаргах тухай шийдвэрт үндэслэлийг тодорхой заана.

157.7. Энэ хуулийн 157.1 болон 157.4-т заасан этгээд өөрөө татгалзан гараагүй бол тал, эсхүл түүний төлөөлөгч шийдвэр гүйцэтгэлийн шүүгчид татгалзан гаргуулах тухай хүсэлт гаргаж болно.

**158 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхэд голмол гаргах, ханалтын хүрээ, харьяалаг**

158.1. Шийдвэр гүйцэтгэх зорилгоор битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотой маргаан гарсан бол холбогдох иргэн, хуулийн этгээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж, үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн жагсаалтаас гаргуулах, эсхүл хөдлөх эд хөрөнгийг хураасан жагсаалтаас хасуулах тухай шаардлага гаргаж болно.

158.2. Энэ хуулийн 158.1-д заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргасан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

158.3. Гуравдагч этгээд энэ хуулийн 158.1-д заасан журмаар нэхэмжлэл гаргаж, шүүх түүний шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг төлбөр төлөгчөөс гаргуулна.

158.4. Энэ зүйлийн дагуу шүүхийн хяналтын хүрээ нь зөвхөн нэхэмжлэлд дурдсан тодорхой асуудлаар хязгаарлагдах бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үндэслэл болсон шүүхийн шийдвэр, тогтоолын агуулга, үндэслэлийг дахин хэлэлцэхгүй.

### **АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, УРАМШУУЛАЛ**

#### **159 дүгээр зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал**

159.1. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардлыг гаргуулах эрхтэй.

159.2. Төлбөр авагч болон төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын боломжит хэмжээ, түүнийг хэн хариуцах талаар урьдчилан мэдээлэл авах эрхтэй. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэгч зардлын урьдчилсан тооцоог талуудад мэдэгдэнэ.

159.3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гэж энэ хуульд заасан шийдвэр гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй гарсан төлбөр, зардлыг ойлгоно. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд дараах зүйлс багтана:

- 159.3.1. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн хураамж;
- 159.3.2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал;
- 159.3.3. Гүйцэтгэлийн урамшуулал.

159.4. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тогтоох, хуваарилах журмыг хууль зүй, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 159.3-т зааснаас өөр төлбөр, хураамж, нөхөн төлбөр авахыг хориглоно.

159.5. Энэ хуулийн 159.3.1-д заасан иргэний шийдвэр гүйцэтгэлийн хураамж нь тогтмол дүнгээр тогтоогдох бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх, мэдээлэл цуглуулах, мэдэгдэл хүргүүлэх, албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах, дуудлага худалдаа зохион байгуулах, захиргааны болон хөдөлмөрийн зардлыг нөхөхөд зориулагдана.

159.6. Энэ хуулийн 159.3.2-т заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд дараах бодит ажиллагаатай холбоотой бодит зардлыг хамааруулна:

159.6.1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хадгалах, тээвэрлэх, шилжүүлэхтэй холбоотой зардал;

159.6.2. Байр, агуулахыг албадан нээх, хаах, саад тотгорыг арилгахтай холбоотой зардал;

159.6.3. Шинжээч, үнэлгээч, орчуулагч, хэлмэрч, гэрч зэрэг оролцогчдын үйлчилгээний хөлс;

159.6.4. Иргэний шийдвэр гүйцэтгэгчийн албан томилолтын зардал;

159.6.5. Төлбөр төлөгч болон нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлахтай холбоотой зардал;

159.6.6. Шуудан, холбоо, мэдэгдэл хүргүүлэхтэй холбоотой зардал;

159.6.7. Гаргуулсан мөнгөн дүнг шилжүүлэх, дамжуулах зардал;

159.6.8. Шийдвэр, тогтоол, мэдэгдлийг хүргүүлэхтэй холбоотой зардал;

159.6.9. Төлбөр төлөгчийг албадан ирүүлэхтэй холбоотой зардал;

159.6.10. Дуудлага худалдаа зохион байгуулах, явуулах зардал;

159.6.11. Банкны шимтгэл, валютын хөрвүүлэлтийн шимтгэл;

159.6.12. Баримт бичгийн хуулбар, хувийг олгох зардал;

159.6.13. Орчуулгын зардал;

159.6.14. Үл хөдлөх эд хөрөнгө, газрын бүртгэлийн лавлагаа, гэрчилгээ авах зардал;

159.6.15. Зар, нийтлэл, олон нийтэд мэдээлэх зардал;

159.6.16. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гарсан бусад зардал.

159.7. Төлбөрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гаргуулсан, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэлийн хураамж болон зардлыг төлбөр төлөгчөөс гаргуулна.

159.8. Хэрэв иргэний шийдвэр гүйцэтгэлийн хураамж, зардлыг төлбөр төлөгчөөс гаргуулах боломжгүй бол түүнийг төлбөр авагч хариуцна. Төлбөрийг хэсэгчлэн гаргуулсан тохиолдолд зардлыг гаргуулсан дүнгээс суутгаж, үлдсэн хэсгийг төлбөр авагч хариуцна.

159.9. Хэрэв шийдвэр гүйцэтгэх баримт бичигт хэд хэдэн этгээд төлбөр төлөгчөөр заагдсан бол тэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хамтран болон тус тусдаа хариуцан төлнө.

159.10. Иргэний шийдвэр гүйцэтгэх зардал гаргуулах тухай шийдвэрийг иргэний шийдвэр гүйцэтгэгч гаргана.

159.11. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын мэдээлэл нь ажиллагаа үргэлжлэх хугацаанд талуудад нээлттэй байна.

159.12. Төлбөр авагч үндэслэлгүйгээр гаргуулсан зардлыг төлбөр төлөгчид нөхөн төлнө.

**160 дугаар зүйл. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хураамж, зардлыг урьдчилан төлөх**

160.1. Энэ хуулийн 159.3.1 болон 159.3.2-т заасан шийдвэр гүйцэтгэлийн хураамж, зардлыг иргэний шийдвэр гүйцэтгэчийн гаргасан тооцоонд үндэслэн төлбөр авагч, эсхүл тухайн ажиллагааг хийлгэхээр хүсэлт гаргасан этгээд мэдэгдэл хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор урьдчилан төлнө. Урьдчилан төлсөн хураамж, зардлыг шийдвэр гүйцэтгэх зардалд тооцож, төлбөр төлөгчөөс гаргуулна.

160.2. Иргэний шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагатай зардлыг нөхөн төлүүлэх эрхтэй бөгөөд тухайн ажиллагааг явуулахаас өмнө төлбөр авагчаас уг зардлыг урьдчилан төлөхийг шаардаж болно.

160.3. Энэ хуулийн 160.1-д заасан хугацаанд хураамж, зардлыг урьдчилан төлөөгүй бол иргэний шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Тодорхой ажиллагаанд шаардагдах зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол тухайн ажиллагааг явуулахгүй.

160.4. Дараах тохиолдолд төлбөр авагч шийдвэр гүйцэтгэлийн хураамж, зардлыг урьдчилан төлөхөөс чөлөөлөгдөнө:

160.4.1. хүүхдийн тэтгэмж гаргуулах ажиллагаанд;

160.4.2. гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын нөхөн төлбөр гаргуулах ажиллагаанд.

**161 дүгээр зүйл. Төлбөрийг хэсэгчлэн болон шат дараатайгаар гаргуулах**

161.1. Төлбөрийг хэсэгчлэн гаргуулсан тохиолдолд төлбөр авагчийн урьдчилан төлсөн шийдвэр гүйцэтгэлийн хураамж, зардлыг энэ хуулийн 161.2-т заасан дарааллын дагуу боломжтой хэмжээгээр нөхөн олгоно.

161.2. Төлбөрийг хэсэгчлэн буюу шат дараатайгаар гаргуулсан тохиолдолд эхний ээлжид шийдвэр гүйцэтгэлийн хураамж болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг суутгана. Гаргуулсан мөнгөн дүнгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг суутгасны дараах үлдэгдэл эерэг байх тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 306 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн урамшуулал авах эрхтэй.

**162 дугаар зүйл. Гүйцэтгэлийн урамшуулал**

162.1. Энэ хуулийн 159.3.3-т заасан гүйцэтгэлийн урамшуулал нь шийдвэр гүйцэтгэх баримт бичигт заасан үүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгэсэн, эсхүл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд, хуульд өөрөөр заагаагүй бол иргэний шийдвэр гүйцэтгэчийн гаргасан шийдвэрийн үндсэн дээр төлбөр авагчаас суутган тооцох төлбөр байна.

162.2. Гүйцэтгэлийн урамшууллыг гаргуулсан мөнгөн дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцно:

162.2.1. 50,000,000 төгрөг хүртэл бол 10 хувь;

162.2.2. 50,000,001–100,000,000 төгрөг бол 8 хувь;

162.2.3. 100,000,001–500,000,000 төгрөг бол 6 хувь;

160.2.4. 500,000,001–1,000,000,000 төгрөг бол 6 хувь;

160.2.5. 1,000,000,001–10,000,000,000 төгрөг бол 3 хувь;

160.2.6. 10,000,000,001 төгрөгөөс дээш бол 2 хувь.

160.3. Гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн шаардлага тодорхойгүй, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхыг даалгасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх бол энэ хуулийн 160.2-т заасан хувь, хэмжээнд нийцүүлэн төлбөр авагчийн саналыг харгалзан тогтооно.

160.4. Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, шийтгэх тогтоолд заасан улсын орлогод оруулах хөрөнгө, улсын тэмдэгтийн хураамж төлүүлэх ажиллагааны дүнгээс урамшуулал суутгахгүй бөгөөд эдгээр гүйцэтгэх баримт бичгийг иргэний шийдвэр гүйцэтгэгчид тэнцвэртэй хуваарилна.

160.5. Энэ хуулийн 160.2-т заасан урамшууллаас дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

160.5.1. иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шаардлагатай технологи, техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх сургалт, албан конторын түрээсийн зардал;

160.5.2. мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах зардал;

160.5.3. гүйцэтгэх баримт бичгийн цахим сан, сүлжээ ашиглалтын зардал;

160.5.4. иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгох улирал бүрийн ажлын үр дүнгийн урамшуулал.

160.6. Иргэний шийдвэр гүйцэтгэх алба урамшуулалд суутгасан мөнгөн хөрөнгийн 30 хувийг энэ хуулийн 160.5.4-т зааснаас бусад үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

160.7. Энэ хуулийн 160.5.4-т заасан урамшууллыг бодит гүйцэтгэлд суурилж оногдуулах бөгөөд нэг иргэний шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх баримт бичгийн 50 хувьас дээшхи гүйцэтгэх хуудсыг гүйцэтгэсэн тохиолдолд улирал бүр иргэний шийдвэр гүйцэтгэх албанд суутгаж авсан нийт урамшууллын 70 хувийг иргэний шийдвэр гүйцэтгэгч, бусад алба хаагчид урамшуулал болгон хувааж, улирал бүр олгоно.

160.8. Энэ хуулийн 160.7-д заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэгчид олгосон урамшууллын мөнгөн дүнгээс иргэний шийдвэр гүйцэтгэгч туслах ажилтан хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулж болно.

160.9. Иргэний шийдвэр гүйцэтгэх алба энэ хуулийн 160.6-д заасан урамшууллыг зарцуулах төлөвлөгөө, тайланг жил бүр хууль зүйн асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

**АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
БУСАД**

**161 дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

161.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

161.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**162 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

162.1.Энэ хуулийг Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭРҮҮГИЙН БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ**

**I ХЭСЭГ  
ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ  
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь эрүүгийн болон зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомж**

2.1.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийн хүчин төгөлдөр эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

**4 дүгээр зүйл.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим**

4.1.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хэргийн эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй байх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, шударга ёс, тэгш байдлын зарчмыг баримтална.

**5 дугаар зүйл.Нэр томьёо**

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."аж ахуйн үйлчилгээний ажил" гэж нээлттэй, хаалттай хорих ангийн цэвэрлэгээ, үйлчилгээний ажлыг хорих ангийн хамгаалалтын хашаанд явуулахыг;

5.1.2."шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд" гэж Зөрчлийн тухай хуулиар шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хүн, хуулийн этгээдийг;

5.1.3."хоригдол" гэж хорих ял эдэлж байгаа ялтан;

5.1.4."тогтоолын биелэлт хойшлуулсан хүн" хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон, албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг;

5.1.5."ялтан" гэж Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнийг;

5.1.6."ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээд" гэж Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийг.

**6 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл**

6.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.

**7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна:

7.1.1.зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа /цаашид "зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа" гэх/;

7.1.2.эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа /цаашид "эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа" гэх/.

7.2.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна:

7.2.1.баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;

7.2.2.торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас;

7.2.3.нийтэд тусгай ажил хийлгэх шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;

7.2.4.эрх хасах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр;

7.2.5.зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр;

7.2.6. хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр;  
7.2.7 албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр;  
7.2.8 албадан сургалтад хамруулах тухай шүүхийн шийдвэр;  
7.2.9. гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулах тухай шүүхийн шийдвэр;  
7.2.10. шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон бусад байгууллага, албан тушаалтны зөрчлийн хэргийн талаарх шийдвэр;

7.2.11. зөрчлийн үр дагавар арилгах.

7.3. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна:

7.3.1. хорих болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэр;

7.3.2. Эрүүгийн хуульд заасан тэнсэх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр;

7.3.3. сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих, хязгаарлалт тогтоох тухай шүүгчийн захирамж.

#### **8 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага**

8.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

8.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд үндэслэлийг тухайн хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх, уг ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг тайлбарлах, хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.

8.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хууль бусаар ашиглах, зохих зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.

#### **9 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хориглох үйлдэл, эс үйлдэхүй**

9.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

9.1.1. хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл хувийн ашиг сонирхлоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах;

9.1.2. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаас зайлсхийх;

9.1.3. дур мэдэн, эсхүл хууль бусаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх;

9.1.4. хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах;

9.1.5. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусдад хувийн ашиг сонирхлын үүднээс дарамт, шахалт үзүүлэх;

9.1.6. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа бусдад ялгавартай хандах, хууль бусаар давуу эрх олгох.

#### **10 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн шаардлагыг биелүүлэх**

10.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй.

10.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **11 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангахад мэдээллийн сүлжээ ашиглах**

11.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхэд цахим мэдээллийн сүлжээ ашиглаж болно.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан цахим мэдээллийн сүлжээг ашиглан ирүүлсэн зохих баталгаа бүхий шийдвэр /баримт бичиг/ болон албаны хэрэгцээнд ашиглаж байгаа төрийн байгууллагын төвлөрсөн мэдээллийн сангийн лавлагааг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор хуульд заасан арга хэмжээг гүйцэтгэж болно.

11.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага энэ хуулийн 11.1, 11.2-т заасан мэдээллийн сүлжээний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

11.4. Эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд энэ хуулийн 11.1-д зааснаас гадна дэвшилтэт техник технологи, сүлжээний дэд бүтцийг ашиглаж болно.

#### **12 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага, албан тушаалтан**

12.1. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ.

12.2. Хуульд заасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хуулиар эрх олгогдсон, эсхүл тухайн шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтан гүйцэтгэнэ.

12.3. Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник, тоног төхөөрөмжийг ашиглаж болно.

### **13 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийн хэлбэр**

13.1. Шийдвэр гүйцэтгэгчийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

13.2. Тогтоол нь доор дурдсан шаардлагыг хангасан байна:

- 13.2.1. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр, байршил;
- 13.2.2. тогтоолын гарчиг, он, сар, өдөр;
- 13.2.3. тогтоол гаргасан алба хаагчийн нэр, албан тушаал, цол;
- 13.2.4. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэргийн дугаар;
- 13.2.5. тогтоол гаргах хууль зүйн үндэслэл;
- 13.2.6. тогтоол гаргах асуудлын агуулга;
- 13.2.7. тогтоолыг гүйцэтгэх хугацаа;
- 13.2.8. тогтоолд гомдол гаргах журам, хугацаа.

13.3. Тогтоолыг түүнд заасан хугацаанд, хугацаа заагаагүй тохиолдолд даруй биелүүлнэ.

### **14 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэл**

14.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнг баталгаажуулах зорилгоор тэмдэглэл /цаашид "тэмдэглэл" гэх/ үйлдэнэ.

14.2. Тэмдэглэл нь доор дурдсан шаардлагыг хангасан байна:

- 14.2.1. тэмдэглэл үйлдсэн газар, он, сар, өдөр;
- 14.2.2. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны товч утга;
- 14.2.3. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байгаа шийдвэр гүйцэтгэгчийн овог, нэр, албан тушаал, цол, уг ажиллагаанд оролцогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр;

14.2.4. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүн;

14.2.5. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч болон шийдвэр гүйцэтгэгчийн гарын үсэг.

14.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол үндэслэлийг зааж, тусгайлан тэмдэглэнэ.

14.4. Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэр гүйцэтгэх тодорхой ажиллагаа, албадлагын арга хэмжээний үйл явц, үр дүнг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж, бэхжүүлж болно.

### **15 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичиг**

15.1. Гүйцэтгэх баримт бичигт энэ хуулийн 7.2.5-7.2.9, 7.2.11-т заасан шийдвэрийг үндэслэн шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас, энэ хуулийн 7.2.1-7.2.4-т заасан шүүхийн шийдвэр хамаарна.

15.2. Гүйцэтгэх баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг дахин олгуулахаар шүүхэд хандана.

### **16 дугаар зүйл. Гүйцэтгэх баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага**

16.1. Гүйцэтгэх баримт бичиг дараах шаардлагыг хангасан байна:

16.1.1. Гүйцэтгэх баримт бичиг олгосон шүүх, шүүгчийн овог, нэр, он, сар, өдөр, дугаар;

16.1.2. Гүйцэтгэх баримт бичгийн үндэслэл болох шүүхийн шийдвэрийн он, сар, өдөр, дугаар;

16.1.3. Тухайн гүйцэтгэх баримт бичгийг олгосон үндэслэл;

16.1.4. Шийтгүүлсэн хуулийн этгээдийн оноосон нэр, регистр, улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа хаяг, шийтгүүлсэн хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын болон ажлын газрын хаяг, утасны дугаар, регистр, иргэний бүртгэлийн дугаар;

16.1.5. Гүйцэтгэх хуудасны үндэслэл болох шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг буюу ял шийтгүүлсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ, түүний хэмжээ, хугацаа, тодорхой үйлдэл хийх, эсхүл үйлдэл хийхээс татгалзах үүрэг хүлээлгэсэн, хязгаарлалт тогтоосон хэсэг;

16.1.6. Гүйцэтгэх хуудасны үндэслэл болох шүүхийн шийдвэрийн дагуу битүүмжлэгдсэн, хураагдсан хөрөнгө, тэдгээрийн байгаа газар;

16.1.7. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон хугацаа.

16.2. Гүйцэтгэх хуудсанд түүнийг олгосон шүүгч гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

16.3. Гүйцэтгэх хуудас энэ хуулийн 16.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч түүнийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор тогтоол гарган, олгосон шүүхэд буцаана.

### **17 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдэгдэх хуудас**

17.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан, тогтоолын биелэлтийг хойшуулсан хүн, бусад этгээдийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, тайлбар авах, холбогдох баримт бичиг гаргуулан авах, эсхүл гаргасан шийдвэр болон түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх харууцлагын талаар танилцуулна.

17.2. Энэ хуулийн 17.1-д зааснаас гадна төлбөр төлөхийг шаардах, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг

ялтан, бусад этгээдэд даалгах, цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх тухай хугацаатай мэдэгдэх хуудас өгнө.

17.3. Шийдвэр гүйцэтгэгч мэдэгдэх хуудсыг дуудан ирүүлж гардуулах бөгөөд боломжгүй тохиолдолд биечлэн, эсхүл баталгаат шуудангаар хүргүүлнэ.

17.4. Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 17.1-д заасан мэдэгдэх хуудсыг утас, факс, цахилгаан, албан ёсны оршин суух бүртгэлтэй хаяг, шуудан эсхүл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэж болно.

17.5. Мэдэгдэх хуудсыг түүнд заасан хүлээн авагчид гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ. Хуулийн этгээдэд өгөх мэдэгдэх хуудсыг тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий ажилтанд гардуулан өгч, гарын үсэг зуруулж, гардуулсан он, сар, өдөр, цагийг тэмдэглэнэ.

17.6. Мэдэгдэх хуудсыг гардуулан өгвөл зохих хүн оршин суугаа газар, эсхүл ажлын байрандаа байхгүй бол мэдэгдэх хуудсыг түүний хамт амьдардаг арван найман насанд хүрсэн хүн, эсхүл сум, баг, хорооны Засаг дарга, түүний ажлын албанд, эсхүл ажлын газрын захиргаанд хүлээлгэн өгч, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

17.7. Мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдэх хуудсанд тэмдэглэж, мэдэгдэх хуудсаар хүлээлгэж байгаа үүргийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тайлбарлан өгнө.

#### **18 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа тоолох**

18.1. Энэ хуульд заасан хугацааг минут, цаг, ажлын өдөр, хоног, сар, жилээр тоолно.

18.2. Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй.

18.3. Хугацааг цагаар тоолоход уг хугацаа нь дуусах хугацааны сүүлийн цаг, минутад дуусна.

18.4. Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь хугацаа дуусах сүүлийн хоногийн 24 цагт дуусна.

18.5. Хугацааг сараар тоолоход уг хугацааг дуусах сүүлийн сарын мөн өдөр дуусна. Хэрэв энэ сард тухайн өдөр байхгүй бол мөн сарын эцсийн өдөр хугацаа дуусна.

18.6. Хугацааг жилээр тоолоход уг хугацаа нь дараа оны тухайн сарын тухайн өдөр дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно.

18.7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримт бичгийг тогтоосон хугацааны сүүлийн өдрийн 24 цагийн дотор шуудан, харилцаа холбооны байгууллагад шилжүүлсэн бол түүнийг хугацаанд нь хүргүүлсэнд тооцно.

#### **19 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа**

19.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчаас хэрэгжүүлж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, түүний эд хөрөнгийг эрэн суравалжлах, олж тогтоох болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албаны үйл ажиллагаатай нь холбогдуулан түүний амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн тохиолдолд тусалцаа үзүүлж, харилцан мэдээлэл солилцоно.

19.2. Энэ хуулийн 19.1-д заасан чиглэлээр тусалцаа үзүүлэх, мэдээлэл солилцох, энэ хуулийн 28.4, 72.4, 84.6, 85.4-т заасны дагуу хамтран ажиллах журмыг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга хамтран батална.

#### **II ХЭСЭГ ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

#### **ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**20 дугаар зүйл. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл**

20.1. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах үндэслэл нь шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон энэ хуулийн 7.2.5-7.2.9, 7.2.11-т заасан шийдвэр, энэ хуулийн 7.2.1-7.2.4-т заасан шүүхийн шийдвэр хамаарна.

20.2. Шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх хуудас олгосон тохиолдолд долоо хоногийн дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

20.3. Энэ хуулийн 20.1-д заасныг гүйцэтгэх баримт бичигт тооцох бөгөөд энэ хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

20.4. Гүйцэтгэх баримт бичиг нь энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгч хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор тогтоол гарган гүйцэтгэх баримт бичиг олгосон шүүхэд буцаана.

#### **21 дүгээр зүйл. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх хугацаа**

21.1. Энэ хуулийн 7.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван жилийн хугацаа өнгөрсөн тохиолдолд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй.

21.2. Шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авадсан этгээд шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан хугацааг энэ хуулийн 21.1-д заасан хугацаанд оруулан тооцохгүй.

## **22 дугаар зүйл.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээх**

22.1.Энэ хуулийн 16.3-т заасан буцаах үндэслэл байхгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ.

22.2.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолын талаар шүүхэд гомдол гаргахгүй.

## **23 дугаар зүйл.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх**

23.1.Шүүгч шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдтэй холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн бол шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно.

23.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараах үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлнэ:

23.2.1.Шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан иргэн нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсон тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл;

23.2.2.Тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа тохиолдолд түүнийг шийдвэрлэх хүртэл;

23.2.3.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл;

23.2.4.Шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл.

23.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд даруй мэдэгдэнэ.

23.4.Шүүх энэ хуулийн 23.1-д заасан үндэслэл арилмагц албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд, эсхүл эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн захирамж, ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 22.2-т заасан үндэслэл арилмагц шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд, эсхүл эрүүгийн

шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн тогтоол гарган зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээнэ.

23.5.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн хугацаанд ахлах шийдвэр гүйцэтгэгч зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэл арилсан эсэхэд хяналт тавина.

## **24 дүгээр зүйл.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох**

24.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуусгавар болсонд тооцож, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг хаана:

24.1.1.Гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болсон шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан;

24.1.2.Шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд гүйцэтгэх баримт бичигт заасан шийтгэл, албадлагын арга хэмжээг биелүүлсэн;

24.1.3.Шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хүн нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, эсхүл шийтүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, тохиолдолд гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих боломжгүй, эсхүл шаардлагыг эрх залгамжлагчаар гүйцэтгүүлэх боломжгүй.

24.2.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсон тухай мэдэгдэнэ.

## **25 дугаар зүйл.Торгох шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх**

25.1.Өсвөр насны хүмүүжигчид оногдуулсан торгох шийтгэлийг Иргэний хуулийн 503.5, 503.6-д заасны дагуу түүний эцэг, эх, харгалзан дэмжигч төлж, барагдуулах үүрэгтэй.

## **26 дугаар зүйл.Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг үндэслэл**

26.1.Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг энэ хуулийн 7.2.1-д заасан шүүхийн шийдвэрийг үндэслэн зохион байгуулна.

26.2.Шүүхийн шийдвэрээр баривчлагдсан хүний шийтгэлийг баривчлах төв болон баривчлах байр /цаашид "баривчлах байр" гэх/-нд эдлүүлэх бөгөөд баривчлах байгууллага нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

26.3.Баривчлах төв болон баривчлах байр нь баривчлах шийтгэлийг эдлүүлэх зориулалтын өрөө, тасалгаа, харуул хамгаалалт бүхий барилга байгууламжтай байна.

26.4.Баривчлах байр, өрөө нь агааржуулах төхөөрөмжтэй байх бөгөөд байгалийн болон ердийн гэрэлтүүлэг, салхивчтай, нэг хүнд ноогдох зай талбайн хэмжээ нь 2.5 кв.м-ээс багатай, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

26.5.Баривчлах байрны нөхцөл болон бусдын эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд баривчлагдсан хүнийг ганцаарчлан хорихыг хориглоно.

26.6.Баривчлах байр нь тусгаарлах тасалгаатай байх бөгөөд түүнд баривчлах байрны дотоод журмыг зөрчсөн, эсхүл эрүүл мэндийн байдлаас шалтгаалан баривчлагдсан хүнийг тусгаарлаж болно.

26.7.Гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэрийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.

26.8.Прокурор Прокурорын тухай хуулийн 23.1.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд баривчлах төв /байр/-ийн ахуй нөхцөл, үйл ажиллагаанд хяналт тавина.

#### **27 дугаар зүйл.Баривчлагдсан хүний эрх зүйн байдал**

27.1.Баривчлагдсан хүн нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байгууллагын захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байна.

27.2.Баривчлагдсан хүн энэ хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

27.3.Баривчлагдсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний адил эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

27.4.Баривчлагдсан хүн энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### **28 дугаар зүйл.Баривчлагдсан хүний эмнэлгийн тусламж, үйлчилгээ**

28.1.Баривчлах байр нь эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгаатай байх ба анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтын тоног төхөөрөмжтэй байна.

28.2.Баривчлагдсан хүн хүссэн үедээ эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч болох бөгөөд баривчлах байрны эмч, сувилагч урьдчилан сэргийлэх үзлэгийг долоо хоногт нэг удаа хийнэ.

28.3.Баривчлагдсан хүн нарийн мэргэжлийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх бол түүний гэр бүлийн гишүүнд болон прокурорт мэдэгдэж, энэ тухай бүртгэнэ. Баривчлагдсан этгээдийн эмнэлэгт хэвтсэн болон чөлөөтэй байсан хугацааг шийтгэл эдэлсэн хонот тооцохгүй бөгөөд баривчлагдсан этгээд нь баривчлах байранд өөрийн зардлаар ирэх үүрэгтэй.

28.4.Баривчлагдсан хүн баривчлах байранд өөрөө хүрэлцэн ирээгүй тохиолдолд цагдаагийн байгууллагатай хамтран албадан ирүүлж, гарсан зардлыг тухайн хүн, түүний батлан даагчаар төлүүлнэ.

28.5.Баривчлах байрны эмч нь баривчлагдсан хүний эмчилгээнд шаардлагатай эмийг зөвхөн нэг өдөр хэрэглэх хэмжээгээр зөвшөөрөх бөгөөд хэрэглэж байгаа эсэхэд болон өвчний явц, эмийн үйлчлэлд хяналт тавина. Мансууруулах болон хүчтэй цочролд оруулж болзошгүй эм хэрэглэхийг хориглоно.

#### **29 дүгээр зүйл.Баривчлагдсан хүнийг хүлээн авах**

29.1.Баривчлагдсан хүнийг хүлээн авах ажлыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэй алба хаагч 09.00-21.00 цагийн хооронд шүүхийн шийдвэрийг үндэслэн хүлээн авна.

29.2.Энэ хуулийн 29.1-д зааснаас бусад хугацаанд баривчлагдсан хүнийг хүлээн авах асуудлыг хүлээн авах ажлыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэй алба хаагч шийдвэрлэж, баривчлах байрны эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

29.3.Баривчлагдсан хүнийг хүлээн авахдаа хүргэж ирсэн албан тушаалтныг байлцуулан шүүхийн шийдвэрт заагдсан хүн мөн эсэхийг тодорхойлох баримт бичигтэй тулган, шүүгчийн гарын үсэг, шүүхийн тамга, тэмдэг, шийдвэрийн огноо, дугаар зэрэг бүрдлийг шалган бүртгэл хөтөлнө.

29.4.Энэ хуулийн 29.3-т заасан баримт бичиг, шийдвэрийн бүрдэл дутуу тохиолдолд тухайн хүнийг хүлээн авахгүй.

29.5.Баривчлагдсан хүнийг хүлээн авахад эмчийн үзлэг заавал хийнэ.

29.6.Баривчлагдсан хүнийг хүлээн авах, бүртгэл хөтлөх, эмчийн үзлэг хийх ажиллагааг баривчлах байрны дотоод журмаар зохицуулна.

29.7.Баривчлагдсан хүнийг хүлээн авахгүй нөхцөл үүссэн үед хүлээн авах ажлыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэй алба хаагч, эмч энэ талаар тэмдэглэл үйлдэж, хувийг хүргэж ирсэн албан хаагчид өгч, прокурорт даруй мэдэгдэнэ. Хүлээн авч болохгүй нөхцөл арилсан үед тухайн хүнийг хүлээн авна.

29.8.Баривчлагдсан хүнд баривчлах байрны дотоод журам, цагийн хуваарь, эрх, үүргийг нийгмийн ажилтан, эсхүл хүлээн авах ажлыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэй алба хаагч 24 цагийн дотор танилцуулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

29.9.Баривчлагдсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд өөрийнх нь мэдэх хэлээр баривчлах байрны дотоод журам, цагийн хуваарийг танилцуулна.

29.10.Баривчлагдсан хүн нь сэтгэцийн эмгэгтэй, эмнэлгийн хяналтад байдаг, жирэмсэн, 0-3 насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг болох нь тогтоогдсон, эсхүл цэргийн албанд татагдах зарлан дуудах хуудас ирсэн тохиолдолд баривчлах байрны захиргаа энэ тухай прокурорт даруй мэдэгдэж, прокурор чөлөөлүүлэх эсэх асуудлыг 72 цагийн дотор шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **30 дугаар зүйл.Баривчлагдсан хүний бие, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийх**

30.1.Баривчлах байрны харуул хамгаалалтын ажилтан баривчлагдсан хүний бие, өрөөнд үзлэг, нэгжлэгийг ямар ч үед хийж болно.

30.2.Баривчлагдсан хүний эргэлтээр оруулж байгаа эд зүйлд тухай бүр үзлэг,

нэгжлэг хийнэ.

30.3.Баривчлагдсан хүний биед ижил хүйсийн алба хаагч үзлэг, нэгжлэг хийнэ.

30.4.Үзлэг, нэгжлэгээр илэрсэн хориотой эд зүйлсийг хураан авч тэмдэглэл үйлдэнэ.

30.5.Хураан авсан эд зүйлсийн талаар баривчлах даргад танилцуулж дараах байдлаар шийдвэрлэнэ:

30.5.1. түргэн гэмтэж муудах болон орчин тойронд аюул учруулж болох эд зүйлийг баривчлах байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан комисс устгах ба энэ тухай тэмдэглэл хөтөлж, тухайн хүнээр гарын үсэг зуруулна;

30.5.2.бусад эд зүйлсийг хураан авч суллагдах үед нь буцаан олгох, эсхүл ар гэрт нь хүлээлгэн өгнө.

30.6.Хураагдсан эд зүйлийг ар гэрт нь хүлээлгэн өгөхдөө хүлээн авч буй хүний биеийн байцаалт, ажлын болон гэрийн хаяг, хүлээлгэн өгсөн эд зүйлийн нэр, тоо, хэмжээг хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэлд тодорхой тусгаж, гарын үсэг зуруулан материалд хавсаргана.

### **31 дүгээр зүйл.Баривчлагдсан этгээдийг хуваарилгах**

31.1.Баривчлагдсан хүнийг баривчлах байрны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ерөөнд хуваарилж, хөнжил, гудас, цагаан хэрэглэл олгоно.

31.2.Баривчлагдсан хүний ерөөг дараах үндэслэлээр солих буюу дахин хуваарилж болно:

31.2.1.эрүүл мэндийн шаардлагаар;

31.2.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор;

31.2.3.баривчлагдсан хүний, эсхүл өмгөөлөгчийн үндэслэл бүхий хүсэлтээр.

### **32 дугаар зүйл.Баривчлагдсан хүний ахуй хангамж**

32.1.Баривчлагдсан хүний бие, ерөөнд баривчлах байрны дотоод журамд заасан эд зүйл байлгахыг зөвшөөрнө.

32.2.Энэ хуулийн 32.1-д зааснаас бусад эд зүйлсийг баривчлагдсан хүний бие болон ерөөнд байлгахыг хориглоно.

32.3.Баривчлах байрны болон баривчлагдсан хүний эрүүл ахуйн шаардлагыг хангах эд зүйл, арга хэмжээг баривчлах байрны дотоод журмаар зохицуулна.

32.4.Баривчлагдсан хүнийг батлагдсан хуваарийн дагуу өдөрт нэг цагаас багагүй хугацаагаар гадаалуулна.

32.5.Баривчлагдсан хүн өдөрт хоёр удаа нэг хүнд ногдох хоногийн хоолны илчлэг нь 2800 килокалориос багагүй, хэрэгцээт үедээ уух ундны усаар хангагдана.

### **33 дугаар зүйл.Баривчлагдсан этгээд бусадтай уулзах, утсаар ярих**

33.1.Баривчлагдсан хүн ажлын өдөр нэг удаа, нэг цагаас ихгүй хугацаагаар бусадтай уулзах, нэг удаа илгээмж авах, захидал илгээж болно.

33.2.Нийгмийн ажилтны зөвшөөрлөөр долоо хоногт нэг удаа таван минутгаас ихгүй хугацаагаар утсаар ярьж болно.

33.3.Баривчлагдсан хүн энэ хуулийн 33.1, 33.2-т заасан үйлчилгээнээс гарах зардлыг өөрөө хариуцна.

33.4.Баривчлагдсан хүний уулзалтыг баривчлах байрны эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийн дагуу зохион байгуулж, бүртгэл хөтөлнө.

### **34 дүгээр зүйл.Баривчлагдсан хүний аюулгүй байдлыг хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх**

34.1.Баривчлагдсан хүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөнд аюул заналхийлэл учирч болзошгүй тохиолдолд алба хаагч аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

34.2.Баривчлагдсан хүнийг хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах нөхцөл боломжоор хангана.

34.3.Баривчлагдсан хүн төлбөрийн чадваргүй бол хууль зүйн туслалцааны төвд түүний хүсэлтийг хүргүүлж, өмгөөлөгчөөр хангах арга хэмжээг авна.

### **35 дугаар зүйл.Баривчлагдсан хүний гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх**

35.1.Баривчлагдсан хүн баривчлах байрны нөхцөл байдал болон алба хаагчдын зан, харилцааны талаар гомдол, хүсэлт гаргаж болно.

35.2.Баривчлах байрны нийгмийн ажилтан гомдол, хүсэлт гаргасан хүнтэй биечлэн уулзаж, энэ талаар эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

### **36 дугаар зүйл.Баривчлагдсан хүнийг хөдөлмөрлүүлэх**

36.1.Баривчлагдсан хүнийг хорих байрны үйлчилгээ болон хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр харуул хамгаалалттай ажиллуулж болно.

36.2.Баривчлагдсан хүнийг гэрээний үндсэн дээр ажиллуулж байгаа хуулийн этгээд ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр тооцон олгох ба гэрээнд хийж гүйцэтгэх ажил, ажлын хөлс, цаг хугацаа, тээврийн зардал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх, ажлын багаж, хувцсаар хангах зэргийг тусгана.

36.3.Баривчлагдсан хүний хөдөлмөрийн хөлсийг баривчлах байрны дансанд төвлөрүүлж, суллагдах үед зохих суутгалыг хийн, үлдэгдлийг өөрт нь олгоно.

36.4.Харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй, хөдөлмөр

хамгаалал, аюулгүй ажиллагааны журам биелэгдээгүй, эмчийн тодорхойлолтоор баривчлагдсан хүний эрүүл мэндийн байдал тэнцэхгүй, хөдөлмөрийн хортой нөхцөлд ажил хийлгэхийг хориглоно.

### **37 дугаар зүйл.Баривчлагдсан хүнд чөлөө олгох**

37.1.Баривчлагдсан хүн, түүний ар гэрт нь гачигдал, хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд холбогдох баримтыг үндэслэн баривчлах байгууллагын даргын тушаалаар долоо хүртэл хоногийн чөлөө олгож болох бөгөөд энэ тухай прокуроррт даруй мэдэгдэнэ.

37.2.Энэ хуулийн 37.1-д заасны дагуу чөлөө авсан баривчлагдсан хүнийг хоёроос доошгүй батлан даагчид хүлээлгэн өгнө.

37.3.Батлан даагч чөлөөний хугацаа дууссаны дараа баривчлагдсан хүнийг баривчлах байранд хүргэх бөгөөд чөлөөний хугацаанд ирээгүй, баривчлах шийтгэл эдлэхээс зайлсхийсэн хүнийг эрэн сурвалжлахад гарсан зардлыг батлан даагч хариуцна.

### **38 дугаар зүйл.Баривчлагдсан хүнийг суллах үндэслэл, журам**

38.1.Баривчлагдсан хүнийг дараах үндэслэлээр суллана:

38.1.1.шүүхийн шийдвэрт заасан хугацаа дууссан;

38.1.2.хугацаанаас өмнө суллах тухай шүүгчийн захирамж гарсан;

38.1.3.шүүхийн шийдвэрт заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд прокурорын тогтоол гарсан.

38.2.Баривчлах байрны алба хаагч баривчлагдсан хүнийг суллах тухай энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан тогтоол, захирамжийг хүлээн авмагц даруй суллана.

38.3.Баривчлагдсан хүнийг суллахын өмнө байрнаас хүлээлгэн өгсөн эд зүйлийг буцаан авч, холбогдох тооцоог хийнэ.

38.4.Суллагдсан хүнд баривчлагдах үед хураагдсан эд зүйлийг бүртгэлийн дагуу хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

### **39 дүгээр зүйл.Баривчлах байрны чиг үүрэг**

39.1.Баривчлах байр нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.1.1.баривчлагдсан хүнд түүний эрх, үүрэг, баривчлах шийтгэл эдлүүлэх нөхцөл, журмын талаар тайлбарлах;

39.1.2.баривчлагдсан хүн болон бусад хүмүүсээс баривчлах байрны талаар гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэх;

39.1.3.баривчлагдсан хүн нэг бүрд хувийн хэрэг нээж, бүртгэл хөтлөх;

39.1.4.баривчлагдсан хүний аюулгүй байдлыг хангаж өөртөө болон бусад хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

39.1.5.энэ хуульд заасан бусад үүрэг.

39.2.Баривчлах байрны дотоод журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

### **40 дүгээр зүйл.Баривчлах байгууллагад байсан хугацааны шууд зардлыг тооцох**

40.1.Баривчлагдсан хүний баривчлах байранд байсан хугацааны шууд зардлын хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

40.2.Баривчлагдсан хүний баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг энэ хуулийн 40.1-д заасны дагуу баталсан хэмжээгээр тооцож төлүүлнэ.

### **41 дүгээр зүйл.Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, зөрчил үйлдэж олон хөрөнгө, орлогыг хураах**

41.1.Энэ хуулийн 20.1-д заасны дагуу гүйцэтгэх хуудас олгосон зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, зөрчил үйлдэж олон хөрөнгө, орлогыг хураах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах шийдвэрийг шийдвэр гүйцэтгэгч Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

41.2.Зөрчил үйлдэхэд ашигласан, хураагдсан эд зүйл, хэрэгсэл, зөрчил үйлдэж олон, хураагдсан хөрөнгө, орлогыг худалдан борлуулах, шилжүүлэх журмыг Засгийн газар батална.

### **42 дугаар зүйл.Торгох шийтгэл, зөрчил үйлдэж олон хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх хөрөнгө, орлого, хохирол, нөхөн төлбөр гаргуулах**

42.1.Шийтгүүлсэн этгээд энэ хуулийн 7.2.2, 7.2.5, 7.2.6-д заасан шийдвэрийг хуульд заасан хугацаанд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

### **43 дугаар зүйл.Эрх хасах шийтгэлийг гүйцэтгэх**

43.1.Эрх хасах шийтгэлийг энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

43.2.Эрх хасах шийтгэл оногдуулсан хугацаа дуусгавар болоход шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг дахин шалгахар хууль тогтоомжид тусгайлан зааснаас бусад тохиолдолд эрх олгосон баримт бичиг, зөвшөөрлийг шийтгэл хүлээсэн этгээдэд буцаан олгоно.

43.3.Эрх хасах шийтгэлийн хугацааг шийтгвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

43.4.Эрх хасах шийтгэлийг биелүүлэх журмыг зөрчсөн, эсхүл хориглосон үйлдэл, үйл ажиллагаа явуулсан хугацааг шийтгэл биелүүлсэн хугацаанд оруулан тооцохгүй.

#### **44 дүгээр зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх**

44.1. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх, зохион байгуулах ажиллагааг гүйцэтгэхэд энэ хуулийн 56, 57, 58, 59, 60 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

#### **45 дугаар зүйл. Албадан эмчлэх албадлагын арга хэмжээг гүйцэтгэх**

45.1. Шүүхийн шийдвэрээр оногдуулсан албадан эмчлэх албадлагын арга хэмжээг гүйцэтгэх харилцааг хуулиар зохицуулна.

#### **ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ III ХЭСЭГ АЖИЛЛАГАА**

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГҮЙЦЭТГЭХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

#### **46 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэх**

46.1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хамт хүлээж авна. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй.

46.2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн тогтоол, магадлалыг тоо бүртгэлд оруулан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, ажлын гурван өдрийн дотор тойрог хариудсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, энэ тухай прокурорт даруй мэдэгдэнэ.

46.3. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 46.2-т заасан тогтоолыг хүлээн авсан даруйд ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх бөгөөд ялтан тус бүрд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, ялганд ял эдлүүлэх журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

#### **47 дугаар зүйл. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх**

47.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах тохиолдолд түдгэлзүүлж, түдгэлзүүлэх үндэслэл арилмагц үргэлжлүүлэн гүйцэтгэнэ:

47.1.1. Ялтан ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон;

47.1.2. Ял шийтгүүлсэн хуулийн этгээд татан буугдах, эсхүл өөрчлөн байгуулагдах ажиллагааны үед;

47.1.3. Ял шийтгүүлсэн хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн;

47.1.4. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсаныг нотлох эмч нарын комиссын дүгнэлт гарсан;

47.1.5. Нийтэд тустай ажил хийх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан жирэмсэлсэн бол төрөхөөс өмнөх 60 хоног, төрснөөс хойш нэг жил хүртэл хугацаагаар;

47.1.6. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас ял эдлүүлэх боломжгүй болсон;

47.1.7. Нийтэд тустай ажил хийх ял шийтгүүлсэн ялтны гэр бүлийн хөдөлмөрийн чадвартай ганц хүн нь хүндээр өвчилсөн, эсхүл бусад хүндэтгэх шалтгаанаар ял эдлүүлэх боломжгүй бол гурван сар хүртэл хугацаагаар;

47.1.8. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан байнга оршин суугаа газраас бусад газарт гурван сараас дээш хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон;

47.1.9. Хуульд заасан халдашгүй байдлыг түдгэлзүүлээгүй бол;

47.1.10. Нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан ял эдэлж байх хугацаандаа цагдан хоригдсон, баривчлах шийтгэл эдэлж байгаа бол шүүхийн шийдвэрт заасан хугацаагаар;

47.1.11. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ялаар шийтгүүлсэн тохиолдолд баривчлах, цагдан хоригдсон хугацааг дуусах хүртэл, хорих ялыг эдэлж дуусах хүртэл.

47.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 47.1-д заасан үндэслэл тогтоолдсон тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх саналаа ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан тав хоногийн дотор хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

47.3. Прокурор энэ хуулийн 47.2-т заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авмагц түдгэлзүүлэх үндэслэлийг хянаж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэж, тогтоол гаргана.

47.4. Энэ хуулийн 47.1.7-д заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл арилаагүй тохиолдолд дахин нэг удаа гурван сар хүртэл хугацаагаар сунгах эсэхийг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

47.5. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 47.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх саналаа ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан гурван хоногийн дотор хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

47.6. Прокурор энэ хуулийн 47.5-д заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авмагц сэргээх үндэслэлийг хянаж, гурван хоногийн дотор эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх эсэхийг шийдвэрлэж тогтоол гаргана.

#### **48 дугаар зүйл. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг**

## дуусгавар болгох

48.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцож, хэргийг хаана:

48.1.1. Ялтан шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг бүрэн эдэлж дууссан;

48.1.2. Ялтын өвчний учир хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн;

48.1.3. Шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр солих тухай шүүхийн шийдвэр гарсан;

48.1.4. Ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон;

48.1.5. Ялтанд өршөөл, уучлал үзүүлсэн;

48.1.6. Ялтан нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш хоёр жилийн хугацаа өнгөрсөн;

48.1.7. Ял шийтгүүлсэн хуулийн этгээд татан буугдсан, эсхүл түүнд холбогдуулан дамуурлын хэрэг үүсгэсэн, эсхүл өөрчлөн байгуулагдах үед тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй;

48.1.8. Ялтан хэрэг хариуцах чадваргүй болсон.

48.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 51.2-т заасны дагуу прокуророор хянуулсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай шийдвэрийг ажлын гурван өдрийн дотор цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

48.3. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг энэ хуулийн 48.1.4-т заасан үндэслэлээр дуусгавар болгосон бол суутгасан төлбөрийг ялтанд буцаан олгоно.

48.4. Гүйцэтгэгдсэн шийдвэрийг хүчингүй болгосон бол гүйцэтгэсэн ажиллагааг цуцална.

## 49 дүгээр зүйл. Хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих

49.1. Ялтан торгох ялыг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих энэ хуульд заасан зөрчил гаргасан тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зөрчил гаргасан, эсхүл торгох ялыг биелүүлвэл зохих өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих тухай саналаа эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

49.2. Прокурор эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор үндэслэлийг хянаж, хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих тухай дүгнэлт үйлдэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

49.3. Энэ хуулийн 49.1-д заасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн санал нь үндэслэлгүй, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн нь хангалттай нотлогдоогүй бол прокурор саналыг хүчингүй болгож, ажлын гурван өдрийн дотор санал гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаан хүргүүлнэ.

## 50 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ялаас чөлөөлөх

50.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн нь тогтоогдсон бол ажлын гурван өдрийн дотор ялтын ялаас чөлөөлүүлэх, ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналаа ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл ажлын гурван өдрийн дотор дүгнэлт үйлдэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

50.2. Энэ хуулийн 50.1-д заасан өвчний жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

## 51 дүгээр зүйл. Хорихоос өөр төрлийн ялыг эдэлж дууссанд тооцох

51.1. Ялтан оногдуулсан ялыг шүүхийн шийдвэр, энэ хуульд заасан журмын дагуу эдэлж дууссан, оногдуулсан торгох ялыг тогтоосон хугацаанд биелүүлсэн бол эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтын ял эдэлж дууссанд тооцох тухай тогтоол гаргаж, ажлын гурван өдрийн дотор эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

51.2. Прокурор энэ хуулийн 51.1-д заасан тогтоолын үндэслэлийг хянах бөгөөд уг тогтоол үндэслэлгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгож, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг үндэслэл бүхий шийдвэрийн хамт ажлын гурван өдрийн дотор тогтоол гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаан хүргүүлнэ.

## 52 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд техник, хэрэгсэл ашиглах, хяналт тавих, гомдол гаргах

52.1. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

52.2. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тоног төхөөрөмжийн жагсаалт, тэдгээрийг ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

52.3. Ялтан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны талаарх гомдлоо шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах албан тушаалтан, эсхүл прокурорт гаргана.

52.4. Энэ хуулийн 52.3-т заасан гомдлыг хүлээн авсан албан тушаалтан хууль тогтоомжид заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

## 53 дугаар зүйл. Хорих, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх

53.1. Шүүхээс эрүүгийн хармуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох хүртэл түдгэлзүүлнэ.

53.2. Энэ хуулийн 48, 88 дугаар зүйлд заасан үндэслэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаадын иргэнийг харьяалах улсад шилжүүлэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлснийг тусална.

53.3. Энэ хуулийн 53.1-д заасан этгээд албан ажлаар гадаад улсад зорчих, өөрөө болон гэр бүлийн гишүүд нь гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон, гадаад улсад амьдарч буй гэр бүлийн гишүүн, төрсөн эцэг эх, ах, эгч, дүү нас барсан, хүндээр өвчилсөн зэрэг зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд түүний хүсэлт, гэр бүлийн лавлагаа, нас барсны гэрчилгээ, эмнэлгийн байгууллагын шийдвэр, магадлагаа, дүгнэлт зэрэг нотлох баримтыг үндэслэн гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга сэргээж болно.

#### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ТОРГОХ, НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ**

#### **54 дүгээр зүйл. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

54.1. Ялтан торгох ял оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй.

54.2. Энэ хуулийн 54.1-д заасан хугацаа дуусгавар болоход ялтан торгох ялыг биелүүлээгүй бол эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч торгох ялыг биелүүлээгүй шалтгаан нөхцөлийг судалж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, ялтны саналыг харгалзан уг хугацаанд торгох ялыг биелүүлэх хуваарь тогтоож болно.

54.3. Энэ хуулийн 54.2-т заасны дагуу тогтоосон хуваарийг ялтан тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд торгох ялыг хорих ялаар солих тухай сануулж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Сунгасан хугацаа дуусмагц торгох ялыг хорих ялаар солиулах саналаа прокурорт даруй хүргүүлнэ.

#### **55 дугаар зүйл. Хуулийн этгээдэд торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

55.1. Торгох ял шийтүүлсэн хуулийн этгээд энэ хуулийн 54.1-д заасан хугацаанд шүүхээс оногдуулсан торгох ялыг биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу албадан гаруулна.

55.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч торгох ял шийтүүлсэн хуулийн этгээдийн эд хөрөнгөөс шүүхээс оногдуулсан торгох ялыг албадан гаргуулах ажиллагааг Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

#### **56 дугаар зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх**

56.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд биечлэн хяналт тавих, ялтны ажлын гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий ажилтан, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авах, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах зэргээр тогтмол хяналт тавина.

56.2. Ялтныг ажиллуулахаар гэрээ байгуулсан байгууллага эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид бүх талын дэмжлэг үзүүлнэ.

56.3. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтны ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн ялын тооцоог үнэн зөв хийх, ял эдлэхээс зайлсхийсэн нөхцөл байдлыг шалган тогтоох, ялтны хувийн хэргийг хөтлөх үүрэгтэй.

56.4. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ялтны байнга оршин суугаа хаягийн дагуу гүйцэтгэж, тухайн тойргийн эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина.

56.5. Ялтныг ажиллуулах ажлын байр тухайн тойрогт байхгүй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаан байгаа бол эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг өөр тойрогт шилжүүлэн ял эдлүүлэх саналаа ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид танилцуулж, прокурорт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

56.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд ял эдлүүлэх ажиллагааны талаар 30 хоног тутам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

#### **57 дугаар зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах**

57.1. Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ.

57.2. Нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг сонгохдоо ялтны эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагыг тогтооно.

57.3. Шүүх ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтан тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгасан тохиолдолд ялыг шүүхийн шийдвэрт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

57.4. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтныг ажиллуулах байгууллагагай ялтны нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг /хөдөлмөрийн норм/, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулна.

57.5.Гэрээнд ялтны ургийн овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүнчлэн ажил хийх цаг, ялтны зан байдал, хүмүүжил, ял эдлэлтийн талаарх тодорхойлолтыг батлагдсан загварын дагуу үйлдэж, гэрээнд заасан хугацаанд ирүүлэх үүргийг тусгана.

57.6.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нь ялтныг шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт ажил хийлгэхээр тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэж өгнө.

57.7.Ялтны ажлын цагийн бүртгэлийг нийтэд тусгай ажил хийлгэхээр гэрээ байгуулсан байгууллага бүртгэж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ажлын цагийн бүртгэл, ажлын гүйцэтгэлийг үндэслэн ялын тооцоо хийнэ.

57.8.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч долоо хоног тутам ялтны ажлыг биечлэн шалгаж, ажлын байрыг шалгасан тэмдэглэлд ялтан болон нийтэд тусгай ажлыг хийлгэж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулна.

57.9.Нийтэд тусгай ажлыг хийлгэж байгаа байгууллага нь ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид долоо хоног тутам тогтмол мэдээлэх үүрэгтэй.

#### **58 дугаар зүйл.Нийтэд тусгай ажил хийлгэх ял эдлэх хугацаа, түүнийг тооцох, ял эдэлж дуусах**

58.1.Нийтэд тусгай ажил хийлгэх хугацаа нь амралтын өдөр болон үндсэн ажил, хичээлээс чөлөөтэй өдөр дөрвөн цагаас ихгүй, ажлын өдөр ажил болон хичээлээс чөлөөтэй үед хоёр цаг, эсхүл ялтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд найман цагаас ихгүй, долоо хоногт 10 цагаас багагүй байна.

58.2.Нийтэд тусгай ажил хийлгэх ял эдэлсэн хугацааг ялтан ажил гүйцэтгэж эхэлсэн цагаас эхлэн тооцож, шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусгавар болтол эдлүүлнэ.

58.3.Ялтан онц байдал, гамшиг, аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах нийтийн хөдөлмөрийн дайчилгаанд дайчлагдан ажилласан цагийг нийтэд тусгай ажил хийлгэх ял эдэлсэн хугацаанд тооцно.

58.4.Ялтны гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол долоо хүртэл хоногийн чөлөө олгож болно.

58.5.Чөлөөг энэ хуулийн 58.4-т заасан нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, дүүргийн Засаг даргын, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ял эдлүүлж байгаа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга шийдвэрлэнэ.

58.6.Энэ хуулийн 58.4-т заасан чөлөөний хугацаа болон ял эдлэх хугацаандаа ажиллаж байгаа байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн хурал, цуглаан, сургалт болон бусад арга хэмжээнд хамрагдсан, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хуурамчаар өвдсөн, бие эрхтэн, эрүүл мэнддээ санаатайгаар гэмтэл учруулсны улмаас ажиллаагүй, ял эдлүүлэх журмыг зөрчсөн хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохгүй.

#### **59 дүгээр зүйл.Нийтэд тусгай ажил хийлгэх ялыг хорих ялаар солих үндэслэл**

59.1.Ялтан нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллагын дотоод журмыг зөрчсөн, ажлаа дүр мэдэн орхисон, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан, архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажилд ирсэн, нийтэд тусгай ажил хийхтэй холбоотойгоор хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, журам, ажил олгогчоос тавьсан хууль ёсны шаардлагыг удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллага энэ тухай эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэнэ.

59.2.Ялтан хуурамчаар өвдсөн, эмнэлгийн магадлагаа, зохих баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, бие эрхтэн, эрүүл мэнддээ санаатайгаар гэмтэл учруулсан, чөлөөний баримт, материалыг хуурамчаар бүрдүүлсэн, зөрчил гаргаж шийтгүүлсэн, эсхүл энэ хуулийн 59.1-д заасан зөрчил үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд нийтэд тусгай ажил хийлгэх ялыг хорих ялаар солино.

#### **60 дугаар зүйл.Нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллагын үүрэг, хүлээлгэх хариуцлага**

60.1.Нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллага дараах үүрэгтэй:

60.1.1.Энэ хуулийн 57.4-т заасан асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулах;

60.1.2.Ялтан аюулгүй ажиллагааны сургалтыг ажил эхлэхийн өмнө зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, ажлын тусгай хувцас, хөдөлмөрийн багаж, хэрэгслээр хангах;

60.1.3.Ялтны ажлын цагийг бүртгэж, ажлын гүйцэтгэл, ялтны гаргасан зөрчлийн талаар эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид тухай бүр мэдээлэх;

60.1.4.Ялтны ажлын цагийн бүртгэл, тодорхойлолтыг үнэн зөв гаргах;

60.1.5.Гэрээнд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон ажлын байранд ялтныг ажиллуулах.

60.2.Нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллагын ажилтан энэ хуульд заасан ялтны гаргасан зөрчлийн талаар эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдээгүй, нуун дарагдуулсан, ялтны цагийн бүртгэлийг хуурамчаар бүртгэсэн бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

**61 дүгээр зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

61.1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

64.1.4.техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн.

64.2.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг дараах тохиолдолд ноцтой зөрчсөнд тооцно:

64.2.1.энэ хуулийн 62.1-д заасан үүргээ гурван сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй;

64.2.2.гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;

64.2.3.энэ хуулийн 64.1.2, 64.1.3, 64.1.4-т заасан зөрчлийг давтан гаргасан;

64.2.4.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;

64.2.5.техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн.

64.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрчсөн ялтанг дахин зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, тэмдэглэл үйлдэнэ.

64.4.Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино.

#### **65 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг сонгох**

65.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно.

65.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг үндэслэн техник хяналт хариуцсан ажилтан суурин болон хөдөлгөөнт хяналтын тоног төхөөрөмжийг ялтны бие, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, шаардлагатай бусад газарт суурилуулж, хяналтын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон ялтанд байнгын хяналт тавина.

#### **66 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хяналт тавих**

66.1.Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирсэн зөрчлийн дохиог ирсэн даруйд хариуцсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ.

66.2.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 66.1-д заасны дагуу ирүүлсэн зөрчлийг биечлэн шалгаж, шалтгаан, нөхцөлийг тогтооно.

26

61.2.Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолно.

61.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

#### **62 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны үүрэг**

62.1.Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан дараах үүрэгтэй:

62.1.1.шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;

62.1.2.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, техникийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

62.1.3.шүүхээс тогтоосон зорчихыг хязгаарласан газарт зорчихгүй байх;

62.1.4.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа өөрчлөхгүй байх;

62.1.5.эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар гаргах;

62.1.6.тогтоосон журмын дагуу зөвөрийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг нь хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

62.1.7.хувийн бичиг баримтаа биедээ авч явах;

62.1.8.ял эдэлж дуусмагц хяналтын тоног төхөөрөмжийг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид бүрэн бүтэн хүлээлгэн өгөх.

#### **63 дугаар зүйл.Хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг төлөх**

63.1.Ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй.

#### **64 дүгээр зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих**

64.1.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг дараах тохиолдолд зөрчсөнд тооцно:

64.1.1.энэ хуулийн 62.1-д заасан үүргээ биелүүлээгүй;

64.1.2.техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулсан;

64.1.3.Зөрчлийн тухай хуульд заасан нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил үйлдэж, шийтгүүлсэн;

25

## журмыг өөрчлөх

68.1.Прокурор ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн ялтны зорчих бүсийг дараах тохиолдолд өөрчилж болно:

68.1.1.ялтны гэр бүлийн байдалд өөрчлөлт орсны улмаас шүүхээс анхлан тогтоосон газарт ял эдлүүлэх боломжгүй болсон;

68.1.2.ялтны санхүүгийн чадавх, гамшиг, аюулт үзэгдлийн улмаас оршин суугаа газраа өөрчлөх шаардлагатай болсон;

68.1.3.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ялтан оршин суух газраа өөрчлөх зорилгоор орон сууц, хашаа байшин худалдан авсан;

68.1.4.ялтны ял шийтгүүлэх үеийн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, эсхүл өөр байгууллага, хуулийн этгээдэд шилжин ажиллах, шинэ ажилд орох, шилжин суралцах шаардлагатай болсон;

68.1.5.дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагад элсэн суралцах;

68.1.6.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсон.

68.2.Ялтан ял эдлэх бүсээ өөрчлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтны хүсэлт, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн санал, холбогдох материалыг хянаж, 10 хоногийн дотор прокурорт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

## 69 дүгээр зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг урамшуулах

69.1.Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд нэг сард тав хүртэл хоногийн шагналын хоног олгож болно.

69.2.Шагналын хоногийг энэ хуулийн 115 дугаар зүйлд заасан журмын дагуу олгоно.

## 70 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

70.1.Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн ажиллагааг нь сарниулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэж, гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

## 71 дүгээр зүйл.Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

66.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн ялтанд биечлэн хяналт тавих ажиллагааг энэ хуулийн 52.1-д заасан журмаар зохицуулна. Биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болно.

66.4.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтан биечлэн, эсхүл бусдаар дамжуулан шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрсөн, эсхүл зөрчихийг завдсан талаар хүн, хуулийн этгээдээс мэдээлэл авч болно.

## 67 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөх, сэргээх

67.1.Прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэл хоногийн хугацаанд дараах үндэслэлээр өөрчилж болно:

67.1.1.ялтны гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;

67.1.2.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй;

67.1.3.бүсдын асрамжид байх шаардлагатай нь эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, лавлагаагаар тогтоогдсон ялтнаас өөр асрамжлан хамгаалах хүнгүй гэр бүлийн гишүүнийг асрамжлан хамгаалах шаардлагатай;

67.1.4.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас шүүхээс тогтоосон газар, байршилд байх боломжгүй болсон;

67.1.5.шүүхээс хориглоогүй тохиолдолд ажилд орох, сургуульд элсэн суралцах шалтгаад шүүхээс тогтоосон газар, байршлаас бүсэд газарт биечлэн оролцох зайлшгүй шаардлагатай;

67.1.6.хуулиар тогтоосон төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнд хамрагдах гэтгэвэр, тэтгэмж тогтоолох/;

67.1.7.хүндэтгэн үзэх бүсэд.

67.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг энэ хуулийн 67.1-д заасны дагуу өөрчлөх саналд ялтны зорчих бүс, явах чиглэлийг тогтоож ялтанд танилцуулж прокурорт мэдэгдэнэ.

67.3.Энэ хуулийн 67.1-д заасан хугацаа дууссан даруйд ялтанд шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоож, ял эдлүүлэх ажиллагааг ердийн журмаар үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

67.4.Ялтан шинээр очсон газарт долоо хоногоос дээш хугацаагаар оршин суух шаардлагатай тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг тухайн газарт нь үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

## 68 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл,

71.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

71.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний нөхцөл, журмыг зөрсөн тохиолдолд хүлээлгэх хармуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

71.3. Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнд хяналтын тоног төхөөрөмж ашиглан хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЭРХ ХАСАХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

#### **72 дугаар зүйл. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг мэдэгдэх**

72.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэнээс хойш тав хоногийн дотор ялтныг төрийн албанд томилсон, сонгосон, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах болон шүүхээс хориглолт, хязгаарлалт тогтоосон бусад эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

72.2. Төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэр /цаашид "шүүхийн шийдвэр" гэх/-ийг биелүүлэх үүрэгтэй.

72.3. Хорих анги эрх хасах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн хоригдлыг ялын хугацаа дуусч суллагдахаас долоо хоногийн өмнө, бусад үндэслэлээр суллагдсан бол суллагдсанаас хойш долоо хоногийн дотор суллагдсан талаарх мэдэгдлийг шүүхийн шийдвэр, мэдэгдэх хуудсын хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.

72.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавихдаа харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн болон бусад байгууллагатай хамтран ажиллана.

#### **73 дугаар зүйл. Эрх хасах ял шийтгүүлсэн ялтан, ялтныг сонгох, томилгох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтны үүрэг**

73.1. Эрх хасах ял шийтгүүлсэн ялтан дараах үүрэгтэй:

73.1.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх, түүний дуудсанаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар болон бичгээр тайлбар гаргах;

73.1.2. Хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад оршин суугаа хаяг, эрхэлж байгаа ажил, үйл ажиллагаа, түүний өөрчлөлтийн талаар тухай бүр мэдэгдэх.

73.2. Ялтныг сонгох, томилгох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар дараах үүрэгтэй:

73.2.1. Ажил, албан тушаалд нэр дэвшигч, бараа, ажил, үйлчилгээ бэлтгэн нийлүүлэгч нь тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх эрхтэй холбоотой эрх хасах ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан эсэхийг нягтлах;

73.2.2. Ажилтан, эсхүл ажил гүйцэтгэгч эрх хасах ял шийтгүүлсэн тохиолдолд шүүхээс хориглолт, хязгаарлалт тогтоосон эрхийг хэрэгжүүлэх ажилд томилгох, цаашид хассан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг гүйцэтгүүлэхээс татгалзах;

73.2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрх хасах ял шийтгүүлсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор ял шийтгүүлсэн ажилтныг ажлаас чөлөөлөх;

73.2.4. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн шаардсанаар шүүхийн шийдвэрийг биелүүлсэн тухай лавлагаа, тодорхойлолт гаргаж хүргүүлэх;

73.2.5. Ялтантай байгуулсан ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх болон хөдөлмөрийн гэрээнд орсон өөрчлөлтийн талаар эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид тухай бүр мэдэгдэх.

#### **74 дүгээр зүйл. Эрх, зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтны үүрэг**

74.1. Тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэр, мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор ялтан олгосон эрх, зөвшөөрлийг хүчингүйд тооцох, энэ тухай ялтан мэдэгдэх, мэргэжлийн үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэгтэй.

#### **75 дугаар зүйл. Эрх хасах ял шийтгүүлсэн ялтан хяналт тавих**

75.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч улирал тутам ялтантай урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар тайлбар авч, шаардлагатай тохиолдолд ялтны ажлын байр, үйл ажиллагааг биечлэн хянаж, тэмдэглэл үйлдэнэ.

75.2. Эрх хасах ял эдэлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

75.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавьж, ялын биелэлтийн талаар улирал тутам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр, эсхүл энэ хуулийн 56.6-д заасан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

**76 дугаар зүйл. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга, хэрэгсэл**

76.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг дараах арга, хэрэгслээр гүйцэтгэнэ:

76.1.1. хассан эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байр, барилга байгууламж, агуулах савыг битүүмжлэх;

76.1.2. эрх, зөвшөөрөл олгосныг нотлох баримт бичгийн эх хувийг хураах;

76.1.3. эрх, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад олгосон эрх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай мэдэгдэл хүргүүлэх, ялтны мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавихыг даалгах.

76.2. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга, хэрэгсэл нь энэ хуулийн 76.1-д зааснаар хязгаарлагдахгүй.

76.3. Эрх хасах ялыг хорихоос бусад төрлийн ял дээр нэмж оногдуулсан тохиолдолд үндсэн болон нэмэгдэл ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг хамтад нь хэрэгжүүлнэ.

**77 дугаар зүйл. Эрх хасах ял шийтүүлсэн ялтанд байнгын хяналт тавих**

77.1. Ялтан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөр орон нутагт хоёр сар хүртэл хугацаагаар зорчих тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих газрын хаяг, холбоо барих утас, хамт зорчих этгээдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэж, ялтны зорчих нутаг дэвсгэрийн эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавихыг даалгаж, прокурорт мэдэгдэнэ.

77.2. Ялтан энэ хуулийн 77.1-д зааснаас урт хугацаагаар өөр орон нутагт оршин суух тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийг ялтны оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлж, энэ тухай прокурорт мэдэгдэх бөгөөд ял эдлүүлэх ажиллагааг ялтны шилжин суурьшсан харьяаллын дагуу үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

**78 дугаар зүйл. Эрх хасах ял эдлэх хугацааг тоолох**

78.1. Хорихоос өөр төрлийн ял дээр нэмж оногдуулсан эрх хасах ялыг эдлүүлэх ажиллагааны явцад шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар сольсон тохиолдолд ялтныг хорих ял эдлэх хугацаанд эрхийг хасах ял эдэлсэн хугацааг тоолохыг зогсоон, хорих ял эдэлж дууссан үеэс үргэлжлүүлэн тоолж, хяналт тавина.

78.2. Ялтан шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тоолохгүй.

**79 дүгээр зүйл. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн ялтан, хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага**

31

79.1. Ялтан эрх хасах ялаас зайлсхийсэн, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн бол Эерчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

79.2. Ялтанд эрх, зөвшөөрөл олгосон, ялтныг сонгох, томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтан эрх хасах тухай шүүхийн шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй, эсхүл биелүүлэхэд саад учруулсан бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**ДОЛДУГААР БҮЛЭГ  
АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВСАН ШҮҮХИЙН  
ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ**

**80 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авах**

80.1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон болон шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг албадлагын арга хэмжээ авадсан этгээдийн хамт хүлээн авна. Холбогдох этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авахад саад болохгүй.

80.2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 80.1-д заасан шийдвэрийг тоо бүртгэлд оруулан хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон болон шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, албадлагын арга хэмжээ авадсан этгээдэд хяналтын хувийн хэрэг нээж, ажлын гурван өдрийн дотор тойрог харуцсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилан, энэ тухай прокурорт даруй мэдэгдэнэ.

**81 дүгээр зүйл. Шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, хорих ялаас хугацаанаас тэнссэн, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх**

81.1. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон /цаашид "тогтоолын биелэлтийг хойшлуулсан" гэж/ хүний бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газар, хэлтэс хариуцан хөтөлнө.

81.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан шийдвэрийг хүлээн авч дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

81.2.1. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулах;

81.2.2. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, хүний хувийн байдлын талаарх бусад мэдээллийг

хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсаргах;

81.2.3. тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүмүүжигч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн хүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэнийг дуудан ирүүлж, тэдгээрийн эрх, үүрэг, тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хууль, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулах;

81.2.4. тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүмүүжигч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

81.2.5. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт улирал тутам тэмдэглэл хийх.

81.3. Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг шүүгчийн захирамжийн хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.

#### **82 дугаар зүйл. Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих**

82.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд дараах журмаар хяналт тавина:

82.1.1. гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, оршин суугаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг долоо хоногоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, улирал тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгах;

82.1.2. оршин суух газар болон эрхлэх ажил, албан тушаал өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж байх тухай баталгаа гаргуулах;

82.1.3. тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүмүүжигчийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн этгээд болон сум, дүүргийн Засаг даргаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх харилцан мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, тогтоолын биелэлтийг хойшлуулсан насанд хүрсэн этгээдийг зохих ажлын байраар хангахад туслалцаа үзүүлэх;

82.1.4. тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүмүүжигч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хараа хяналтдаа байлгах хүсэлт гаргасан буюу хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэний хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах;

82.1.5. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хязгаарлалт, үүргийг биелүүлээгүй, эсхүл хяналтаас зайлсхийсэн тохиолдолд албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах;

82.1.6. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, эсхүл холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах;

82.1.7. гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх талаар тогтоолын биелэлтийг нь хойшлуулсан этгээдэд санамж, зөвлөгөө өгөх, ярилцлага зохион байгуулах;

82.1.8. хяналтад нь байгаа тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн зан байдал, үйл ажиллагааны талаар байгууллага, албан тушаалтнаас тодорхойлолт, лавлагаа авах;

82.1.9. тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд хүндэтгэх шалтгаанаар оршин суух газраа өөрчлөх бол түүний хяналтын хугацааг тооцож, хяналтын хувийн хэргийг шинээр оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлж, прокурорт даруй мэдэгдэх.

82.2. Тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээд дараах үүрэгтэй:

82.2.1. байнга оршин суух газраа очсоноос хойш ажлын гурван өдрийн дотор нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст мэдэгдэх;

82.2.2. улирал тутамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, шүүхээс хүлээлгэсэн үүргийн биелэлтийн талаар тайлбар гаргах;

82.2.3. байнга оршин суух хаягаа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх, шинээр суурьших нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд, эсхүл цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

82.2.4. байнга оршин суугаа газраасаа долоо хоногоос илүү хугацаагаар явах, гадаадад зорчих бол хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст, оршин суугаа нутаг дэвсгэрт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгжгүй бол харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

82.2.5. хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, цагдаагийн байгууллагын алба хаагч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг биелүүлэх.

82.3. Тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүмүүжигч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн өсвөр насны хүмүүжигчийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн дуудсан цагт хүрэлцэн ирэх, шүүхээс даалгасан үүрэг, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

#### **83 дугаар зүйл. Тэнссэн, тогтоолын биелэлтийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай санал гаргах**

83.1.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, тэнссэн хугацаанд хүн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга хандлагаараа харуулсан, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан ялтны хянан харгалзахаар тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч ялтныг ялаас чөлөөлүүлэх саналыг прокуроррт гаргаж болно.

83.2.Прокурор хяналтын хувийн хэрэгтэй танилцаж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлнэ.

83.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 83.1-д заасан санал гаргаагүй, эсхүл прокурор гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд шүүхийн тогтоолд заасан хянан харгалзах хугацаа дууссан боловч дараагийн шийдвэр гаргаагүй тохиолдолд уг хугацаа дуусмагц эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч цаашид авах арга хэмжээний тухай саналаа хяналтын хувийн хэргийн хамт прокуроррт хүргүүлнэ.

83.4.Тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зургаан сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан, эсхүл энэ хуулийн 82.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч тав хоногийн дотор тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах саналаа прокуроррт хүргүүлнэ.

83.5.Прокурор эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн энэ хуулийн 83.4-т заасан саналыг хүлээн авч үндэслэлийг хянаж тэнссэн, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулах, ял оногдуулах эсэхийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

**84 дүгээр зүйл. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

84.1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүнд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацааг танилцуулж, энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан журмын дагуу биелэлтэд нь хяналт тавина.

84.2.Зан үйлээ засах, сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авадгасан хүнд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 84.1-д зааснаас гадна зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулна.

84.3.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүний хувийн байдал, албадлагын арга хэмжээ авадгасан хугацаанд хүлээлгэсэн үүргээ биелүүлсэн байдлын талаар шүүх, прокурорын байгууллагын хүсэлтийг үндэслэн тодорхойлолт гаргана.

84.4.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүн дуудсан цагт хүрэлцэн ирэх, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны

шаардлагыг биелүүлэх, оршин суух газар, ажил, албан тушаал өөрчлөгдсөн тухай болон шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр танилцуулах үүрэг хүлээнэ.

84.5.Сум, дүүргийн Засаг дарга үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүнд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих тусалцаа үзүүлж, хамтран ажиллана.

84.6.Цагдаагийн байгууллага үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүний сахилга, шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтын биелэлт, засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих ажилд туслалцаа үзүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэстэй харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллана.

84.7.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авадгасан этгээд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо бүрэн төлсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй тохиолдолд шүүхээс тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөний дараа хугацаанаас нь өмнө хүчингүй болгох саналыг прокуроррт гаргаж болно.

84.8.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 84.7-д заасан санал гараагүй, эсхүл прокурор гаргасан саналыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд албадлагын арга хэмжээ авадгасан хугацаа дууссаны дараа тухайн хүнд ял оногдуулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэх саналаа хяналтын хувийн хэргийн хамт прокуроррт хүргүүлнэ.

84.9.Энэ хуулийн 84.8-д заасны дагуу гаргасан эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл прокурор энэ талаарх дүгнэлтийг шүүхэд хүргүүлнэ.

84.10.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авадгасан хүн шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн талаар хуульд заасан аргаар мэдээлэл авч болно.

84.11.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 84.1-д заасан хугацаа, хуваарь, шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг зөрчсөн этгээдэд албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах тухай саналыг прокуроррт гаргана.

84.12.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд энэ хуульд заасан техникийн болон биечилсэн хяналт тавьж болно.

84.13.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авадгасан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мөргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна.

84.14.Сургалт явуулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

84.15.Албадлагын арга хэмжээ авадгасан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг сургалтын эрх бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

**85 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

85.1. Гэмт хэрэг үйлдсэн хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана.

85.2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гармагц уг хүнийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх бөгөөд шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийг хамтад нь хүргүүлнэ.

85.3. Энэ хуулийн 85.1-д заасан хүний эмчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

85.4. Албадан эмчлүүлж байгаа хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, эмнэлэг, цагдаагийн байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

85.5. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага дараах үүрэг хүлээнэ:

85.5.1. Албадан эмчлүүлж байгаа хүнд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийх;

85.5.2. эмчилгээний явц, үр дүнг үнэн зөв, тодорхой тусгах;

85.5.3. эмчилгээний үр дүнг, өвчний шинж байдлыг харгалзан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргуулах;

85.5.4. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй, эсхүл хугацааг сунгах шаардлагатай тохиолдолд энэ тухай прокурорт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дөрүй мэдэгдэх.

85.6. Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан, хугацаа дууссан бол албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй тухай дүгнэлтийг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч санал гарган арван хоногийн дотор прокурорт хүргүүлнэ.

85.7. Прокурор дүгнэлт, холбогдох баримт бичгийг үндэслэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүчингүй болгож урьд оногдуулсан ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хүчингүй болгож, ял оногдуулах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох тухай дүгнэлт үйлдэж, шүүхэд хүргүүлнэ.

85.8. Прокурор энэ хуулийн 85.6-д заасан саналыг хянан үзэж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн тохиолдолд уг албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагад шийдвэрийг хүргүүлнэ.

85.9. Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авалдсан хүний сэтгэцийн байдал засарсан, албадан эмчлэх хугацаа дууссан боловч, асран хамгаалах хүнгүй, асран хамгаалагч нь хүлээн авахаас татгалзсан, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн бусад /Тасаг/ клиникт шилжүүлэхээр шийдвэрлэж болно.

85.10. Албадан эмчлүүлж байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлт, прокурорын саналаар албадан эмчлэх хугацаа дуусахаас өмнө энэ хуулийн 85.5.3-т заасан дүгнэлтийг гаргуулж болно.

85.11. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хариуцсан шийдвэр гүйцэтгэгч албадан эмчлүүлж буй этгээдийн сэтгэц засралын байдлын талаар сар тутам эмчилж буй байгууллагаас тодорхойлолт авч, хяналтын хувийн хэрэгт хавсаргана.

85.12. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авалдсан хүний сэтгэцийн байдал засарсан, албадан эмчлэх хугацаа дууссан боловч, хүлээн авах арг гэр, төрөл садны хүн байхгүй, эсхүл асран хамгаалалтад авахаас татгалзсан тохиолдолд тухайн хүнийг энэ хуулийн 85.5-д заасан байгууллагын бусад клиникт шилжүүлэх асуудлыг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагын саналыг үндэслэнэ.

85.13. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний харуул, хамгаалалтын журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**86 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

86.1. Хөрөнгө, орлогыг хураах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрт заасан эд зүйл, хөрөнгийг хариу төлбөргүйгээр албадан хураан авах, улсын орлого болгох зорилгоор төрийн холбогдох байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулж олсон орлогыг улсын төсөвт оруулах арга хэмжээнээс бүрдэнэ.

86.2. Эд хөрөнгийг хураан авч, худалдан борлуулж, улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг худалдан борлуулж, улсын орлого болгоно.

86.3. Эд хөрөнгийг хураан авч, улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэрийн дагуу хураагдсан хөрөнгийг худалдан борлуулахгүйгээр төрийн өмчид шилжүүлэхээр төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлнэ. Хэрэв төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага худалдан борлуулахаар санал өгсөн бол төрийн өмчид шилжүүлэхгүйгээр худалдан борлуулж, улсын орлого болгоно.

86.4. Энэ хуулийн 86.1, 86.2-т заасны дагуу тухайн хөрөнгө борлогдоогүй бол шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах нутгийн захиргааны байгууллагад шилжүүлнэ.

86.5. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

86.6. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг улсын орлого болгох тухай шүүхийн шийдвэрт заасан мөнгөн хөрөнгийг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч төрийн сангийн холбогдох дансанд шилжүүлнэ.

86.7. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаад улсад байгаа хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ.

86.8. Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрлөөр олж авах эд зүйлийг шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад худалдаж, эсхүл шилжүүлнэ.

86.9. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хураан авсан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

86.10. Галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураан авч хадгалах, устгах, шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

#### **87 дугаар зүйл. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

87.1. Өсвөр насны хүмүүжигчид оногдуулсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуульд заасны дагуу хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой хамтран гүйцэтгэнэ.

87.2. Энэ хуулийн 87.1-д заасан ажиллагаанд прокурор хяналт тавьна.

87.3. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.

#### **88 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээг дуусгавар болгох**

88.1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч дараах үндэслэлээр албадлагын арга хэмжээг дуусгавар болсонд тооцож, хяналтын хувийн хэргийг хаана:

88.1.1. албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болсонд тооцсон;

88.1.2. албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дууссан;

88.1.3. өршөөл, уучлал үзүүлсэн;

88.1.4. албадлагын арга хэмжээ авагдсан этгээд нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш хоёр жилийн хугацаа өнгөрсөн;

88.1.5. албадлагын арга хэмжээ авагдсан этгээд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн;

88.1.6. албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож, ял шийтгэсэн;

39

88.1.7. шүүхийн шийдвэрт заасан албадлагын арга хэмжээг бүрэн биелүүлсэн;

88.1.8. хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг биелүүлэх гүйцэтгэх баримт бичигт шүүхийн шийдвэрт нэрлэн заасан хөрөнгө устгаж үгүй болсон, үрэгдсэн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тогтоогдсон.

88.2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээг дуусгавар болгосон тухай шийдвэрийг ажлын гурван өдрийн дотор прокурор, цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

#### **89 дүгээр зүйл. Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

89.1. Хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг тухайн хуулийн этгээдийг албадан татан буулгаж, улсын бүртгэлээс хассанаар биелэгдсэнд тооцно.

89.2. Татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32.2-т заасны дагуу татан буулгах комисс гүйцэтгэх бөгөөд татан буулгах комисс /цаашид "Комисс" гэх/-т татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийн төлөөлөл, ахлах эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөөс бүрдсэн дөрвөөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

89.3. Комисс нь татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн этгээдийг татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу татан буулгах ажлыг зохион байгуулж, хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулах мэдэгдлийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагад, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох мэдэгдлийг уг зөвшөөрлийг олгосон этгээдэд хүргүүлнэ.

89.4. Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах шийдвэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, нийтэд мэдээлнэ.

89.5. Татан буугдаж байгаа хуулийн этгээдээс шаардах эрхтэй этгээдийн өргөдлийг хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна.

89.6. Комисс татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг дараах дарааллаар хангана:

89.6.1. гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

89.6.2. шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулах төлбөр;

89.6.3. хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтанд төлөх хөдөлмөрийн хөлс;

89.6.4. хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.

89.7. Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь энэ хуулийн 85.5-д заасан шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд Комисс түүний бусад эд хөрөнгийг

40

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, төлбөрийг барагдуулна.

89.8.Харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг шүүхийн шийдвэрт заасны дагуу шийдвэрлэнэ.

89.9.Хуулийн этгээдэд оногдуулсан эрх хасах албадлагын арга хэмжээг энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

## **ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛЫГ ГҮЙЦЭТГЭХ**

### **НАЙМДУГААР БҮЛЭГ**

#### **90 дүгээр зүйл.Хорих байгууллага**

90.1.Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг Цаашид "хорих анги" гэх/-ээс бүрдэнэ.

90.2.Хорих анги нь улсын онцгой объект бөгөөд төвлөрсөн бүтэцтэй байна.

90.3.Хорих ангийн дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

90.4.Хорих ангийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, хоригдлыг эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөрлүүлэх, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангах, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хоригдлыг анх хуваарилсан хорих ангиас өөр хорих ангид шилжүүлэхийг хориглоно.

#### **91 дүгээр зүйл.Хорих ангид нэвтрэх**

91.1.Прокурор, Хүний эрхийн Үндэсний комиссын хүний эрхийн болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хуульд заасан албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хорих ангид саадгүй нэвтрэнэ.

91.2.Хуулиар эрх олгогдсон албан тушаалтан хорих ангийн даргад мэдэгдсэнээр, бусад иргэн, албан тушаалтан хорих ял эдлүүлэх албаны даргаас олгосон зөвшөөрлийн дагуу хорих ангид нэвтрэх болно.

91.3.Хорих ангийн үйлдвэрлэл, үйлчилгээний байранд хоригдолд мэргэжлийн сургалт явуулах, дадлагажуулах заавар, зөвлөгөө өгөх үүрэг бүхий энгийн ажилтан хорих ангийн байршилд ажиллаж болно. Үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж байгаа энгийн ажилтан нь хоригдлуудтай ижил хүйсийн байх бөгөөд тухайн үйлдвэрлэлд ажиллаж байгаа нийт хоригдлын дөрөвний нэгээс илүүгүй байна.

91.4.Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн ажиглан хорих ял эдлүүлэх албаны даргаас олгосон зөвшөөрлийн дагуу хорих ангид нэвтрэх бөгөөд дуу-дүрсний бичлэгийг хорих ангийн даргын, хоригдлоос ярилцлага авах, түүний дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг хоригдлын бичгээр өгсөн зөвшөөрлөөр хийнэ.

#### **92 дугаар зүйл.Хорих анги шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, хорих ангийн үйлдвэрлэлийн**

41

## **чиглэл, байршлыг тогтоох**

92.1.Хорих анги шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох, өөрчлөх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

92.2.Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

92.3.Хорих байгууллагын үйлдвэрлэлийг бүс нутгийн онцлогоос шалтгаалан бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж болно.

92.4.Улс орны бүтээн байгуулалт, бүсчилсэн хөгжилд хоригдлыг ажиллуулалх зорилгоор хорих ангийг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулж болно.

92.5.Нүүдлийн хорих анги нь хоригдлын аюулгүй байдлыг хангах, нийгэмшүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эргэлт, уулзалтын хэсэгтэй байна.

#### **93 дугаар зүйл.Нээлттэй хорих анги**

93.1.Шүүхээс нээлттэй хорих ангид хорих ял эдлэхээр шийтгүүлсэн, эсхүл хаалттай хорих ангиас хуульд заасан журмын дагуу нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн хоригдлын ялыг эдлүүлнэ.

93.2.Хоригдол долоо хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, долоо хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй.

#### **94 дүгээр зүйл.Хаалттай хорих анги**

94.1.Хаалттай хорих анги нь энгийн, онцгой, тусгай гэсэн төрөлттэй байна.

94.2.Хаалттай хорих ангийн энгийн төрөлд шүүхээс хаалттай хорих ангид хорих ял эдлэхээр шийтгүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу нээлттэй хорих ангиас хаалттай хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хоригдлыг ял эдлүүлнэ.

94.3.Хаалттай хорих ангийн онцгой төрөлд удаа дараа хорих ял шийтгүүлж байсан, энэ хуулийн хаалттай хорих ангийн төрөл хүндэрсэн үндэслэлээр үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн хоригдлыг ял эдлүүлнэ.

94.4.Хаалттай хорих ангийн энгийн төрөлд ял эдэлж байгаа хоригдол нь 45 хоногт нэг удаа түр, 60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.

94.5.Хаалттай хорих ангийн онцгой төрөлд ял эдэлж байгаа хоригдол 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.

#### **95 дугаар зүйл.Хаалттай хорих ангийн тусгай төрөлд ял эдлүүлэх**

42

насанд хүрэхээс гурван сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

96.4.Энэ хуулийн 96.3-т заасны дагуу шилжүүлсэн хүмүүжигчийн эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэх хорих ангийн төрлийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

96.5.Шүүх энэ хуулийн 96.3-т заасан хүмүүжигчийн эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

96.6.Өсвөр насны хүмүүжигчийн илгээмж авах, түр уулзалт хийх, угсаар ярих тоог хязгаарлахгүй бөгөөд 15 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

96.7.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэд өсвөр насны хүмүүжигчид ерөнхий боловсрол олгох ерөнхий боловсролын сургууль, амьдрах ухааны дадал олгох мэргэжлийн сургалтын төв байна.

96.8.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдлэхээр ирсэн өсвөр насны хүмүүжигчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

96.9.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэдэх ерөнхий боловсролын сургууль өсвөр насны хүмүүжигчийг Боловсролын ерөнхий хуульд заасан суралцагчийн нийгмийн баталгаа, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан суралцагчийн эрхээр хангагдах боломжийг бүрдүүлнэ.

96.10.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журмыг Улсын ерөнхий прокурор, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **97 дугаар зүйл.Өсвөр насны хүмүүжигчийн эрх зүйн байдал**

97.1.Өсвөр насны хүмүүжигч энэ хуулийн 106, 107 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээхээс гадна дараах эрх зүйн баталгаагаар хангагдана.

97.1.1.сургалт, нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий өөрсдийн хүсэл санаачилгаар дугуйлан, секц, клуб байгуулах, уралдаан, тэмцээн зохион байгуулах, оролцох;

97.1.2.байгууллагын захиргаанд ерөнхий боловсролын сургалтад шаардлагатай ном, сурах бичиг, сургалтын орчныг шаардах;

97.1.3.элсэлтийн ерөнхий шалгалтад бэлдэх, өгөх;

97.1.4.энэ хуулийн 130 дугаар зүйлд заасны дагуу чөлөө авах.

97.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нийгмийн ажилтан шинээр ирсэн өсвөр насны хүмүүжигчид байгууллагын дотоод журам, цагийн хуваарь, нийгэмшүүлэх хөтөлбөр, түүний үр дагавар, эрх, үүргийн талаар мэдээлэл өгнө.

95.1.Хаалттай хорих ангийн тусгай төрөлд бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ. Энэ төрөлд хоёр хоригдлыг нэг дор ял эдлүүлж болно.

95.2.Хоригдлыг тусгай тоноглолдон газарт, зохих хяналт хамгаалалтад өдөрт нэг цагаас доошгүй хугацаагаар гадаалуулна.

95.3.Хоригдол гадаалуулах хугацаанд алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, бие эрхтэндээ гэмтэл учруулахыг завдсан тохиолдолд гадаалуулах ажиллагааг даруй зогсооно.

95.4.Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.

95.5.Хоригдол 90 хоногт нэг удаа түр уулзалт хийж, 30 хоногт нэг удаа захидал явуулж, 90 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа угсаар ярьж болно.

95.6.Хоригдлыг түр хугацааны уулзалт хийх үед харуул хамгаалалтын ажилтан хяналт тавина.

95.7.Хоригдол төрөл, садангийн хүнтэй 6 сард нэг удаа 24 цагийн удаан хугацааны уулзалт хийж болно.

95.8.Хоригдол алба хаагчтай бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр уулзалтын өрөө, төлөөлөгчийн болон эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтны албан өрөөнд уулзах бөгөөд гарын гав, шаланд бэхлэгдсэн хөлийн гав хэрэглэнэ.

95.9.Хорих өрөөний түлхүүрийг ерөнхий жижүүр биечлэн хариуцаж, өрөөг онгойлгох үед заавал байлцана.

95.10.Байгалийн гамшиг, гал түймэр, үер, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, цагийн тариа хийх зэрэг онцгой тохиолдлоос бусад үед шөнийн цагт хорих өрөөний хаалга онгойлгохыг хориглоно.

95.11.Хоригдлыг хорих өрөөнөөс гаргах тохиолдолд хаалганы нээлхийгээр гарыг ард нь гавлан хуяглан хүргэнэ.

95.12.Хоригдлыг хорих өрөөнд нь эмчлэх ба зайлшгүй тохиолдолд эмчилгээг эмч, сувилагчийн өрөөнд хийхэд гарын гавыг урд нь, эсхүл эмнэлгийн ор, сандалтай холбон гавлах бөгөөд хамгаалалтын ажилтан эмчилгээний хугацаанд байлцана.

#### **96 дугаар зүйл.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүмүүжигчид ял эдлүүлэх**

96.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүмүүжигчийн ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.

96.2.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүмүүжигчид оногдуулсан хорих ялыг эдлүүлэхэд тусгаарлагдсан байдлаар зохион байгуулна.

96.3.Өсвөр насны хүмүүжигч арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хүмүүжигчийг арван найман

## 98 дугаар зүйл.Хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хүнд ял эдлүүлэх

98.1.Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ.

98.2.Эмэгтэйчүүдийн нээлттэй хорих ангид анх удаа гэмт хэрэг үйлдэж таван жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж таван жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ. Хоригдол долоо хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, долоо хоногт нэг удаа утсаар ярьж болно. Хоригдлын илгээмж авах тоо болон хугацааг хязгаарлахгүй.

98.3.Шүүхээс хаалттай хорих ангид ял эдлүүлэхээр шийтгүүлсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн хаалттай хорих ангид эдлүүлнэ. Хоригдол 30 хоногт нэг удаа түр, 60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, 30 хоногт нэг удаа утсаар ярьж болно.

98.4.Ял эдэлж байгаа хоригдлыг хоёр нас хүртэлх хүүхдийнх нь хамт байлгаж болно. Илгээмж явуулахад хугацааны хязгаарлалтыг харгалзахгүй.

98.5.Хүүхэд нь хоёр нас хүрсэн боловч эмэгтэй хоригдлын ял эдлэх үлдэгдэл хугацаа нэг жилээс илүүгүй тохиолдолд хорих ял эдлэх хугацааг дуусах хүртэл хүүхдийг үргэлжлүүлэн хамт байлгаж болно.

98.6.Хорих анги нь эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.

98.7.Эмэгтэй хүнд оногдуулсан бүх насаар хорих ялыг энэ хуулийн 95 дугаар зүйлд заасны дагуу эдлүүлнэ.

## 99 дүгээр зүйл.Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, түүний чиг үүрэг

99.1.Хорих ял эдлүүлэх алба нь нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хорих анги нь хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэг, цагдан хорих төв нь эмнэлэгтэй байна.

99.2.Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг нь хаалттай төрөлтэй байна.

99.3.Нэгдсэн эмнэлэг дараах үүрэгтэй:

99.3.1.Хоригдлыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

99.3.2.Хорих ангийн эмнэлгийн салбарыг мэргэжлийн удирдлагаар хангах;

99.3.3.Хоригдлыг хорих ялаас хугацааны өмнө суллах тухай тодорхойлолт, саналыг ял эдлүүлж байгаа хорих ангийн захиргаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст гаргах;

99.3.4.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолоход шаардлагатай тодорхойлолт, лавлагааг тухайн хоригдлын ял эдлэх байгаа хорих ангийн харьяалагдах аймаг, сум, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх эрүүл мэндийн магадлалын зөвлөлд гаргах.

99.3.5.Хоригдол, алтан ял эдэлж байх хугацаандаа ялаас чөлөөлөх өвчний жагсаалтад багтсан өвчнөөр өвдөж, ял эдлэх боломжгүй болсон эсэх талаар дүгнэлт гаргуулахаар харьяалах прокурорт санал гаргах;

99.3.6.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмчилгээ, түүний үр дүнд хяналт тавих.

99.4.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг дараах үүрэгтэй:

99.4.1.Хоригдлын дунд бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, оношлох, хяналт тавих, эмчлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбогдсон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

99.4.2.Хоригдлыг хорих ангийн төрөл харгалзахгүй өвчлөл, халдварын байдлаар ангилан тусад нь байрлуулж, ял эдлүүлэх;

99.4.3.Ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах.

99.5.Төлбөрийн чадваргүй хоригдлын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн бол зардлыг улсын төсвөөс гаргана.

99.6.Эрүүл мэндийн асуудал харуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хорих эмнэлгийг мэргэжил, арга зүйн удирдлага, боловсон хүчнээр хангана.

99.7.Хоригдолд эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан нөхцөлд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

99.8.Хоригдолд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэг нь эмчлэх эрх бүхий эмнэлгийн мэргэжилтэнтэй байх ба эмнэлгийн үзлэг хийх, анхан шатны болон амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтын тоног төхөөрөмж, өрөө тасалгаатай байна.

99.9.Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хоригдлыг эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны болон бүх насаараа хорих ял шийтгүүлсэн гэж ангилан байрлуулах ба тасгуудыг өвчтөн чөлөөтэй явахгүй байхаар тусгаарлана.

99.10.Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг нь төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдтэй, орон нутаг дахь хорих анги нь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хоригдлыг эмчлэх чиглэлээр хамтран ажиллаж болно.

99.11.Хүнд өвчний шинж тэмдэг илэрсэн, өвчний онош тодорхойгүй, нэмэлт оношилгоо, шинжилгээ хийлтэх шаардлагатай, онош тодорхой боловч эмчилгээний үр дүн хангалтгүй байгаа тохиолдолд хоригдлыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэгт харуул хамгаалалттайгаар хэвтүүлэн эмчлүүлнэ.

99.12.Хоригдлыг төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг болон аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлэх тохиолдолд прокурорын байгууллагад даруй мэдэгдэнэ.

99.13.Шаардлагатай тохиолдолд хорих анги нь холбогдох эмнэлгийн байгууллагад яаралтай тусламжийн дуудлага өгч, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч болно.

99.14.Энэ хуулийн 99.12-т заасны дагуу шилжсэн хоригдлын хэвтэн эмчлэх өрөөг бусад өвчтөнөөс тусгаарлах, цонх, хаалганд төмөр сараалжин хаалт хийх, дүрс бичлэгийн хяналт тавих, харуул хамгаалалтыг зохион байгуулах, эмнэлэгт хэвтэн үйлчлүүлж буй үйлчлүүлэгч, эмч, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах ажлыг түүнийг шилжүүлсэн хорих анги, байгууллага тухайн эмнэлгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.

99.15.Хоригдлын эрүүл мэндийн байдал маш хүнд, хүнд, хүндэвтрээр үнэлэгдсэн, өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асаргаа шаардлагатай тохиолдолд эмчлэгч эмчийн дүгнэлтийг үндэслэн гэр бүлийн гишүүнээр асаргаа, сувилгаа хийлгэх асуудлыг хорих ангийн дарга шийдвэрлэнэ.

99.16.Хоригдлын биеийн байдал хүнд, эсхүл мэс засал хийлгэснээр бусдын асаргаа зайлшгүй шаардлагатай бол гэр бүлийн гишүүдийн хүсэлтийг харгалзан, хорих ангийн даргын шийдвэрээр харуул хамгаалалтын хяналт тавих боломжтой, тусгаарласан өрөөнд төрөл садангийн нэг хүнийг 14 хоног хүртэл хугацаагаар сахиураар байлгаж болох ба хорих ял эдлүүлэх албаны даргад мэдэгдэнэ.

#### **100 дугаар зүйл.Хоригдолд хорих ангиас гадуур эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх**

100.1.Хүнд өвчтэй хоригдолд харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллага дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ:

100.1.1.хорих ангийн дуудлагаар яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх;

100.1.2.хорих ангитай байгуулсан гэрээний дагуу төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

100.1.3.хоригдлын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох асуудлыг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зааврын дагуу шийдвэрлэх.

100.1.4.эрүүл мэндийн даатгал бүрэн төлөөгүй хоригдлыг хорих ангид хуваарилахын өмнө болон зургаан сар тутамд халдварт өвчин илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

#### **101 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дэргэдэх зөвлөл**

101.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дэргэд шинээр хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлэх хорих анги болон хорих ангийн төрлийг тогтоох чиг үүрэг бүхий зөвлөл Цаашид "Зөвлөл" гэж/ ажиллана.

101.2.Зөвлөлийн ажиллах дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

101.3.Зөвлөл нь энэ хуулийн 101.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тогтоол гаргах бөгөөд уг тогтоолыг 10 хоногийн дотор прокурорт хянуулахаар хүргүүлнэ.

101.4.Зөвлөлийн гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хариуцна.

#### **102 дугаар зүйл.Хорих ял эдлүүлэх хорих ангийн төрлийг өөрчлөх**

102.1.Хорих ял эдэлж байгаа хоригдлын ял эдлүүлэх хорих ангийн төрлийг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу өөрчилж болно.

102.2.Төрлийг өөрчлөх тухай тогтоолыг энэ хуулийн 101.1-д заасан Зөвлөл прокурорт хүргүүлж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

102.3.Хаалттай хорих ангийн онцгой төрөлд эдлэх ялын гуравны хоёрыг эдэлсэн, сүүлийн нэг жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй бол хоригдлын ял эдлэх төрлийг бууруулна.

102.4.Хоригдол нэг жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн төрлөөс онцгой төрөлд хүндрүүлэн шилжүүлнэ.

102.5.Энэ хуулийн 102.1-д заасны дагуу нээлттэй хорих ангид шилжүүлсэн хоригдол сахилгын зөрчил гаргасан тохиолдолд хаалттай хорих ангид шилжүүлэн ял эдлүүлэх саналыг прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор үндэслэлийг хянаж, шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

102.6.Энэ хуулийн 102.2-т заасан Зөвлөлийн саналыг үндэслэн хоригдлын ял эдлэх төрлийг өөрчлөх асуудлыг прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

102.7.Хорих ангийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангах болон эзэмшсэн мэргэжлийн дагуу хөдөлмөрлүүлэх зэрэг шалтгаанаар хорих ангийн төрлийг өөрчлөхгүйгээр хорих анги солихоор болсон тохиолдолд хорих анги солих саналыг прокурорт даруй хүргүүлнэ.

102.8.Прокурор хорих анги солих саналыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

102.9.Нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хоригдлыг хорих ял эдэлж байсан хорих ангиас өөр хорих

ангид ял эдлүүлэх шаардлагатай бол хорих анги эмчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэж, энэ талаар прокурорт мэдэгдэнэ.

#### **103 дугаар зүйл.Хоригдлыг хуяглан хүргэх, хүлээн авах**

103.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь хоригдлыг ял эдлүүлэх хорих ангид нь хүргэх хуяглан хүргэх чиг үүрэг бүхий нэгжтэй байна.

103.2.Өсвөр насны хүмүүжигч, эрэгтэй, эмэгтэй, халдварт өвчтэй хоригдлыг тусад нь тээвэрлэх байдлаар хоригдлыг хуяглан хүргэнэ.

103.3.Хуяглан хүргэх ажиллагаанд ашиглагдах автомашинд тавигдах ерөнхий шаардлага болон хуяглан хүргэх ажиллагааны зааврыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

103.4.Хоригдлыг хорих ангийн даргын томилсон бүрэлдэхүүн хүлээн авна.

103.5.Шинээр хүлээн авсан хоригдлыг 14 хүртэл хоног тусгаарлан байрлуулж, ангийн дотоод журамтай танилцуулан зохих сургалтад хамруулж, хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч түүнтэй биечлэн уулзалт хийж, зан байдлыг тодорхойлно.

103.6.Хоригдлыг тусгаарлах тасалгаанд байрлуулах хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

103.6.1.тухайн ангийн хоригтой бус, хоригдлын эрх, үүргийн талаар танилцуулах;

103.6.2.хоригдлын боловсролын түвшин, мэргэжил, хөдөлмөрийн дадлага, чадварыг тогтоох;

103.6.3.хоригдлыг байрлуулах, хөдөлмөрлөх хуваарь гаргах;

103.6.4.хоригдлыг нэг заагарын гадуур хувцас, гутлаар хангах;

103.6.5.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

103.6.6.хоригдол тухайн ангид ял эдлэхээр ирсэн талаар түүний ар гэрт нь мэдэгдэж, хорих ангийн байршил, хориглох эд зүйлсийг танилцуулах.

103.6.7.хорих ангийн дотоод журамтай танилцуулах, сургалтад хамруулах;

103.6.8.сэтгэл зүйн зан байдлыг тодорхойлох;

103.6.9.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх зааварчилгаа өгөх.

103.7.Хоригдлын мөнгө, үнэт эдлэл, үнэт цаас зэргийг ар гэрт нь хүлээлгэн өгч тэмдэглэл үйлдэн хувийн хэрэгт хавсаргана.

103.8.Энэ хуулийн 103.6-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хоригдлыг эрх бүхий алба хаагчийн саналыг үндэслэн ангийн даргын баталсан хуваарийн дагуу хорих өрөөнд байрлуулна.

103.9.Хоригдлыг хорих байгууллагад анх хүлээн авах, түр болон удаан хугацааны уулзалтад орсны дараа, бусад байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх, түүнээс хүлээн авахдаа бие болон эд зүйлд нь үзлэг хийнэ.

103.10.Хоригдлын биед шарх, сорви, гэмтэл бэртэл байгаа эсэх, хэрэв байгаа бол түүний хэлбэр, хүрээ, шинж байдлын талаар тэмдэглэлд тусгаж, гэрэл зураг, дүрс бичлэгийн хэрэгслийн тусламжтай бэхжүүлнэ. Хоригдлын биед үүссэн шарх, сорви, гэмтэл бэртэл нь аливаа хууль бус үйлдлийн улмаас үүссэн гэх үндэслэлтэй бол шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шалгуулна.

#### **104 дүгээр зүйл.Хоригдлыг тусад нь ял эдлүүлэх**

104.1.Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүмүүжигч болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ.

104.2.Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ.

104.3.Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусгаарлан ял эдлүүлнэ.

104.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт шийтгүүлсэн хоригдлыг бусад төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос тусад нь ял эдлүүлнэ.

#### **105 дугаар зүйл.Хорих өрөөнд тавигдах шаардлага**

105.1.Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байна.

#### **106 дугаар зүйл.Хоригдлын эрх**

106.1.Хоригдол дараах эрх эдэлнэ:

106.1.1.хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах;

106.1.2.хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;

106.1.3.өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;

106.1.4.холбогдох зардлаа өөрөө хариуцаж хорих байгууллагаас тогтоосон газарт шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих;

106.1.5.эмнэллийн тусламж авах;

106.1.6.энэ хуульд заасны дагуу гэр бүлийн гишүүнтэй удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, суурин утас, захидлаар харилцах, илгээмж авах, өөрийн нэрийн дансаар дамжуулж мөнгөн гуйвуулга авах, явуулах;

- 106.1.7.бусдад төлөх гэм хорын төлбөргүй бол өөрийн нэрийн данснаас сард 1 удаа өөрийн төрөл, садангийн хүнд мөнгө шилжүүлэх;
- 106.1.8.хоригдлын хөдөлмөрийн хөлсийг энэ хуулийн 111.3, 111.4, 111.5-д заасны дагуу суутгасан суутгал, зарцуулалтын талаар танилцах;
- 106.1.9.өөрийн зардлаар өдөр тутмын сонин, сэтгүүл захиалах, хорих анги дахь номын санг үнэ төлбөргүй ашиглах;
- 106.1.10.урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох;
- 106.1.11.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах;
- 106.1.12.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах;
- 106.1.13.өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх;
- 106.1.14.энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөгдсөн тоо, хэмжээний хоол, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн болон нэн тэргүүний бусад зүйл худалдан авах;
- 106.1.15.шашны зан үйл үйлдэх;
- 106.1.16.өөрийн зардлаар их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад хамрагдах;
- 106.1.17.хуваарилалдан очсон хорих ангийн байршил, холбоо барих мэдээллийн талаар гэр бүлийн гишүүнд мэдэгдэх.
- 107 дугаар зүйл.Хоригдлын үүрэг**
- 107.1.Хоригдол дараах үүрэг хүлээнэ:
- 107.1.1.хорих ангид мөрдөх хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас баталсан дүрэм, журам, хорих байгууллага, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх;
- 107.1.2.хорих байгууллагаас тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөх;
- 107.1.3.хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих;
- 107.1.4.тогтоосон журмын дагуу зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах;
- 107.1.5.эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх;

107.1.6.хоригдол хувцас, ор дэрний хэрэглэлийг эдэлгээний хугацаанаас өмнө хэрэглэх боломжгүйгээр гэмтээж, устгасан бол холбогдох зардлыг төлөх;

107.1.7.зээмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, эвдэж гэмтээхгүй байх;

107.1.8.гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд уриалах, өдөөн хатгах, зохион байгуулах идэвхтэй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

107.1.9.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтан, бусад хоригдол болон хорих байгууллагад байгаа бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах;

107.1.10.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих;

107.1.11.ажлын байрыг дур мэдэн орхихгүй байх;

107.1.12.харуул хамгаалалтын техник, тоног төхөөрөмжийд зөвшөөрөлгүй хүрэх, эвдэж гэмтээхгүй байх.

107.2.Хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлах, хоригдол хөдөлгөөнт утас ашиглах, хадгалах болон бэлэн мөнгө, валют, үнэт зүйл ашиглах, хадгалахыг хориглоно.

107.3.Хоригдол энэ хуульд заасан эрхээ эдлэхдээ энэ хууль, хорих ангийн дотоод журам болон бусад хоригдол, хорих ангийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүрэгтэй.

107.4.хоригдлын хувцасны баруун энгэрт хувийн дугаар, овог, нэрийг бичсэн энгэрийн тэмдэг байна.

107.5.Хорих ял эдэлж байгаа гадаадын иргэн энэ зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийн зэрэгцээ гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулдан асуудал хариуцсан нэгжээр дамжуулан өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газрын ажиглалттай уулзах, харилцах эрхтэй.

#### **108 дугаар зүйл.Хоригдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх**

108.1.Хоригдол шүүхийн шийтгэх тогтоол гарахаас өмнө, эсхүл ял эдэлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогдсон бол прокурорын зөвшөөрлийг үндэслэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлж болно.

108.2.Энэ хуулийн 108.1-д заасны дагуу шилжүүлэх тохиолдолд хоригдлыг яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг үндэслэн шилжүүлэн авсан албан тушаалтан цагдан хорих төв, эсхүл цагдан хорих байранд хүргэх бөгөөд уг хугацааг ял эдэлсэн хугацаанд тооцно.

#### **109 дүгээр зүйл.Хоригдол бусадтай уулзах, харилцах**

109.1.Хоригдол зохих хяналтад хувийн хэрэгт бүртгэгдсэн эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам

булд хамт амьдардаг ач, эзэтэй удаан, бусад хүнтэй түр хугацааны уулзалт хийж болно.

109.2.Хорих ангийн дарга түр хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа гурван цаг хүртэл, удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа 72 цаг хүртэл байхаар тогтооно.

109.3.Удаан хугацаагаар уулзах хүн хоригдлын гэр бүлийн гишүүн мөн болохыг нотолсон хууль ёсны баримт бичигтэй байна.

109.4.Хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хорих ангийн болон хоригдлын аюулгүй байдлыг хангах зорилгоор хоригдлын захидал, илгэмжид үзлэг хийнэ.

109.5.Хоригдлын нэг удаа утсаар ярих хугацаа таван минутаас илүүгүй байна.

109.6.Хорих ангийн алба хаагч хоригдол ямар дугаарын утсанд, ямар хугацаанд ярьсан тухай дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэж, бүртгэл хөтөлнө.

109.7.Хоригдол захидал илгээх, утсаар ярих, удаан хугацааны уулзалт хийх зардлыг харуулна.

109.8.Түр хугацааны уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд түр хугацааны уулзалттай адилтган үзнэ.

109.9.Хорих байгууллага цахим уулзалтыг интернэт сүлжээнд холбогдсон тусгайлан тохижуулсан зориулалтын өрөөнд зохион байгуулна.

109.10.Цахим уулзалтын үргэлжлэх хугацаа 30 минут хүртэл байна.

109.11.Нийгмийн ажилтан хоригдолд цахим уулзалт хэрхэн хийх талаарх зааврыг танилцуулж, хяналт тавин ажиллана.

109.12.Цахим уулзалтын хугацаанд нууц тэмдэг, үл ойлгогдох хэлээр ярих болон хүсэлт гаргаагүй иргэнтэй харилцах, хорих байгууллагын аюулгүй байдал, харуул хамгаалалтын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар ярих оролдлого хийх тохиолдолд цахим уулзалтыг шууд зогсооно.

109.13.Хорих байгууллага нь хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн олон нийтийн арга хэмжээг энэ хуулийн 109.1-д заасан иргэдийг хамруулан жилд нэг удаа зохион байгуулсныг хоригдлын түр, удаан хугацааны уулзалтад тооцохгүй.

#### **110 дугаар зүйл.Хоригдлын хөдөлмөр, түүний нөхцөл**

110.1.Хоригдлын хөдөлмөрийг холбогдох хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.

110.2.Хорих анги хоригдлыг хөдөлмөрлөх, тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх, дадлага олгох тэгш нөхцөл, боломж бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

110.3.Хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

110.4.Хоригдлоор ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзаж бөгөөд мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

110.5.Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлыг хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээлд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан прокурорын зөвшөөрлөөр зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно.

110.6.Гэрээнд хоригдлыг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах, ажиллах болон чөлөөт цаг, гэрээг цуцлах үндэслэл, тавигдах шаардлага, олгох цалин хөлс, албан хаагч, хоригдлын байр, эргэлт уулзалтын байрны ахуй нөхцөлийн талаар тусгана.

110.7.Хоригдлыг гэрээгээр ажиллуулах үед гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд холбогдох харууллагыг хорих ангийн дарга бүрэн харуулна.

110.8.Хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлнэ.

110.9.Нээлттэй хорих ангийн хоригдлыг хорих байгууллагын аж ахуйн үйлчилгээнд хөдөлмөрлүүлж болох ба хоригдлын хөдөлмөрийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.

110.10.Хуульд өөрөөр заагаагүй бол хоригдлыг төрийн нууц, цэрэг стратегийн холбогдолтой болон тусгай төрөл бүхий онцгой объектод хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

110.11.Хоригдолд хөдөлмөрийн хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгоно.

110.12.Хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй, 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй хоригдлыг бие, эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно.

110.13.Нээлттэй хорих ангид ял эдэлж буй хоригдлын мэргэжил, боловсрол, ял шийтгэл, сэтгэл зүйн болон зан байдлын тодорхойлолтыг үндэслэн хамгаалалтын бүсээс гадна харуул хамгаалалтын зохих шаардлага хангасан нөхцөлд, хорих ял эдлүүлэх албанаас ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хөдөлмөрлүүлж болох бөгөөд энэ талаар прокурорт мэдэгдэнэ.

#### **111 дүгээр зүйл.Хоригдлын хөдөлмөрийн хөлс**

111.1.Хоригдлыг хорих байгууллагын хөдөлмөрийн дадал олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулах зорилгоор хөдөлмөрт хамруулснаас бусад тохиолдолд хийсэн хөдөлмөрт нь тохирсон цалин хөлс олгох бөгөөд хоригдлын хөдөлмөрийн нормыг ажлын цагаар, эсхүл ажлын гүйцэтгэлээр тооцно.

111.2.Гэрээний үндсэн дээр хоригдлыг хөдөлмөрлүүлсэн ажил олгогч хоригдлын хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ.

111.3.Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс дараах байдлаар хоригдолд олгоно:

111.3.1.1.000.000 хүртэлх цалин хөлсний орлогоос 70 хувь;

111.3.2.2.000.000 хүртэлх цалин хөлсний орлогоос 65 хувь.

111.4.Энэ хуулийн 111.3-т заасны дагуу хоригдолд оногдох цалин хөлснөөс 70 хувийг шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөр, хоригдлын буруутай үйлдлээс хорих ангид учирсан хохирлыг суутгаж, үлдэх хэсгийг хоригдлын нэрийн дансанд төвлөрүүлнэ.

111.5.Хоригдол өөрөө хүсэлт гаргавал энэ хуулийн 111.3-т заасны дагуу оногдсон цалин хөлсийг бүхэлд нь шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөр, хоригдлын буруутай үйлдлээс хорих ангид учирсан хохирлыг төлүүлж болно.

111.6.Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс энэ хуулийн 111.3-т заасны дагуу хуваарилснаас үлдэх хувийг дараах байдлаар зарцуулна:

111.6.1.улсын төсөвт 70 хувь;

111.6.2.харуул, хамгаалалтыг сайжруулах үйл ажиллагаанд 10 хувь;

111.6.3.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид 20 хувь.

111.7.Хоригдлын хөдөлмөрийн хөлсийг энэ хуулийн 111.3, 111.4, 111.5-д заасны дагуу суутгасан суутгал, зарцуулалтын талаар хоригдолд өөрт нь тухай бүр танилцуулна.

111.8.Хоригдол энэ хуулийн 111.4-т заасны дагуу зөвхөн өөрийн нэрийн дансаар дамжуулан нэн тэргүүний хэрэгцээт хүнсний болон ахуйн барааг сар бүр авах бөгөөд үлдсэнийг суллагад үед өөрт нь олгоно.

111.9.Хоригдлын хөдөлмөрийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байх бөгөөд тухайн ажлын байрны зах зээлийн ханштай тэнцэхүйц байна.

111.10.Хоригдлын нарийн мэргэшил, мэдлэг, мэргэжил шаардлага болон онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн үнэлгээг зах зээлийн доод үнэлгээнээс багагүй байна.

111.11.Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс хорих ял эдлэхээс өмнөх эрүүл мэндийн даатгалын дутуу хэсгийг нөхөн төлүүлнэ.

#### **112 дугаар зүйл.Хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглох**

112.1.Дараах нөхцөлд хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглоно:

112.1.1.харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй;

112.1.2.хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй, эсхүл энэ талаар зааварчилга өгөгдөөгүй;

112.1.3.эмч болон сэтгэл зүйч хоригдлын биеийн эрүүл мэндийн байдал дордсон, сэтгэл санаа тогтворгүй байгаа тухай тодорхойлолт гаргасан.

#### **113 дугаар зүйл.Хоригдлыг хорих ангийн гадна хөдөлмөрлүүлэх**

113.1.Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хорих ялын 50-нас дээш хувийг эдэлсэн хоригдлыг харуул хамгаалалтгүй, нээлттэй, хаалттай хорих ангийн энгийн, онцгой төрөлд ял эдэлж байгаа хоригдлыг хорих ангийн хамгаалалтын хашаанаас гадна прокурорын зөвшөөрлөөр гэрээний үндсэн дээр харуул хамгаалалттай хөдөлмөрлүүлж болно.

113.2.Энэ хуулийн 113.1-д зааснаас бусад тохиолдолд хоригдлыг хорих ангийн гадна хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

#### **114 дүгээр зүйл.Хоригдлыг урамшуулах**

114.1.Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлсэн хоригдлыг хорих ангийн даргын шийдвэрээр дараах хэлбэрээр урамшуулна:

114.1.1.энэ хуульд заасан түр, удаан хугацааны уулзалтын тоог 45 хоногт тус бүр нэгээр нэмэгдүүлэх;

114.1.2.хуульд заасан журмын дагуу шагналын хоног олгох;

114.1.3.хорих ангийн дотоод журмын дагуу хориглоогүй үнэ бүхий эд зүйлээр урамшуулах.

#### **115 дугаар зүйл.Хоригдолд шагналын хоног олгох**

115.1.Хоригдол хууль тогтоомж, хорих ангийн дотоод журмыг мөрдөж, хорих ял эдлэх хугацаанд сүүлийн нэг жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, нийгэмшүүлэх болон сэтгэл зүйн хөтөлбөр болон хөдөлмөрт хамрагдаж, өөрийн зан үйл, хувийн байдлаараа хорих ангийн алба хаагчаас эерэг үнэлгээ авсан тохиолдолд түүнд шагналын хоног олгоно.

115.2.Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дэргэд хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн төрлийг өөрчлөх болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн дүрэм, ажиллах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

115.3.Хоригдол энэ хуулийн 115.1-д заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрт хамрагдсан, тухайн сард ажилласан хугацаа, ажлын бүтээмж, чанарыг үндэслэн нэг сард 10 хүртэл хоногийн шагналын хоног олгоно.

115.4.Шагналын хоног олгоходоо хоригдлын илүү цагаар, шөнийн болон амралтын цагаар, нийтээр тэмдэглэх баярын өдөр ажилласан цагийг 1.5 дахин нэмэгдүүлж тооцно.

115.5.Хоригдолд олгох шагналын хоног нь нэг улиралд 30 хоногоос илүүгүй байна.

115.6.Хоригдолд олгосон шагналын хоногийг хоригдлын эдлэх ялын хугацаанаас хасч тооцно.

**116 дугаар зүйл.Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах**

116.1.Хорих анги нь Эрүүгийн хуульд заасан үндэслэлээр хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох хурлыг 30 хоног тутамд зохион байгуулна.

116.2.Энэ хуулийн 116.1-д заасан хурлаар хоригдол хуульд заасан шаардлагыг хангасан гэж шийдвэрлэсэн тохиолдолд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга хорих ялаас хугацаанаас өмнө суллуулах, хяналт тогтоох саналаа хурлын тэмдэглэл, шаардлагатай бусад мэдээлэл, баримт бичгийн хамт ажлын таван өдрийн дотор прокурорт хүргүүлж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл 10 хоногийн дотор дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэх ба шүүх 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.

116.3.Хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолох тухай хорих ангийн даргын саналыг прокурор хүлээж аваагүй бол дөрвөн сарын дотор, прокурорын дүгнэлтийг шүүх хангаагүй бол уг асуудлыг зургаан сарын дотор дахин авч хэлэлцэхгүй.

**117 дугаар зүйл.Нээлттэй хорих ангид шилжүүлэх санал гаргах**

117.1.Сахилгын зөрчил гаргаагүй, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж урамшуулал авч, хорих анги дахь сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцож байсан хоригдол Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасан хугацаанаас нэг жилийн өмнө нээлттэй хорих ангид ял эдлүүлэх саналыг энэ хуулийн 101.1-д заасан Зөвлөлөөр хэлэлцэж, саналаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

**118 дугаар зүйл.Хоригдолд хүлээлгэх сахилгын шийтгэл**

118.1.Хоригдол хууль тогтоомж, хорих ангид тогтоосон төрөл, журам, хуулиар хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр дараах сахилгын шийтгэл оногдуулна:

118.1.1.хоног, сар, улирал, жилд авах түр, удаан хугацааны уулзалт, эсхүл утсаар ярих эрхийг гурван сар хүртэл хугацаагаар хасах;

118.1.2.сахилгын хорих байранд хорих;

118.1.3.тухайн сар, улирал, жилд олгосон шагналын хоногийг хасах.

118.2.Энэ хуулийн 118.1.1-д заасан түр, удаан хугацааны уулзалт хийх эрхийг хасах шийтгэлийг өсвөр насны хүмүүжигчид оногдуулахгүй.

57

118.3.Хоригдлыг ямар үйлдэлд буруутгаж байгааг урьдчилан мэдээлж, өөрийгөө өмгөөлөх зохих боломж олгохгүйгээр шийтгэж болохгүй.

118.4.Хоригдлын хорих ангийн дотоод журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй гэж хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хорих ангийн дарга прокурорт даруй мэдэгдэж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулна.

118.5.Сахилгын нэг зөрчил гаргасан хоригдолд энэ хуулийн 118.1-д заасан шийтгэлийг давхардуулан оногдуулахыг хориглоно.

118.6.Хоригдолд сахилгын шийтгэл оногдуулсан тушаал, зөрчил шалгасан материалын хуулбарын хамт прокурорт даруй хүргүүлнэ.

118.7.Өсвөр насны хүмүүжигчид энэ хуулийн 118.1.3-т заасан сахилгын шийтгэлийг ногдуулна.

118.8.Хоригдол сахилгын шийтгэл оногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор дахин зөрчил гаргаагүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

**119 дүгээр зүйл.Хоригдлыг сахилгын хорих байранд хорих**

119.1.Араан найман насанд хүрсэн эрэгтэй хоригдлыг 30 хүртэл хоног, эмэгтэй хоригдлыг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд эрэгтэй хоригдлыг 60 хүртэл хоног, эмэгтэй хоригдлыг 30 хүртэл хоног сахилгын хорих байранд ганцаарчлан хорино.

119.2.Хорих ангийн дотоод журмыг ноцтой зөрчсөн дараах тохиолдолд сахилгын хорих байранд хорих сахилгын шийтгэл оногдуулна:

119.2.1.хорих ангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын болон хорих ангийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн, доромжилсон, эсхүл хорих ангийн алба хаагч, түүний гэр бүлийн гишүүнд хүч хэрэглэхээр заналхийлсэн, айлган сүрдүүлсэн;

119.2.2.хоригдол санаатайгаар өөртөө гэмтэл учруулсан;

119.2.3.бусад хоригдолд хүч хэрэглэсэн, нэр төрийг нь гугаан доромжилсон, заналхийлсэн;

119.2.4.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөт бодис олж авсан, хадгалсан, хэрэглэсэн;

119.2.5.ашиг хонжоо олох зорилгоор мөрийтэй толгоом тоглуулсан, толгосон, хөдөлгөөнт угас олж авсан, ашигласан, хадгалсан;

119.2.6.гурван сарын хугацаанд хоёр, эсхүл түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан.

119.3.Хорих ангийн дарга хоригдлыг сахилгын хорих байранд хорих тухай шийдвэрийг хоригдлын зөрчлийн тодорхойлолт, зөрчлийг шалган тогтоосон материалтай танилцаж, хорих ангийн эрх бүхий алба хаагчийн саналыг үндэслэн гаргана.

58

заасан хугацаагаар, сахилгын шийтгэл оногдуулах хангалттай үндэслэлгүй тохиолдолд тусгаарлах тасалгаанд шилжүүлнэ.

121.4.Энэ хуулийн 121.2, 121.3-т заасан хугацаанд хоригдлын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюул, эрсдэл арилаагүй бол хорих ангийн даргын саналыг үндэслэн хорих ангийн төрлийг өөрчлөхгүйгээр өөр хорих ангид шилжүүлэх асуудлыг хорих ангид харьяалан хяналт тавьж байгаа прокурорын газрын дээд шатны прокурорт танилцуулж шийдвэрлэнэ.

121.5.Хорих анги, хорих ангийн алба хаагч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авсан хоригдлыг хамгаалах ажиллагаанд бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

121.6.Хорих ангийн хамгаалалтын бүсээс гадна ажиллаж байгаа хоригдлын амь нас, эрүүл мэндэд халдаж болзошгүй тухай мэдээллийг хорих ангийн алба хаагч олж мэдсэн, эсхүл цагдаагийн байгууллагын болон бусад байгууллага, иргэдийн мэдээлэл ирсэн бол харуул хамгаалалтын байнгын хяналтад авах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх зэрэг шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна.

#### **122 дугаар зүйл. Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгааны нөхцөл**

122.1.Сахилгын хорих байранд хоригдсон хориголд гудас, хөнжил, аяга, халбага, ариун цэврийн хэрэгсэл, оо, сойзыг өглөө, оройн цагт олгож, бусад үед хураан авна.

122.2.Хоригдлыг харуул хамгаалалтын ажилтны хяналтад өдөрт нэг удаа 30 минутын хугацаатай гадаалуулах ба долоо хоногт нэг удаа усанд оруулна.

122.3.Сахилгын хорих байрны хаалгыг давхардуулан нээхгүй бөгөөд эхний хаалгыг хааж, аюулгүй байдлыг хангасны дараа дараагийн хаалгыг нээнэ.

122.4.Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд хоригдож байгаа хориголд олгох хоолны илчлэгийн хэмжээг бууруулахгүй.

122.5.Хоригдлыг сахилгын хорих байрны багтаамж, хорих өрөөний тоог харгалзан ганцаарчлан болон хоёроор хорьж болох бөгөөд халдварт өвчтэй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх зуршилтай хоригдлыг тусгаарлан хорино.

122.6.Хоригдлын эрүүл мэндийн байдалд эмч, эмнэлгийн ажилтан өдөр бүр хяналт тавьж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө.

122.7.Хоригдолтой хорих байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар зөвхөн ажлын цагаар уулзаж болно.

122.8.Энэ хуулийн 120 дугаар зүйлд заасан үндэслэлээс бусад тохиолдолд хоригдлыг сахилгын хорих байрнаас гаргахыг хориглоно.

122.9.Хоригдлын уулзалт хийх, угсаар ярих, илгээмж авах, хоол, хүнсний бүтээгдэхүүн авах эрхийг сахилгын хорих байранд хоригдох хугацаанд түдгэлзүүлнэ.

119.4.Хоригдлыг сахилгын хорих байранд шилжүүлэхийн өмнө түүний эрүүл мэндийн байдалд үзлэг хийнэ.

119.5.Хоригдлыг сахилгын хорих байранд хорьсон тухай бүр прокурорт мэдэгдэнэ.

119.6.Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

119.7.Сахилгын хорих байранд хоригдсон хоригдлын уулзалт хийх, угсаар ярих илгээмж авах, хоол, хүнсний бүтээгдэхүүн авах эрхийг сахилгын хорих байранд хоригдох хугацаанд түдгэлзүүлнэ.

119.8.Энэ хуулийн 98.6-д заасны дагуу хүүхэдтэйгээ байгаа болон жирэмсэн хоригдолд сахилгын хорих байранд хорих шийтгэл оногдуулахгүй.

119.9.Хоригдлын сахилгын зөрчлийг шалгах хугацаанд түүнийг тусгаарлах тасалгаанд байлгасан хугацааг сахилгын хорих байранд хорьсон хугацаанд оруулан тооцно.

#### **120 дугаар зүйл. Сахилгын хорих байрнаас гаргах**

120.1.Хоригдлыг дараах үндэслэлээр сахилгын хорих байрнаас гаргана:

120.1.1.сахилгын хорих байранд хорих хугацаа дууссан;

120.1.2.хоригдлыг сахилгын хорих байранд үндэслэлгүйгээр хорьсон тухай прокурорын шийдвэр гарсан;

120.1.3.хорих ангид онцгой байдал зарласан, эсхүл хоригдол эрүүл мэндийн хойшлуулшгүй туслалцаа авах шаардлагатай болсон.

120.2.Энэ хуулийн 120.1.3-т заасан үндэслэл арилсан бол сахилгын хорих байранд хорих сахилгын шийтгэлийг нөхөн эдлүүлэх эсэхийг хорих ангийн дарга шийдвэрлэнэ.

#### **121 дүгээр зүйл.Хоригдлын аюулгүй байдлыг хангах, хоригдлыг тусгаарлах тасалгаанд шилжүүлэх**

121.1.Хорих анги, хорих ангийн алба хаагч хоригдлын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй гэх хангалттай үндэслэл байгаа бол даруй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

121.2.Хоригдлын амь нас, эрүүл мэндэд бусад хоригдлын хууль бус үйлдлийн улмаас хохирол, хор уршиг учрах хангалттай үндэслэл байгаа бол хорих ангийн ерөнхий жижүүрийн шийдвэрээр хоригдлыг 72 цаг хүртэл хугацаанд тусгаарлах тасалгаанд шилжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хорих ангийн даргын шийдвэрээр уг хугацааг дахин 72 цагаар сунгаж болно.

121.3.Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй хоригдолд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлтэй бол сахилгын хорих байранд хуульд

- 122.10. Тусгаарлах тасалгаа нь сахилгын хорих байртай ижил нөхцөлтэй байна.
- 122.11. Хоригдлын сахилгын зөрчлийг шалгах хугацаанд түүнийг тусгаарлах тасалгаанд байлгасан хугацааг сахилгын хорих байранд хорьсон хугацаанд оруулан тооцно.
- 122.12. Тусгаарлах тасалгаанд шилжсэн хоригдлын гудас, хөнжил, аяга, халбага, ариун цэврийн хэрэгсэл, оо, сойзыг хураан авахгүй.
- 122.13. Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд шилжүүлсэн хоригдолд энэ хуулийн 155.1.3, 155.1.6-д заасны дагуу энэ хуулийн 153.1.1, 153.1.2-т заасан тусгай хэрэгсэл хэрэглэж болно. Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд шилжүүлсэн хоригдолд тусгай хэрэгсэл хэрэглэсэн бол энэ тухай тэмдэглэлд тусган, тусгай хэрэгслийг 30 минут тутам эргэж шалгана. Хоригдлыг усанд оруулахаас бусад үед тусгай хэрэгсэл салгахыг хориглоно.
- 122.15. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн саналыг үндэслэн хорих байгууллагын даргын шийдвэрээр тусгай хэрэгслийг авч болно.
- 123 дугаар зүйл. Хоригдлын ахуйн нөхцөл**
- 123.1. Хоригдлыг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байр, ахуйн нөхцөл, энэ хуулийн 123.9-д заасан хэмжээний илчлэгтэй хоол, хүнсний бүтээгдэхүүнээр хангана.
- 123.2. Хорих анги нь хоригдлын ор, хөнжил, гудас, цагаан хэрэглэл болон хүйтэн, дулааны улирлын зориулалттай нэг загварын гадуур хувцсаар хангах ба хоригдол өөрийн зардлаар дотуур хувцас, цамц, бээлий өмсөхийг зөвшөөрнө.
- 123.3. Хоригдлын хоолны илчлэгийн хэмжээг хорих ангийн нөхцөл, хоригдлын ажлын нөхцөлийг харгалзан ялгамжтай тогтооно.
- 123.4. Эмнэлгийн комиссын дүгнэлтийг харгалзан жирэмсэн болон өвчтэй хоригдлын нөхцөлийг нь сайжруулж, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 123.5. Хоригдлыг хооллох танхим, үйлдвэрлэлийн бүс дэх тогтоосон газар, эмнэлэг, сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд, хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдлыг өрөөнд нь зохих хяналтад хооллоно.
- 123.6. Хорих байгууллага хоригдлыг хэрэгцээтэй үед уух ундны усаар хангана.
- 123.7. Хоригдол цагаан хоол, гурилан бүтээгдэхүүнийг хэрэглэж болох ба тогтоосон газарт хадгалж, ангийн даргын баталсан дотоод цагийн хуваарийн дагуу зөвшөөрөгдсөн цагт, зөвхөн хооллох танхимд хэрэглэнэ.
- 123.8. Хортой, хүнд нөхцөлд ажиллаж байгаа хоригдолд хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгоно.
- 123.9. Хоригдолд олгох хоолны илчлэгийн доод хэмжээ, орц, норм, хувцасны загвар, төрөл, тоо, эдэлгээний хугацааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв

байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

123.10. Хорих ял эдэлж байхдаа нас барсан хоригдлын тухай гэр бүлд нь мэдэгдсэнээс хойш долоо хоногийн дотор хариу ирээгүй бол хорих анги өөрийн зардлаар оршуулах бөгөөд нас барсан шалтгаан, нөхцөлийн талаарх материалыг хувийн хэрэгт хавсаргана.

123.11. Хоригдол өвчтэй нь хорих байгууллагын эмнэлгийн байгууллагаар тогтоогдсон бол энэ хуульд зааснаас гадна эмчийн заавар, зөвлөгөөний дагуу шаардлагатай эм, тариа бүхий илгээмжийг тоо харгалзахгүй авч болно.

123.12. Хорих анги хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын онцлог байдлыг хүндэтгэсэн, тэдгээрийн эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

**124 дүгээр зүйл. Хоригдлын бие, эд зүйл, хорих өрөө, сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд үзлэг, нэгжлэг хийх**

124.1. Хоригдлын бие, байр, түүний ойр орчинд алба хаагч ямар ч үед үзлэг, нэгжлэг хийж болно.

124.2. Хоригдлын биед хийх үзлэг, нэгжлэгийг хоригдолтой ижил хүйсийн алба хаагч гүйцэтгэнэ.

124.3. Сахилгын хорих байр, тусгаарлах тасалгаанд байгаа хоригдлыг хүлээлцэхдээ тухай бүр үзлэг, нэгжлэг хийнэ.

**125 дугаар зүйл. Түр ба удаан хугацааны уулзалт**

125.1. Уулзалтыг хорих ангийн даргын зөвшөөрлөөр ерөнхий жижүүр, эсхүл ээлжийн дарга зохион байгуулна.

125.2. Түр болон удаан хугацааны уулзалтын үед хууль, хорих ангийн дотоод журмыг биелүүлэх талаар хорих ангийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй болон дотоод журам зөрчсөн тохиолдолд уулзалтыг зогсоож, энэ тухай зөвшөөрөл өгсөн албан тушаалтанд мэдэгдэж, уулзалтыг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлүүлнэ.

125.3. Хорих ангийн алба хаагч уулзалтад хяналт тавьж, хоригдолд өгч байгаа хүнсний болон бусад эд зүйлд үзлэг, шалгалт хийх бөгөөд хоригдолд өгөхийг хориглосон эд зүйлс үзлэг, шалгалтаар илэрсэн тохиолдолд тэдгээрийг түр хурааж, уулзалт дууссаны дараа уулзалтаар ирсэн этгээдэд буцаан өгч, тэмдэглэл үйлдэн хоригдлын хувийн хэрэгт хавсаргана.

125.4. Хоригдлын хувийн хэрэгт албан ёсоор бүртгэгдээгүй, төрөл, садны хүн болохыг нотолсон хууль ёсны баримт бичиг, эсхүл сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолтыг этгээдтэй удаан хугацааны уулзалт хийлгэхийг хориглоно.

**126 дугаар зүйл. Уулзалтын өрөө**

126.1.Хорих анги нь хоригдол энэ хуульд заасан журмын дагуу түр хугацаагаар уулзалт хийхэд дүрс-бичлэгийн болон биечилсэн хяналт тавих, удаан хугацаагаар уулзалт хийхэд биечилсэн хяналт тавих боломж бүхий зориулалтын уулзалтын өрөөтэй байна.

126.2.Уулзалтын өрөө нь хоригдол болон уулзаж байгаа этгээдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

#### **127 дугаар зүйл.Захидал, илгээмж илгээх, мөнгөн гуйвуулга хийх**

127.1.Хорих ангийн тоо бүртгэлийн нэгж нь хоригдлыг байлцуулан захидал, илгээмжийг задлан үзлэг хийж, хүлээн авсан тухай өөрөөр нь гарын үсэг зуруулах бөгөөд хориглосон зүйл илэрсэн тохиолдолд устгаж, эсхүл хураан авч суллагдах үед нь буцаан олгоно.

127.2.Хоригдолд дараах утга, агуулгатай захидал, илгээмжийг шилжүүлэхгүй:

- 127.2.1.оргох болон бусад гэмт хэрэгт уриалан дуудсан;
- 127.2.2.бусдыг гутаан доромжилсон, айлган сүрдүүлсэн;
- 127.2.3.хоригдлын сэтгэл зүйд цочрол үзүүлэх зорилготой;
- 127.2.4.нууц тэмдэг, үл ойлгогдох хэл дохиогоор бичигдсэн;
- 127.2.5.бусад хоригдол, хоригдсон этгээдээс бичигдсэн.

127.3.Хоригдолд шилжүүлж болохгүй утга, агуулгатай захидал, илгээмжийг хорих ангийн даргад танилцуулан тэмдэглэл үйлдэж, хоригдлын хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

127.4.Хорих ангийн алба хаагч хоригдлын захидал харилцаа, хувийн бусад нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

127.5.Хорих анги, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хаягласан захидлын агуулга, тоо хэмжээнд хяналт тавихгүй бөгөөд хорих ангийн захиргаа уг захидлыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор илгээнэ.

127.6.Хоригдлын нэр дээр ирсэн мөнгөн гуйвуулгыг банк, санхүүгийн байгууллага дахь түүний нэрийн дансанд хадгалах бөгөөд хоригдол ямар зорилго, хэмжээгээр зарцуулах тухай баримт гаргуулж, гарын үсэг зуруулна.

127.7.Энэ хуулийн 127.6-д заасан мөнгөн гуйвуулгын зарцуулалтад хорих ангийн санхүүгийн нэгж хяналт тавина.

#### **128 дугаар зүйл.Хоригдол өргөдөл, гомдол, хүсэлт гаргах**

128.1.Хоригдлын өргөдөл, гомдол, хүсэлтийг хорих ангийн алба хаагч хүлээн авч, бүртгэсний дараа хорих ангийн даргад танилцуулж харьяаллын дагуу шилжүүлнэ.

128.2.Өргөдөл, гомдол, хүсэлтийн хариуг хорих ангийн тоо бүртгэлийн нэгж тухай бүр хоригдолд танилцуулж, гарын үсэг зуруулан хувийн хэрэгт хавсаргана.

#### **129 дүгээр зүйл.Хувийн чөлөөт цаг**

129.1.Хорих ангийн дотоод журмын дагуу хоригдол хөдөлмөрлөх, амрах, хооллох болон нийгэмшүүлэх хөтөлбөрийн дагуу явагдаж байгаа сургалт хүмүүжлийн арга хэмжээнд оролцохоос бусад хугацааг чөлөөт цагт тооцно.

129.2.Чөлөөт цагт хоригдол шашны зан үйл үйлдэх, хорих ангийн боломж нөхцөл, харуул хамгаалалтын нөхцөл, шаардлага, төрөлд тохирсон спортын сонирхсон төрлөөр хичээллэх, ном, сонин унших, суралцах, хорих ангийн номын санг ашиглах боломжоор хорих анги хангана.

#### **130 дугаар зүйл.Хоригдолд чөлөө олгох**

130.1.Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүмүүжигчийн энэ хуулийн 109.1-д заасан төрөл, садангийн хүн хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол тухайн хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийг харгалзан хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан долоо хүртэл хоногийн чөлөө олгоно.

130.2.Чөлөө хүсэгч хоригдол, өсвөр насны хүмүүжигч түүнийг батлан даагч энэ хуулийн 130.1-д заасан нөхцөл байдал бий болсныг нотолсон сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга, эмнэлгийн байгууллагын магадлагааг бүрдүүлэн хорих ангийн даргад чөлөө хүссэн өргөдлийн хамт өгч шийдвэрлүүлнэ.

130.3.Чөлөө авах хоригдлыг түүний төрөл, садангийн хоёроос доошгүй хүний батлан даалтад өгөх бөгөөд хоригдол оргон зайлсан тохиолдолд түүнийг эрэн сурвалжлахтай холбогдон гарсан зардлыг батлан даагч бүрэн хариуцна.

130.4.Батлан даагч нь хоригдлыг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, чөлөөний хугацаа дуусмагц өөрийн биеэр хоригдлыг буцаан авчрах үүрэг хүлээнэ.

130.5.Чөлөөгөөр явах хоригдол, түүний батлан даагч чөлөөгөөр зорчиж байгаа орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгж байхгүй тохиолдолд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад ажлын цагаар өдөрт нэг удаа бүртгүүлэх үүрэгтэй.

130.6.Чөлөөний хугацаандаа бүртгүүлээгүй, чөлөөгөөр зорчихоор бүртгүүлсэн газарт очоолгүй, зөрчил үйлдэж шийтгүүлсэн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн бол чөлөөг даруй зогсоож, хоригдолд энэ хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулна.

130.7.Хоригдол эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа, эсхүл ял эдэлж байхдаа дахин гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн, эсхүл оргохыг завдсан, зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаа, сум, баг, дүүрэг, хорооны Засаг даргын тодорхойлолт, тамга, тэмдэг, батлан даагчийн иргэний үнэмлэх зөрчилтэй бол хоригдолд чөлөө олгохыг хориглоно.

#### **131 дүгээр зүйл.Хорих ангиас хоригдолд үзүүлэх төлбөрт үйлчилгээ**

131.1.Хорих анги ашиг, орлого олох зорилгогүйгээр эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд хорих ангийн дотоод журмаар хориглогдоогүй нэр төрөл, тоо хэмжээгээр хоол, хүнсний бүтээгдэхүүн, ариун цэвэр, ахуйн хэрэглээний нэн тэргүүний хэрэгцээт зүйлс, ном, сонин, сэтгүүл хоригдолд худалдаалаж болно.

131.2.Энэ хуулийн 131.1-д заасан үйлчилгээний төлбөрийг бэлэн бусаар гүйцэтгэнэ.

#### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

##### **132 дугаар зүйл.Хорих ангийн аюулгүй байдлыг хангах**

132.1.Хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь дараах төрөл, бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- 132.1.1.аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт;
- 132.1.2.техникийн хяналт, хамгаалалт;
- 132.1.3.биечилсэн хяналт, хамгаалалт;
- 132.1.4.аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх;
- 132.1.5.гүйцэтгэх ажил.

132.2.Хорих ангийн харуул хамгаалалтыг хорих ангийн төрөл, байршил, алба хаагчдын орон тоо, зохион байгуулалт, хамгаалалтын бус, байгууламж, инженер, техникийн хэрэгсэл, хоригдлын тоог харгалзан хорих ангид биечилсэн, техникийн хяналт, гадна хамгаалалт, гадна хэсэгт ажиллах нөхцөлд биечлсэн, техникийн хяналт гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

132.3.Хорих ангийн харуул хамгаалалтын зохион байгуулалтын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

132.4.Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

##### **133 дугаар зүйл.Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт**

133.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий тусгай ажиллагааны нэгжтэй байна.

133.2.Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих ял эдлүүлэх газар, хэлтэс нь хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

133.2.1.хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийн мэдээлэл солилцох;

133.2.2.хорих ангид онцгой нөхцөл үүссэн үеийн харилцан ажиллагаа;  
133.2.3.тусгай техник, хэрэгсэл, мэргэжлийн дэмжлэг авах;

133.2.4.оргосон хоригдол, хоригдсон этгээдийг эрэн сураалжлах, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад туслалцаа авах;

133.2.5.хоригдол, хоригдсон этгээдийг нүүлгэн шилжүүлэх, хуяглан хүргэх ажиллагаанд дэмжлэг авах.

133.3.Хорих ангийн аюулгүй байдлын техник, тусгай хэрэгсэл, ажиллагааны зардлыг тооцон жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

##### **134 дүгээр зүйл.Хорих ангийн техникийн хяналт, хамгаалалт**

134.1.Хорих анги нь хамгаалалтын дараах бүстэй байна:

- 134.1.1.гадна хорियोтой бүс;
- 134.1.2.хамгаалалтын хашаа;
- 134.1.3.дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас;
- 134.1.4.нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт бүхий бүс.

134.2.Хорих ангийн гадна хорियोтой бүс нь хоригдлын амьдралын бүсээс хот суурин газарт 500 метр, хөдөө орон нутагт 1000 метр байна.

134.3.Хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан дуу-дүрсний бичлэгийн хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохион байгуулна.

134.4.Хаалттай хорих анги нь хамгаалалтын хашааны гадна талд дүрсний бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон хяналтын цамхагтай байна.

134.5.Энэ зүйлийн 134.1.4-т заасан хяналт бүхий бүсэд дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл ашиглан хяналт тавих бөгөөд хорих байгууллага, байр, өрөөнд нэвтрэх хэсэгт хамгаалалтын хаалттай байна. Дуу-дүрсний бичлэгийн техник хэрэгсэл нь хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын систем байж болно.

134.6.Хорих ангийн аюулгүй байдлыг хангахад албаны нохой ашиглаж болно.

134.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэд албаны нохой сургалтын төвтэй байж болно.

134.8.Хорих ангийн хамгаалалтын бүсээс гарч ажиллаж байгаа хоригдолд хяналт тавихад нисгэгчгүй нисэх төхөрөөмж, цахим хяналтын төхөөрөмжийг ашиглаж болно.

134.9.Хорих байгууллагын алба хаагч болон хоригдлын аюулгүй байдлыг хангах, хорих байгууллагад гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дараах тохиолдолд цахим хяналтын төхөөрөмж ашиглан хоригдолд хяналт тавьж болно.

134.9.1.хорих байгууллагын хамгаалалтын бүсээс гадна байрлан хөдөлмөр эрхлэх;

139.3.1.Хорих ангийн алба хаагч, иргэн, хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял эдлэж буй ялтны аюулгүй байдлыг хангах;

139.3.2.Хорих байгууллагад гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

139.3.3.Хоригдол, хоригдсон этгээд, ялтны дундаас урьд үйлдсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэх;

139.3.4.Хорих ангиас оргосон хоригдол, хоригдсон этгээд болон хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн ялтанг эрэн сурвалжлах;

139.3.5.Хорих ангиас оргосон хоригдол, хоригдсон этгээд болон хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн ялтанг эрэн сурвалжлах явцад түүний хамаарал бүхий этгээдийг олж тогтоох, үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль, журам, зааварт заасан гүйцэтгэх ажлын ажиллагаа, арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх;

139.3.6.Нуугдмал эд хөрөнгийг олж тогтоох.

#### **140 дүгээр зүйл.Хорих ангид онцгой төрөл тогтоох**

140.1.Хорих ангид дараах тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга 30 хүртэл хоногийн хугацаагаар онцгой төрөл тогтоож болно:

140.1.1.Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;

140.1.2.Тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан;

140.1.3.Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;

140.1.4.Хорих байгууллагад зэвсэглэн халдсан.

140.2.Хорих ангид тогтоосон онцгой төрлийг түүнийг тогтоосон албан тушаалтан цуцлах бөгөөд энэ хуулийн 140.1-д заасан үндэслэл арилагагүй тохиолдолд 30 хүртэл хоногоор сунгаж болно.

140.3.Хорих ангид онцгой төрөл тогтоосон үед хоригдлын оролцоотой зохион байгуулагддаг бүх ажиллагааг зогсоох бөгөөд хорих ангийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж, эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглох, хорих ангийн өдрийн цагийн хуваарийг өөрчилж болно.

140.4.Энэ хуулийн 140.1-д заасан шийдвэрийг Улсын ерөнхий прокурорт даруй мэдэгдэнэ.

#### **141 дүгээр зүйл.Эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах**

141.1.Хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авадсан хүнийг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

141.2.Хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авадсан хүнийг эрэн сурвалжлах,

134.9.2.Хорих байгууллагын даргын шийдвэрээр чөлөөгөөр гарах;

134.9.3.Хорих байгууллагын даргын шийдвэрээр гадна эмнэлгийн тусламж үйлчилгээ авах.

#### **135 дугаар зүйл.Үүрэн холбооны хэрэгсэл ашиглахыг хориглох**

135.1.Хорих ангийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих анги, түүний ойр орчимд үүрэн холбооны хэрэгслийн сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглана.

135.2.Энэ хуулийн 135.1-д заасан тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглах журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **136 дугаар зүйл.Хорих ангийн биечилсэн хяналт, хамгаалалт**

136.1.Биечилсэн хяналт, хамгаалалт, нээлттэй болон хаалттай хорих ангийн дохиолол, гадна хамгаалалтыг хорих ангийн алба хаагчдын хүчээр зохион байгуулна.

136.2.Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ.

136.3.Хамгаалалтын ажилтан нь хоригдол, хорих байгууллагад нэвтэрч байгаа хүний бие, эд зүйл, техник хэрэгсэлд өдөр, шөнийн аль ч цагт үзлэг, нэгжлэг хийнэ.

#### **137 дугаар зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх**

137.1.Хорих ангийн алба хаагч онцгой нөхцөл үүссэн үед ашиглагдах нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана.

137.2.Хорих ангийн алба хаагч үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэнэ.

#### **138 дугаар зүйл.Аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх**

138.1.Хорих ангийн аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ хийх арга-члалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

#### **139 дүгээр зүйл.Хорих анги дахь гүйцэтгэх ажил**

139.1.Эрх бүхий алба хаагч гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хорих ангид гүйцэтгэх ажил явуулна.

139.2.Хорих ангид гүйцэтгэх ажил явуулах журам, зааврыг гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тангуулын төв байгууллагын дарга шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргатай зөвшилцөн батална.

139.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажил хариуцсан нэгж нь дараах үйл ажиллагааг явуулж мэргэжлийн удирдлагаар хангана.

мөрдөн хөөх, баривчлах ажиллагаанд бусад байгууллагаас хүч хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж татан оролцуулж болно.

141.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг эрэн сурвалжлах нэгж/алба хаагч/-тай байна.

141.4.Хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг эрэн сурвалжлах ажлын зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

141.5.Оргосон хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүнээс эрэн сурвалжлах ажиллагаанд гарсан зардлыг нөхөн төлүүлнэ.

141.6.Эрэн сурвалжлах ажилтан нь эрэн сурвалжлах ажиллагааны явцад хууль тогтоомжийн хүрээнд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх, гүйцэтгэх ажил явуулах эрхтэй байна.

141.7.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг эрэн сурвалжилж олж тогтоосон тохиолдолд 48 цаг саатуулна.

#### **142 дугаар зүйл.Хорих анги, хорих ангийн алба хаагчид хориглох үйл ажиллагаа**

142.1.Хорих анги, хорих ангийн алба хаагчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

142.1.1.хорих ангид зохих зөвшөөрөлгүйгээр гадны хүн нэвтрүүлэх;

142.1.2.хоригдолтой хувийн харилцаа тогтоох, зохих зөвшөөрөл, хяналтгүйгээр хоол хүнс, хувцас, илгээмж болон бусад зүйл дамжуулах, хоригдолтой худалдаа, наймаа хийх;

142.1.3.галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хорих өрөөний түлхүүрийг зохих зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх;

142.1.4.хоригдолд хууль бус үүлзалт зохион байгуулах, хуульд зааснаас бусад этгээдэд хоригдол, хорих ангийн талаар мэдээлэл, лавлагаа өгөх;

142.1.5.хоригдолтой хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах.

#### **АРАВДУГААР БҮЛЭГ ХОРИГДЛЫГ СУЛЛАХ**

#### **143 дугаар зүйл.Хоригдлыг суллах үндэслэл**

143.1.Хоригдлыг дараах үндэслэлээр суллана:

143.1.1.шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацаа дууссан, эсхүл хорих ялаас өвчний учир чөлөөлсөн;

143.1.2.өрсөөл, уучлал үзүүлсэн;

143.1.3.хорих ялаас хугацаанаас өмнө сулласан;

143.1.4.шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл цагаатгасан.

#### **144 дүгээр зүйл.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг суллах тухай санал гаргах**

144.1.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан хугацаа өнгөрсний дараа суллуулах тухай хүсэлтээ шүүхэд гаргана.

144.2.Хорих анги нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын хувийн байдлыг тодорхойлж, энэ хуулийн 144.1-д заасан хүсэлтийн хамт хүсэлт гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор прокурорт хүргүүлнэ.

144.3.Хорих ангийн тодорхойлолт, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг суллах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

#### **145 дугаар зүйл.Хоригдлыг суллах журам**

145.1.Хоригдлыг ялын хугацаа дууссан бол тухайн өдөрт, ялын хугацаа нь амралт, баяр ёслолын өдөр бол өмнөх өдөр нь, бусад үндэслэлээр уг хоригдлыг суллах тухай шийдвэрийг хүлээн авсан өдөрт нь, хэрэв ажлын цаг дууссаны дараа хүлээн авсан бол дараагийн өдөрт нь суллана.

145.2.Суллагдсан хүнд хувийн бичиг баримт, эд зүйл, хоригдын банк, санхүүгийн байгууллага дахь нэрийн дансны үлдэгдлийг шилжүүлж, суллагдсан тухай тодорхойлолт олгож, хоригдлын хувийн хэрэгт зохих тэмдэглэл хийнэ.

145.3.Шаардлагатай бол суллагдаж байгаа хоригдолд тухайн улирлын хувцас, байнга оршин суух газартаа очих уналга, хоолны зардлыг хорих ангиас олгож болох ба уналтын зардлыг автомашин, төмөр замын тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцно.

145.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүнчлэн бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдол суллагдвал энэ тухай харьяалах эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлнэ.

#### **146 дугаар зүйл.Өвчний учир ялаас чөлөөлөх**

146.1.Хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, хорих ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

146.2.Хоригдлын ялаас чөлөөлөх өвчнийг баталгаажуулах шинжилгээ, оношилгоо хийлгэхэд шаардагдах төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг хоригдол өөрөө, төлбөрийн чадваргүй хоригдлын төлбөрийг хорих анги хариуцна.

146.3.Өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлөх журам нь эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулсан хоригдолд хамаарахгүй.

148.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.

148.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд цагдаа, эмнэлгийн байгууллагад даруй мэдэгдэн, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, шууд захирах даргад, шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.

**149 дүгээр зүйл.Биеийн хүч хэрэглэх**

149.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүчийг дараах тохиолдолд хэрэглэнэ:

149.1.1.алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн;

149.1.2.цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн;

149.1.3.нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд.

149.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсноос бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд биеийн хүч хэрэглэхийг хориглоно.

**150 дугаар зүйл.Тусгай хэрэгслийн төрөл**

150.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч дараах тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

150.1.1.нэг бүрийн;

150.1.2.олон хүнд нөлөөлөх;

150.1.3.бусад.

150.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана.

**151 дүгээр зүйл.Хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл болон галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл**

151.1.Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:

151.1.1.гар, хөл, хурууны гав;

151.1.2.хулэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;

151.1.3.резин, төмөр сунадаг бороохой;

151.1.4.цахилгаан гүйдлээр цохигч, буу;

151.1.5.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу.

шүршүүр;

151.1.6.резин болон хуванцар сумтай буу;

151.1.7.хөл тушигч буу;

**147 дугаар зүйл.Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох**

147.1.Хоригдол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах хуульд заасан шаардлагыг хангасан бол уг шаардлагыг хангаснаас хойш тав хоногийн дотор хоригдолд энэ тухай мэдэгдэнэ.

147.2.Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдах тухай хүсэлтийг хэлэлцэхэд шаардлагатай мэдээллийг хорих анги, алба хаагч нь хоригдол хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор бэлтгэж, энэ хуулийн 101.1-д заасан Зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

147.3.Хоригдол суллагдах нөхцөл, шаардлагыг хангасан тухай шийдвэр гаргасан бол ажлын гурван өдрийн дотор прокурорт хүргүүлнэ. Хоригдлыг суллагдах тухай хүсэлт гаргахаас өмнө эдэлсэн хорих ялын хугацааг тоолоходоо хамгийн сүүлд авсан шагналын хоногийг оруулан тоолно.

147.4.Прокурор материалыг хүлээн авч үндэслэлтэй гэж үзвэл арван хоногийн дотор дүгнэлтийн хамт шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
БИЕИЙН ХҮЧ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ  
ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ**

**148 дугаар зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг  
хэрэглэх нийтлэг үндэслэл**

148.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.

148.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт, тэдгээрийг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

148.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

148.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ дараах нийтлэг шаардлагыг баримтална:

148.4.1.зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

148.4.2.нэн тэргүүнд хэрэглэхгүй байх;

148.4.3.тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.

148.5.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг бусдыг гугаан доромжлох, цээрлүүлэх, шийтгэх зорилгоор хэрэглэхийг хориглоно.

- 151.1.8.холбооны станц, дуу-дүрс бичлэгийн хэрэгсэл;  
151.1.9.нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

#### **152 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх**

- 152.1.Нэг бүрийн тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:  
152.1.1.өөрийн, бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох;  
152.1.2.зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй ялтан, хоригдлыг баривчлах;  
152.1.3.хоригдол хорих ангийн алба хаагчийн тавьсан шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн;  
152.1.4.алба хаагчийн аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн;  
152.1.5.хоригдлыг хуяглан хүргэх;  
152.1.6.хяналтад байгаа хоригдол амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлж болзошгүй бол тэдгээрээс урьдчилан сэргийлэх;  
152.1.7.хорих байгууллага дотор гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хяналтаа авах, хорих байгууллага доторхи аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, хорих байгууллагыг бүслэн хаасныг чөлөөлөх;

152.1.8.бүх насаар хорих ял шийтгүүлсэн, сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчдсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, эсхүл догшин хэргийг авирлаж, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохиро учруулахаар бол;

- 152.1.9.энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан бусад.

152.2.Хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, бэртэл гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа, амь тэмцсэн хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

#### **153 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл**

- 153.1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна:  
153.1.1.олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;  
153.1.2.усан хөөрөг;  
153.1.3.угтаан хөшиг үүсгэгч;  
153.1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.

#### **154 дүгээр зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх**

154.1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай шийдвэрийг хорих ангийн дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан гаргана.

154.2.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ:

- 154.2.1.хорих ангид бүлэглэн халдсан;  
154.2.2.хорих ангийн дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, эсхүл хорих ангид гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох.

154.3.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө дараах арга хэмжээг авна:

- 154.3.1.боломжтой тохиолдолд прокурорт мэдэгдэх;  
154.3.2.тусгай хэрэгсэл хэрэглэх тухай анхааруулж, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах.

154.4.Энэ хуулийн 154.3.2-т заасан шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах бодит аюул үүссэн тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг шууд хэрэглэж болно.

#### **155 дугаар зүйл.Галт зэвсэг хэрэглэх үндэслэл**

155.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

- 155.1.1.хоригдол оргон зугтсан, оргохыг завдсан;  
155.1.2.оргосон хоригдол, хоригдсон этгээд, ялтан нь өөрийн болон өөрийн, бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

155.1.3.хорих ангид зэвсэглэн, эсхүл бүлэглэн халдсан, эсхүл хорих ангийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон;

155.1.4.галт зэвсэг, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хоригдол зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн;

155.1.5.хуяглан хүргэж байгаа хоригдлыг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

155.1.6.хорих ангид эмх замбараагүй байдал үүсч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон;

155.1.7.зэвсэглэсэн, зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хоригдлыг баривчлах;

155.1.8.нийтийг хамарсан нүүлгэн шилжүүлэх ажиллагаа болон хуяглан хүргэх ажиллагааны явцад гаднаас хүч хэрэглэн халдан довтолсон;

155.1.9.онцгой учралын үед объектын болон биечилсэн хамгаалалт зохион байгуулах явцад зэвсэглэн халдан довтолсон тохиолдолд;

155.1.10.эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн дагуу терроризмтэй тэмцэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, эрэн сурвалжлах, хойшуулашгүй ажиллагаанд хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлэх, олон

нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад хүч нэмэгдүүлэн дэмжлэг үзүүлэх явцад өөрийн болон хамтрагч бусад энгийн ард иргэдийг амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдолд.

#### **156 дугаар зүйл. Галт зэвсэг хэрэглэх нийтлэг журам**

156.1. Галт зэвсэг хэрэглэх сургалтад хамрагдан, галт зэвсэг хэрэглэх эрх олгогдсон хорих ангийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг хадгалах, биедээ авч явах, хэрэглэх эрхтэй.

156.2. Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Сануулга өгөх нь цаг алдаж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийг шууд хэрэглэж болно.

156.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч галт зэвсэг хэрэглэхийн өмнө дараах арга хэмжээг шат дараалан авах үүрэгтэй:

156.3.1. энэ хуулийн 155.1-д заасан тохиолдол бий болсон үед галт зэвсгээ бэлэн байдалд авах;

156.3.2. галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай, байр тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;

156.3.3. энэ хуулийн 156.3.2-т заасны дагуу сануулсны дараа тухайн хүн үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэх.

156.4. Хуяглан хүргэж яваа хоригдол хорих ангийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон тохиолдолд галт зэвсэг шууд хэрэглэж болно.

156.5. Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ. Галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд бүрд прокурор, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

156.6. Хорих байгууллага цагдаагийн байгууллага иртэл хэрэг болсон газрыг хамгаалалтад авна.

156.7. Алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд акт үйлдэж, удирдах албан тушаалтанд өгөх бөгөөд галт зэвсэг хэрэглэсэн тухай актын загварыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

#### **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ СУРГАЛТ, НИЙГМИЙН АЖИЛ, СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **157 дугаар зүйл. Сургалт, нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ**

157.1. Хорих байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс дараах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг явуулна:

157.1.1. хоригдолд явуулах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ;

75

157.1.2. хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд явуулах сургалт, нөлөөллийн ажил.

157.2. Хорих байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хоригдол, ялтан, этгээд, баривчлагдсан хүнийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байхад чиглэгдсэн сургалт, нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нэржтэй байна.

157.3. Сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болно.

157.4. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлолт тохирсон сургалт, нийгэмшүүлэх, сэтгэл зүйн ажлын хөтөлбөрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална.

157.4.1. хоригдолд явуулах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ;

157.4.2. хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд явуулах сургалт, нөлөөллийн ажил;

157.4.3. баривчлагдсан этгээдэд явуулах албадан сургалт.

#### **158 дугаар зүйл. Хорих байгууллагад явуулах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ, хэлбэр, зохион байгуулалт**

158.1. Хорих байгууллагад явуулах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшилийг бий болгоход чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

158.2. Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэний оролцуулж болно.

158.3. Хорих ангид нийгэмшүүлэх ажлыг хоригдлыг хүлээн авах үеийн, ял эдлэх үеийн, суллахад бэлтгэх үеийн гэсэн үе шатаар зохион байгуулна.

158.4. Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн төрлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.

158.5. Энэ хуулийн 158.4-т заасан үйлчилгээг соёл, урлагаар дамжуулан зохион байгуулж болно.

#### **159 дүгээр зүйл. Хорих анги дахь сургалт**

159.1. Өсвөр насны хүмүүжигчийг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги тусалцаа үзүүлнэ.

76

**165 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

165.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

159.2.Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд танхимаар болон цахимаар зохион байгуулна.

**160 дугаар зүйл.Хорих анги дахь сургалтын хэлбэр**

160.1.Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.

160.2.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.

**161 дүгээр зүйл.Хорих анги дахь албадан сургалт**

161.1.Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.

**162 дугаар зүйл.Хоригдол сургалтад хамрагдах**

162.1.Хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 20-иас доошгүй хувийг эзэлсэн, сүүлийн нэг жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй бөгөөд их, дээд сургууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9.3-т заасан мэргэжлийн боловсролын сургуулиас зохион байгуулах сургалтад суралцах тухай хүсэлт, хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэнэ.

162.2.Сургалтыг хорих ангийн байранд танхимаар болон цахимаар явуулна.

**АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД**

**163 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт**

163.1.Эрүүгийн болон зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд прокурорын байгууллага хяналт тавина.

**164 дүгээр зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

164.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

164.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг нэмсүгэй:

**1/136 дугаар зүйлийн 136.2-136.4 дэх хэсэг:**

"136.2. Шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийг агуулгаар нь дахин гаргасан бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохгүй бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үндэслэл болно.

Тайлбар: Шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийг агуулгаар нь дахин гаргасан гэж шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийн үр дагаврыг хадгалах зорилгоор өөр бусад эрх зүйн акт гаргасан, тухайлбал албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг өөрчлөх зэргээр нэхэмжлэгчийн эрхийг сэргээхгүй үр дагавартай шийдвэр гаргасан, үүний улмаас нэхэмжлэгчийн эрх зүйн байдал дээрдээгүй буюу өмнөх нөхцөл байдалтай адил байгаа тохиолдлыг ойлгоно.

136.3. Энэ хуулийн 138.3-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгосон, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд холбогдох бүртгэлийг хийснээр уг шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно.

136.4. Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн шийдвэрт заасан, эсхүл энэ хуулийн 140.4-т заасан хугацаанд гаргах, хэрэгжүүлэх үүргийг бүрэн хэрэгжүүлснээр шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно."

**2/137 дугаар зүйл:**

**"137 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл**

137.1. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна.

137.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг захиргааны хэргийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх удирдан явуулах бөгөөд тухайн шүүхэд шийдвэр гүйцэтгэлийн чиг үүрэг хариуцсан шүүхийн ажилтан ажиллана.

137.3. Шүүхийн шийдвэр захиргааны байгууллагад эерэг нөлөө үзүүлж гүйцэтгэгдэхээр бол Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

**137.4. Дараах шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ:**

137.4.1. хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр;  
137.4.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүчин төгөлдөр шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

137.4.3. хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

**137.4.4. шийтгэвэр.**

**137.5. Шүүхийн шийдвэрийг дараах тохиолдолд нэн даруй гүйцэтгэнэ:**

137.5.1. төрийн албан хаагчийг ажил, албан тушаалд нь эзүүлэн тогтоох тухай;

137.5.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай;  
137.5.3. шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч хүн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учрааар бол түүний хүсэлтээр;

Тайлбар: "Ноцтой хохирол" гэж шүүхийн шийдвэрийг яаралтай биелүүлэхгүй бол иргэний амь нас нь эрсдэлд орох, эрүүл мэнд нь доройтох, эд хөрөнгө нь зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох, тухайн этгээд түүний өөрийн хүчээр эргүүлэн сэргээх боломжгүй, эсхүл сэргээсэн ч өмнөх байдлаасаа чанар байдлын хувьд дордохоор сөрөг үр дагавар үүсэхийг ойлгоно.

**137.5.4. хуульд заасан бусад тохиолдол.**

137.6. Энэ хуулийн 137.4.1-д заасан шүүхийн шийдвэрт энэ хуулийн 106.3.4, 106.3.6, 106.3.7-д заасан шүүхийн шийдвэр хамаарна.

137.7. Гүйцэтгэх хуудаст албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх хугацаа, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, тогтоосон хугацааны дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд авах албадлагын арга хэмжээ болон хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

137.8. Гүйцэтгэх хуудасны загварыг Улсын дээд шүүх батална.

137.9. Гүйцэтгэх хуудсыг үл маргалдах журмаар биелүүлнэ."

**3/138 дугаар зүйл:**

"138 дугаар зүйл. Захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх

138.1.Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай, хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон тухай, эсхүл захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор маргаан бүхий шийдвэрийн эрх зүйн үйлчлэл дуусгавар болж, нэхэмжлэгчид эрх сэргэнэ.

138.2.Шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон, илт хууль бус болохыг тогтоосон захиргааны шийдвэрийг хэрэгжүүлсний улмаас бусдад учруулсан хохирлыг буруутай этгээд өөрөө хариуцна.

138.3.Захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгосон, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох бүртгэл хийхийг шийдвэр гаргасан шүүгч захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэл хариуцсан байгууллагад үүрэг хүлээлгэнэ."

#### 4/139 дүгээр зүйл:

"139 дүгээр зүйл.Захиргааны шийдвэр гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

139.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 141.5-д заасан хугацаанд гаргах, хэрэгжүүлэх үүрэгтэй.

139.2.Хариуцагч энэ хуулийн 139.1-д заасан шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг энэ хуульд заасан журмын дагуу албадан гүйцэтгэнэ."

#### 5/140 дүгээр зүйл:

"140 дүгээр зүйл.Төлбөр, хохирлын хэмжээг өөрчлөн тогтоосон, төлбөр хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх

140.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан хугацаанд маргаан бүхий захиргааны актаар тогтоосон төлбөрийн хэмжээнд шүүхийн шийдвэрт заасны дагуу өөрчлөлт оруулна.

140.2.Маргаан бүхий захиргааны актаар тогтоосон төлбөрийг нэхэмжлэгч төлж барагдуулсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр тогтоосон зөрүүг захиргааны байгууллага нэхэмжлэгчид буцаан олгох, эсхүл дараагийн төлбөрт суутган тооцно.

140.3.Хариуцагч энэ хуулийн 140.1, 140.2-т заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг энэ хуульд заасны дагуу албадан гүйцэтгэнэ.

140.4.Хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрт заасан зургаагаас 12 сарын дотор биелүүлээгүй бол хариуцагч, түүний дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд энэ хуулийн 140.5-д заасан ажиллагааг хэрэгжүүлэх талаар шүүгч мэдэгдэл хүргүүлнэ.

140.5.Энэ хуулийн 140.4-т заасан хугацаа өнгөрсөн боловч хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээний зардалд харгалзах төсвөөс бусад төрийн сан дахь дансны мөнгөн хөрөнгөөс нь албадан гаргуулна.

140.6.Энэ хуулийн 140.5-д заасан ажиллагааг гүйцэтгэх хуудасны үндсэн дээр шийдвэр гүйцэтгэгч Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гүйцэтгэнэ."

#### 6/141 дүгээр зүйл:

"141 дүгээр зүйл.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа

141.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан үүргийг тухайн шийдвэрт заасан хугацаанд хэрэгжүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэнэ.

141.2.Хэргийн оролцогч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхэд гаргана.

141.3.Шүүгч дараах тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудас олгоно.

141.3.1.Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан;  
141.3.2.Энэ хуулийн 137.5-д заасан шүүхийн шийдвэрийг нэн даруй гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан.

141.4.Шүүгч энэ хуулийн 141.3.2-т заасан тохиолдолд гүйцэтгэх хуудсыг нэн даруй олгоно.

141.5.Энэ хуулийн 137.2-т заасан шүүхийн ажилтан нь гүйцэтгэх хуудас бичигдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас, шаардлагатай бусад баримт бичгийг хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд болон шийдвэрийг гүйцэтгэвэл зохих этгээдэд хүргүүлнэ.

141.6.Энэ хуулийн 137.7-д заасан шүүхээс тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан уг хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор албадлагын арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шүүхэд хүргүүлнэ.

141.7.Нэн даруй биелүүлэх шүүхийн шийдвэрийг дараах журмын дагуу гүйцэтгэнэ:

141.7.1.Энэ хуулийн 137.4-т заасан шийдвэр гаргасан шүүгч 137.7-д зааснаар шүүхийн шийдвэрийн хамт гүйцэтгэх хуудас бичиж, хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд, энэ талаар шүүхийн мэдэгдлийг холбогдох этгээдэд тус тус хүргүүлнэ;

141.7.2.Хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гүйцэтгэх хүлээн авмагц холбогдох этгээдэд шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусахад сайн дураар биелүүлээгүй бол албадан гүйцэтгэх ажиллагаа шууд эхлэх талаар мэдэгдэж, ажлын 3 хоногийн дотор албадлагын арга хэмжээ авхуулах тухай хүсэлтийг шүүхэд хүргүүлэх.

141.8.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд тухайн актын агуулгаас хамаарч хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

141.8.1.Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид болон үүрэг хүлээсэн гурвадагч этгээдэд даалгах;

141.8.2.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу эд хөрөнгийг битүүмжлүүлэхээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэх;

141.8.3.Энэ хуулийн 141.8.1, 141.8.2-т заасан хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүргийг зөрчсөн буруутай этгээдэд албадлагын арга хэмжээ авах хүсэлтийг шүүхэд хүргүүлэх."

#### 7/142 дугаар зүйл:

##### "142 дугаар зүйл.Албадлагын арга хэмжээ

142.1.Шүүгч хариуцагчийн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албадлагын арга хэмжээ авах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй шалтгааныг судлан үзэж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хариуцагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль оногдуулсан захирамж гаргаж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

142.2.Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй нь тогтоогдвол сайн дураар биелүүлэх хугацааг шүүгч 14 хүртэл хоногор сунгаж болно.

142.3.Албадлагын арга хэмжээ оногдуулсан захирамжид хэрэгжих хугацааг 14 хүртэл хоногор тогтоох бөгөөд торгуулийн хэмжээг тогтоохдоо шүүгч хариуцагчийн санхүүгийн болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

142.4.Шүүгчийн захирамжийг хүлээн авмагц шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр гүйцэтгэлч албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шүүгчийн захирамжид заасан хугацааны дотор хэрэгжүүлнэ.

142.5.Албадлагын арга хэмжээ авагдсан боловч энэ хуулийн 142.3-т заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хариуцагчид тухайн албадлагын арга хэмжээг шүүгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл хэдэн ч удаа ногдуулж болно.

142.6.Албадлагын арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж гарсны дараа хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлбэл хамгийн сүүлд ногдуулсан торгуулийн төлбөрийг хариуцагчаас гаргуулахгүй байж болно.

142.7.Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан, үргэлжилсэн албадлагын үе шат тул энэ хуулийн дагуу явуулсан ажиллагаанд талууд томдол гаргахгүй."

#### 8/143 дугаар зүйл:

##### "143 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлтгэх хариуцлага

143.1.Шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй хоёр буюу түүнээс дээш удаа албадлагын арга хэмжээ авагдсан хариуцагчид шүүгч Төрийн албаны тухай болон холбогдох хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл бүрдсэн талаар эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд хугацаатай мэдэгдэл хүргүүлнэ.

143.2.Энэ хуулийн 143.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан, байгууллага мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан сахилгын шийтгэлийг шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд ногдуулж, энэ тухай шүүхэд мэдээлнэ.

143.3.Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүйн улмаас сахилгын шийтгэл хүлээсэн нь тухайн албан тушаалтны шүүхийн шийдвэр биелүүлэх энэ хуульд заасан албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

143.4.Энэ хуульд заасан албадлагын арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн нь шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхэд саад болохгүй.

143.5.Энэ хуулийн 143.2, Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасны дагуу шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны мэдээллийг захиргааны хэргийн шүүхийн бүртгэлд бүртгэж, тухайн шүүхийн цахим санд олон нийтэд нээлттэй байршуулна."

#### 9/144 дүгээр зүйл:

##### "144 дүгээр зүйл.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

144.1.Шүүгч энэ хуулийн 143.1, 143.2-т заасныг хэрэгжүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны талаар төрийн албаны төв байгууллагад хугацаатай мэдэгдэл хүргүүлнэ.

144.2.Энэ хуулийн 144.1-д заасан мэдэгдлийг төрийн албаны төв байгууллага хүлээн авснаас хойш Төрийн албаны тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4, 76.7-д заасны дагуу шүүхийн шийдвэрийг биелүүлбэл зохих байгууллагын өмнөөс шийдвэр

146.1.2.Хариуцагч гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн;

146.1.3.Хариуцагч татан буугдсан, өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих боломжгүй, эсхүл уг шаардлагыг эрх залгамжлагчаар гүйцэтгүүлэх боломжгүй нь тодорхой болсон;

146.1.4.Хариуцагч албан тушаалтан гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй болсон нь шүүхээр тогтоогдсон;

146.1.5.Нэхэмжлэгч иргэн нас барсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон;

146.1.6.Нэхэмжлэгч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан үед түүний эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй.

146.2.Шүүгч шүүхийн шийдвэрийн биелэлтийг дуусгавар болгох захирамжид үндэслэлийг дэлгэрэнгүй тусгана."

**2 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1135 дугаар зүйлийн 135.1 дэх хэсэг:**

"135.1.Хариуцагч шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелүүлээгүй тохиолдолд энэ бүлэгт заасан журмын дагуу албадан биелүүлнэ."

**2/136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэг:**

"136.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актыг гаргах, захиргааны гэрээ байгуулах, эсхүл шүүхийн шийдвэр, мэдэгдэлд заасан үүргийг тогтоосон хугацаанд, зохих ёсоор биелүүлсэн бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно."

**3 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэгт "шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага" гэснийг "энэ хуулийн 137.2-т заасан шүүхийн ажилтан" гэж, 136 дугаар зүйлийн гарчгийг "Шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцох" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 138 дугаар зүйлийн дугаарыг "147" гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэлчлэйн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

гаргах бөгөөд шүүгчийн мэдэгдэлд заасан хугацаанд биелэлтийг хангуулж хариу мэдэгдэнэ."

**10/145 дугаар зүйл:**

**"145 дугаар зүйл.**Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээн явуулах

145.1.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх баримт бичгийн үндэслэл болох шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан бол түүнийг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарах хүртэл захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно.

145.2.Шүүгч захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараах үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлнэ:

145.2.1.Нэхэмжлэгч иргэн нас барсан, эсхүл нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, хариуцагч, нэхэмжлэгч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эрх залгамжлагч, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл;

145.2.2.Тухайн захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогддуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа тохиолдолд түүнийг шийдвэрлэх хүртэл;

145.2.3.Хариуцагчийг татан буулгах ажиллагааг эхлүүлсэн.

145.3.Энэ хуулийн 145.2-т зааснаас бусад үндэслэлээр захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

145.4.Энэ хуулийн 145.2-т заасан үндэслэл арилсан тохиолдолд нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүгч захирамж гарган захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээн явуулна."

**11/146 дугаар зүйл:**

**"146 дугаар зүйл.**Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох

146.1.Шүүгч дараах үндэслэлээр захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дуусгавар болсонд тооцож, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай захирамж гаргана:

146.1.1.Гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болох шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан;

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 19.6 дахь хэсэг нэмсүгэй:

“19.6.Энэ хуулийн 19.1-д заасны дагуу бүртгүүлсэн хаягаар холбогдох төрийн байгууллагаас хуульд заасан мэдэгдэх хуудас, нэхэмжлэл зэргийг хүргүүлснийг хүлээн авагчид хүргүүлсэнд тооцно.”

**2 дугаар зүйл.**Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “бүртгүүлнэ.” гэснийг “бүртгүүлэх үүрэгтэй.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

## ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт "нэхэмжлэгчийн хүсэлтийг" гэсний өмнө "шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах боломжийн талаар нэхэмжлэгчид танилцуулах үүрэгтэй бөгөөд" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75<sup>1</sup> дүгээр зүйлийн 75<sup>1</sup>.2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

**1/8 дугаар зүйлийн 8.8.7 дахь заалт:**

"8.8.7.Энэ хуулийн 8.1.10, 8.2-т заасны дагуу хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн хуулийн этгээдийн удирдлага, гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөн бол,"

**2/22 дугаар зүйлийн 22.5-22.6 дахь хэсэг:**

"22.5.Энэ хуулийн 22.1, 22.4-т заасны дагуу бүртгүүлсэн хаягаар холбогдох төрийн байгууллагаас хуульд заасан мэдэгдэх хуудас, нэхэмжлэл зэргийг хүргүүлснийг хүлээн авагчид хүргүүлсэнд тооцно."

22.6.Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, эрх шилжүүлэх тухай шүүхийн шийдвэрийн дагуу бүртгүүлэхэд энэ зүйлийн 22.4 дэх хэсэгт заасан шаардлага хамаарахгүй бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдлийн дагуу улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 21.6-д заасан хугацаанд бүртгэж, хариу мэдэгдэнэ."

**2 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн "бүртгүүлэх" гэснийг "бүртгүүлэх үүрэгтэй" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2. Хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх, асран хамгаалж, харгалзан дэмжихээр тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нүүн дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үргэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг дүр мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан, тодорхой үүрэг гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхыг даалгасан шийдвэрийг биелүүлээгүй, дүр эсгэн биелүүлсэн, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>2</sup> дугаар зүйлийн 21<sup>2</sup>.3 дахь хэсэгт доор дурдсан агуулга бүхий 21<sup>2</sup>.3.4 дэх заалт нэмсүгэй:

"21<sup>2</sup>.3.4. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 106 дугаар зүйлд заасан тэтгэлэг төлөгчийн төлөх хүүхдийн тэтгэлгийг төрөөс урьдчилан төлөх."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 42.19, 42.20 дахь хэсэг нэмсүгэй.

"42.19.Шүүхийн шийдвэрээр өмчлөх эрх өөрчлөхөөр тогтоосон бол иргэний шийдвэр гүйцэтгэчийн заасан хугацаанд энэ хуулийн 42.7-д заасны дагуу өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулж, нэн дарюу хариу мэдэгдэнэ.

42.20.Энэ зүйлийн 42.19-д заасан үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйлчилгээний хөлсийг өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа этгээд хариуцна."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалтын "шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга" гэснийг "иргэний шийдвэр гүйцэтгэгч" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

ЗӨРЧЛИЙН ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.9, 9-д "ахлах шийдвэр гүйцэтгэгч" гэснийг "шийдвэр гүйцэтгэгч" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтын "шүүгч" гэсний дараа "Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад иргэний шийдвэр гүйцэтгэгчид" гэж, "үг" гэсний дараа "шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухайлсан нэг төлбөр төлөгчийн нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх" гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР  
ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4/ дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4/зөрчлийн шийтгэлээр шийтгүүлсэн бол уг шийтгэлийг биелүүлж дуусгал, төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төлбөр төлөгчийн хувьд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болох хүртэл."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО,  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ  
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдахаас өмнө иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчаар ажиллаж байсан бөгөөд тэтгэвэрт гарахад таван жил үлдсэн алба хаагч энэ хууль батлагдсанаас хойш гурван сарын дотор эрүүгийн болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэгтэй албанд орохоор гаргасан хүсэлтийг үндэслэн тухайн алба алба хаагчаар шилжүүлж авна.

**2 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдахаас өмнө иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу гүйцэтгэх бөгөөд ажиллагаатай холбогдуулан шүүхэд гаргасан гомдол, нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...  
Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ  
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан, дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Хууль батлагдсантай холбогдуулан хувийн шийдвэр гүйцэтгэгчийн талаарх холбогдох зохицуулалтыг тусган, хуулийн төсөл боловруулж, Улсын Их Хурлын 2027 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх

2/Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн талаарх хуулийн төсөл батлагдсанаас хойш жил бүр нийт иргэний шийдвэр гүйцэтгэгчийн 10 хувийг хувийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээ авах;

3/Хууль батлагдсантай холбогдуулан иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтад үндэслэн цахим системийг хөгжүүлэх;

4/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шийдвэр гүйцэтгэл хариуцсан ажилтанг авч ажиллуулах, иргэний хэргийн анхан шатны шүүхэд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч авч ажиллуулах, холбогдох зардлыг төсөвт тусгуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлтгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>2</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлтгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>3</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>4</sup> 3.2.2.7-д "... иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж заасны дагуу иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, олон улсын сайн жишигт хүргэх" гэж тус тус заасан.

Иймд иргэний шийдвэр гүйцэтгэх албаны тогтолцоо, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг олон улсын жишигт нийцүүлэх үүднээс уг хуулийн төслийг боловсруулах үндэслэл бүрдсэн.

Хуулийн төслийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/33 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийн хүрээнд боловсрууллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Засгийн газрын агентлаг хэвээрээ байхаар, ингэхдээ эрүү, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төрийн цэргийн алба хаагчдаас бүрдэхээр, харин иргэний болон захиргааны хэргийн шийдвэр

гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь тус байгууллагын харьяа алба байхаар, гэсэн хэдий ч төрийн цэргийн алба хаагчийн статусгүй зөвхөн төрийн албан хаагчийн цалин хөлс авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулал авахаар тусгалаа. Ингэснээр төсөвт үүсэх зардал хэмнэх юм.

Иймд хуулийн төслөөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тэр дундаа иргэний шийдвэр гүйцэтгэх албыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог, олон улсын жишигт нийцүүлж, цэргийн албаны хууль тогтоомж хамаарахгүй, урамшуулалд суурилсан шуурхай, үр дүнтэй тогтолцоог ялгажтай байдлаар бий болгосон зохицуулалтыг тусгалаа.

Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг 5 удаа зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд харгалзан үзэж, тусгав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хариуцдаг [eda.info.mn](http://eda.info.mn) сайтад мөн оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус тус байршуулж, олон нийтээс санал авсан болно.

---000---

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтэлдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтэлдсэн.

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө харуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлтэгч иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>2</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>3</sup> 3.2.2.7-д "... иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж заасны дагуу иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, олон улсын сайн жишигт хүргэх" гэж тус тус заасан нь Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

Хуулийн төслийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, ХБНГУ, Нидерланд, Эстони, Сингапур, БНСУ, Япон зэрэг улсуудын иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх хууль тогтоомжид үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/33 дугаар тушаалын хавсралтаар байгуулсан Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий Дэд ажлын хэсгээс боловсруулсан.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (Шинэчилсэн найруулга) төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн харууцагч legalinfo.mn сайтад мөн оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус тус байршуулж, олон нийтээс санал авсан болно.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгалаа.

Тогтолцоо, зохион байгуулалтын хувьд:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

1

1. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, дотоод, гадаадын арбитрын шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс иргэний шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоог олон улсын чиг хандлагад нийцүүлэн өөрчлөх шаардлага үүссэн тул шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн талаарх зохицуулалтыг бий болгосон. Ингэснээр шийдвэрийн биелэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих эрх зүйн орчныг бий болгоно.

2. Шийдвэр гүйцэтгэгч урамшуулалгүй мөртлөө цэргийн цолтой буюу дэслэгчээс хурандаа хүртэл цалингийн 26-36 хувийн цолны нэмэгдэл<sup>4</sup> авдаг бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн<sup>5</sup> дагуу тэтгэмж, тэтгэврийн онцлог зохицуулалт үйлчилдэг.

Иргэний болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчдыг цэргийн эрдэмд сургах шаардлагагүй бөгөөд эрх зүйн болон эдийн засгийн бусад үр чадваруудыг сургах шаардлагатай талаар ЕСБХБ-ны судалгаанд дурджээ.<sup>6</sup>

БНСУ, ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэгч нь төрийн захиргааны алба хаагч байх бөгөөд олон улсад шийдвэр гүйцэтгэгч төрийн албан хаагчийн цалингаас гадна гүйцэтгэсэн төлбөрийн үнийн дүнгээс тооцсон урамшуулал авах жишиг байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэлийг үр дүнтэй, шуурхай болгож, төлбөр авагчийн зөрчилдсөн эрхийг шуурхай сэргээх үүднээс шийдвэр гүйцэтгэгч цэргийн бус төрийн алба хаагч байх, харин урамшууллыг зохистой хэмжээнд авахаар тусгалаа.

3. Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 50 гаруй ахлах шийдвэр гүйцэтгэгч байгаа ч шийдвэр гүйцэтгэгчид туслах алба хаагч дутмаг байна. Гэтэл Гүрж улсад, 3 сая 800 мянга гаруй хүн амтай ч<sup>7</sup> нийт 424 албан хаагчтай 158 шийдвэр гүйцэтгэгчтэй тэдэнд туслах 157 захиргааны албан хаагчтай, 57 шийдвэр гүйцэтгэлийн цагдаатай багтай байна. Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 56 ахлах шийдвэр гүйцэтгэгчтэй ч Захиргаа, мэргэжлийн удирдлага-ханалт тавих 26 албан хаагч байгаа нь нийт 460 албан хаагчийн 6.7 хувь нь байгаа нь туслах чиг үүрэгтэй захиргааны албан хаагч дутмаг байгаа нь ажиллагаа удаашралтай, шийдвэр гүйцэтгэгч ачаалалтай байгаатай холбоотой байж болохоор байна.

Түүнчлэн ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хэрэгжүүлэх чиг үүргийг шийдвэр гүйцэтгэгч бие даан гүйцэтгэх боломжтой төдийгүй шат дамжин зөвшөөрөл авсаар ажиллагаа удаашрах, зөвшөөрөл авахгүйгээр харууцлагыг хүлээж, тэдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлж болохоор байна. Тухайлбал, орон байранд нэвтрэн орох, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авахад шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан хийх боломжтой байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хийх үйл ажиллагааг цахимжилтаар шийдэх боломжтой байна. Тухайлбал, ажиллагааг нээх, хаах, гүйцэтгэх баримт бичгийг буцаах, дуудлага худалдаа явуулах шийдвэр гаргах гэх мэт.

<sup>4</sup> Засгийн газрын 1999 оны 38 дугаар тушаалын хавсралт.

<sup>5</sup> Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> ЕСБХБ-ны хийсэн Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам, холбогдох эрх зүйн актын шинэчлэлийн үзэл баримтлал, 2024.

<sup>7</sup> <https://www.worldometers.info/world-population/georgia-population/>

2

Ахлах, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчдэд талуудаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан гаргах гомдол жилд маш их ирдэг бөгөөд энэхүү чиг үүргийг байхгүй болгож, шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шуурхай шийдэх боломжтой байхаар тусгаж, бусад чиг үүргийг нь шийдвэр гүйцэтгэгч бие даан хуульд заасны дагуу хэрэгжүүлэхээр тусгасан.

Ингэснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь шат дамжлага үгүй болж, шуурхай, үр дүнтэй байдал хангагдахад эерэг нөлөө үзүүлнэ.

Ажиллагааны тухайд:

1. Хөдөлмөрийн чадвартай ч төлбөр төлөх шүүхийн шийдвэр биелүүлэхгүй, удаашруулах тохиолдол их байна. Энэ тохиолдолд энэ төрлийн төлбөр төлөгчийг хөдөлмөр эрхлүүлж, төлбөрийг гаргуулах зохицуулалт байхгүй байна.

Түүнчлэн хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа хөрөнгө, орлогогүй төлбөр төлөгч бол хүүхдийн төлөө сангаас хүүхдийн тэтгэлгийг урьдчилан төлөх, тухайн этгээд ажил хөдөлмөр, аж ахуй эрхлэх зэргээр төлбөрийн чадвартай болсны дараа төлбөрийг нөхөн гаргуулж, уг санд төлдөг механизмыг бүрдүүлээ. ХБНГУ-д ийм төрлийн тэтгэлгийн сан ажилладаг байна.<sup>8</sup>

2. Ажиллагааны талаар гаргах талуудын гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гаргаж, төлбөр төлөгч нэхэмжлэгч, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болж, зохигчийн эрх, үүргийг эдэлж, 3 шатны шүүхээр явах боломжтой байдаг төдийгүй тус хугацаанд ажиллагааг түдгэлзүүлдэг нь төлбөр төлөгч үндэслэлгүй олон гомдол шүүхэд гаргаж ажиллагааг удаашруулах арга барил болгон ашигладаг практик тогтсон байна.

Харин гадаад орны зарим туршлагын хувьд, тухайлбал, БНСУ-д, нэн даруй гомдол гаргах нь гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй. Гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл төлбөр төлөгчийн барьцаатайгаар, эсхүл барьцаагүйгээр шийдвэрийн биелэлтийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх шийдвэр гаргах, эсхүл төлбөр авагчийн барьцаатайгаар гүйцэтгэлийн ажиллагааг үргэлжлүүлэх шийдвэр гаргана. Энэ түдгэлзүүлэх, эсхүл үргэлжлүүлэх шийдвэрт гомдол гаргаж үл болно.<sup>9</sup>

Мөн ХБНГУ-ын хувьд, гомдол гаргасан бол шүүх хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг төлбөр төлөгчөөс баталгаа гаргуулан эсхүл, баталгаа гаргуулахгүйгээр түр түдгэлзүүлэх, эсхүл зөвхөн төлбөр авагчаас баталгаа гаргуулсныг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулна. Төлбөр авагч баталгаа гаргаж чадахгүй, эсхүл онцгой хүндрэлтэй байгаа бөгөөд хойшлуулах нь төлбөр авагчид нөхөн төлөхөд бэрхшээлтэй байх, эсхүл хохирол учрахаар бол, эсхүл бусад шалтгааны улмаас төлбөр авагч зөвшөөрөхгүй байгаа бол хүсэлтийг нь үндэслэн шүүхийн шийдвэрийг урьдчилсан байдлаар гүйцэтгэх боломжтойд тооцно. Төлбөр авагчийн ашиг сонирхол илт давамгай байх тохиолдолд төлбөр төлөгчийн түдгэлзүүлэх хүсэлтийг хангахгүй зохицуулалттай байна.<sup>10</sup>

<sup>8</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>9</sup> <https://www.gesetze-im-internet.de/1807&type=part&key=8>

<sup>10</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

БНСУ-д нэн даруй гомдол (**immediate compliant**) гаргах буюу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журам зөрчсөн гэж үзвэл гүйцэтгэлийн шүүхийн шийдвэрт зөвхөн хуульд заасан үндэслэлээр нэн даруй гомдол гаргаж болдог.<sup>11</sup> Харин ХБНГУ-ын хувьд шийдвэр гүйцэтгэлийн шүүх нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдлыг хянадаг байна.<sup>12</sup>

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гомдол нь нэхэмжлэл (**law suit**) биш шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь эсэргүүцэл буюу гомдол (**objection, complaint**) бөгөөд энэ утгаараа шийдвэр гүйцэтгэл хариуцсан шүүгч шуурхай 7-14 хоногт шийдвэрлэдэг буюу аман хураалдаан хийх шаардлагагүй гомдол байхаар тусгалаа.

3. Түүнчлэн төлбөрийн үүргийг хангуулах эд хөрөнгийн үнэлгээний тайланг эс зөвшөөрвөл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу төлбөр төлөгч нэхэмжлэгч, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болж, зохигчийн эрх, үүргийг эдэлж, 3 шатны шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой байдаг төдийгүй тус хугацаанд ажиллагааг түдгэлзүүлдэг нь төлбөр төлөгч үндэслэлгүй олон гомдол шүүхэд гаргаж, ажиллагааг удаашруулах арга барил болгон ашигладаг практик тогтсон байна.

Эд хөрөнгийн үнэлгээний талаар шүүхэд гаргасан гомдол 2023 онд 362 буюу нийт 546 гомдлын 66.3 хувь нь байсан бол 2024 онд үнэлгээний гомдол 377 буюу нийт 486 гомдлын 77.5 хувь нь байсан байна.<sup>13</sup> Харин 2023 онд нийт гаргасан энэ төрлийн гомдлын 31.5 хувь буюу 172 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн бол 2024 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 35.8 хувь буюу 174 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн байна.<sup>14</sup>

2023 оны байдлаар 267 тэрбумын 330 төлбөр төлөгчид хамаарах ажиллагаатай холбоотой эд хөрөнгийн үнэлгээний гомдол шүүхэд гаргаснаас улбаалан түдгэлзсэн байна.<sup>15</sup>

Үнэлгээчний үнэлгээ тогтоосон үнэлгээний тайланг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах нь дараах эрсдэлийг бий болгож байна.<sup>16</sup> Үүнд:

- ойролцоогоор 2-4 жил шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зогсох;
- төлбөр авагч төлбөрөө барьцаа хөрөнгөөс хүртэл гаргуулах боломжгүй хязгаарлагдах, удаашрах.

Иймээс эд хөрөнгийн үнэлгээний талаар гарсан гомдлыг шүүхэд бус, дахин, эсхүл нэмэлт үнэлгээ хийлгэх байдлаар шийдвэрлэхээр тусгав.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх жиллагаанд саад учруулахад харилцаагч оногдуулах механизм нь Эрүү, зөрчлийн хууль тогтоомжоор зохицуулагддаг тул цагдаа, прокурор, шүүх гээд олон шат дамжлагыг туулдаг, гэтэл шийдвэр гүйцэтгэх

<sup>11</sup> [https://elaw.klnr.de/krfeng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.klnr.de/krfeng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>12</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>13</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

<sup>14</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

<sup>15</sup> Т.Наранцогт, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, ШШГЕГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

<sup>16</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023-аас.

ажиллагаа нь шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх сүүлийн үе шат байдаг ч шийдвэр гүйцэтгэгчид албадлага хэрэглэх хөшүүргүүд байхгүй байна.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдаж, дагаж мөрдөж эхэлсэн буюу 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хойш 7 орчим жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх гэмт хэрэгт 11 тохиолдолд шүүх хуралдаан хийж, гэм бурууг шийдвэрлэсэн байна.<sup>17</sup> Үүнээс нийслэлд 7, орон нутагт 4 шүүхийн шийдвэр хамаарч байна. Үүнээс 2 хэрэгт 6 сарын хугацаагаар хорих шийдвэр гаргасан байна. Гэхдээ эдгээр тохиолдлуудад хөрөнгийн мэдүүлгээ буруу гаргасан, зайлсхийсэн гэх үйлдлийг шийтгэсэн тохиолдол байхгүй буюу хөрөнгийн мэдүүлэг гаргахгүй байсан ч харьцуулагын механизм ажилладаггүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2-т заасан Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан, төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл бүхий зөрчлийн хэргээр маш цөөн хүн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор шалгасан дараах тохиолдол байна. Үүнд:

2023 онд 16 хүнд, 2024 онд 28 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан бол мөн хуулийн 15.27 дугаар зүйлд заасан Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх зөрчлийн хэргээр 2022 онд 14 хүн шалгаснаас 4, 2023 онд 8 хүнд, 2024 онд 5 хүнд тус тус торгох шийтгэл ногдуулсан байна.<sup>18</sup>

Гэтэл биелэгдээгүй иргэний шийдвэр гүйцэтгэл их буюу 2024 онд гэхэд 26619 төлбөр төлөгч төлбөрөө төлөөгүй байна.

БНСУ, ХНБГУ, Гүржийн туршлагаас харахад, шийдвэр гүйцэтгэлийн шүүх эдгээр торгох, баривчлах хөшүүргийг хэрэглэх эрх нь байна.

Тухайлбал, ХБНГУ-ын хуулийн 802g-д зааснаар шийдвэр гүйцэтгэлийн шүүх баривчлах /soercive detention/ шийдвэр гаргана.<sup>19</sup>

Гүрж улсын хуулийн 14<sup>14-18</sup>-д зааснаар шийдвэр гүйцэтгэлийн цагдаа /enforcement police office/ ажиллах бөгөөд дүрэмт хувцас өмсөж, ID card-тай, даатгалд хамрагдсан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн цагдаагаар гүйцэтгүүлэх ажлын хүсэлтийг гаргах, хувийн шийдвэр гүйцэтгэгч мөн хүсэлт гаргах гэхдээ төлбөр төлдөг байна.<sup>20</sup>

Иймд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч эдгээр арга хэмжээг шууд хэрэглэх боломжтой байдлаар зохицууллаа.

5. Хугацаа хэтэрсний хүү төлдөггүй, шийдвэр гарсан дүнгээр хэдэн ч жилийн дараа төлөхөд харьцуулага тооцохгүй байгаа нь төлбөр төлөгч төлбөрийг төлөхгүй удаашруулах боломжийг олгож байна.

<sup>17</sup> <https://shukh.mn/cases/2/1>

<sup>18</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл.

<sup>19</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>20</sup> <https://imatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

Төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүйн хүү, торгууль, алдангийг ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапур, Эстонид төлбөр төлөгчид оногдуулдаг байна. Гэрээгээр зохицуулаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэгчдэд ийнхүү төлбөр төлөгчөөс хугацаандаа төлөөгүй нөхцөлд хүү, алданги, торгуулийг авах эрхийг олгосон байдаг.<sup>21</sup>

Энэ асуудлыг хуульчилж, төлбөр төлөгч төлбөрөө цаг тухайд нь төлөх хөшүүргийг бий болгох үүднээс хуульчиллаа.

6. Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх нь тухайн этгээдийг төлбөрөө төлөх хөшүүрэг болох хязгаарлалтуудыг тавьж чадахгүй, хэлбэрийн төдий бүртгэл болжээ.

Төлбөртэй этгээдийн бүртгэл нь хааптай мэдээлэл байна. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.<sup>22</sup>

Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлөх, тодорхойлолт, лавлагаа гаргах журмыг<sup>23</sup> ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаалаар баталсан бөгөөд тус журамд зааснаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдэд олгож болохоор заасан. Ийнхүү тодорхойлолт, лавлагаа авахад төлбөртэй байхаар заажээ. Төлбөртэй бол лавлагаа, төлбөргүй бол тодорхойлолт гаргана. Гэхдээ энэхүү сангаас иргэн, хуулийн этгээдэд бусад этгээдийн талаарх мэдээлэл өгөхийг хориглосон.<sup>24</sup>

ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 882f-д зааснаар төлбөр төлөгчтэй дараа дараад гэрээ байгуулах гэсэн ямар ч этгээд эдийн засгийн сөрөг үр дагавар гарахаас сэргийлж, гэрээ байгуулах эсэхээ шийдэхийн тулд энэхүү төлбөртэй этгээдийн бүртгэлээс мэдээлэл авч болдог байна.<sup>25</sup>

Гүрж улсын хувьд, Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн 19<sup>1</sup>-д зааснаар төлбөртэй этгээдийн бүртгэлийг мөнгөн хөрөнгө гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эхэлмэгц заавал хийнэ.<sup>26</sup>

Төлбөртэй этгээдийн бүртгэлд заавал бүртгэх, түүнд бүртгэгдсэнээр төлбөр төлөгч төлбөрөө төлөх эрхийн хязгаарлалт бүхий хөшүүргүүдийг хуульчиллаа.

7. Эд хөрөнгийн мэдүүлгийг албадан гаргуулдаг тогтолцоо байхгүй байна.

ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 882f-д зааснаар төлбөр төлөгчтэй дараа гэрээ байгуулах гэсэн ямар ч этгээд эдийн засгийн сөрөг үр дагавар гарахаас

<sup>21</sup> ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

<sup>22</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.1 дэх хэсэг.

<sup>23</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.2 дахь хэсэг.

<sup>24</sup> ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаал.

<sup>25</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>26</sup> <https://imatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

сэргийлж, гэрээ байгуулах эсэхээ шийдэхийн тулд энэхүү төлбөртэй этгээдийн бүртгэлээс мэдээлэл авч болдог байна.<sup>27</sup>

Гүрж улсын хувьд, Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн 19<sup>1</sup>-д зааснаар төлбөртэй этгээдийн бүртгэлийг мөнгөн хөрөнгө гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эхэлмэгц заавал хийнэ.<sup>28</sup>

ХБНГУ-ын Иргэний процессын хуульд зааснаар эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахаар дуудахад төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацааг хожимдуулсан, эсхүл мэдүүлэг өгөх үүргээ зөрчсөн бол төлбөр төлөгчдийн бүртгэлд бүртгэгдэх үр дагавартай байна.<sup>29</sup>

Түүнчлэн хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс баривчлах шийдвэр гаргана. Баривчлах шийдвэрт төлбөр авагч ба төлбөр төлөгчийг, түүнчлэн баривчлах үндэслэлийг заана. Баривчлах шийдвэрийг биелүүлэхээс өмнө зайлшгүй хүргүүлэх шаардлагагүй.<sup>30</sup>

Хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, эсхүл буруу өгсөн, эсхүл төлбөр төлөх хөрөнгөгүй, хөрөнгө нь хүрэлцэхгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулдаг. Тус бүртгэлд орсноор банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, бусадтай бизнесийн үйл ажиллагааг хамтрах боломж хязгаарлагдахын зэрэгцээ тухайн төлбөр төлөгчийн үндсэн үйл ажиллагааг хязгаарладаг. Тухайлбал, төлбөр төлөгч хуульч бол хуульчаар ажиллах зөвшөөрлийг түдгэлзүүлдэг. Мөн төлбөртэй этгээдийн бүртгэл нь нийтэд нээлттэй байдаг тул төлбөр төлөгчид даруй төлбөрөө төлж, бүртгэлээс гарах гэж хичээх хөшүүрэг нь болдог.<sup>31</sup>

Гүрж улсын хувьд, төлбөртэй этгээдийн бүртгэл нь банк, ББСБ, төрийн байгууллагуудад нээлттэй бөгөөд сонирхогч этгээдэд төлбөртэйгээр нээлттэй байна.<sup>32</sup>

Гүрж улсын хувьд, мөн энэхүү бүртгэлд бүртгэгдсэнээр аливаа бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох үр дагавартай байдаг.<sup>33</sup>

Энэхүү мэдүүлгийг албадан заавал гаргуулах, бүртгэгдсэний үр дагавар нь төлбөр төлөгч төлбөрөө төлөх албдлагыг бий болгосон, мэдүүлгээ буруу, эсхүл дуутуу мэдүүлсэн, зайлсхийсэн бол шийтгэл хэрэглэдэг ажиллагаанд ач холбогдол авчрах байдлаар тусганаа.

8.Үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагааны журмыг боловсронгуй болгох шаардлага тулгарсан. Тухайлбал, үл хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагаанд битүүмжлэх, хураах 2 ажиллагааг заавал хийдэг. Гэтэл хураах асуудал үл хөдлөх эд хөрөнгийн тухайд байхгүй байдаг. Мөн барьцааны зүйл бол битүүмжлэх шаардлагагүй шуурхай албадан худалдах зэрэг зохицуулалт

<sup>27</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>28</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

<sup>29</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>30</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>31</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>32</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

<sup>33</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

байхгүйгээс барьцааны зүйлийг үл маргах журмаар гаргуулах Иргэний хуулийн зохицуулалт хэрэгжих боломжгүй болдог.

Шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа явуулах ялгамжтай зохицуулалт бий болгох буюу барьцааны зүйл бол битүүмжлэх шаардлагагүй шууд дуудлага худалдаа явуулах шийдвэр шуурхай гаргадаг байх, ингэснээр гэрээнд итгэх итгэлийг хамгаалах зарчим хангагдана.

Ийнхүү дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлага, тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн шүүгч ажиллагааны гомдлыг аман хуралдаангүйгээр шуурхай хянах, үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой ажиллагааг боловсронгуй болгох, төлбөр төлөгчийн хариуцлагатай байдлыг хангах буюу төлбөр төлөх хөшүүргийг бий болгох, шийдвэр гүйцэтгэгч бие даан хариуцлагатайгаар ажиллагааг хараат бусаар гүйцэтгэх болон тус ажиллагааг үр дүнтэй, шуурхай явагдах нөхцөлийг бүрдүүлж, шийдвэр гүйцэтгэлийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх хүрээнд уг хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслөөр иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгож, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай, үр дүнтэй байхад чиглэсэн зохицуулалтыг бий болголоо.

---oOo---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгаа бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээж эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.3.2-т "хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ" гэж, 7.4.8-д "ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор "Цахим хяналтын төв"-ийг байгуулж, пробагийн тогтолцоог хөгжүүлнэ" гэж, 7.4.14-т "үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна" гэж тус тус заасан.<sup>2</sup>

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>3</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>4</sup> 4.1.8-д "...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессуулан хуульчилна", гэж, 4.2.1.11-д "ялын бодлогыг нийтийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангаж, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ." гэж тус тус заасан нь Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

Хуулийн төслийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/104 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс боловсруулсан.

2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэлбэрээр, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг салгаж, нарийвчлан анхдагч хуулийн хэлбэрээр боловсрууллаа.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.  
<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2020 оны 25 дахь дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх, эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн төлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх, эрүүгийн болон зөрчлийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг боловсронгуй болгох, уг чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоо, зохион байгуулалтыг дэлхийн жишиг хандлага, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөх шаардлага үүсэж байна.

2025 оны 03 дугаар сарын байдлаар, 4615 хоригдол ял эдэлж байгаагаас нээлттэй дэглэмийн хоригдол 3449 буюу нийт хоригдлын 74.7 хувь, хаалттай дэглэмийн хоригдол 1126 буюу 24.3 хувийг эзэлж байна.

2024 онд нийт 2448 хоригдол 288.5 тэрбум төгрөгийн хохирол, төлбөртэй байснаас хөдөлмөрийн хөлснөөс хэсэгчилж төлсөн 677 хоригдлын 526.5 сая төгрөг, бүрэн барагдуулсан 54 хоригдлын 56.8 сая төгрөг, ар гэрээс нь хэсэгчилж төлсөн 70 хоригдлын 1.4 тэрбум төгрөг, бүрэн барагдуулсан 353 хоригдлын 2.8 тэрбум төгрөг, нийт 407 хоригдол 4.8 тэрбум төгрөгийг хохирогч буюу төлбөр авагчид шилжүүлж, 283.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монгол Улсын хэмжээнд 2024 онд хорих ангийн үйлдвэрлэлд 1307 хоригдол ажилласан бөгөөд үүнээс нээлттэй дэглэмд ял эдэлж байгаа 299 хоригдол, хаалттай дэглэмд ял эдэлж байгаа 271, нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа 737 хоригдол тус тус байна. Аж ахуйн үйлчилгээнд 328 хоригдол, аж ахуй нэгжид гэрээгээр 120, нийт 1775 хоригдлыг буюу нийт хоригдлын 38 хувь хөдөлмөрт хамрагдаж байгаа нь хоригдлыг хөдөлмөрт хамруулах хуулийн хэрэгжилт бүрэн дүүрэн хангагдахгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215 дугаар зүйлийн 215.5 дахь хэсэгт хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батлах бөгөөд хоригдлын хөдөлмөрийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна гэж заасны дагуу хоригдлын нэг өдрийн цалин 3929 төгрөгөөс дээш тогтоож, хоригдол гэрээгээ ажиллуулах журмын дагуу ажиллуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214 дүгээр зүйлийн 214.8 дахь хэсэгт зааснаар хаалттай хорих ангийн хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болох бөгөөд тус хуулийн 200.3 дахь хэсэгт зааснаар хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно. Иймээс хаалттай хорих ангийн хоригдлын хувьд хорих байранд л хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг.

Гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол хөдөлмөр эрхлэлтийн хоригдлын төлбөр төлөлт 2024 оны мөн үеэс 8.5 хувиар, цалинтай ажлын байраар хангасан хоригдлын тоо 30 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа нь гэм хорын төлбөр барагдуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу зөвхөн нээлттэй дэглэмд хорих ял эдэлж буй хоригдол хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хөдөлмөр эрхэлдэг бөгөөд мөн эрүүл мэндийн шалтгаанын улмаас хөдөлмөр

эрхлэх боломжгүй, хөдөлмөр эрхлэхээс татгалзсан, хорих ялын хугацаа бага, хорих ангийн дэглэм, зэрэглэл өөрчлөх, хорих анги солих зэрэг шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэх хоригдлын тоо буурсан байна.

Мөн эрүүгийн хариуцлагын зорилтын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, хоригдолд мэргэжлийн боловсрол эзэмшүүлж, хөдөлмөрийн дадал олгож ажлын байраар хангах, нийгмийн амьдралд бие даан ухамсартайгаар оролцох чадвартай, бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх зохицуулалт бий болгосон

Иймд хаалттай хорих ангийн тусгай төрлөөс бусад төрөлд ял эдэлж байгаа хоригдлыг байнгын ажлын байраар хангаж, хөдөлмөрт хамруулах, иргэн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулахад онцгойлон анхаарах, улс орны бүтээн байгуулалт, бүсчилсэн хөгжилд хоригдлыг ажиллуулах зорилгоор хорих ангийг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Иймд хуулийн төслөөр эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгож, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол нөхөн төлөлтийг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болголоо.

Хуулийн төслөөр хоригдлын хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцохыг өөрчилж, зах зээлийн үнэлгээгээр тооцохоор тусгаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хоригдлын хөдөлмөрлөх эрхийг хангаж, нэгдүгээрт хохирол төлүүлэх, хоёрдугаарт, ар гэртээ олсон орлогын тодорхой хувийг илгээх, мөн тодорхой хувийг нь хорих анги үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж авч, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжихэд, тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлэхээр /хоригдол хоол хүнс, урсгал зардлын тодорхой хувийг татвар төлөгч бус өөрөө гаргах суутгальг бий болгох/ тусгаснаар цаашдаа улсын төсвөөс хорих байгууллагын үйл ажиллагаанд зардал гаргуулахгүй байх зэрэг үр дүнг авчирна.

Дараах эрх олгосон заалтыг хуулийн төслөөр хүчингүй болгож, одоогийн журмын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа:

- 1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах хоригдлын ял эдлэх хорих ангийн дэглэм, төрлийг өөрчлөх болон хорих ангийг солих тухай санал гаргах журам;
- 2.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам;
- 3.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам;
- 4.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам;

5.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээлэх журам.

Дараах эрх олгосон заалтын хүрээнд батлах журмын хүрээг хумьж, одоогийн журмын үндсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа:

- 1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлах харуул хамгаалалтын журам;
- 2.Хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах хүнд өвчтэй хоригдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, хорих ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт;
- 3.Хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам;
- 4.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батлах Зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, бүрэлдэхүүн батлах журам.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/ЗЗ дугаар тушаалын хавсралтаар байгуулсан Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий Дэд ажлын хэсгээс боловсруулсан.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайтад 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хариуцдаг legalinfo.mn сайтад мөн оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус тус байршуулж, олон нийтээс санал авсан болно.

Мөн хуулийн төслийн хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулж, хэлэлцүүлэг оролцогчдын санал, хүсэлтийг хуулийн төсөлд харгалзан үзэж, тусгав. Үүнд, иргэний шийдвэр гүйцэтгэгчдийн зөвлөгөөнд хуулийн төслийг хэлэлцүүлээ.

---oOo---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө харуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>2</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>3</sup> 3.2.2.7-д "... иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж заасны дагуу иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, олон улсын сайн жишигт хүргэх" гэж тус тус заасан нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/33 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар байгуулсан Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий Дэд ажлын хэсгээс боловсруулсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр, мөн оны 3 дугаар сарын 10-ны өдөрүүдэд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн хурал, 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ын төслийн үзэл баримтлалыг танилцуулах олон нийтийн хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.

Мөн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдэд 2026 оны 05 дугаар сарын 11-ны өдөр, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран мөн оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Монголын Хуульчдын Холбооноос зохион байгуулах 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн симпозиумд хуулийн төслийг танилцуулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайтд 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан "legalinfo.mn" сайтд мөн оны 03 дугаар сарын 05-ны өдөр тус тус байршуулж, олон нийтээс санал авсан болно.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

Манай улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас хойш шүүхэд эерчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо тогтмол өсөж, цаашдаа нэмэгдэх хандлагатай байна. Монгол Улсад анх захиргааны хэргийн шүүх байгуулагдан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн 2004 онд 145 хэрэг шийдвэрлэгдсэн бол 2023 онд 2366 хэрэг шийдвэрлэгдсэн<sup>4</sup> нь үүнийг нотлон харуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг шаардлагатай бол албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог.<sup>5</sup> Гэвч захиргааны хэргийн шүүх байгуулагдсан өнгөрсөн 20 жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийн биелэлт төдийлөн хангалттай хэмжээнд биш байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь иргэний болон эрүүгийн шүүхийн шийдвэрээс мөн чанарын хувьд эрс ялгаатай. Тухайлбал, захиргааны акт хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, түдгэлзүүлэх, тодорхой захиргааны шийдвэр гаргахыг даалгах зэрэг шийдвэр нь эд хөрөнгө гаргуулах, эсхүл бэлэн мөнгөн төлбөр гаргуулах шинжээс ирүүтэйгээр төрийн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээ, чиг үүрэг, захиргааны үйл ажиллагаатай холбоотой байдаг. Иймээс эдгээр шийдвэрийг иргэний шийдвэр гүйцэтгэлтэй адилтган шийдвэр гүйцэтгэгчээр хэрэгжүүлүүлэх нь тохиромжгүй, үр нөлөө багатай байна.

Иймд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэн, эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас ялгаж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хяналтад шуурхай, үр нөлөөтэйгээр албадан гүйцэтгэх бие даасан тогтолцоог бүрдүүлэх замаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн төрөл бүрд тохирсон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ялгажтай, нарийвчилсан зохицуулалтыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслөөр шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелүүлсэнд тооцох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл, захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх, захиргааны шийдвэр гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, төлбөр, хохирол гаргуулах шийдвэрийг биелүүлэх, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ, шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээн явуулах, дуусгавар болгох журмыг 135-146 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтүүдийг тусгав:

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харилцааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бие даасан бүлгээр иж бүрэн зохицуулах;
2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн төрөл бүрд тохирсон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ялгажтай журам тогтоох;

<sup>4</sup> Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, (УБ, 2004-2023).

<sup>5</sup> А.Дугармаа, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал" сэдэвт илтгэл.

3. Захиргааны акт хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, түдгэлзүүлэх зэрэг шийдвэрийн шууд эрх зүйн үр дагаврыг тодотгосон;

4. Хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй тохиолдолд шүүхээс мөнгөн албадлага хэрэглэх буюу торгуулийг давтан ногдуулах;

5. Шүүхийн шийдвэрийг зөвхөн хэлбэрийн төдий биелүүлснийг биелэлтэд тооцохгүй байх;

6. Дээд шатны захиргааны байгууллага, төрийн албаны төв байгууллагын оролцоо, хяналтыг тодорхой болгох;

7. Төлбөр, хохирол гаргуулах асуудлыг төсөвтэй уялдуулан хугацаа тогтоох замаар шийдвэр гүйцэтгэл удааширдаг байдлыг шийдвэрлэх;

8. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа, баримт бичгийн хөдөлгөөн, гомдол, түдгэлзүүлэх үндэслэлийг тодорхой болгож, процессын удаашралыг бууруулах.

9. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх өөрөө удирдан явуулах.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах зэрэг үр нөлөө гарна гэж үзэж байна.

Нэгдүгээрт, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт сайжирна. Өнөөгийн байдлаар биелэлт сул, удаашралтай байгаа гол шалтгаан нь зохицуулалтын дутмаг байдал, мөнгөн болон сахилгын хөшүүргийн сул байдал юм. Шүүх өөрөө албадлагын арга хэмжээ авч, давтан хэрэглэх боломжтой болсноор хариуцагч байгууллага, албан тушаалтанд нөлөөлөх бодитой механизм бүрдэнэ.

Хоёрдугаарт, шүүхээр хамгаалагдсан эрх бодитоор, шуурхай сэргэх нөхцөл бүрдэнэ. Тэр дундаа ажилд эгүүлэн тогтоох, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, даалгах шийдвэр зэрэг "хугацаа" чухал ач холбогдолтой байдаг маргаанд нэн даруй болон шуурхай гүйцэтгэх боломж нэмэгдэнэ.

Гуравдугаарт, захиргааны актыг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, түдгэлзүүлэх зэрэг шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагаврыг тодорхой болгосноор шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад гардаг төөрөгдөл арилна.

Дөрөвдүгээрт, захиргааны байгууллага, албан тушаалтны хариуцлага нэмэгдэнэ. Мөнгөн торгууль, сахилгын шийтгэл, олон нийтэд мэдээлэх, шүүхийн цахим бүртгэлд байршуулах зэрэг олон талт механизм нь шүүхийн шийдвэрийг үл ойшоох байдлыг бууруулна.

Тавдугаарт, процессын удаашрал, тодорхой бус байдал багасна. Гүйцэтгэх хуудас, хүргүүлэх баримт бичиг, хугацаа, түдгэлзүүлэлт, дуусгавар болгох үндэслэл тодорхой болсноор шүүх, оролцогч талууд, захиргааны байгууллагын хоорондын ойлголтын зөрүү багасна.

Зургадугаарт, шүүхийн шийдвэрийн биелэлтэд төрийн албаны төв байгууллага, дээд шатны захиргааны байгууллагын оролцоог илүү үр нөлөөтэй болгож, институт ц хоорондын уялдаа сайжирна.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удаашралыг арилгахад чиглэсэн тогтолцоог шуурхай, үр дүнтэй болгоход чиглэсэн зохицуулалтыг бий болголоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл нь 7 бүлэг, 42 зүйлтэй.

### Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

Уг бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээг тусгалаа. Ингэхдээ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа, зохион байгуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа иргэний шийдвэр гүйцэтгэх албаны үйл ажиллагаа, зохион байгуулалт, иргэний шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршихоор тусгасан.

Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Засгийн газрын агентлаг хэвээрээ байхаар, ингэхдээ эрүү, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төрийн цэргийн алба хаагчдаас бүрдэхээр, харин иргэний болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь тус байгууллагын харьяа алба байхаар, гэсэн хэдий ч төрийн цэргийн алба хаагчийн статусгүй зөвхөн төрийн албан хаагчийн цалин хөлс авах, мөн нэмэлтээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулал авахаар тусгалаа.

### Шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид

2025 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба буюу иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх албанд нийт 460 алба хаагч ажилладаг бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч 56, шийдвэр гүйцэтгэгч 244, захиргаа, мэргэжлийн удирдлага 26, санхүү үйлчилгээ 42, тоо бүртгэл, лавлагаа мэдээлэл 17, харуул, хамгаалалт 6, эрэн сурвалжлах 9 албан хаагч ажиллаж байна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 244 шийдвэр гүйцэтгэгч байсан. 118 нь нийслэлд, 126 нь орон нутагт байдаг. Ахлах шийдвэр гүйцэтгэгч 47 байна. /1 ахлах зөрчил шалгадаг./ нийслэлд 18 ахлах, үүний 5 нь ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид ирсэн гомдол, хүсэлтийг хянадаг байсан байна.

Улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/23 тоот тушаалын хавсралтаар батлагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тооны дагуу 304 шийдвэр гүйцэтгэгчтай байхаар буюу 2021 оноос хойш 244<sup>2</sup> байснаас 60-аар нэмэгджээ.<sup>3</sup>

### Шийдвэр гүйцэтгэгчийн цалин

Цалин хөлсний тухайд Дөслөгч цолтой шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлсийг тооцож үзвэл гарт олгох цалин 2,318,892 төгрөг байна.

Үндсэн цалин	Нэмэгдэл	Эрүүл мэндийн даатгал	Татвар
ТТ-7 <sup>4</sup>	1. Цол/Дөслөгч/- 26% 2. ХАН- 10% 3. ОНН- 25% 4. ТТАХН- 0% Нийт 61%	2%	10%
1,633,000 төг	996,130 төг	52,582.6 төг	257,654.7 төг

Гарт олгох : 2,318,892.7 төг

Цаашид шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах бодлоготой уялдуулан судлаачын зүгээс эдгээр албан хаагчдын цалин хөлс хэрхэн өөрчлөгдөх талаар тооцоолох шаардлагатай гэж үзэн дараах байдлаар тооцлоо.

Үндсэн цалин	Нэмэгдэл	Эрүүл мэндийн даатгал+Нийгмийн даатгал	Татвар
Т3-6 <sup>5</sup>	1. зэрэг дэвийн нэмэгдэл /дэс түшмэл/- 18% 2. ТАН- 3% Нийт 21%	11.5 %	10%
1,693,000 төг	355,530 төг	235,580 төг	181,294 төг

<sup>2</sup> ХЗДХС-ын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тоо тогтоох тухай 2021 оны А/293 тоот тушаал.

<sup>3</sup> ХЗДХС-ын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тойргийн тоо тогтоох тухай 2025 оны А/23 тоот тушаал.

<sup>4</sup> ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ"

<sup>5</sup> ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ"

Гарт олгох : 1,631,656 төг

Дээрх тооцоолоос үзэхэд шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргаж, төрийн захиргааны албан хаагчийн ангилалд хамруулснаар шийдвэр гүйцэтгэчийн цалин хөлс 30 орчим хувиар буурахаар байна.

#### Шийтгээ

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах тохиолдолд алба хаагчдын тэтгэвэр, тэтгэвэр тэтгэмжийн асуудал хөндөгдөх бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авсан мэдээлэлээ үзэхэд ирэх 5 жилийн хугацаанд 48 албан хаагчийн тэтгэвэрийн эрх үүсэхээр байна.

Иймд цаашид шийдвэр гүйцэтгэх албыг төрийн тусгай албаны ангиллаас гаргах эсэх, ангилал зэрэглэлийг хэрхэн тогтоохыг харгалзан эдгээр алба хаагчдын эрх зүйн байдлын талаар Хууль тогтоомжийг тухай хуульд заасан холбогдох бусад судалгааг гүйцэтгэх замаар судлах нь зүйтэй.

#### Урамшуулал

1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 2002 он хүртэл дагаж мөрдөж байсан ба энэ үед шийдвэр гүйцэтгэгч урамшуулал авдаггүй байсан байна.<sup>6</sup> Харин 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгч цалингаас гадна урамшуулал авдаг байсан байжээ.<sup>7</sup> Энэхүү зохицуулалт 2017 оны буюу одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдах хүртэл хэрэгжсэн.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83.1 дэх хэсэгт "Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10 хүртэлх хувиар урамшуулна." гэж, мөн зүйлийн 83.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчилэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна." гэж, хуулийн 83.3 дахь хэсэгт зааснаар олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор заажээ.

ХЗДХС-ын 2002 оны 208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шийдвэр гүйцэтгэчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмын<sup>8</sup> 2.1-д зааснаар биелүүлсэн шүүхийн шийдвэрийн хувьд мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс 5-10 хувийн урамшууллыг суутгаж, аймаг, нийслэлийн ШГА-ны дансанд төвлөрүүлнэ. 3-т зааснаар урамшууллыг шийдвэр гүйцэтгэгчид, болзошгүй эрсдлийн санд, шийдвэр гүйцэтгэчийн үйл ажиллагааны бусад зардалд хуваарилдаг. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэгчид хуваарилах урамшууллын хэмжээ нь 1 сая хүртэлх төгрөгийн шийдвэрийн хувьд 5.5 хувь, 1-5 сая бол 4 хувь, 5-10 сая бол 3 хувь, 10-25 сая бол 2.5 хувь, 25-50 сая бол 2 хувь, 50-75 сая 1.5 хувь, 75-100 сая төгрөгийн 1 хувь, 100 саяас дээш бол 0.5 хувь байхаар заасан байна.

<sup>6</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=7165>

<sup>7</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=89>

<sup>8</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=203760>

1-5 сая төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудас биелүүлэхэд 200 мянган төгрөг, 75 сая төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх хуудас биелүүлэхэд 1,875,000 төгрөгийн урамшууллыг шийдвэр гүйцэтгэгчид олгохоор байсан байна.

Түүнчлэн дээрх Шийдвэр гүйцэтгэчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журмыг ХЗДХС-ын 2010 оны 104 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар шинэчлэн тогтоосон байна.<sup>9</sup>

Урамшуулалтай байсан 2002-2016 оны хоорондын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл 4,7 тэрбум орчим мөнгөн дүн бүхий 413916 гүйцэтгэх хуудаст хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 1,6 тэрбум мөнгөн дүн бүхий гүйцэтгэх ажиллагаа биелэгдсэн байх бөгөөд энэ нь нийт гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх хуудасны 53 хувь, мөнгөн дүнгийн 35 хувийг эзэлж байна.

Харин Урамшуулалгүй үеийн /2017-2024/ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн үзүүлэлт дундажаар 52.5 хувь, мөнгөн дүн 26.3 хувьтай ажилласан байна. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүнээс хамаарсан ялгамжтай урамшуулалгүй болсноор гүйцэтгэх баримт бичиг бага үнийн дүнтэй эсэхээс үл хамааран гүйцэтгэх баримт бичгийн биелэлт өндөр, мөнгөн дүнгийн биелэлт буурсан байна.

Өөр нэг ажиглагдаж буй чухал давтамж бол урамшуулалгүй үеийн 2017-2024 оны шийдвэрийн биелэлтийг үзэхэд, бүх онуудад гүйцэтгэх баримт бичгийн биелэлт мөнгөн дүнгийн биелэлтээс илүү байсан байна.

2015 онд буюу ШШГТХ 2017 батлагдахаас өмнө гүйцэтгэх хуудасны биелэлт 46.3 хувь, 2022 онд 54.6 хувь болж өссөн ч энд бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн өсөлтийн хувь 9.2 байсан, 5 саяас дээш гүйцэтгэх хуудаст явуулсан ажиллагааны биелэлт 3.3 хувиар өссөн. Шийдвэр гүйцэтгэгч урамшуулалтай байсан 2017 оноос өмнөх үед өндөр үнийн дүнтэй буюу урамшуулал ахиухан авах гүйцэтгэх баримт бичигт хийх ажиллагаа түлхүү явагдаж, бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн биелэлт сул, харин 2017 оноос хойш урамшуулалгүй тул бага үнийн дүнтэй хялбар гүйцэтгэж болох гүйцэтгэх баримт бичгийн биелэлт нь нэмэгджээ.<sup>10</sup>

Мөн урамшууллын хувь хэмжээг зохистой тогтоохгүй бол төлбөр төлөгч, төлбөр авагчийн хувьд санхүүгийн дарамт болох, улмаар шүүхийн шийдвэрийн биелэлтэд сөргөөр нөлөөлөх, гагцхүү том үнийн дүнтэй хэргүүд дээр ажиллагаа төвлөрөх зэрэг сөрөг үзэгдлүүд түгээмэл ажиглагддаг.<sup>11</sup>

#### Бусад улсын туршлага

##### Зардал ба түүнээс бодох шийдвэр гүйцэтгэчийн бонус

ХБНГУ-ын хувьд гэхэд, шийдвэр гүйцэтгэгч нь төрийн албан хаагчийн үндсэн цалингаас гадна төлбөр авагчийн урьдчилан төлсөн ажиллагааны зардлын 15 хувийг

<sup>9</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawid=205350>

<sup>10</sup> Я.Батгэрэл, Шийдвэр гүйцэтгэчийн урамшуулал, хэрэгцээ шаардлага, ШШГГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

<sup>11</sup> З.Шардурсрэн, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо, олон улсын туршлага, ШШГГ-ын Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

бонус болгон авдаг.<sup>12</sup> Ажиллагаа бүр энэхүү бонусыг шингээсэн хэмжээнд тогтоосон зардалтай байдаг.

Түүнчлэн Гүрж улсын хувьд мөн адил шийдвэр гүйцэтгэгч ажиллагааны зардлаас 15 хувийг бонус байдлаар авдаг, хувийн шийдвэр гүйцэтгэгч зардлыг бүтэн авч, үйл ажиллагаандаа зарцуулдаг байна.<sup>13</sup>

#### Шийдвэр гүйцэтгэгч ба бусад ажилтан

Гүржид нийт 424 албан хаагч байх ба үүний 158 нь шийдвэр гүйцэтгэгч, захиргаанд 157, шийдвэр гүйцэтгэлийн цагдаа 57 байна.<sup>14</sup>

#### Цалин урамшуулал

Монгол Улсын иргэний шийдвэр гүйцэтгэгчид төрийн тусгай албан хаагч бөгөөд цолны нэмэгдэл авч байна. Гэхдээ бонусгүй.

Бусад улсын хувьд цэргийн цолгүй ч бонус авч, төрийн албан хаагч байгаа нь урамшуулах тогтолцоог бүрдүүлжээ. Цэргийн цолгүй болвол уг бонусаар нэмэгдэл цалинтай байх боломжтой байгааг харгалзан урамшууллыг сэргээсэн.

Цэргийн цолтой байснаар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дээд албан тушаалтны үүрэг даалгаврыг биелүүлэх, цол авахын тулд дээд албан тушаалтанд таалагдах зэрэг ашиг сонирхлын зөрчил үүсгэх боломжтой байгааг засч, ажиллагааг шуурхай, үр дүнтэй байлгах үүднээс цэргийн цолыг болиулж, урамшууллаар нэмэгдэл орлого олох олон улсын сайн туршлагыг бий болголоо.

#### Шийдвэр гүйцэтгэгч ба бусад захиргааны албан хаагч

Гүрж улс гэхэд 3 сая 800 мянга гаруй хүн амтай ч<sup>15</sup> нийт 424 албан хаагчтай 158 шийдвэр гүйцэтгэгчтэй тэдгээр туслах 157 захиргааны албан хаагчтай, 57 шийдвэр гүйцэтгэлийн цагдаатай багтай байна. Манай улсад 304 шийдвэр гүйцэтгэгч, 56 ахлах шийдвэр гүйцэтгэгчтэй ч Захиргаа, мэргэжлийн удирдлага-хяналт тавих 26 албан хаагч байгаа нь нийт 460 албан хаагчийн 6.7 хувь нь байгаа нь туслах чиг үүрэгтэй захиргааны албан хаагч дутмаг байгаа нь ажиллагаа удаашралтай, шийдвэр гүйцэтгэгч ачаалалтай байгаатай холбоотой байж болохоор байна.

Иймээс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ахлах шийдвэр гүйцэтгэгч, ерөнхий шийдвэр гүйцэтгэгч ханах, тушаал өгөх бус туслах чиг үүргийн алба хаагчийг бүрдүүлэх шаардлагыг хуулийн төсөлд тусгалаа.

#### Хоёрдугаар бүлэг

#### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо

Энэ бүлэгт байгууллагын тогтолцоо, туг, далбаа, бэлэг тэмдэг хэрэглэх алба хаагчийн тангараг зэргийг тусгалаа.

<sup>12</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>13</sup> Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

<sup>14</sup> Гүржийн шийдвэр гүйцэтгэлийн туршлага судлах аялалын баримтаас 2023

<sup>15</sup> <https://www.worldometers.info/world-population/georgia-population/>

#### Гуравдугаар бүлэг Бүрэн эрх, чиг үүрэг

Энэ бүлэгт шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, даргын бүрэн эрх, мөн иргэний шийдвэр гүйцэтгэх албаны онцлог, албаны чиг үүрэг, даргын бүрэн эрхийг тусгалаа.

Ингэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэх алба нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяанд байх бөгөөд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд<sup>16</sup> зааснаас гадна иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй болгоход чиглэсэн төлөвлөгөө, санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байхаар тусгасан.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, биелэгдээгүй шийдвэрийн шалтгаан нөхцөл, ажлын үр дүнг улирал бүр Улсын дээд шүүхэд танилцуулах бөгөөд Улсын дээд шүүх энэхүү ажиллагаанд хяналт тавьж, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг сайжруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах, ингэснээр шийдвэр гүйцэтгэл, шийдвэр гаргасан шүүх хоорондын харилцан уялдааг хангах, ажиллагааг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг бий болголоо.

Мөн тус албаны дарга нь цэргийн алба хаагч биш байх, дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

- иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй болгоход чиглэсэн төлөвлөгөө, санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- иргэний шийдвэр гүйцэтгэгч, албаны бусад алба хаагчийг хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх, сэлгэх, шилжүүлэх;
- иргэний шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулах;
- иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан урамшууллыг улирал бүр тус хуульд заасны дагуу хуваарилах, захиран зарцуулах;
- иргэний шийдвэр гүйцэтгэх албыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

<sup>16</sup> Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

**Дөрөвдүгээр бүлэг**  
**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид тавигдах шаардлага**

Энэ бүлэгт иргэний шийдвэр гүйцэтгэгч, эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг ажиллагааны онцлог бүрд нь тохирсон байдлаар хуульчиллаа. Иргэний шийдвэр гүйцэтгэчийг мөн сонгон шалгаруулалтаар өрсөлдүүлж, иргэний шийдвэр гүйцэтгэлийн албаны дарга томилохоор тусгасан.

**Тавдугаар бүлэг**  
**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчийн эрх зүйн байдал**

Энэ бүлэгт алба хаагчийн эрх зүйн байдлыг иргэний шийдвэр гүйцэтгэгч, эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэгчид ялгаатай байдлаар тусгаж, алба хаагчийн нийгмийн баталгааг нарийвчлан тусгасан.

**Зургадугаар бүлэг**

Энэхүү бүлэгт иргэний шийдвэр гүйцэтгэгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, журам, сахилгын хорооны талаар тусгалаа.

**Долдугаар бүлэг**  
**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төсөв, данс бүртгэл**

Энэ бүлэгт байгууллагын данс, төсвийн талаар тусгаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүхэлдээ улсын төсвөөс санхүүжих ч иргэний шийдвэр гүйцэтгэх албаны хувьд урамшууллын 30 хувиар сургалт, цахим систем зэргийг зохион байгуулах, 70 хувийг алба хаагчдаа хуваарилах байдлаар тусгасан.

**Наймдугаар бүлэг**  
**Бусад**

Энэ бүлэгт уг хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгалаа.

---oOo---

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээх, эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулахдаа иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удаашралыг арилгахад чиглэсэн тогтолцоо, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмыг шуурхай, үр дүнтэй болгоход чиглэсэн зохицуулалтыг бий болголоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хэрэг янхан шийдвэрлэх ажиллагааны дараа шүүхийн шийдвэр гарах, улмаар түүний "үргэлжлэл" болсон бие даасан үе шат болдог. Нөгөө талаас, хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй этгээдэд холбогддуулан нэхэмжлэгч, эсхүл төлбөр авагчийн хүсэлтээр гүйцэтгэх хуудас шүүхээс бичигдэж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхэлдэг буюу албадлагын журмаар шүүхийн шийдвэрийг биелүүлэх үе шат байдаг.

Гэтэл одоо дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр албадан биелүүлэх ажиллагааны зохицуулалт нь удаашрал дагуулсан, албадлага хэрэглэх үндэслэл бага, шүүхийн шийдвэр заавал биелэгдэх хөшүүрэг багатай байгаа болно.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл нь 16 бүлэг, 162 зүйлтэй.

### Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, зарчим, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёо, шийдвэр гүйцэтгэгчид хориглох зүйлс, шийдвэр гүйцэтгэх хугацаа, шийдвэр гүйцэтгэлийн шүүгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тэмдэглэл, шийдвэр, мэдэгдэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үе шатанд тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол хугацаа эхтрүүлсний хүү тооцох, ингэснээр төлбөр төлөгч төлбөрөө цаг хугацаанд нь төлөх хөшүүргийг бий болгох, төлбөр авагчийн мөнгөний үнэ цэнийг хамгаалах ач холбогдолтой зохицуулалтыг тус тус тусгасан.

### Хуулийн зарчим

Хуулийн төслийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг бодитоор сэргээх, нөхөн төлүүлэх үүднээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

гүйцэтгэх ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах зорилгоор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг албадан гүйцэтгэх ажиллагаа болон албадлагын үе шат дахь гомдол гаргах үндэслэл, журмыг тогтоох, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршихоор тусгалаа.

ШШГЕГ-ын статистик мэдээллээс үзэхэд иргэний шийдвэр гүйцэтгэлийн биелэлт 2024 оны хувьд биелүүлбэл зохих 56920 гүйцэтгэх хуудаснаас 26619 гүйцэтгэх хуудас биелэгдээгүй бөгөөд мөнгөн дүнгийн хувьд 3 их наяд 486 тэрбум 12 сая 933 мянган төгрөгийг биелүүлэхээс 2 их наяд 383 тэрбум 137 сая 592 мянган төгрөгийг биелүүлээгүй буюу мөнгөн дүнгийн биелэлтийн хувь 31.6 хувьтай байна.<sup>2</sup>

Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 639 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 167 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 50 гүйцэтгэх хуудсанд хамаарах 45 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 7.2 хувь буюу 593 тэрбум орчим төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.<sup>3</sup>

Иймд шүүхийн шийдвэр албадан биелүүлэх ажиллагааг шуурхай, үр дүнтэй байхад чиглэсэн зохицуулалтыг бий болгох, эдгээр нь ажиллагааны гол зарчим болохоор тусгалаа.

### Мэдэгдэх үүрэг

Эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгчийн талаарх гүйцэтгэлийг харуулбал:

Он	Оны үлдэгдэл	Шинээр нэмсэн	Олж тогтоосон	Үлдэгдэл
2017	400	471	490	381
2018	381	739	614	506
2019	506	761	719	548
2020	548	1348	1102	794
2021	794	614	804	604
2022	604	1495	1181	918
2023	918	2498	2427	989
2024	989	1332	1372	349
2025	949	150	226	873

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025 оны 3 дугаар сар.

Дээрх эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн тоо нь зөвхөн төлбөр авагчийн гомдол, хүсэлтээр шийдвэр гүйцэтгэгч эрэн сурвалжлах алба, цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулж байгаа тоо болно. Үүнээс гадна шийдвэр гүйцэтгэгч өөрөө хайж байгаа хагь тодорхойгүй олон тохиолдол байдаг бөгөөд төлбөр авагч гомдол, хүсэлт гаргаагүй үед өөрөө хайдаг.

Ийнхүү төлбөр төлөгчийн хагь тодорхойгүй үед тэр хэмжээгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч саатдаг.

Хуулийн төсөлд мэдэгдэх үүргийн тухайд иргэн, хуулийн этгээд улсын бүртгэлд сүүлд бүртгүүлсэн хаягаар, эсхүл цахим хаягаа урьдчилан өгсөн бол цахимаар

<sup>2</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024 оны 12 дугаар сарын байдлаар.

<sup>3</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024.

Статистик мэдээлээс үзэхэд, 2023 онд 546, 2024 онд 575 шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хэрэгт шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцагч (defendant)-аар татагдан оролцсон байна.<sup>5</sup> Эдгээр тохиолдол бүрд урт удаан хугацааны турш шүүхэд төлөөлж, шүүх хуралд оролцох бэлтгэл хангаж, оролцох байдлаар цаг хугацааг үр ашгийг өнгөрөөхөөр байдаг буюу ажиллагаа нь түдгэлзэж зогссон байдаг.

### Төлбөр төлөгчийн шүүхэд гаргасан гомдлын хувь

Он	Шүүхэд гаргасан гомдол	Төлбөр төлөгчийн нэхэмжлэлтэй гомдол	Нийт шүүхэд гаргасан гомдолд эзлэх төлбөр төлөгчийн гомдлын хувь хэмжээ
2023	546	425	77.8 %
2024	575	444	77.2 %

Эх сурвалж: Шийдвэр гүйцэтгэгч хариуцагчаар шүүхэд татагдсан тохиолдлын судалгаа, 2025.

### Төлбөр авагчийн шүүхэд гаргасан гомдлын хувь

ШШГЕГ-аас ирүүлсэн 2022 оны статистик мэдээллээс харахад 2022 оны байдлаар ажиллагаатай байсан болон байгаа материалуудаас 786 гүйцэтгэх хуудасны 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг битүүмжлэн хурааснаас 508 гомдлыг шүүхэд гаргасан байна. Эдгээр гомдлын 435 нь төлбөр төлөгчийн гаргасан, харин гуравдагч этгээд буюу өмчлөгчийн гаргасан нь 57 байна.<sup>6</sup>

Харин нийт шүүхэд гаргасан гомдлын ердөө 3 хувь нь төлбөр авагчийн гаргасан гомдол байх тул иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах зохицуулалт нь төлбөр төлөгчийн ажиллагааг удаашруулах буюу түдгэлзүүлэх зохицуулалтыг ашиглах тактик болох боломжийг олгосон гэж үзэхээр байна.<sup>7</sup>

### Шүүхэд гаргасан гомдол үндэслэлтэй эсэх

Үүнээс гомдол шүүхэд гаргаснаас гомдлыг хангаж шийдвэрлэсэн тохиолдлын тоо, хувийг харуулав. Үүнд:

- 2023 онд 546 гомдол шүүхэд гаргаснаас 28 гомдлыг хангасан буюу нийт гомдлын 5.1 хувь;
- 2024 онд 575 гомдлыг шүүхэд гаргаснаас гомдлыг хангаж шийдвэрлэсэн 43 буюу гомдлыг хангаж шийдвэрлэсэн тохиолдол нийт гомдлын 7.8 хувь.

Харин гомдлыг хангаж шийдвэрлэсэнээс бусад гомдлын хувьд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл нэхэмжлэлийг буцаасан байна.<sup>8</sup>

### Шүүхэд гаргасан төлбөр төлөгчийн гомдлыг шийдвэрлэсэн хугацаа

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай гомдлыг шүүх тусгайлан журмаар хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт нь 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд үүний дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

<sup>5</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2024 он.

<sup>6</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2022 он.

<sup>7</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээлэл 2022 он.

<sup>8</sup> Шийдвэр гүйцэтгэгч хариуцагчаар шүүхэд татагдсан тохиолдлын судалгаа, 2025.

мэдэгдэхээр тусгасан бөгөөд хэрэв сүүлд бүртгүүлсэн хаяган дээрээ байхгүй бөгөөд хаягийн өөрчлөлтөө улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол тухайн иргэн, хуулийн этгээдэд хүргэсэнд тооцож, үүний дараа шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудсанд тусгай булан үүсгэж, хаяг дээрээ байгаагүй этгээдийн мэдэгдэх хуудсыг тодорхой хугацаанд байршуулснаар танилцах боломжоор хангасанд тооцож, тус хугацаа өнгөрмөгч мэдэгдэх хуудсыг гардуулсанд тооцохоор тусгалаа.

Ингэснээр иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчийн хариуцлага дээшилж, ажиллагаанд санаатайгаар саад учруулж, удаашруулахаас сэргийлэх ач холбогдолтой.

### Хугацаа хэтрүүлсний хүү

Төлбөрийг цаг хугацаанд нь төлөөгүйн хүү, торгууль, алдангийг ХБНГУ, Норвеги, Швед, Япон, БНСУ, Сингапур, Эстонид төлбөр төлөгчид оногдуулдаг байна. Гэрээгээр зохицуулаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэгчдэд ийнхүү төлбөр төлөгчөөс хугацаандаа төлөөгүйгийн хүү, алданги, торгуулийг авах эрхийг олгосон байдаг.<sup>4</sup>

Манай улсад ийм хүү шийдвэр гүйцэтгэлийн шатанд бодолгүй бөгөөд бий болговол төлөх ёстой төлбөр төлөхгүй удаа тусам нэмэгдэх үр дагавартай гэсэн ойлголт, хөшүүрэг бүрдэж, төлөлтөд эерэгээр нөлөөлнө.

### Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Тус хэсэгт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмыг нарийвчлан зохицуулах бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2025, олон улсын экспертний дүгнэлтэд үндэслэн энэхүү ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицууллаа.

### Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх гомдол

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1-д "Шүүх дараах хэргийг гомдлоор авч хэлэлцэнэ" гэж, 156.1.3-т "шүүх шийдвэрлэхээр хуульд заасан бусад гомдол" гэж, мөн зүйлийн 156.2-т "Гомдлоор авч хэлэлцэх хэргийг шүүх энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу хэлэлцэнэ." гэж тус тус заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний хэргийн шүүхэд гомдол гаргадаг бөгөөд ингэснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /enforcement agents and debtors/ дараах иргэний хэрэг хянан шийдвэрлэх /litigation process/-ын талууд болж хувирдаг. Үүнд:

- шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүнийг төлөөлж шийдвэр гүйцэтгэгч enforcement agents нь хариуцагч буюу (defendant) болох;
- төлбөр төлөгч debtor нь нэхэмжлэгч буюу (claimant) болж, хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаа (litigation)-ны оролцогчийн эрх, үүргийг эдэлж эхэлдэг.

<sup>4</sup> ЕСБХБ, Зарим улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулийн зохицуулалтыг харьцуулсан судалгаа, 2025 оны 1 дүгээр сар.

асуудал байхгүйгээр шууд барьцаа болон шүүхийн энэ талаарх гүйцэтгэх хуудсыг үндэслэн үнэлгээ тогтоож, дуудлага худалдааг эхлүүлж байна.<sup>9</sup>

Түүнчлэн ХБНГУ-ын иргэний процессын хуулийн 867 дугаар зүйлийн 3-т "Баталгаат ипотекийг албадан дуудлага худалдаагаар дамжуулан шаардлагыг хангахад бүртгүүлсэн тухай тэмдэглэл бүхий шийдвэр гүйцэтгэлийн баримт бичиг хангалттай." гэж заасан. Мөн адил барьцаатай бол барьцааг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шууд худалдан борлуулах боломжийг олгосон буюу барьцаагүй тохиолдолд ҮХЭХ-ийг битүүмжилж, албадан дуудлага худалдаа явуулдаг асуурхай ажиллагаа явуулдаг байна.<sup>10</sup>

### Хөөн хэлэлцэх хугацаа

Мөн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлүүлэх хөөн хэлэлцэх хугацааг олон улсын жишигт нийцүүлэн уртасгалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа нэлээд богино буюу 2-4 жил байхаар заасан байна.<sup>11</sup>

Үүнээс гадна хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо нэлээн төвөгтэй байна. Хэдийгээр ажиллагаа үүсгэх хугацаа богино байгаа ч төлбөр авагч нь шүүхээс хугацаа дахин гурван жилээр сунгах хүсэлт гаргах эрхтэй (18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт). Хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийд нь сунгаснаар энэ шаардлагагүй хүнд суртлын тогтолцооноос зайлсхийх боломжтой. Жишээлбэл, Нидерландад хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа (Иргэний хуулийн 3:324-т) 20 жил байдаг (Австри, Люксембург: 30 жил). Мөн Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас хугацааг сайтар хэлэлцэж, хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийд нь сунгах саналыг гаргасан.<sup>12</sup> Хөөн хэлэлцэх хугацааны хувьд Энэтхэгт гэхэд 12 жил байна.<sup>13</sup>

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэх үндэслэл

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа одоо дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар ажиллагаа бүрд гомдол гаргах боломжтой байдлаар хуульчилснаас шалтгаалж, ажиллагаа үндэслэлгүйгээр удааширч, ажиллагаа түдгэлзэх практик бий болсон.

Үүнийг сайжруулж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэх үндэслэлийг хуульд тодорхой тусгасан.

Тухайлбал, өвлийн улиралд орон байрнаас албадан нүүлгэх тухай шийдвэрийг нүүн гарч байгаа этгээдийн амьдралын нөхцөлийг харгалзан өвлийн улирал дуусгал, төлбөр төлөгч, төлбөр авагч нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, эсхүл төлбөр төлөгч, төлбөр авагч хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг

<sup>9</sup> [https://law.kiri.re.kr/eng\\_mobileviewer.do?hseq=41807&type=part&key=8](https://law.kiri.re.kr/eng_mobileviewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>10</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>11</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйл.

<sup>12</sup> ЕС5ХБ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд хийсэн дүн шинжилгээ, нэмэлт өөрчлөлт оруулах талаарх санал, зөвлөмж 2024.

<sup>13</sup> <https://cdnbbsr.s3waas.gov.in/s3ec030655f117444fc1911ab9c6f6b013/urloads/2024/06/2024062630.pdf>

хуульд орсон нэмэлтийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдлыг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75<sup>2</sup> дугаар зүйлийн 75<sup>2</sup>.3-т "Иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ." гэж, мөн зүйлийн 75<sup>2</sup>.4-т "Энэ хуулийн 75<sup>2</sup>.3-т заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно." гэж тус тус зааснаас үзэхэд шүүхэд гомдол гаргах замаар ажиллагааг хэргийн оролцогч шүүх хуралданыг хойшлуулах, шүүгчээс татгалзах зэрэг зохигчийн эрхээ эдлэхгүй бол хамгийн багадаа 45-59 хоногийн хугацаагаар шийдвэрлэхээр болсон байна.

Гэвч энэ нь мөн л litigation үе шатны гомдол шийдвэрлэлт бөгөөд шүүх хуралдаан хийж мэтгэлцэх зарчим үйлчилж, шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болж, төлбөр төлөгч нэхэмжлэгч болсон хэвээр.

Иймээс иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудаас гаргах гомдолд шийдвэр гүйцэтгэгч хариуцагч болох, төлбөр төлөгч нэхэмжлэгч болж, зохигчийн эрх, үүрэг эдлэх нь зарчмын хувьд зохисгүй байгааг засч, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай гомдол гаргах, шуурхай гомдлыг аман хуралдаан хийхгүйгээр бичгээр шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шуурхай шийдвэрлэх, мөн энэхүү гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх нь ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй байхаар, хэрэв төлбөр төлөгч үндэслэлтэйгээр ажиллагааг энэ гомдлыг гаргасан шалтгаанаар түдгэлзүүлэхийг хүсвэл баталгаа төлснөөр түдгэлзүүлэх хүсэлт гаргаж болохоор тусгалаа.

### Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох

Энэ бүлэгт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх хуудсын үндсэн дээр үүсгэх, гүйцэтгэх баримт бичигт тусгах асуудлыг нарийвчлан тусгасан. Үүнд, хугацаа хэтрүүлсний хүү, тэжээн тэтгэх үүрэг бол хугацаандаа биелүүлээгүй хоног тугамд алданиг тооцохыг шийдвэр гүйцэтгэгчид шүүхээс даалгахаар тусгалаа.

### Шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлэх

Шүүхийн шийдвэрт заасан барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах бол битүүмжлэх ажиллагаа хийлгүй шуурхай албадан дуудлага худалдаанд оруулах үүднээс гүйцэтгэх хуудас шаардлагагүйгээр ажиллагааг төлбөр авагчийн хүсэлтээр эхлүүлэхээр тусгасан.

Бусад улсын туршлагыг харвал, БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 264 дүгээр зүйлд заанаар ипотекийн зүйлийг албадан дуудлага худалдаанд оруулах хүсэлтийг шүүхэд гаргахдаа тухайн ҮХЭХ-д барьцааны эрхтэй талаарх эрхийг гэрчилсэн баримтыг мөдүүлнэ. Дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэрийг ҮХЭХ-ийн өмчлөгчид гаргаж барьцаатай ҮХЭХ-ийн хувьд битүүмжлэх

эрхлэн хамгаалагчийг, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх баримт бичгийн үндэслэл болох шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шүүх хүлээн авч, хэрэг үүсгэсэн тохиолдолд түүнийг хянан шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол гэх мэт үндэслэлээр болон хуулийн төсөлд ажиллагаа тус бүрд шаардлагатай тохиолдолд шуурхай гомдол гаргаж болохоор ойлгомжтой, тодорхой тусгалаа.

#### **Мөнгөн шаардлагыг хангуулах ажиллагааны албадлагын арга хэмжээ**

Энэ бүлэгт шийдвэр гүйцэтгэгчээс авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ боловсронгуй болгож тусгалаа. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэлийн шүүгчээс шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой талуудаас гаргасан шуурхай гомдлыг шийдвэрлэх, үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулах шийдвэр гаргах, ажиллагаанд саад учруулсан буюу тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй төлбөр төлөгчийг торгох, албадан ирүүлэх, хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, худал, эсхүл дутуу мэдүүлсэн бол саатуулах зэрэг шийдвэр гаргах талаар, мөн шийдвэр гүйцэтгэгчийн явуулах албадлагын арга хэмжээг нарийвчлан тусгалаа.

#### **Төлбөртэй этгээдийн бүртгэл**

Төлбөртэй этгээдийн бүртгэл нь хаалттай мэдээлэл байна. Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтөлнө.<sup>14</sup>

Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, тодорхойлолт, лавлагаа гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.<sup>15</sup> Тус журмыг ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаалаар баталсан бөгөөд тус журамд зааснаар иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргалч иргэн, хуулийн этгээдэд олгож болохоор заасан. Ийнхүү тодорхойлолт, лавлагаа авахад төлбөртэй байхаар заажээ. Төлбөртэй бол лавлагаа, төлбөргүй бол тодорхойлолт гаргана. Гэхдээ энэхүү сангаас иргэн, хуулийн этгээдэд бусад этгээдийн талаарх мэдээлэл өгөхийг хориглосон.<sup>16</sup>

#### **Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэсний үр дагавар**

Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн ч хязгаарлалт, төлбөрийг төлүүлэхэд хүргэх хөшүүрэг үр дагаваргүй.

#### **Бусад улсын туршлага**

#### **Төлөгчийн хөрөнгийн мэдүүлэг**

БНСУ-ын хувьд, төлбөр авагчийн хүсэлтээр шүүх төлбөртэй этгээдийг өөрийн эд хөрөнгийн байдлыг тодорхойлсон эд хөрөнгийн жагсаалт ирүүлэхийг шаардана. Өр төлбөртэй этгээдийн хөрөнгийг хялбар илрүүлэх боломжтой бол шүүх хүсэлтээр

<sup>14</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.1 дэх хэсэг.

<sup>15</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.2 дахь хэсэг.

<sup>16</sup> ХЗДХС-ын 2017 оны А/219 дүгээр тушаал

татгалзана. Ингэхдээ төлбөртэй этгээдийн тайлбарыг авахгүй. Хөрөнгийн жагсаалт гаргах шийдвэрийг биелүүлэхгүй бол 20 хүртэл хоногоор баривчлах шийтгэл оногдуулна. Хуулийн этгээд бол төлөөлөгч, удирдлага нь баривчлагдана.<sup>17</sup> Харин худал мэдүүлсэн бол 5 сая хүртэл вонноор торгох, эсхүл 3 жил хүртэлх хугацаагаар хорих ялтай.

Түүнчлэн төлбөртэй этгээд албадан ажиллагаа хийгдэх эд хөрөнгө болон дараах асуудлыг тусгасан хөрөнгийн жагсаалтыг гаргана.

- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн төлбөртэйгөөр бусдад шилжүүлсэн үл хөдлөх эд хөрөнгө
- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн үл хөдлөх эд хөрөнгөөс бусад төлбөртэйгөөр өөрийн эхнэр, нөхөр, цусан төрлийн хамаатан садан, өөр эцэг, эхийн ах, эгч, дүүдээ шилжүүлсэн хөрөнгө
- Хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө хоёр жилийн хугацаанд төлбөртэй этгээдийн бусдад шилжүүлсэн хандив, тусламж
- Дээд шүүх хөрөнгийн жагсаалтад тусгах зүйл, хамрах хүрээг журмаар тогтооно.<sup>18</sup>

6 сарын хугацаанд төлөөгүй бол төлбөртэй этгээдийн жагсаалтад оруулахаар шийднэ. Засаг захиргаа, банк БСБС буюу зээлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад мэдэгдэнэ.<sup>19</sup>

ХБНГУ-ын хувьд төлбөр төлөгч нь өөрийн санхүүгийн нөхцөл байдал, өмчилж байгаа хөрөнгийн талаарх мэдээллээр хангах үүрэгтэй.

Дараах мэдээллийг оруулна:

- Төлбөр төлөгчийн энэ хуулийн 802е-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс хоёр жилээс доошгүй хугацааны өмнө ойр дотны хүндээ төлбөртэй шилжүүлсэн эд хөрөнгө (Дампуурлын тухай хуулийн 138-р зүйл);
- Төлбөр төлөгч энэ хуулийн 802е-р зүйлийн 1-д заасан хугацаанаас буюу эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс дөрвөн жилээс доошгүй хугацааны өмнө бусдад шилжүүлсэн бөгөөд ёс заншлын дагуу бэлэглэсэн, ялимгүй өртөг бүхий зүйлсээс бусад эд хөрөнгө.

Түүнчлэн ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 882f-д зааснаар төлбөр төлөгчтэй дараа дараад гэрээ байгуулах гэсэн ямар ч этгээд эдийн засгийн сөрөг үр дагавар гарахаас сэргийлж, гэрээ байгуулах эсэхээ шийдэхийн тулд энэхүү төлбөртэй этгээдийн бүртгэлээс мэдээлэл авч болдог байна.<sup>20</sup>

<sup>17</sup> [https://elaw.kfir.re.krfeng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kfir.re.krfeng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>18</sup> [https://elaw.kfir.re.krfeng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kfir.re.krfeng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>19</sup> [https://elaw.kfir.re.krfeng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kfir.re.krfeng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>20</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

Гүрж улсын хувьд, Иргэний шийдвэр гүйцэтгэх хуулийн 19<sup>1</sup>-д зааснаар төлбөртэй этгээдийн бүртгэлийг мөнгөн хөрөнгө гаргуулах шийдвэр гүйцэтгэлийг эхэлмэгц заавал хийнэ.<sup>21</sup>

#### Хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй, худал өгсөн бол үүсэх үр дагавар

ХБНГУ-ын Иргэний процессын хуульд зааснаар эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах үед төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шапгаангүйгээр тогтоосон хугацааг хожимдуулсан, эсхүл мэдүүлэг өгөх үүргээ зөрчсөн бол эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахад төлбөр төлөгчдийн бүртгэлд бүртгэгдэх үр дагавартай байна.<sup>22</sup>

Түүнчлэн хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй бол төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс баривчлах тушаал гаргана. Баривчлах тушаалд төлбөр авагч ба төлбөр төлөгчийг түүнчлэн баривчлах үндэслэлийг заана. Баривчлах тушаалыг биелүүлэхээс өмнө зайлшгүй хүргүүлэх шаардлагагүй.<sup>23</sup>

Хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, эсхүл буруу өгсөн, эсхүл төлбөр төлөх хөрөнгөгүй, хүрэлцэхгүй бол төлбөртэй этгээдийн бүртгэлд оруулдаг. Тус бүртгэлд орсноор банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, бусад бизнес хамтрах боломж хязгаарлагдахын зэрэгцээ тухайн төлбөр төлөгчийн үндсэн үйл ажиллагааг хязгаарладаг. Тухайлбал, төлбөр төлөгч хуульч бол хуульчаар ажиллах зөвшөөрлийг түдгэлзүүлдэг. Мөн төлбөртэй этгээдийн бүртгэл нь нийтэд нээлттэй байдаг тул төлбөр төлөгчид даруй төлбөрөө төлж, бүртгэлээс гарах гэж хичээх хөшүүрэг нь болдог.<sup>24</sup>

Гүрж улсын хувьд, төлбөртэй этгээдийн бүртгэл нь банк, ББСБ, төрийн байгууллагуудад нээлттэй бөгөөд сонирхогч этгээдэд төлбөртэйгээр нээлттэй байна.<sup>25</sup>

Гүрж улсын хувьд, мөн энэхүү бүртгэлд бүртгэгдсэнээр аливаа бүртгэлтэй ҮХЭХ, хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах эрхэд нь хязгаарлалт тогтоох үр дагавартай байдаг.<sup>26</sup>

Иймд хуулийн төсөлд дараах асуудлыг тусгалаа.

- Ажиллагаа эхлэмэгц хөрөнгийн мэдүүлэг заавал албадан авах зохицуулалт. бусад улсад байгаа нь төлбөр төлөгчийг хариуцлагажуулах, төлбөр төлөгчийн араас эрэн сурвалжилж, хугацаа алдахаас сэргийлж байх тул төлбөртэй этгээдийн бүртгэлд ажиллагаа эхлэмэгц оруулж, төлбөр төлөгдөхөд уг бүртгэлээс хасахаар.
- Төлбөртэй этгээдийн бүртгэлд тодорхой хэмжээнд нээлттэй мэдээлэл байх практик бусад улсад байгаа ч манай улсад төлбөртэй этгээд зөвхөн өөрөө л лавлагаа авдаг хаалттай мэдээлэл тул хэрэв тухайн төлбөр төлөгчтэй гэрээ байгуулах эсэхээ шийдэх гуравдагч этгээд нууцын баталгаа гаргавал уг бүртгэлээс төлбөртэй эсэх талаар мэдээлэл гаргах боломжтой байдлаар.

<sup>21</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

<sup>22</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>23</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>24</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын

Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>25</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

<sup>26</sup> <https://matsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

- Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэсний үр дагавар төлбөр төлөгчид байхгүй ч бусад улсад захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох, зарим төрийн үйлчилгээ авах эрхэд хязгаарлалт тогтоох зэрэг үр дагавартай байгаа нь төлбөр төлөгч төлбөрөө төлөх хөшүүрэг болсон байгааг мөн тусгасан.

#### Хөрөнгийн мэдүүлэг

ШШГТХ-ийн 44.2.3-т зааснаар төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх нь шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний нэг төрөл юм.

Гэхдээ иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан арга хэмжээ, түүний гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн арга хэмжээг гүйцэтгэсэн өдрөөс хойш, энэ тухай мэдээгүй бол олж мэдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгчид гомдол гаргаж болох<sup>27</sup> буюу төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэхэд хүртэл гомдол гаргаж болохоор байна. Уг гомдлыг цаашлаад шүүхэд ч гаргаж болно.<sup>28</sup>

Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр төлөгчөөс түүний хөрөнгийн тухай бичгээр мэдүүлэг авах бөгөөд мэдүүлэг гаргахын өмнө мэдүүлгийг худал гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.<sup>29</sup>

Төлбөр төлөгч хөрөнгийн тухай мэдүүлэг авах талаар мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.<sup>30</sup> Төлбөр төлөгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгийн байдалд орсон өөрчлөлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, өөрчлөлтийг хөрөнгийн мэдүүлэгт тусгана.<sup>31</sup>

#### Төлөгч хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс зайлсхийсний үр дагавар

Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдлалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд түүний хөрөнгийг эрэн сурвалжилна.<sup>32</sup> Ингэхдээ төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч бүрэн эрхийнхээ хүрээнд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхдээ ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авдаг.<sup>33</sup>

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах заавар, аргачлалыг ХЗДХС-ын 2017 оны А/218 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан байх бөгөөд ажиллагааг эхлүүлэхдээ даалгасан шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хувийн хэрэг нээх, хамаарал бүхий этгээдийн оршин суугаа хаяг, тэдгээртэй харилцаа үүсгэж байгаа эсэхийг шалгах, цагдаагийн байгууллагаас туслалцаа авах, төлбөртэй

<sup>27</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44.3 дахь хэсэг.

<sup>28</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44.4 дэх хэсэг.

<sup>29</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.1 дэх хэсэг.

<sup>30</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.3 дахь хэсэг.

<sup>31</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.4 дэх хэсэг.

<sup>32</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 46.5 дахь хэсэг.

<sup>33</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 57.4 дэх хэсэг.

мэдээлэл авах, олон нийтийн хэрэгслээр зарлана. Мөн эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олсон бол албадан ирүүлж, батлан даалт 2-оос дээш хүнээс гаргуулж авна.<sup>34</sup>

Өөрөөр хэлбэл, хөрөнгийн мэдүүлэг гаргах нь заавал албадлагын биш зохицуулсан буюу мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлсэн, хөрөнгөө нуун далдалсан гэх үндэслэлтэй бол шийдвэр гүйцэтгэгч эрэн сурвалжилж төлбөр төлөгчийн араас хөөцөлдөх зохицуулалт болжээ.

Эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгчийн талаарх гүйцэтгэлийг харуулбал:

Он	Оны үлдэгдэл	Шинээр нэмсэн	Олж тогтоосон	Үлдэгдэл
2017	400	471	490	381
2018	381	739	614	506
2019	506	761	719	548
2020	548	1348	1102	794
2021	794	614	804	604
2022	604	1495	1181	918
2023	918	2498	2427	989
2024	989	1332	1372	349
2025	949	150	226	873

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025 оны 3 дугаар сар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дүр мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>35</sup>

Эрүүгийн хууль дагаж мөрдсөн 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хойш буюу 7 жил орчмын хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх гэмт хэрэгт 11 тохиолдолд шүүх хуралдаан хийж, гэм бурууг шийдвэрлэсэн байна.<sup>36</sup> Үүнээс нийслэл 7, орон нутагт 4 шүүхийн шийдвэр хамаарч байна. Үүнээс 2 хэрэгт 6 сарын хугацаагаар хорих шийдвэр гаргасан байна. Гэхдээ эдгээр тохиолдлуудад хөрөнгийн мэдүүлгээ буруу гаргасан, зайлсхийсэн гэх үйлдлийг шийтгэсэн тохиолдол байхгүй буюу хөрөнгийн мэдүүлэг гаргахгүй байсан ч хариуцлагын механизм ажилдаггүй болно.

2025 оны байдлаар гэхэд хөрөнгийн мэдүүлгийг авч чадаагүй эрэн сурвалжилж байгаа 873 тохиолдол байна.

Мөн эд хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй байхад төлбөр төлөгчийн бүртгэлд бүртгэдэг байх хөшүүрэг байхгүй.

Иймд хуулийн төсөлд битүүмжилсэн, хураасан хөрөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахаас бусад тохиолдолд заавал, албадан хөрөнгийн мэдүүлэг авахаар тусгалаа. Түүнчлэн хөрөнгийн мэдүүлэг өгөхгүй, эсхүл дугуу, худал

<sup>34</sup> ХЗДХС-ын 2017 оны А/218 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

<sup>35</sup> Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл

<sup>36</sup> <https://shuukh.mmi/cases/211>

мэдүүлбэл саатуулахаар тусгалаа.


Мөн хөрөнгийн мэдүүлэгт эд хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөр төлөгчийн төлбөртэйгөөр бусдад шилжүүлсэн эд хөрөнгө, эд хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө нэг жилийн хугацаанд төлбөр төлөгчийн өөрийн эхнэр, нөхөр, хүүхэд, садан, төрөлдөө шилжүүлсэн эд хөрөнгө, эд хөрөнгийн жагсаалт ирүүлэх шийдвэр гарахаас өмнө хоёр жилийн хугацаанд төлбөр төлөгчийн бусдад шилжүүлсэн хандив, тусламж, төлбөр төлөгчийн өөрийн болон дундын өмчийн бүх үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, банк, эрх бүхий байгууллага дахь дансны мэдээллийг гаргуулахаар тусгасан нь шүүхийн шийдвэр гүйцэтгэхээс зайлсхийсэн үйлдлийг тогтоох, энэ талаар төлбөр авагч шүүхэд нэхэмжлэл гарган тухайн хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл буюу хүчин төгөлдөр бусад тооцуулах боломжийг бий болголоо.

### Хөрөнгө үнэлэлт

#### Үнэлгээний гомдол гаргах нь түдгэлзүүлж, удаашруулах арга хэрэгсэл

2023 онд 229 үнэлгээний гомдлыг шүүхэд гаргаснаас 3 гомдлын хувьд үнэлгээг хүчингүйд тооцсон, 2024 онд гомдлоос 4 үнэлгээг хүчингүйд тооцсоноос үзэхэд, үнэлгээний гомдол нийт гомдлын 60.2 хувь нь, мөн ихэнх тохиолдолд үндэслэлгүй гомдол байх бөгөөд нөгөө талаас үнэлгээний гомдол шийдвэрлэгдэхгүй талууд ажиллагааг удаашруулах зорилгоор гаргадаг арга хэрэгсэл болсныг илтгэж байна.

#### Үнэлгээний гомдлын нийт гомдолд эзлэх хувь дунджаар 60 хувь



Шүүхээс үнэлгээтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал

Үнэлгээний талаар шүүхэд гаргасан гомдол 2023 онд 362 буюу нийт 546 гомдлын 66.3 хувь нь үнэлгээний гомдол байсан бол 2024 онд үнэлгээний гомдол 377 буюу нийт 486 гомдлын 77.5 хувь нь үнэлгээний гомдол байсан байна.<sup>37</sup> Харин 2023 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 31.5 хувь буюу 172 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн бол 2024 онд нийт гаргасан үнэлгээний гомдлын 35.8 хувь буюу 174 гомдлыг 1-ээс дээш жилийн хугацаанд шийдвэрлэсэн байна.<sup>38</sup>

<sup>37</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

<sup>38</sup> ШШГЕГ-ын мэдээллээс 2025.

2023 оны байдлаар 267 тэрбумын 330 төлбөр төлөгчид хамаарах ажиллагаа үнэлгээний гомдол шүүхэд гаргаснаас улбаалан түдгэлзсэн байна.<sup>39</sup>

#### Үнэлгээний гомдлыг шүүхээс шийдвэрлэсэн хугацаа

Үнэлгээний үнэлгээ тогтоосон үнэлгээний тайланг хүчингүй болгуулахаар шүүхэд хандах нь дараах эрсдэлийг авчирч байна.<sup>40</sup> Үүнд:

- ойролцоогоор 2-4 жил ажиллагаа зогсох;
- төлбөр авагч төлбөрөө барьцаа хөрөнгөөс хүртэл гаргуулах боломжгүй удах.

Үнэлгээ зах зээлийн ханшаас доогуур, эсхүл үнэлгээний үнэд их хэмжээний өөрчлөлт орсон гэх үндэслэлээр шүүхэд гомдол гаргах ШШГТХ-ийн 55.7-ийн хүрээнд гаргасан төлбөр төлөгчийн гомдол нийт шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд гаргасан гомдлын ихэнх буюу 60 орчим хувийг эзэлж байна.

Гэтэл 2023 онд гаргасан үнэлгээний 362, 2024 онд гаргасан 377 гомдлыг шүүх шийдвэрлэхдээ үнэлгээг хүчингүйд тооцсон нь 2023 онд 3, 2024 онд 4 бөгөөд ихэнх тохиолдолд үнэлгээг үндэслэлгүй тогтоосон гэх нотлох баримт үгүй байна гэж хэргийг хэргэсэхгүй болгож байна.

Учир нь үнэлгээний гомдлыг гаргаснаар шүүх ШШГТХ-ийн 27.1.4-т зааснаар ажиллагааг түдгэлзүүлдэг тул түдгэлзүүлж, удаашруулах зорилгоор уг гомдлыг гаргадаг практик тогтсон байна.

#### Бусад улсын туршлага

Одоо мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд үнэлгээг дахин хийлгэх зохицуулалт байхгүй байна.

Бусад улсад хэрхэн зохицуулсныг харвал, Казакстаны хувьд үнэлгээг буруу хийсэн бол үнэлгээний дахин үнэлгээний төлбөрийг нөхөн төлнө.<sup>41</sup> Дахин үнэлгээний төлбөрийг дахин үнэлгээ хийлгэхээр хандсан тал төлөх буюу дахин үнэлгээ хийлгээг шийддэг бол ХБНГУ-д мөн адил үнэлгээг дахин хийлгэх боломжтой бөгөөд шүүхэд энэ талаарх гомдлыг гаргадаггүй.

Үнэлгээний гомдлыг шүүхэд гаргах зохицуулалт практикт төлбөр авагчийн эрх удаан хугацаанд сэргэхгүй байх сөрөг үр дагавар бий болгосон байна.

Иймд үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргах бус, үнэлгээний тайлантай санал нийлэхгүй бол дахин, эсхүл нэмэлт үнэлгээ хийлгэх байдлаар тусгалаа.

#### Үл хөдлөх эд хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

<sup>39</sup> Т.Наранцогт, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түдгэлзүүлэх үндэслэл, хугацааны зарим асуудал, ШШГТГ-ын Шүүхийн шийдвэрийн биеллэлд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам хэлэлцүүлэг, 2023.

<sup>40</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ 2023-аас.

<sup>41</sup> [https://radiet.zan.kz/tengrdocs/Z100000261\\_#?text=Article%20.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings.2021](https://radiet.zan.kz/tengrdocs/Z100000261_#?text=Article%20.&text=The%20tasks%20of%20enforcement%20proceedings.2021).

Энэ бүлэгт үл хөдлөх эд хөрөнгөд явуулах ажиллагааг шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг гаргуулах, мөн төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгөөс ажиллагаа явуулах 2 ажиллагааг ялгамтгай байдлаар тусгалаа.

#### ҮХЭХ албадан дуудлага худалдааны хүртээмж

2022 онд 982.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа явуулах 863 гүйцэтгэх баримт бичиг байснаас анхны албадан дуудлага худалдаагаар 412.7 тэрбум төгрөгийн 612 хөрөнгийг худалдан борлуулахаар нийтэд мэдээлэхэд, 247.1 тэрбум төгрөгийн 165 хөрөнгийн дуудлага худалдаа түдгэлзэж, 12.1 тэрбум төгрөгийн 31 хөрөнгийн худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшуулж, 8.9 тэрбум төгрөгийн 71 түдгэлзүүлж, хөрөнгийн дуудлага худалдаанд 71 оролцогч бүртгүүлэн 7.4 тэрбум төгрөгийн 59 үл хөдлөх эд хөрөнгө зарагдсан буюу нийт нийтэд зарласан албадан дуудлага худалдааны үл хөдлөх эд хөрөнгийн 1.8 хувь нь анхны албадан дуудлага худалдаагаар худалдан борлогдсон байна.<sup>42</sup>

Харин хоёр дахь албадан дуудлага худалдаагаар 124.1 тэрбум төгрөгийн 369 хөрөнгийг худалдан борлуулахаар нийтэд мэдээлж, 47.2 тэрбум төгрөгийн 48 хөрөнгийн албадан дуудлага худалдаа түдгэлзэж, 16.4 тэрбум төгрөгийн 41 хөрөнгийн албадан дуудлага худалдааг төлбөр авагчийн хүсэлтээр хойшуулж, 14.8 тэрбум төгрөгийн 122 хөрөнгийн албадан дуудлага худалдаанд 122 оролцогч бүртгүүлэн 23.0 тэрбум төгрөгийн 119 хөрөнгө буюу нийт нийтэд зарласан хоёр дахь албадан дуудлага худалдааны үл хөдлөх эд хөрөнгийн 18.5 хувь нь худалдан борлогджээ.<sup>43</sup>

2022 онд зохион байгуулсан 980 үл хөдлөх эд хөрөнгийн анхны болон хоёр дахь дуудлага худалдааны 19.6 хувьд дэнчин тавьж, 193 оролцогч бүртгүүлсэн байна. Хөрөнгийн албадан дуудлага худалдаанд багадаа 2, ихдээ 28 оролцогч бүртгүүлж, оролцсон байх бөгөөд нэг хөрөнгийн дуудлага худалдаанд дунджаар 3-4 оролцогч бүртгүүлжээ.<sup>44</sup>

Тухайлбал, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын фэйсбүүк хуудсаар зарлалыг хүргэдэг ба 2025 оны 2 сарын 6-нд оруулсан зар нэг лайктай<sup>45</sup> буюу нийтэд хүрэх байдал тааруу байна.

#### Ялагчид өмчлөх эрх шилжих зохицуулалт

ШШГТХ-ийн 71.14-т зааснаар "Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно." Үүний дагуу төлбөр төлөгч шүүхэд үндэслэлгүй гомдол гаргаж, ялагчид өмчлөх эрх шилжихийг удаашруулдаг.

2023 онд 1 их наяд 370 тэрбум төгрөгийн 738 үл хөдлөх эд хөрөнгийг нийтэд зарласнаас анхны дуудлага худалдаанд 64 оролцогч, хоёр дахь дуудлага худалдаанд 178 оролцогч бүртгүүлж, анхны дуудлага худалдаагаар 45, хоёр дахь дуудлага худалдаагаар 167 буюу нийт 74 орчим тэрбумын 212 үл хөдлөх эд хөрөнгө борлуулагдсан байна. Энэ нь нийт дуудлага худалдаанд орсон үл хөдлөх эд хөрөнгийн 28 орчим хувийг эзэлж байна.<sup>46</sup> Үүний бас нэг шалтгаан нь ялагчид өмчлөх эрх шилжих

<sup>42</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

<sup>43</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

<sup>44</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

<sup>45</sup> Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим хуудас 2025.03.08

<sup>46</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2023.

баталгаа байхгүй тул ҮХЭХ албадан дуудлага худалдаанд итгэх сонирхогчийн итгэл буурсан гэж хэлж болно.

#### Шигтгээ 1

Ялагч төлбөрийг төлсөн ч төлбөр төлөгчийн гомдлоор ажиллагааг дуусгавар болгосон тохиолдол

2021 оны 10 дугаар сард албадан дуудлага худалдаагаар ҮХЭХ-ийг худалдан борлуулж, ялагч тодорч, төлбөрийг шилжүүлсэн байхад 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлбөр төлөгч төлбөрийг бүрэн төлж, улмаар ялагч үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн авах боломжгүй болсон. Төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох тухай гомдлыг 2022 оны 06 сард иргэний хэргийн анхан шатны шүүхэд гарган мөн оны 11 сард шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангасан буюу "албадан дуудлага худалдаа хууль ёсны болсон ч гэсэн албадан дуудлага худалдаа болоод ялагч тодорч ялагч төлбөрийг бүрэн шилжүүлсэнээс хойш 2 сар орчимын дараа төлбөр төлөгч төлбөрөө төлсөн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь зүйтэй, ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгөө өмчлөх эрхгүй" гэж шүүх шийдвэрлэжээ.

#### Шигтгээ 2

2016 оны 4 сард шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн. 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр иргэн З дуудлага худалдааны ялагчаар тодорсон. Төлбөр төлөгч үнэлгээг хүчингүй болгоулахаар 2017 оны 12 дугаар сард иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2019.09 сард УДШ хяналтын гомдлыг хуралдаанаар хэлэлцэхээс татгалзсан. Үндэслэл нь хууль заасан үнэлгээний талаарх гомдол гаргах 7 хоногийг хэтрүүлсэн гэх боловч зөвхөн энэхүү шийдвэрийг гаргахын тулд 2 жил болж, ажиллагааг ийнхүү хугацаагаар түдгэлзэхэд хүрээжээ. 2022.05.24-нд төлөгч ШШГТХ-ийн 55.5-ын дагуу үнэлгээ хийгдсэнээс хойш 4 жил 5 сар өнгөрсөн тул ҮХЭХ-ийг дахин үнэлгээ тогтоологхоныг шийдвэр гүйцэтгэгчид даалгах, анхны албадан дуудлага худалдааг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаж, 7 жил төлбөр авагч барьцаа хөрөнгөөс төлбөр гарсуулж чадахгүй, түдгэлзсэн, ялагч 2017 оны 11 сараас хойш өмчлөлийн хөрөнгөө авч чадахгүй 6 жил болж байна.

ШШГТХ-ийн 71.14-т "Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гараагүй тохиолдолд худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно." гэсэн зохицуулалт нь Иргэний хуулийн 178 дугаар зүйлийн 178.2-т "Дуудлага худалдаагаар худалдсан зүйлийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагч тухайн зүйлийн өмчлөгч болно." гэж заасантай зөрчилдөж байх бөгөөд хэрэв өмчлөх эрх шилжүүлсэн шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд дуудлага худалдаагаар өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн өмчлөх эрхийг хязгаарлаж байна.

#### Битүүмжлэх, хураах 2 тусдаа ажиллагаа

ШШГТХ-ийн 49.1-д зааснаар "Хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах гэж тухайн хөрөнгийг захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагааг ойлгоно." Үүний дараа төлбөр төлөгч гомдол шүүхэд гарган удаашруулна.

#### Шигтгээ 1

Ажиллагааг 2017 оны 4 сарын 17-нд эхлүүлж 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр битүүмжлээд битүүмжилсэн тогтоолд өмчлөгч гомдол гарган 2022 оны 6 сард эцэслэн шийдвэрлэжээ. Ийнхүү 5 жил болоход 2023 онд хураах тогтоол гаргаж, ҮХЭХ-ийг хураасан байдлаартай байгаа буюу төлбөр авагчийн эрх ашиг ноцтой зөрчигдөж, үндэслэлгүй гомдол өмлөгч гарган ажиллагаа удааширчээ.

Эх сурвалж: 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр Дугаар 102ШШ202200313

ШШГТХ-ийн 54.1-д зааснаар "Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн хөрөнгийг худалдан борлуулах, эсхүл гүйцэтгэх баримт бичигт заасан тохиолдолд төлбөр авагчид шилжүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авна." Үүний дараа мөн хураах тогтоолд гомдол гаргаж, худалдан борлуулах ажиллагааг удаашруулдаг.

ҮХЭХ-ийг битүүмжлэх, дараа нь хураах тогтоол гаргах зохицуулалтаас шалтгаалан энэ хэмжээгээр удаашралыг бий болгожээ.

#### Барьцааны ҮХЭХ-ийг албадан борлуулах зохицуулалт

Монгол Улсын хувьд барьцаатай буюу ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах, эсхүл барьцаагүй ч төлбөр төлөгчийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах албадлагын ажиллагаа нь ижил байна. Өөрөөр хэлбэл, аль ч тохиолдолд битүүмжлээд, хураасны үндсэн дээр үнэлгээ тогтоолгон, үүний дараа албадан дуудлага худалдаанд оруулж байна.

Барьцааны ҮХЭХ-д шуурхай ялгаатай зохицуулалт үгүйгээс дараах сөрөг үр дагавар гарч байна.

#### Шигтгээ 1

Төлбөр авагч Х банкнд төлбөр төлөгч М ХХК, И ХК 1.8 их наяд төгрөгийн үргийн гүйцэтгэлд барьцаа хөрөнгийг албадан худалдах гүйцэтгэх хуудастай хэрэгт 2019 оны 09 сард ажиллагаа үүсгэж, барьцаа хөрөнгийг 2 удаа үнэлүүлсэн. Үнэлгээ бүрд төлбөр төлөгч тус бүр шүүхэд гомдол гарган 2023 оны 3 сарын байдлаар нийт 4 жил ажиллагааг түдгэлзүүлсэн байдалтай байна.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн үнэлгээний гомдол төлбөр төлөгч гаргаж 4 жил ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдол

#### ҮХЭХ-ийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх

Үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх зохицуулалтын тухайд практикт хэрэглэсэн тохиолдол байхгүй байна.

Тодруулбал, ШШГТХ-ийн 60.1-д "Төлбөр төлөгчийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлж дуусах хүртэл хугацаагаар

төлбөр төлөгчийн хүсэлтэд заасан үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлж болно.” гэж тул төлбөр төлөгч үл хөдлөх хөрөнгөө төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх хүсэлт илгээх нь өөрөө практикт энэ зохицуулалт хэрэглэгдэхгүй байх шалтгаан болсон байна.

#### Бусад улсын туршлага

##### Битүүмжлэх

Seize гэх нэр томъёог хураах, битүүмжлэх гэсэн утгаар тайлбарласан байна.<sup>47</sup> Судалгаанд хамрагдсан улсуудын хуульд битүүмжлэх, хураах 2 үйлдэл хийхгүй байна.

ХБНГУ-ын хувьд, дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэр гаргахдаа үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх буюу битүүмжлэх, дуудлага худалдаа явуулах шийдвэрийг цуг нь гаргаж байна.<sup>48</sup>

##### Цахим дуудлага худалдаа

Мөн дуудлага худалдааг цахимаар явуулах зохицуулалт хуульд байхгүй. Харин БНСУ, ХБНГУ, Казахстан улсын хувьд цахим дуудлага худалдааг хуульчилсан байна.

##### Барьцааны ҮХЭХ-д явуулах албадан ажиллагаа

Бусад улсын туршлагыг харвал, БНСУ-ын Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 264 дүгээр зүйлд заанаар ипотекийн зүйлийг албадан дуудлага худалдаанд оруулах хүсэлтийг шүүхэд гаргахдаа тухайн ҮХЭХ-д барьцааны эрхтэй талаарх эрхийг гэрчилсэн баримтыг мэдүүлнэ. Дуудлага худалдааг эхлүүлэх шийдвэрийг ҮХЭХ-ийн өмчлөгчид гаргаж барьцаатай ҮХЭХ-ийн хувьд битүүмжлэх асуудал байхгүйгээр шууд барьцаа болон шүүхийн энэ талаарх гүйцэтгэх хуудсыг үндэслэн үнэлгээ тогтоож, дуудлага худалдааг эхлүүлж байна.<sup>49</sup>

Түүнчлэн ХБНГУ-ын иргэний процессын хуулийн 867 дугаар зүйлийн 3-т “Баталгаат ипотекийг албадан дуудлага худалдаагаар дамжуулан шаардлагыг хангахад бүртгэлд бүртгүүлсэн тухай тэмдэглэл бүхий шийдвэр гүйцэтгэлийн баримт бичиг хангалттай.” гэж заасан. Мөн адил барьцаатай бол барьцааг шүүхийн шийдвэрийн үндсэн дээр шууд худалдан борлуулах боломжийг олгосон буюу барьцаагүй тохиолдолд ҮХЭХ-ийг битүүмжилж, албадан дуудлага худалдаа явуулдаг аргаар шүүрхай ажиллагаа явуулдаг байна.<sup>50</sup>

Гүрж улсын хувьд, Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2н-д зааснаар барьцаалсан талаарх гэрчилгээ нь шууд шийдвэр гүйцэтгэх үндэслэл болж байна.<sup>51</sup>

Энэ нь барьцаалагчийн эрхийг шуурхай хангах, гэрээндээ үл маргах журмаар барьцааг үүргийн гүйцэтгэлд гаргуулахаар тохиролцсон талуудын гэрээнд итгэх итгэлийг хангах зарчмыг хангах үр дүнтэй арга хэрэгсэл болж байна.

<sup>47</sup> С.Нарангэрэл – Хууль зүйн Англи-Монгол эх толь 2012 он, 489 дүгээр тал.

<sup>48</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>49</sup> [https://law.kiri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://law.kiri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

<sup>50</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>51</sup> <https://imatsne.gov.ge/en/document/view/18442?publication=99>

#### Ялагчид өмчлөх эрх шилжих

БНСУ-ын хуульд зааснаар ҮХЭХ-ийг худалдсаны төлбөрийг бүрэн төлөхөөс өмнө дуудлага худалдаа эхлүүлэх шийдвэрт шүүхэд эсэргүүцэл гаргаж болно. /Даруй шуурхай шийддэг! Мөн эсэргүүцлийг шийдвэрлэсэн шийдвэрт нэн даруй гомдол гаргаж болно. Төлбөр төлөгдөхөөс өмнө энэ талаарх гомдол гаргах, үүнээс хойш гомдол гаргахгүй бөгөөд төлбөр төлснөөр өмчлөх эрхийн бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлэхээр БНСУ, Герман улсын хуульд,<sup>52</sup> харин Казахстаны хувьд төлбөрийг төлснөөр худалдах худалдан авах гэрээ ялагчтай байгуулах ба уг гэрээ нь өмчлөгчөөр бүртгүүлэх үндэслэл болохоор байна.<sup>53</sup>

#### Төлбөр авагчийн удирдлагад ҮХЭХ-ийг шилжүүлэх

Бусад улсын туршлагаас харахад, БНСУ-ын хувьд, төлбөр авагчийн хүсэлтээр ҮХЭХ-ийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх, эсхүл албадан дуудлага худалдаагаар борлуулах аргын аль нэгийг сонгож, албадан гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлдэг байна.<sup>54</sup>

Иймд дараах асуудлыг хуулийн төсөлд нарийвчлан тусгалаа.

- Дуудлага худалдааны зарыг шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд мэдүүлэх байдал сайнгүй байгаа нь дуудлага худалдааны талаар олж мэдэх хүмүүс бага байхад хүргэж байгааг олон сугаар хүргэх байдлаар.
- Ялагчид өмчлөх эрх төлбөр төлснөөр шилжихгүй, гомдол гаргаж удаашруулдаг тул дуудлага худалдаанд итгэх итгэлийг бууруулж, дуудлага худалдааны хүртээмжид сөргөөр нөлөөлж байгааг зассан.
- Цахим дуудлага худалдааны зохицуулалт, дэд бүтэц байхгүй тул цахим дуудлага худалдааны эрх зүйн боломжийг бий болгосон.
- Битүүмжлэх, дараа нь хураах тогтоол гаргадаг зохицуулалт удаашралыг тэр хэрээр үүсгэж байгааг засаж зөвхөн битүүмжлэх ажиллагаа явагдах талаар.
- Барьцааны зүйл ҮХЭХ-д явуулах ялгаатай, шуурхай зохицуулалт байхгүй байгааг засаж, шүүхийн шийдвэрээр барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг гаргуулах бол битүүмжлэх шаардлагагүй байхаар.
- ҮХЭХ-ийг албадан удирдлагад шилжүүлэхэд төлбөр авагчийн хүсэлтээр бус төлбөр төлөгчийн хүсэлтээр шилжүүлэх зохицуулалттай тул төлбөр төлөгч уг хүсэлтийг гаргахгүй учраас энэ зохицуулалт практикт хэрэгжихгүй байгааг засаж боловсронгуй болголоо.

#### Хөдлөх эд хөрөнгөд явуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

<sup>52</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>53</sup> [https://radiot.zan.kz/eng/idsdocs/Z100000261\\_#~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforceme nt%20proceedings,2021](https://radiot.zan.kz/eng/idsdocs/Z100000261_#~:text=Article%202.&text=The%20tasks%20of%20enforceme nt%20proceedings,2021)

<sup>54</sup> [https://elaw.kiri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8](https://elaw.kiri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=41807&type=part&key=8)

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны биелэлт (2020-2024 он)

ҮЗҮҮЛЭЛТ	Оны эхний үндэс	Шинээр	Төлбөр			
			Биелүүлсэн зөмж	Биелүүлсэн	Хувь	
2020 он	гүйцэтгэх хуудас	19808	13097	2044	11053	15.6
	мөнгөн дүн /млн/	1,605,346,793.7	51,296,952.1	24,274,228.9	27,022,723.2	47.3
2021 он	гүйцэтгэх хуудас	19019	12724	1444	11280	11.3
	мөнгөн дүн /млн/	1,315,863,593.9	70,406,769.3	36,428,354.7	33,976,414.6	51.7
2022 он	гүйцэтгэх хуудас	16528	13416	1170	20325	8.7
	мөнгөн дүн /млн/	1,450,604,118.1	46,363,522.3	18,026,381.8	1,855,107,300.6	38.9
2023 он	гүйцэтгэх хуудас	20325	14182	1038	22121	7.3
	мөнгөн дүн /млн/	1,855,107,380.6	50,566,295.7	20,693,635.3	2,374,780,552.7	40.9
2024 он	гүйцэтгэх хуудас	22121	15435	1327	14108	8.6
	мөнгөн дүн /млн/	2,374,780,552.7	48,596,184.7	18,308,909.4	30,287,275.3	37.7

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарах Эрүүгийн хармуцлага

Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, ургэдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дүр мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Статистик мэдээллээс үзэхэд 2022 онд 48, 2023 онд 90, 2024 онд 61 хэрэг шалгасан боловч, дийлэнх тохиолдолд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд прокуророос хэрэг үүсгэхээс татгалзсан байна.<sup>55</sup>

2024 оны байдлаар хүүхдийн тэтгэлэг гаргуулах 48 гаруй төрөгийн 15435 гүйцэтгэх хуудаснаас 18 гаруй тэрбум төгрөгийн 1327 гүйцэтгэх хуудас биелэгдэж, биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудасны 91.4 хувь биелэгдээгүй байна. Үүнээс хөрөнгө, орлогогүй 733, оршин суух хаяг тодорхойгүй 817, эрэн сурвалжлагдаж байгаа 420, бусад 1825 байх тул эдгээр хүүхэд тэтгэлгээ цаг хугацаанд авч чадахгүйд хүрсэн.

Иймд хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа хөрөнгө, орлогогүй төлбөр төлөгч бол хүүхдийн төлөө сангаас хүүхдийн тэтгэлгийг урьдчилан төлөх, тухайн этгээд ажил хөдөлмөр, аж ахуй эрхлэх зэргээр төлбөрийн чадавтай болсны дараа төлбөрийг

<sup>55</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл.

Энэ бүлэгт хөдлөх эд хөрөнгө, үндэс биет болон биет бус, үнэт цаас, виртуаль хөрөнгө, шаардах эрхэд явуулах ажиллагааг тус бүр боловсронгуй болгож тусгалаа.

Үнэт цаасны албадан дуудлага худалдаанд нэг бол үнэлгээчнээр үнэлүүлэх, нэг бол тухайн өдрийн зах зээлийн ханшаар биржээр нь борлуулуулах зөрчилтэй зохицуулалттай байсныг нээлттэй компани бол биржээр тухайн өдрийн ханшаар борлуулах, хаалттай компанийн хувьцаа бол үнэлгээчнээр үнэлүүлж борлуулуухаар тусгалаа.

Төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогоос төлбөр гаргуулах, гаргуулж үл болох хөрөнгө, орлого

Энэ бүлэгт төлбөр төлөгчийн хөрөнгө, орлогоос гаргуулж болохгүй хөрөнгө, орлогыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоолоо.

Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Тус бүлэгт тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх, орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах тухай шийдвэрийг гүйцэтгэх, төлбөр авагчийг байр, барилга байгууламжид нүүлгэн оруулах тухай шийдвэрийг албадан гүйцэтгэх, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх тэдгээртэй уулзуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх, үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжүүлсэн ажилтныг эгүүлэн тогтоосон тухай шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг тусгалаа.

Тухайлбал, эдгээр үйлдэл хийх, хийхгүй байх талаар шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн шийдвэр гүйцэтгэлийн шүүгч торгох зэрэг хөшүүрэг хэрэглэхээр тусгалаа.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах

Энэ бүлэгт хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа боловсронгуй болгож тусгалаа. Үүнд хүүхэд насанд хүрсэн эсэхээс үл хамааран төлж дуустал төлбөр төлөгч төлөх үүрэгтэй байхаар, мөн тэтгэлгийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол хоног тутам алдани гаргуулахаар тусгалаа.

Түүнчлэн хөрөнгө, орлогогүй тэтгэлэг төлөгчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатан дахь хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлд бүртгэж, хяналт тавих, мөн хөдөлмөр эрхлэхэд зуучлах, цалин орлогоос нь суутгал хийх, үүнтэй зэрэгцэн хүүхдийн тэтгэлэг заавал төлөгдөх нөхцөлийг бүрдүүлж тэтгэлгийг төрөөс урьдчилан төлж, төлбөр төлөгчийг ажилд зуучилж, санд нөхөн хийлгүүлэхээр тусгалаа.

Учир нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны сүүлийн 5 жилийн биелэлтийн дундажлан авч үзэхэд гүйцэтгэх хуудасны тоогоор 10.3 хувь, мөнгөн дүнгээр 43.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь энэ төрлийн гүйцэтгэх ажиллагаа төдийлэн хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа ч ердөө жилд 50 орчим төлөгч зөрчлийн шийтгэл ногдуулж байгаа нь хангалтгүй, хуулийн хармуцлагын зохицуулалт хэрэгжихгүй оновчгүй байгааг илтгэж байна.

нөхөн гаргуулж, уг санд төлдөг механизмыг бүрдүүлсэн. ХБНГУ-д ийм төрлийн тэтгэлгийн сан ажилладаг байна.<sup>56</sup>

**Төлбөр төлөгчийн хөрөнгөөс суутгал хийх, төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хуваарилах, төлбөр авагчийн шаардлагыг хангах**

Энэ бүлэгт суутгал хийх, харилцан шаардлагыг тооцох, төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг төлбөр авагчид хуваарилах дараалал, журмыг тусгалаа.

**Гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэр, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагын монгол улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа**

Дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 639 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 167 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 50 гүйцэтгэх хуудсанд хамаарах 45 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 7.2 хувь буюу 593 тэрбум орчим төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.<sup>57</sup>

Түүнчлэн дотоод, гадаадын арбитрын шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, 2024 оны байдлаар 598 орчим тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140 гүйцэтгэх хуудсанд хамаарах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас 19 гүйцэтгэх хуудсанд хамаарах 120 тэрбум төгрөгийн мөнгөн дүн бүхий шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биелэгдэж, арбитрын шийдвэр гүйцэтгэлийн биелэлтийн хувь мөнгөн дүнгийн хувьд 80 орчим хувь буюу 478 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арбитрын шийдвэр биелэгдээгүй байна.<sup>58</sup>

Энэ бүлэгт гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэр, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллагын монгол улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тусгалаа.

**Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч**

Тус бүлэгт иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч төлөр төлөгч, төлбөр авагчийн эрх, үүрэг, шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч оролцох, мөн гуравдагч этгээдийн гомдол гаргах эрх, энэ нь ажиллагаа түдгэлзэх үндэслэл болохгүй байхаар тусгалаа.

**Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал, урамшуулал, гүйцэтгэсэн шийдвэрийг цуцлах**

Тус бүлэг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр авагч урьдчилан төлөх, төлбөр төлөгчийн хөрөнгөөс дараа гаргуулж төлбөр авагчид олгохоор тусгалаа.

<sup>56</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бавариа мужид хийсэн ажлын айлчлалын үр дүнгээс, 2024 оны 12 дугаар сар.

<sup>57</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл.

<sup>58</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэгч цэргийн цолтой албан хаагч бус, төрөөс төрийн албан хаагчийн цалин хөлсөө авах, төлбөр гаргуулсан орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр урамшуулал авахаар тусгалаа.

Ингэснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгч үр дүнтэй ажиллах, дээд албан тушаалтнаас цэргийн захирах захирагдах ёсноос шалтгаалж хамааралтай байхаас сэргийлэх, ажиллагаа шуурхай байх ач холбогдолтой.

---000---

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээх эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх эдлүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Хоригдлын хохирол төлөлт тааруу байх тул хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүссэн тул Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулсан.

Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл нь 3 хэсэг, 13 бүлэг, 165 зүйлтэй байна. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан доор танилцуулья.

### I хэсэг Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр бүлэгт эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг үндэслэл, хуулийн зорилго, зарчим, үндэслэлийг зааснаас гадна шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрөл, тухайн ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хориглох үйлдэл, эс үйлдэхүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн шаардлагыг биелүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангахад мэдээллийн сүлжээ ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан.

### II хэсэг Хоёрдугаар бүлэг

#### Зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллага

Хоёрдугаар бүлэгт зөрчлийн хэргийн шүүхийн торгох, баривчлах, эрх хасах шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээх, ажиллагаа эхлүүлэх, түдгэлзүүлэх, дуусгавар болгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан.

Тухайлбал, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, дуусгавар болгох харилцаа болон эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг тусгасан.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

Эрх хасах шийтгэл хэрэгжиж эхэлснээс хойш 2024 онд 7200 этгээд, 2025 оны 3 дугаар сарын байдлаар 780, нийт 7980 этгээдэд эрх хасах шийтгэл оногдуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан байна.<sup>2</sup>

### III хэсэг

Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг энэ хэсэгт тусгасан бөгөөд үүнд, хорих ял эдлүүлэх болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журам, бусад гэх зэрэг асуудал хамаарна.

#### Гуравдугаар бүлэг Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам

Гуравдугаар бүлэгт гүйцэтгэх баримт бичиг, гүйцэтгэх баримт бичгийн агуулга, түүнд тавигдах шаардлага, шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэх, түдгэлзүүлэх, мэдэгдэх хуудас, дуусгавар болгох, хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих, ялаас чөлөөлөх болон тус ялыг эдэлж дууссанд тооцох, ял эдлүүлэх ажиллагаанд техник, хэрэгсэл ашиглах, хяналт тавих, гомдол гаргах асуудлыг тусгасан.

Хорих болон хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх харилцааг Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлд "эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ" гэж заасныг үндэслэн түдгэлзүүлж байх тул дээрх харилцааг хуулийн төсөлд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар нарийвчлан зохицуулсан.

#### Торгох, нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам

Дөрөвдүгээр бүлэгт торгох, нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмыг зохицуулсан.

Тухайлбал, ялтан торгох ял оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй ба дээрх хугацаанд ялтан торгуулаа төлөөгүй тохиолдолд төлж барагдуулаагүй шалтгаан нөхцөлийг судалж эрх бүхий албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгах зохицуулалтыг тусгалаа.

Мөн нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх болон зохион байгуулахдаа нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ял шийтгүүлсэн этгээдийг байнга оршин суугаа хаягийн дагуу гүйцэтгэж, тухайн тойргийн эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавихаар зохицуулсан.

<sup>2</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

Харин нийтэд тустай ажил хийлгэх хугацаа нь амралтын өдөр болон үндсэн ажил, хичээлээс чөлөөтэй өдөр 4 цагаас ихгүй, ажлын өдөр ажил болон хичээлээс чөлөөтэй үед 2 цаг, эсхүл ялтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 8 цагаас ихгүй, 7 хоногт 10 цагаас багагүй байхаар тусгасан.

Торгох ялыг Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэхээр тусгалаа.

#### **Тавдугаар бүлэг** **Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

Тавдугаар бүлэг зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, ялсны үүрэг, зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг сонгох, ялтанд хяналт тавих, зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөх, зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөх, ялсныг урамшуулах, ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

Тухайлбал, Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавихаар зохицуулсан ба ялсны үүргийг нарийвчлан зохицуулахдаа ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт үүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцахаар тусгасан.

Мөн ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож ялсныг урамшуулах зохицуулалтыг тусгаснаас гадна хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих харилцааг тухайлан тусгалаа.

#### **Зургадугаар бүлэг** **Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

Зургадугаар бүлэгт эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг мэдэгдэх, ял шийтүүлсэн ялтан, ялсныг сонгох, томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтны үүрэг, эрх, зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтны үүрэг, эрх хасах ял шийтүүлсэн ялтанд хяналт тавих, ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга, хэрэгсэл, ялтанд байнгын хяналт тавих, ял эдлэх хугацааг тоолох, ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн ялтан, хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага оногдуулахтай холбоотой харилцааг тусгасан.

Тухайлбал, Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч 30 хоног тутам ялтантай урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар тайлбар авч шаардлагатай тохиолдолд ялтны ажлын байр, үйл ажиллагааг биечлэн хяналт тавих ба эрх хасах ял эдэлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолохоор зохицуулсан.

#### **Долдугаар бүлэг** **Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх**

Долдугаар бүлэгт албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авах, шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх, этгээдийн засрал хүмүүжлийн байдалд тавих хяналт, тэнссэн, тогтоолын биелэлтийг хойшуулсан шийдвэрийг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх тухай санал гаргах, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, албадлагын арга хэмжээг дуусгавар болгох, хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Тухайлбал, Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нь тогтоолын биелэлтийг хойшуулсан этгээдийн засрал хүмүүжлийн байдалд хяналт тавихдаа тогтоолын биелэлтийг хойшуулсан хүн оршин суугаа газраа 7 хоногтоос дээш хугацаагаар орхин явах тохиолдолд зөвшөөрөл авах, 30 хоног тутам нэг удаа биечлэн ирж, бүртгүүлэхийг даалгахаар тусгасан.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гармагц уг этгээдийг албадан эмчлэх байгууллагад хүргэх үүргийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх бөгөөд шүүхийн шийдвэр, этгээцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, холбогдох бусад баримт бичгийг хамтад хүргүүлэх ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагын үүргийг нарийвчлан тусгасан.

#### **Наймдугаар бүлэг** **Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх**

Наймдугаар бүлэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа буюу хорих байгууллагын тогтолцоо, хорих ангид нэвтрэх, хорих анги шинээр болон өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох, хорих ангийн төрөл, чиг үүрэг, хаалттай хорих ангийн тусгай төрөлд ял эдлүүлэх, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд ял эдлүүлэх, хорих хорих эмнэлэг, түүний чиг үүрэг, хоригдолд хорих ангиас гадуур эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дэргэдэх зөвлөлийн чиг үүргийг тус тус тусгалаа.

Түүнчлэн хорих ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, төрлийг өөрчлөх, хоригдлыг хуяглан хүргэх, хүлээн авах, хоригдлыг тусад нь ял эдлүүлэх, хорих өрөөнд тавигдах шаардлага, хоригдлын эрх, үүрэг, хоригдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх, хоригдол бусадтай уулзах, харилцах, хоригдлын хөдөлмөр, түүний нөхцөл, хөлс, хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглох, хоригдлыг хорих ангийн гадна хөдөлмөрлүүлэх, хорих байгууллагад явуулах сургалт, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ, хэлбэр, зохион байгуулалт, хорих анги дахь сургалт, хоригдлыг урамшуулах, хоригдлын аюулгүй байдлыг хангах, хоригдлыг тусгаарлах тасалгаанд шилжүүлэх, хоригдлын ахуйн нөхцөл, хоригдлын бие, эд зүйл, хорих өрөөнд үзлэг, нэржлэг хийх, түр ба удаан хугацааны уулзалт, уулзалтын өрөө, захидал, илгээмж илгээх, мөнгөн

гүйвуулга хийх, хоригдол өргөдөл, гомдол, хүсэлт гаргах, хоригдолд чөлөө олгох, хорих ангиас хоригдолд үзүүлэх төлбөрт үйлчилгээтэй харилцааг тухайлан зохицуулсан.

Тухайлбал, Нийт хорих ангидаас 2022 онд 25 хоригдол, 2023 онд 39 хоригдол, 2024 онд 81 хоригдол, 2025 оны эхний 2 сарын байдлаар 16 нийт 131 хоригдлын дэглэм, зэрэглэлийг хүндрүүлсэн байна.<sup>3</sup>

Хоригдлын гаргасан зөрчлийн дийлэнх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 228 дугаар зүйлийн 228.2.1-д заасан хорих ангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын болон хорих ангийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцэн, доромжилсон, эсхүл хорих ангийн алба хаагч, түүний гэр бүлийн гишүүнд хүч хэрэглэхээр заналхийлсэн, айлган сүрдүүлсэн, мөн хуулийн 228.2.4-т заасан хоригдолд хүч хэрэглэсэн, нэр төрийг нь гутаан доромжилсон, заналхийлсэн үндэслэлээр дэглэм, зэрэглэл хүндрүүлсэн байна.<sup>4</sup>

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198.1-д нээлттэй хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй, мөн хуулийн 199.1-д хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна гэж заасан.

Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна гэж заасан боловч хоригдлын ял эдлүүлэх хугацаа, орчин нөхцөл, уулзалт, хөдөлмөр эрхлэлтийн байдлаараа харилцан адилгүй байна.

Хуульд зааснаар хоригдлын уулзалт нь тухайн хоригдолд оногдуулсан ялын хугацаа, дэглэмээс шалтгаалан харилцан адилгүй байгаа боловч хөдөлмөр эрхлэлт нь хоригдлыг нийгэмшүүлэх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, улс эх орны бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулах ач холбогдолтой байтал, хаалттай дэглэмийн хоригдлуудыг хөдөлмөр эрхлэх нөхцөл боломж хязгаарлагдмал байна.

2025 оны 03 дугаар сарын байдлаар 4615 хоригдол ял эдэлж байгаагаас нээлттэй дэглэмийн хоригдол 3449, хаалттай дэглэмийн хоригдол 1126 буюу 32,6 хувийг эзэлж байгаа бөгөөд хорих ангийн үйлдвэрлэлд 821 хоригдол, аж ахуйн үйлчилгээнд 382 хоригдол, аж ахуй нэгжид гэрээгээр 120, нийт 1323 хоригдлыг буюу нийт хоригдлын 28,6 хувийг хөдөлмөрт хамруулж байна.<sup>5</sup>

2024 онд нийт 2448 хоригдол 288,5 тэрбум төгрөгийн хохирол, төлбөртэй байснаас хөдөлмөрийн хөлснөөс хэсэгчилж төлсөн 677 хоригдлын 526,5 сая төгрөг, бүрэн барагдуулсан 54 хоригдлын 56,8 сая төгрөг, ар гэрээс нь хэсэгчилж төлсөн 70 хоригдлын 1,4 тэрбум төгрөг, бүрэн барагдуулсан 353 хоригдлын 2,8 тэрбум төгрөг, нийт 407 хоригдол 4,8 тэрбум төгрөгийг хохиролч буюу төлбөр авагчид шилжүүлж, 283,7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.<sup>6</sup>

Монгол Улсын хэмжээнд 2024 онд хорих ангийн үйлдвэрлэлд 1307 хоригдол ажилласан бөгөөд үүнээс нээлттэй дэглэмд ял эдэлж байгаа 299 хоригдол, хаалттай дэглэмд ял эдэлж байгаа 271, нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа 737 хоригдол тус тус байна.<sup>7</sup>

<sup>3</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

<sup>4</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

<sup>5</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

<sup>6</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024.

<sup>7</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2024.

Аж ахуйн үйлчилгээнд, аж ахуй нэгжид гэрээгээр нийт хоригдлын 38 хувь хөдөлмөрт хамрагдаж байгаа нь хоригдлыг хөдөлмөрт хамруулах хуулийн хэрэгжилт бүрэн дүүрэн хангагдахгүй байна.<sup>8</sup>

Цалинтай ажлын байраар хангасан хоригдлын тоо 30 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь гэмт хорын төлбөр барагдуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна.<sup>9</sup>

Тус судалгаанаас дүгнэхэд хоригдлыг аж ахуй нэгжид гэрээгээр цалинтай ажлын байраар хангах хувь нийт хоригдлын 2,7 хувийг эзэлж байгаа нь хангалтгүй байгаа тул хаалттай онцгой төрлөөс бусад хоригдлыг байнгын ажлын байраар хангаж, хөдөлмөрт хамруулж, иргэн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулахад онцгойлон анхаарах шаардлага үүсэж байна.

Тус хуулийн төсөлд хорих ангийг зэрэглэлгүй болгож хаалттай хорих ангийг энгийн, онцгой, тусгай гэсэн төрөлтэй байхаар тусгасан нь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт хангагдах, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол төлбөр барагдуулалт нэмэгдэх, хоригдлын уулзалт, утсаар ярих, цахим уулзалт хийх эрхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Энэхүү ажил нь хорих ангийн дэглэм, зэрэглэл үйлдвэрлэлийн чиглэл, дотоод нөөц бололцоо, эрх зүйн зохицуулалтаас хамаарч хязгаарлагдмал байдалтай явагдаж байгаа бөгөөд цаашид улс орны томоохон бүтээн байгуулалтын ажил болон ногоон хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдтэй уялдуулах нь хоригдлын хөдөлмөрийг үр ашигтай зарцуулах, нийгэм-эдийн засгийн өгөөжийг бий болгох боломжтой юм.

Дээрх хэрэгцээ шаардлага болон Алсын хараа 2050, Монгол улсын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд хорих байгууллагын үйлдвэрлэлийг бус нутгийн онцлогоос шалтгаалан бүсчилсэн, Улс орны бүтээн байгуулалт, бүсчилсэн хөгжилд хоригдлыг ажиллуулах зорилгоор хорих ангийг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулах, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар бүрэн хангаж, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол төлбөрийг барагдуулах зорилгоор зөвхөн хорих ангийн байрнаас гадна хөдөлмөрлүүлэх зэрэг зохицуулалтыг шинээр тусгасан.

Мөн хоригдлын эрхийг хангах зорилгоор түр болон удаан хугацааны уулзалт зохион байгуулах, захидал, илгээмж илгээх, мөнгөн гуйвуулга хийх, хорих байгууллагад ерөнхий боловсролын болон хөдөлмөрийн дадлага олгох сургалтыг зохион байгуулах, хоригдлыг урамшуулж тэдгээрт шагналын хоног олгох, тус тус зохион байгуулахаар тусгасан.

Түүнчлэн, Хоригдол, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд явуулах сургалт, нөлөөллийн ажлыг тодотгон, хоригдлын эрх зүйн байдлыг дээшлүүлэх зорилгоор "Сургалт, нийгмийн, ажил, сэтгэл зүйн үйлчилгээ" тусгасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгмийн ажил үйлчилгээний хүрээнд бясалгалын сургалтыг анхан болон дунд гүнзгийрүүлсэн хэлбэрээр үйлдсэн гэмт хэргийг харгалзахгүйгээр зохион байгуулан давхардсан тоогоор 3782 хоригдлыг,

<sup>8</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

<sup>9</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

мансуурах сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн давхардсан тоогоор 1921 хоригдлыг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн давхардсан тоогоор 2551 хоригдлыг, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай давхардсан тоогоор 9512 хоригдлыг тус тус хамруулсан байна.<sup>10</sup>

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан хоригдлын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, бясалгалын сургалтад хамрагдсан хоригдлын тоо 59.5 хувиар буурсан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэн, сургалтад хамрагдсан хоригдлын тоо 72.6 хувиар өссөн, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай сургалтад хамрагдсан хоригдлын тоо 81.9 хувиар өссөн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт шийтгэгдэн сургалтад хамрагдсан хоригдлын тоо 80.8 хувиар өссөн тус тус үзүүлэлттэй байна.<sup>11</sup>

Дээрх тоон судалгаанаас дүгнэхэд хоригдлын дунд зохион байгуулах сургалт нь бясалгалын сургалт дийлэнх хувийг эзэлж байгаа нь хуульд хоригдлын дунд зохион байгуулах сургалтын агуулга, хэлбэрийг бүрэн тусгаж өгөөгүйтэй холбоотой гэж дүгнэхээр байна.

Мөн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд явуулах сургалт, нөлөөллийн ажлын хүрээнд хууль, эрх зүйн сургалт, сэтгэл зүйн сургалт, явуулах, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгийн, цагдан хоригдсон этгээдэд явуулах сэтгэл зүйн үйлчилгээ, цагдан хорих байранд сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдсон этгээдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зэрэг харилцааг зохицуулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх албадан сургалт, сэтгэлүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

#### Есдүгээр бүлэг Хорих байгууллагын аюулгүй байдал

Есдүгээр бүлэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдал, түүний удирдлага, зохион байгуулалт, хорих байгууллагын техникийн хяналт, хамгаалалт, үүрэн холбооны хэрэгсэл ашиглахыг хориглох, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх, хорих анги дахь гүйцэтгэх ажил, хорих ангид онцгой дэглэм тогтоох, нрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах, хорих анги, хорих ангийн алба хаагчид хориглох үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байна.

Тухайлбал, хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, техникийн хяналт, хамгаалалт, биечилсэн хяналт, хамгаалалт, аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх, гүйцэтгэх ажил гэсэн төрөлтэй байхаар тусгасан.

Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс,

<sup>10</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

<sup>11</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2025.

алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий тусгай ажиллагааны нэгжтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд шинэ төрлийн тоног төхөөрөмж нэвтрүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хоригдлын аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих ангийн хамгаалалтын бүсээс гарч ажиллаж байгаа хоригдолд хяналт тавихад нистэгчгүй нисэх төхөөрөмж, цахим хяналтын төхөөрөмжийг ашиглахаар тусгасан.

Түүнчлэн, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад тогтоомжийн хүрээнд хоригдол, хоригдолч, ялтны аюулгүй байдлыг хангах, гарч бароолох гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангийн алба хаагч, иргэн, хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял эдлэж буй ялтны аюулгүй байдлыг хангах, хорих байгууллагад гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хоригдол, хоригдсон этгээд, ялтны дундаас урьд үйлдсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэх, хорих ангиас өргосон хоригдол, хоригдсон этгээд болон хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн ялтанг эрэн сурвалжлах зорилгоор дараах зохицуулалтыг тусгасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд газар, хэлтэс нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүн эрэн сурвалжлах нэгж, алба хаагчтай байх, өргосон хоригдол, хоригдсон этгээд, хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүнээс эрэн сурвалжлах ажиллагаанд гарсан зардлыг нөхөн төлүүлдэг байх, эрэн сурвалжлах ажилтан нь эрэн сурвалжлах ажиллагааны явцад хууль тогтоомжийн хүрээнд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх, гүйцэтгэх ажил явуулах эрхийн талаар нарийвчлан тусгалаа.

Мөн эрэн сурвалжилж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг саатуулахдаа ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын тогтоолоор 72 цаг хүртэл хугацаанд саатуулах, саатуулагдсан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан хүний ялыг солих, албадлагын арга хэмжээг хүчингүй болгож ял оногдуулах саналыг прокурорт гаргах зохицуулалтыг шинээр тусгасан.

#### Аравдугаар бүлэг Хоригдлыг суллах

Аравдугаар бүлэгт хоригдлыг суллах, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг суллах тухай санал гаргах, өвчний учир ялаас чөлөөлөх, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, хорих ангийн алба хаагчид хориглох үйл ажиллагааны талаар хууль тогтоомжид нийцүүлэн тусгасан.

Тухайлбал, хоригдол нь шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацаа дууссан, эсхүл хорих ялыг өөр төрлийн ялаар сольсон, эсхүл хорих ялаас өвчний учир чөлөөлсөн, өршөөл, уучлал үзүүлсэн, хорих ялаас хугацаанаас өмнө сулласан, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл цагаатгасан гэх үндэслэлээр суллах зохицуулалтыг тусгасан.

Мөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг суллах тухай санал гаргахдаа Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан хугацаа өнгөрсний дараа суллуулах тухай хүсэлтээ шүүхэд гаргана гэж тусгасан.

Түүнчлэн, хоригдлыг ялын хугацаа дууссан бол тухайн өдөрт, ялын хугацаа нь амралт, баяр ёслолын өдөр бол өмнөх өдөр нь, бусад үндэслэлээр уг хоригдлыг суллах тухай шийдвэрийг хүлээн авсан өдөрт нь, хэрэв ажлын цаг дууссаны дараа хүлээн авсан бол дараагийн өдөрт нь суллаж, суллагдсан хүнд хувийн бичиг баримт, эд зүйл, хоригдын банк, санхүүгийн байгууллага дахь нэрийн дансны үлдэгдлийг шилжүүлж, суллагдсан тухай тодорхойлолт олгож, хоригдлын хувийн хэрэгт зохих тэмдэглэл хийх талаар тус тус тухайлан боловсруулсан.

**Арван нэгдүгээр бүлэг**  
**Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх**  
**үндэслэл, журам**

Арван нэгдүгээр бүлэгт биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаарх харилцааг зохицуулсан.

Тухайлбал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх ба алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх, нэн тэргүүнд хэрэглэхгүй байх, тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх нийтлэг шаардлагыг баримтлахаар тусгасан.

Биеийн хүчийг алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн, нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхээр энэ хуульд заасан тохиолдолд хэрэглэхээр зохицуулсан.

Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсноос бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд биеийн хүч хэрэглэхийг хориглохоор тусгасан.

Мөн галт зэвсэг хэрэглэх нийтлэг журмын хэсэгт галт зэвсэг хэрэглэх сургалтад хамрагдан, галт зэвсэг хэрэглэх эрх олгогдсон хорих ангийн алба хаагч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг хадгалах, биедээ авч явах, хэрэглэх эрхтэй байхаар тусгасан.

**Арван хоёрдугаар бүлэг**  
**Сургалт, нийгмийн ажил, сэтгэлзүйн үйлчилгээ**

Энэхүү бүлэгт хорих, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд, баривчлагдсан этгээдэд эдгээр төрлийн үйлчилгээ үзүүлэх харилцааг тусгалаа.

**Арван гуравдугаар бүлэг**  
**Бусад**

Арван гуравдугаар бүлэгт энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан харилцааг хүлээлгэнэ гэж тус тус заасан.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> Араан есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн эрхэм зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, шударга шүүхээр шүүлтгэх иргэний эрхийг хангах гэж тус тус заажээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн<sup>2</sup> 47-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн<sup>3</sup> 3.2.2.7-д "... иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, ... эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж заасны дагуу иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах хууль, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, олон улсын сайн жишигт хүргэх" гэж тус тус заасан нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг 16 бүлэг, 138 зүйлтэй баталснаас хойш өнгөрсөн 9 жилийн хугацаанд нийт 15 удаа 2016, 2017 онд 2 удаа, 2019 онд 2 удаа, 2021 онд 3 удаа, 2022 онд 3 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 2 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оржээ. Тус хуулийн 135 дугаар зүйлд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулна", 136 дугаар зүйлд "Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна" гэсэн нэг өгүүлбэр бүхий маш товч зохицуулалтаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдох харилцааг зохицуулсан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь 302 зүйлтэй бөгөөд үүний 14 зүйлд нь захиргааны шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой зохицуулалтыг хуульчилсан байна. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д зааснаар захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1-д заасан "анхан шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр" болон захиргааны актыг биелэлтийг түдгэлзүүлэх тухай хуулийн хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж, хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамжийг үндэслэн явуулж байна.

Манай улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас хойш шүүхэд зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо тогтмол өсөж, цаашдаа нэмэгдэх хандлагатай байна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

Монгол Улсад анх захиргааны хэргийн шүүх байгуулагдан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн 2004 онд 145 хэрэг шийдвэрлэгдсэн бол 2023 онд 2366 хэрэг шийдвэрлэгдсэн<sup>4</sup> нь үүнийг нотлон харуулж байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг шаардлагатай бол албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг бодит байдлаар сэргээхэд оршдог.<sup>5</sup> Гэвч захиргааны хэргийн шүүх байгуулагдсан өнгөрсөн 20 жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийн биелэлт төдийлөн хангалттай хэмжээнд биш байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь иргэний болон эрүүгийн шүүхийн шийдвэрээс мөн чанарын хувьд эрс ялгаатай. Тухайлбал, захиргааны акт хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, түдгэлзүүлэх, тодорхой захиргааны шийдвэр гаргахыг даалгах зэрэг шийдвэр нь эд хөрөнгө гаргуулах, эсхүл бэлэн мөнгөн төлбөр гаргуулах шинжээс илүүтэйгээр төрийн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээ, чиг үүрэг, захиргааны үйл ажиллагаатай холбоотой байдаг. Иймээс эдгээр шийдвэрийг иргэний шийдвэр гүйцэтгэлтэй адилтган шийдвэр гүйцэтгэгчээр хэрэгжүүлүүлэх нь тохиромжгүй, үр нөлөө багатай байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын иргэний шийдвэр гүйцэтгэгч нь тус ажиллагааг хэрэгжүүлж байна. Ингэхдээ ахлах шийдвэр гүйцэтгэгч мэдэгдэл хүргүүлэх замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн хэрэг маргааны анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн оролцоо, хяналт байхгүй байна.

Монгол Улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн нийт хэргийн тоо болон тэдгээрийн хэдэн хувьд гүйцэтгэх хуудас бичигдсэн тоон мэдээллийг дараах статистикаас харж болохоор байна.

## Монгол Улсын хэмжээнд нийт шийдвэрлэсэн захиргааны хэрэг /2022-2024.10 сар нийт 6354/




■ Нийт ■ Үндэслэл ■ Орон нутаг


<sup>4</sup> Монгол Улсын Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. (УБ, 2004-2023).

<sup>5</sup> А.Дугармаа, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилгааны онол, практикийн асуудал" сэдэвт илтгэл.


## Шүүхийн шийдвэрт бичигдсэн гүйцэтгэх хуудас /Нийт 521/



## Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлсэн хугацаа /2013 оноос хойш дуусгавар болсон 2211 ТӨБ-г дүн шинжилгээ хийхэд/



Монгол Улсын хэмжээнд нэг жилд шийдвэрлэгдсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дунджаар 8.2%-д гүйцэтгэх хуудас бичигддэг байна. Эдгээр гүйцэтгэх хуудасны 61 орчим хувийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх олгосон байна.



Энэхүү хуулийн төсөл нь захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн шийдвэр гүйцэтгэчийн ажиллагаа гэж үзэх уламжлалт хандлагаас татгалзаж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг шүүхийн хяналтын дор хэрэгжүүлэх, захиргааны шийдвэрийн төрөл тус бүрт тохирсон ялгамжтай журам тогтоох, мөнгөн албадлага болон бусад хариуцлагын механизмыг бий болгоход үндсэн зорилгод тулгуурлаж болно.

Хуулийн төслөөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван тавдугаар бүлгийг шинэчлэн найруулж, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелүүлсэнд тооцох, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл, захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх, захиргааны шийдвэр гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, төлбөр, хохирол гаргуулах шийдвэрийг биелүүлэх, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ, шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээн явуулах, дуусгавар болгох журмыг 135-146 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтүүдийг тусгав:

- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн харилцааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бие даасан бүлгээр иж бүрэн зохицуулах;
- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн төрөл бүрд тохирсон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ялгамжтай журам тогтоох;

3. Захиргааны акт хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, түдгэлзүүлэх зэрэг шийдвэрийн шууд эрх зүйн үр дагаврыг тодорхойлох;

4. Хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй тохиолдолд шүүхээс мөнгөн албадлага хэрэглэх буюу торгуулийг давтан ногдуулах;

5. Шүүхийн шийдвэрийг зөвхөн хэлбэрийн төдий биелүүлснийг биелэлтэд тооцохгүй байх;

6. Дээд шатны захиргааны байгууллага, төрийн албаны төв байгууллагын оролцоо, хяналтыг тодорхой болгох;

7. Төлбөр, хохирол гаргуулах асуудлыг төсөвтэй уялдуулан хугацаа тогтоох замаар шийдвэр гүйцэтгэл удааширдаг байдлыг шийдвэрлэх;

8. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа, баримт бичгийн хөдөлгөөн, гомдол, түдгэлзүүлэх үндэслэлийг тодорхой болгож, процессын удаашралыг бууруулах;

9. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг тухайн хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх өөрөө удирдан явуулах.

Хуулийн төслийн гол зохицуулалтуудыг авч үзвэл:

1. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелүүлсэнд тооцох зохицуулалт

Хуулийн төслийн 135 дугаар зүйлд хариуцагч шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелүүлэхгүй тохиолдолд энэ бүлэгт заасан журмын дагуу албадан биелүүлэхээр тогтоосон, Ингэснээр захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлт сайн дурын болон албадлагын гэсэн хоёр шатлалтай болохыг тодорхой зааж өгсөн.

Хуулийн төслийн 136 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцох шалгуурыг дэлгэрэнгүй тогтоосон. Тухайлбал, хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актыг гаргах, захиргааны гэрээ байгуулах, эсхүл шүүхийн шийдвэр, мэдэгдэлд заасан үүргийг тогтоосон хугацаанд, зохих ёсоор биелүүлсэн бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохоор тусгасан. Мөн шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийг агуулгаар нь дахин гаргасан бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохгүй байхаар тусгасан нь хэлбэрийн төдий, дүр үзүүлэн шүүхийн шийдвэрийг биелүүлдэг байдлыг таслан зогсоох ач холбогдолтой.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл, хэрэгжүүлэх байгууллагын зохицуулалт

Хуулийн төслийн 137 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байхаар заасан. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх удирдан явуулах бөгөөд тухайн шүүхэд шийдвэр гүйцэтгэлийн чиг үүрэг хариуцсан шүүхийн ажилтан ажиллахаар тусгасан

нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг шүүх байгууллагатай нягт холбож, үргэлжилсэн хяналт хэрэгжүүлэх боломжтой байхаар тусгасан.

Мөн энэ зүйлд шүүхийн шийдвэрийг нэн даруй гүйцэтгэх тохиолдлыг тодорхойлсон. Үүнд төрийн албан хаагчийг ажил, албан тушаалд нь зүүлэн тогтоох, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, хугацаанаас хамаарч хүн, хуулийн этгээдэд ноцрол хохирол учрахаар бол түүний хүсэлтээр нэн даруй гүйцэтгэхээр тусгасан. Энэ нь иргэн, хуулийн этгээд өөрийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо түргэн шуурхай хамгаалуулах нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой зохицуулалт болсон.

3. Захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Хуулийн төслийн 138 дугаар зүйл нь захиргааны шүүхийн шийдвэрийн онцлогийг тусгасан чухал зохицуулалт юм. Уг зүйлээр Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай, хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон тухай, эсхүл захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор маргаан бүхий шийдвэрийн эрх зүйн үйлчлэл дуусгавар болж, нэхэмжлэгчийн эрх сэргэхээр тусгасан. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн шүүхийн шийдвэрийн биелэлт нь албадлагын арга хэмжээ шаардахгүйгээр шууд эрх зүйн үр дагавар үүсгэдгийг хуульчилж өгч байна.

Мөн шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон, илт хууль бус болохыг тогтоосон захиргааны шийдвэрийг хэрэгжүүлсний улмаас бусдад учруулсан хохирлыг буруутай этгээд өөрөө хариуцна гэж заасан нь захиргааны байгууллага, албан тушаалтны хариуцлагыг тодотгож өгсөн.

4. Захиргааны шийдвэр гаргахыг даалгасан, төлбөр болон хохирол гаргуулах шийдвэрийг биелүүлэх

Хуулийн төслийн 139 дүгээр зүйлд захиргааны шийдвэр гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх журмыг тусгайлан заасан бөгөөд хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тогтоосон хугацаанд гаргах, хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд биелүүлэхгүй бол шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхээр тусгасан.

Хуулийн төслийн 140 дугаар зүйлээр төлбөрийн хэмжээ өөрчлөн тогтоосон, төлбөр, хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх журмыг нарийвчлан зохицуулсан болно. Хэрэв хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг зургаагаас 12 сарын дотор биелүүлээгүй бол шүүгч хариуцагч болон түүний дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, цаашид төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээний зардалд харгалзах төсвөөс тусгад төрийн сан дахь дансны мөнгөн хөрөнгөөс албадан гаргуулах зохицуулалтыг тусгасан. Энэ нь зөвхөн "дараа жилийн төсөвт тусгуулна" гэх үр нөлөө багатай механизм аас нэг шат ахисан шийдэл юм.

5. Албадан гүйцэтгэх ажиллагаа, мөнгөн албадлагын механизм

Хуулийн төслийн 141 дүгээр зүйлд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны үндсэн процессыг тусгасан. Хэргийн оролцогч

шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргаж, шүүгч гүйцэтгэх хуудас олоно. Шүүхийн ажилтан гүйцэтгэх хуудас бичигдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас болон шаардлагатай бусад баримт бичгийг холбогдох этгээдэд хүргүүлэхээр тусгасан нь процессын шуурхай байдлыг хангана.

Хуулийн төслийн 142 дугаар зүйлд албадлагын арга хэмжээг тусгайлан зохицуулсан. Шүүгч хариуцагч шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сайн дураар биелүүлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль оногдуулж, уг арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоон, биелүүлэх хүртэл давтан хэрэглэж болохоор тусгасан. Энэ нь одоогийн хуулийн хамгийн сул байсан хэсгийг бодит хөшүүрэгтэй болгож буй гол шинэчлэлүүдийн нэг юм.

#### 6.Хариуцлага, хяналтын тогтолцоо







Хуулийн төслийн 143 дугаар зүйлээр шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй хоёр буюу түүнээс дээш удаа албадлагын арга хэмжээ авагдсан хариуцагчид шүүгч сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл бүрдсэн талаар эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлэхээр заасан. Эрх бүхий байгууллага нь тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, шүүхэд мэдээлэх үүрэгтэй байхаар тусгасан. Мөн энэ хуульд заасан албадлагын арга хэмжээ авсан, хариуцлага хүлээлгэсэн нь эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээлгэхэд саад болохгүй гэж заасан.




Түүнчлэн шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны мэдээллийг шүүхийн бүртгэлд бүртгэж, тухайн шүүхийн цахим санд олон нийтэд нээлттэй байршуулна гэж зааснаар ил тод байдал, нэр хүндтэй холбогдсон хөшүүргийг хэрэглэж буй хэлбэр юм.

Хуулийн төслийн 144 дүгээр зүйлд шүүхийн шийдвэрийн биелэлтэд шүүгч хяналт тавих зохицуулалтыг тусгаж, дээд шатны байгууллага, улмаар төрийн албаны төв байгууллагын оролцоог тодорхой болгосон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2026 оны 45 дугаар сарын 18-ны  
өдрийн 1/2525 дугаартай албан  
бичгийн хавсралт.

Хуулийн төслийн холбогдох материалыг дараах холбоосоор үзэж, танилцана  
уу.

<p>1.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан /Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарим зохицуулалт/</p>	
<p>2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ</p>	
<p>3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ</p>	
<p>4.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан</p>	
<p>5.Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлан</p>	
<p>6.Эрүүгийн хэргийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан</p>	

<p>7.Эрүүгийн хэргийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлан</p>	
<p>8.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ</p>	
<p>9.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо</p>	

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ